




СОЁЛЫН ЯАМ



Тайлангийн дугаар: 220017

**“МОНГОЛ БА ДОТООД АЗИЙН УЛС ОРНУУДЫН ОЮУН САНААНЫ НЭГДМЭЛ
ҮНЭТ ЗҮЙЛСИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН”**

сэдэвт тойм судалгааны ажлын завсрын тайлан

(Common spiritual values of Mongolia and Inner Asia)

Progressive report

Захиалагч: Соёлын яам

Гүйцэтгэгч: ЮНЕСКО-ийн ивээл дор НСИСОУХ

Улаанбаатар хот

2022 он

*Энэхүү тайланг Монгол Улсын Соёлын Яамны захиалгаар ЮНЕСКО-ийн ивээл дор
Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэнгийн “МОНГОЛ БА ДОТООД
АЗИЙН УЛС ОРНУУДЫН ОЮУН САНААНЫ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ” сэдэвт тойм
судалгааны ажлын хүрээнд хийж гүйцэтгэв.*

Хянасан: Ч. Мөнхтуул (Доктор, НСИСОУХ)

Судалгааны багийн ахлагч: Г.СОДБАЯР (НСИСОУХ)

Судалгааны багийн гишүүд: Н.ГЭРЭЛТ (Доктор, НСИСОУХ)

Улаанбаатар хот
2022 он

Талархал

Юуны түрүүнд энэхүү судалгааг хийх боломжийг олгосон ЮНЕСКО-ийн ивээл дор НСИСОУХ-ийн захирал, доктор И.Бямбабаатар болон хүрээлэнгийнхээ хамтран ажиллагч нарт судалгаанд минь өөрсдийн үнэтэй зөвлөгөөгөөрөө тус дэм болж байсанд талархал илэрхийлэх нь зүйн хэрэг юм.

Мөн хээрийн судалгаанд хамтран оролцож Увс, Баян-Өлгий, Говь-Алтай аймгуудаар бие даан хээрийн хийж Архангай, Баянхонгор аймгуудад хамтран хээрийн судалгаа хийж, олон яриа, ярилцлага хийж, өөрийн үнэтэй санаагаараа судалгаанд хувь нэмэр оруулсан МУИС-ийн Шашин судлалын магистрант Э.Хонгорзулд тусгайлан талархал илэрхийлж байна.

Үүнээс гадна 3 сараас эхэлсэн хээрийн судалгаанд тав тухтай судалгаа хийхэд минь бүхий л талаар тусалж дэмжиж байсан Хэнтий аймгийн Биндэр сумын иргэн Сайнбуян, Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Соёлын төвийн эрхлэгч Энхцэцэг, ажилтан Мөнх-Эрдэнэ, Дэлгэрдалай, нутгийн иргэн Мөнхбаатар нар болон тэдний ар гэрийнхэнд чин сэтгэлээсээ талархал илэрхийлж байна.

Мөн хээрийн судалгаа хийх явцад гүн туслалцаа үзүүлсэн Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Соёлын төвийн албан хаагчид, Тарагт сумын ЗДТГ-ын албан хаагчид, Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Соёлын төвийн албан хаагчид, Баянбулаг сумын Соёлын төвийн албан хаагчид, Завхан аймгийн Шилүүстэй сумын ЗДТГ болон Соёлын төвийн албан хаагчид, Цагаанхайрхан сумын Соёлын төвийн албан хаагчид, Тэлмэн сумын Соёлын төвийн албан хаагчид, Сонгино сумын Соёлын төвийн албан хаагчид, Архангай аймгийн Цахир сумын Соёлын төвийн албан хаагчид, Увс аймгийн Улаангом хотын Соёлын төвийн албан хаагчид, Завхан сумын Соёлын төвийн албан хаагчид, Тариалан сумын Соёлын төвийн албан хаагчид, Ховд сумын Соёлын төвийн албан хаагчид, Баян-Өлгий аймгийн Өлгий хотын Соёл төвийн албан хаагчид, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Соёлын албан хаагчид, Бигэр сумын албан хаагчдад талархал илэрхийлж байна.

Хамгийн чухал нь монголчуудын үнэт зүйлсийг тодруулахд зорилго бүхий энэхүү судалгаанд маань өөрийн үнэт үзэл, санаа бодлоороо харамгүй тус хүргэсэн судалгаа явуулсан бүхий л нутгийн иргэд, малчид, албан хаагчид, өндөр настан та бүхэнд чин сэтгэлээсээ талархал илэрхийлж байна. Баярлалаа.

Агуулга	
Талархал.....	iii
Удиртгал	5
Судалгааны үндэслэл.....	5
Судлагдсан байдал.....	7
Судалгааны зорилго ба зорилт.....	10
Судалгааны ач холбогдол.....	10
Судалгааны асуудал ба нэр томъёо.....	10
Судалгааны онолын өнцөг.....	13
Судалгааны арга зүй ба бэрхшээл.....	16
Судалгааны бүтэц.....	17
Нэгдүгээр бүлэг: Монгол Улсын Монголчуудын үнэт зүйлс	18
“Алсын хараа 2050” ба “Үнэт зүйлс”.....	18
Гэр бүл ба хувь хүний үнэт зүйлс.....	21
Бүлгийн дүгнэлт.....	40
Хоёрдугаар бүлэг: Өвөр Монголын нийгэм, соёл дахь “үнэт зүйлс”	42
“Дундадын үндэстэн” ба “үнэт зүйлс”.....	42
Соёлын ялгаа ба “үнэт зүйл”.....	50
Бүлгийн дүгнэлт.....	53
Гуравдугаар бүлэг: Буриадын нийгэм-соёл дахь үнэт зүйл	54
ОХУ-ын засгийн газар ба “үнэт зүйл”.....	54
Бүлгийн дүгнэлт.....	58
Дөрөвдүгээр бүлэг: Казакстан, Киргизстаны үнэт зүйлс	59
Засгийн газар ба “үнэт зүйл”.....	59
Гэр бүл, хувь хүн ба "үнэт зүйл".....	64
Бүлгийн дүгнэлт.....	66
Дүгнэлт	67
Ном зүй	70
Хавсралт	73

Удиртгал

Судалгааны үндэслэл

Хүн төрөлхтөн үүсэн бий болсон цагаасаа эхлэн өөрсдийн нийгэм, соёлыг бүтээж, тэрхүү нийгэм, соёлынхоо хүрээнд амьдралын хэв маяг, итгэл үнэмшил, ёс суртахуун, зан заншил, уламжлал зэргийг танин тайлбарлаж, өөр өөрсдийн орчлон ертөнц, амьдралын мөн чанарын тухай мэдлэгийг бүтээж ирсэн билээ. Тэрхүү мэдлэг ухааны цогц байдал нь аливаа үндэстэн, угсаатны ижилсэл (identity) буюу бусад үндэстэн, угсаатнаас юугаараа ялгарч байгаа, тэдгээр өөрсдийгөө хоорондоо адил нэгэн үндэстэн, угсаатан хэмээн нэрлээд байгаа бүлэг хүмүүс чухам юугаараа ижил, юун дээр нэгдэж байгааг илэрхийлдэг юм. Энэхүү мэдлэг ухааны цогц байдлыг илэрхийлж буй нэгэн чухал илэрхийлэл бол тухайн үндэстэн, угсаатны ямар зүйлийг эрхэмлэн, дээдэлж үзэж байна гэх үнэлэмжийн тухай асуудал юм.

Монголчуудын үнэлэмж буюу аливаа зүйлийг үнэлж юуг хамгийн эрхэмлэн үзэж байгаа асуудал нь монголчуудын сэтгэлгээний онцлог, монгол хүн гэж ямар хүн байдаг талаарх асуултад хариулах гол хэрэгсэл юм. Орчин үед даяаршлын нөлөөгөөр Европ, Америк төвтэй барууны соёл, урлаг дэлхий нийтэд асар том нөлөө үзүүлж байгаа нь нүдэнд ил харагдаж байгаа билээ. Ийм цаг үед бусад эдийн засаг болон улс төрийн хүч харьцангуй сул буурай улс орнууд өөрсдийн бүтээн бий болгосон өвөрмөц, дахин давтагдашгүй тэрхүү соёлоо алдахад хүрээд байгаагаа эргэцүүлэн ухаарч эхэлсэн байна. Тэр ч утгаараа өөрсдийгөө танин мэдэж, өөрсдийн онцлог байдлаа гаргаж ирэх нь өнөөгийн цаг үед хамгийн чухал асуудал болжээ. Тэр ч утгаараа Казакстан улс гэхэд 2014 онд 2050 он хүртэл Казакстан улсыг ямар байлгах, Казак хүн гэж ямар хүн байх тухай “Казакстаны замнал-2050 нэгдмэл зорилго, нэгдмэл эрх ашиг, нэгдмэл хойч ирээдүй” гэх Ерөнхийлөгчийн илгээлтийг ард түмэндээ хандан гаргасан байдаг. Үүнтэй адилаар Монгол Улс 2020 онд өөрсдийн шинжлэх ухааны үндэстэйгээр тогтоосон үнэт зүйлс дээр суурилсан Монгол Улсыг бий болгох зорилгоор “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг баталж хэрэгжүүлж эхэлсэн юм.

Монголчуудын үнэт зүйлсийн талаарх судалгааг социологийн шинжлэх ухааны судалгааны арга зүйгээр СЭЗДС /одоогийн СЭЗИС/-Хофштедийн аргачлалаар (2015), Удирдлагын Академи Шварцын аргачлалаар (2017), СУИС өөрсдийн судалгааны аргачлалыг боловсруулан (2019) хийсэн судалгаанууд байгаа юм. Үүнээс гадна НСИСОУХ-ээс академич Б.Энхтүвшингээр ахлуулсан баг системийн хандцын арга гэх аргаар хийсэн судалгаа (2011), философийн үүднээс Монголчуудын үнэлэмжийн талаар авч үзсэн доктор Ц.Баатартогтохын докторын зэрэг горилсон судалгааны диссертациуд (2000) ч байгаа билээ.

Монголчуудын үнэт зүйлсийн талаар хийсэн эдгээр судалгаанууд нь монголчуудын нийтлэг, үндэсний гэж хэлж болох үнэт зүйлсийн талаар авч үзсэн боловч ихэнх судалгаа нь социологийн шинжлэх ухааны асуулга, анкетын арга зүй дээр тулгуурлан тоон судалгааны арга зүйгээр хийгдсэн юм. Хэдийгээр Хофштед, Шварцын аргачлалаар хийсэн судалгаанууд нь соёлын харьцангуй, олон талт байдлыг хүлээн зөвшөөрч, өөрсдийн соёлд хөрвүүлэн ашигласан боловч анкет, асуулгын үнэт зүйлс

хэмээх нарийн категоричлол үйлдэж, тэрхүү гаргаж ирсэн үнэт зүйлсийнхээ хүрээнд л судалгаанд оролцогчдоос авч байгаа тул үнэт зүйлс хязгаарлагдсан байх боломжтой хэмээн үзэж байгаа юм. Тиймээс бид монголчуудын үнэт зүйлс, тэр дундаа соёлын үнэт зүйлсийг антропологийн шинжлэх ухааны судалгааны арга зүй буюу чанарын судалгааны арга зүйгээр хийх хэрэгтэй хэмээн үзсэн юм.

Дээр өгүүлсэнчлэн Монгол Улс 2050 хүртэлх урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байгаа билээ. Энэхүү хөгжлийн хөтөлбөрт Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр нарийвчлан судалж, хөдөлшгүй бодит баримтад үндэслэсэн “Эх хэл, эх түүх, өв соёлыг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар, дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно (УИХ 2020) хэмээн нэгдүгээр бүлгийн зорилгыг тодорхойлсон байгаа билээ. Энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд бид нийгэм, хүмүүнлэгийн олон салбар ухаануудын судалгааг зайлшгүй хийх шаардлагатай бөгөөд антропологийн шинжлэх ухаан нь аливаа нийгэм, соёлыг улс төр, ураг төрөл, эдийн засаг, шашны зэрэг олон талаас нь авч үздэгээрээ онцлогтой юм. Тиймээс бид антропологийн арга зүйгээр энэхүү судалгааг хийхээс гадна зөвхөн Монгол Улсын хэмжээнд бус Дотоод Азийн бүс нутгийн хэмжээнд нүүдэлчин угсаа гарал, соёл уламжлал бүхий улс орнуудын хэмжээнд авч үзэж байгаа юм.

Судлагдсан байдал

Монгол Улс хууль тогтоомж хийгээд бүс нутгийн болоод олон улсын актууд

1992 оны Монгол Улсын Үндсэн Хуульд монголчуудын үнэт зүйлс хэмээх нэр томъёог шууд авч хэрэглээгүй боловч монголчуудын эрхэмлэн дээдлэх, хүндэтгэн авч үзэх ёстой зүйлсийг зааж өгсөн байдаг. Үүнд:

Монголын ард түмэн бид:

-Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,

-Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,

-Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,

-Хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,

-Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно (АИХ, 1992)

хэмээн авч үзэж байгаа нь Монголын төрийн зүгээс 1990 оны ардчилсан хувьсгалын дараах Монгол Улсыг бүтээхдээ Монгол Улсын тусгаар тогтнол, шударга ёс, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, уламжлал зэрэг зүйлсийг хамгийн эрхэм дээд зүйл болгоно гэж тунхаглан зарласан юм.

Энэхүү үзэл баримтлал “Алсын хараа-2050” урт хугацааны баримт бичигт мөн тусгагдсан байгааг тус баримт бичгийн эрхэм зорилгод -Үндэс язгуур, төрт ёс, өв соёлоо дээдэлж, -үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэж (УИХ, 2020) хэмээн зааснаас харж болохоор байгаа юм. 1992 оны Үндсэн Хуулиас ялгаатай байгаа зүйл нь үндэсний үнэт зүйлс гэх ойлголтыг шууд ашигласанд оршиж байна.

Монгол Улсын энэхүү бодлогын баримт бичигтэй төстэй санааг Казакстан-2050 буюу Казакстан Улсын 2050 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрт “Мэңгiлiк ел” буюу “Мөнхийн улс” хэмээх ойлголтыг гол баганаа болгон гаргаж ирсэн ба энэхүү ойлголтын хамгийн үнэт зүйл нь тусгаар тогтнол хэмээн тодорхойлсон байна (*Казакстан 2050*, 2012). Энэхүү “Мэңгiлiк ел” гэх ойлголтоор Казакстан Улсын үндэсний үнэт зүйлсийг тунхаглан зарласан ба дээр дурдсанчлан хамгийн чухал үнэт зүйл нь тусгаар тогтнол бол энх тайван, эв нэгдэл, нийгмийн эв эе хоёрт, үнэт зүйл, гуравт, иргэнлэг, өндөр оюунлаг нийгэм, дөрөвт, аж үйлдвэржилт, шинэчлэлийн үндсэн дээр эдийн засгийн өсөлтийг хангах, тавд, бүх нийтээр ажил хөдөлмөр эрхлэх нийгэм, зургаад, түүх, соёл, хэлний нэгдэл, долоод, үндэсний аюулгүй байдал, дэлхийн болон бүс нутгийн асуудлыг шийдвэрлэхэд оролцох Казакстан Улсын оролцоог үндэснийхээ үнэт хэмээн зарласан байна.

ЮНЕСКО-ийн “Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхүүлэн дэмжих тухай конвенц”-ийг тус байгууллагын 2005 оны 10 дугаар сард Парис хотод болсон 33-р хурлаар соёрхон баталсан билээ. Тус конвенцийг батлахдаа соёлын үнэт зүйлсийн талаар дурдсан байдаг ба ...Соёлын олон төрөл нь сонголтын хүрээг өргөжүүлж, хүн төрөлхтний чадавх, үнэт зүйлсийг тэтгэн хөгжүүлэх олон талт баялаг

ертөнцийг цогцлоож, ингэснээрээ нийгмийн бүлэг, ард түмэн, үндэстнүүдийн тогтвортой хөгжлийн гол хөдөлгөгч хүч гэдгийг ухамсарлан...; ...Соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь өвөрмөц хэв шинж, үнэт зүйлс, утга агуулгыг илэрхийлдгийн хувьд эдийн засгийн хийгээд соёлын аль алиных нь шинжийг агуулдаг учраас тэдгээрийг зөвхөн арилжааны үнэ цэнтэй зүйлс төдий ойлгож болохгүй гэдэгт итгэн... (ЮНЕСКО, 2005) 2005 оны 10-р сарын 20-ны өдөр энэхүү конвенцийг батлав хэмээн заасан байдаг. Үүнээс харвал Дэлхийн боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагаас үнэт зүйлсийг тухайн улс, үндэстний хөгжлийн гол хөдөлгөгч хүч мөн боловч зөвхөн эдийн засгийн хүрээнд арилжаа, соёлын бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ашиглах төдий зүйлс хэмээн ойлгож болохгүй, үнэ цэн бүхий зүйлсийг илэрхийлж байгаа юм.

Монгол улсын хэмжээнд хийсэн үнэт зүйлсийн судалгаа

Монголчуудын үнэт зүйлсийн талаарх судалгааг 2009 оноос 2011 оны хооронд НСИСОУХ-ээс “Нүүдэлчдийн соёл: Үнэт зүйлс, Хөгжлийн чиг хандалга” нэртэйгээр хийж байжээ. Тус судалгаагаар орчин үеийн Монгол Улсын нийгэм, соёлд өрнөж байгаа суурин соёл хийгээд уламжлалт нүүдлийн соёлын харилцан холилдож байгаа үйл явцын өнгөрсөн болон эдүгээг танин мэдэж, цаашлаад нүүдэлчин монголчуудын ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг таамаглах ажлыг хийсэн байна. Чингэхдээ Монголын соёлыг үүсэл гарлын хувьд харилцан адилгүй ч хоорондоо харилцан нягт шүтэлцсэн үндсэн 4 соёл нэгэн систем болон бүрдүүлж байна хэмээн үзсэн байна. Үүнээс гадна орчин үеийн Монголын соёлыг “нүүдэлчдийн сонгодог” хийгээд ба “суурин соёл” хэмээн ерөнхийд нь 2 хэсэгт хуваан авч үзэж, энэхүү 2 соёлын түүх, уламжлал хийгээд эдүгээ болон ирээдүйд хэрхэн сүлэлдэж орших талаар авч үзсэн байна (Энхтүвшин, 2011). Гэвч энэхүү судалгааг хийсэн арга зүй нь хаана ямар газар хийсэн, ямар материал ашигласан зэрэг нь тодорхойгүйн дээр онолын үндэслэл хангалтгүй байсан юм.

Монгол Улсын хэмжээнд үндэсний үнэт зүйлсийн талаар хийсэн судалгаа хэд хэд бий бөгөөд Монгол Улсын Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуулиас (СЭЗДС) 2015 онд хийж хэрэгжүүлсэн байдаг. Энэхүү судалгааг социологич Geert Hofstede-ийн Value survey module 2013 Hofstede гэх аргачлалаар хийсэн бөгөөд үүндээ нийт 4214 хүний түүвэрлэлт дээр үндэслэн монголчууд нь гэр бүлийн хүрээнд хамтач боловч ажлын талбарт илүү бие даасан шинжтэй бол, маскулин байдал феминин байдлаас илүү давамгайл, урт хугацааны хандлага бага, тодорхойгүй зүйлээс зугтах түвшин бага, эрх мэдлийн ялгаа заагийг хүлээн зөвшөөрөх хандлага ялимгүй өндөр, баригдмалаас илүү чөлөөт нь илүү давамгайлсан гэсэн дүгнэлтэд хүрчээ (Түвшинзаяа нар., 2015) Энэ судалгаа нь монголчуудын аливаа зүйлд хандах хандлагыг гаргаж ирж байгаа боловч монголчуудын хэм хэмжээ, ёс суртахууныг тогтоож өгөөд буй соёлын талаас авч үзээгүй байна.

2017 онд Удирдлагын академиас Шварцын аргачлалаар 797 хүнийг санамсаргүй байдлаар түүвэрлэн өнөөгийн монголчуудын үнэт зүйлсийн төлөв байдлыг тодорхойлох судалгааг хийсэн байна. Уг судалгаагаар нэгд, Монгол хүний чин шударга зан, чин үнэнч нөхөрлөл, үнэнч шударга байдал, хариуцлагатай байдал, хайр халамж, уучлах сэтгэл, тусч байдал, оюун санаа, уужуу ухааныг эрхэмлэдэг (Collectivist); хоёрт, эрх мэдэл-

амжилт, нийгмийн байр суурь, удирдах эрх мэдэл, нөлөөтэй байх, нийгэмд танигдсан байдал, эд баялаг, амжилттай байдал, нэр хүндээ хамгаалах, ухаалаг байдал, чадвар чадавх гэсэн хувь хүний байр суурийг бэхжүүлэх гэсэн үнэт зүйлсийг эрхэмлэж; гуравт, аюулгүй байх-эрүүл мэнд, нийгмийн дэг журам, гэр бүлийн амар жимэр байдал, холбоо хамаарлаа мэдэх, харилцаа холбоо, үндэсний аюулгүй байдал, цэвэрч нямбай байдал, универсализм-нийгмийн шударга ёс, энх тайван, байгаль орчноо хамгаалах, эрх тэгш байдлыг эрхэмлэдэг хэмээн тодорхойлсон байна (Хэрлэн нар., 2017).

Хамгийн сүүлд Соёл Урлагийн Их Сургуулиас (СУИС) 2019 онд тоон судалгааны арга зүй дээр тулгуурласан судалгааг хийжээ. Гэхдээ энэ судалгаа нь зөвхөн тоон судалгаагаар хязгаарлагдалгүй зарим тохиолдолд чанарын судалгааны зарим нэгэн арга зүйг авч ашигласан байна. Чанарын судалгааг ихэвчлэн соёл, урлагийн чиглэлийн мэргэжилтэн хүмүүсээс ярилцлага хийх байдлаар ашиглажээ. Харин ерөнхий судалгааг тоон арга зүй дээр тулгуурлан, анкет, асуумжийн аргаар хийж, нэг фокус бүлэгт бүрэн бүтэцлэгдсэн ярилцлагын аргаар судалгаа авсан байна. Судалгааны үр дүнд монголчуудын үнэт зүйлийг:

1. *Ёс суртахууны үнэт зүйл* – Шударга ёс, хариуцлага, хүнлэг ёс, эх оронч үзэл, сайн үйл, нинжин сэтгэл, нэр төр, хамтач, нийтэч чанар, аз жаргал, үнэнч нөхөр;
2. *Эдийн засгийн үнэт зүйл* – Эрүүл байх, цаг ашиглалт, бүтээлч хөдөлмөр, мэдлэг боловсрол, цалин хангамж, арвигч хямгаач зан, хуримтлал, эд хөрөнгө өвлөх;
3. *Шашны үнэт зүйл* – Сургаал номлол, бурхан шүтээн, итгэл бишрэл, ертөнцийг үзэх үзэл, сүм хийд, үзэл онол, олон шашныг тэгш үзэх;
4. *Урлагийн үнэт зүйл* – Үндэсний язгуур урлаг (Морин хуур, уртын дуу, хөөмий, бий биелгээ);
5. *Соёлын үнэт зүйл* – Монгол хэл, Монгол хувцас, Монгол бичиг, Монгол гэр сууц, эрийн гурван наадам, мал маллах арга ухаан, аман зохиол, цагаан сар, судар ном, малын тоног хэрэгсэл, хуримлах ёс, тайлга тахилга;
6. *Улс төрийн үнэт зүйл* – Тусгаар тогтнол, Үндэсний язгуур эрх ашиг, төрөө дээдлэх ёс, ардчилал, эрх чөлөө, тэгш эрх хэмээн тодорхойлсон байна (Сонинтогос нар., 2019)

Энэхүү судалгаа нь монголчуудын үндэсний үнэт зүйлсийг тодорхойлсон боловч тэрхүү үнэт зүйлсийнхээ соёлын утга холбоог тайлбарлаагүй байгаа нь СЭЗДС-ийн хийсэн судалгаатай адил байгаа юм. Энэ нь социологийн судалгааны арга зүйтэй шууд холбоотой юм. Тодорхой бэлэн судалгааны асуумжийг судалгаанд оролцогчдоос сонголт хийлгэж байгаа нь судалгааны үр дүнд нөлөөлж буй бөгөөд түүндээ судалгаанд оролцогч ямар учраас энэхүү сонголт хийсэн болохыг тайлбарлах боломж өгөөгүй байгаа юм. Харин ч эсрэгээрээ судалгаанд оролцогчдын хийсэн сонголтуудыг судалгаа хийж буй судлаач өөрөө тайлбарлах юмуу хэн нэгэн өөр судлаачаар тайлбарлуулж байгаа бөгөөд энэ нь тус судалгааны үр дүнд субъектив хандлага орсон байхыг үгүйсгэх аргагүй юм.

Улмаар СУИС-аас хийсэн энэхүү судалгааны дүнд монголчуудын 9 үнэт зүйлсийг тодорхойлж 2019 онд Х.Баттулга Ерөнхийлөгчийн зарлигаар *Эрдэнийн судар*

хэмээх судрыг бүтээн Төрийн ордонд ёслол төгөлдөр залсан юм (Монгол Улсын Ерөнхийлөгч, 2020).

Судалгааны зорилго ба зорилт

Бидний энэхүү судалгааны зорилго нь юуны түрүүнд Монгол Улс ба Дотоод Азийн соёл, оюун санааны нэгдсэн үнэт зүйлсийг судлан гаргаж ирэх ба түүнийгээ Дотоод Азийн бүс нутгийн бусад улс орнуудын үнэт зүйлстэй харьцуулан антропологийн өнцгөөс судлах юм. Тиймээс бид энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлээд байна.

Зорилт 1: Монголын үнэт зүйлсийг хээрийн үр дүн дээр тулгуурлан тодорхойлох;

Зорилт 2: Дотоод Азийн бусад улсуудын үнэт зүйлсийн талаар хэрэгжүүлж буй төрийн бодлого хийгээд гэр бүл, хувь хүний түвшинд хэрхэн үнэт зүйлсээ тодорхойлж буйг танин мэдэх;

Судалгааны ач холбогдол

Онолын талаас

Тус судалгааны хувьд хоёр талын онолын ач холбогдол байна гэж хэлж болох юм. Үүнд нь:

1. Тус судалгаа нь нүүдлийн гэгдэх практиктай нийгэм-соёлууд дахь “үнэт зүйл”-ийг судлахаар дамжуулан эдгээр нийгэм-соёлд “төр” гэх ойлголт хэрхэн бүтээгдэж байдгийг судалж, хүн судлал дахь “төр”-ийн тухай тайлбарыг хөгжүүлнэ.
2. Тус судалгаа нь өмнөх энэ чиглэлийн хүн судлалын судалгаа, тэр тусмаа монголын дотоодын эрдэм шинжилгээнд огт хийгдээгүй нэг өнцөг болох “үнэт зүйл” гэх мэт ийм олон талт ойлголтыг хүн судлал хэрхэн судалж болох талаарх арга зүйг мөн хөгжүүлнэ.

Практик талаас

Тус судалгааны практик ач холбогдолын тухайд бид тус судалгааг хийснээр улс төрийн талбарт, магадгүй бүс нутгийн нэгэн соёлт үндэстний нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэхэд зөвлөмж болох давуу тал байна гэж хэлж болох юм.

Судалгааны асуудал ба нэр томьёо

Судалгааны асуудлууд

Тус судалгааны хүрээнд бид антропологийн судалгааны арга зүйгээр Монгол улс, Өвөр Монгол, Буриад, Казакстан, Киргизстаны нийгэм –соёл дахь "үнэт зүйл" гэх ойлголт хэрхэн "төр"-ийг бүтээж байгаа тухай судлах юм. Ингэхийн тулд бид дараах гурван гол асуудлуудыг дэвшүүлж, түүний дагуу судалж байгаа бөгөөд эдгээрт нь:

Эдгээр нийгэм-соёлуудын дотоод улс төрийн орон зайд “үнэт зүйл” гэх энэхүү ойлголтыг нийгэм, соёлын олон талбарт, тэр дундаа “government” буюу “засгийн газар”

гэх талбарт хэрхэн төрийн бодлого болгож байдаг, тэр нь бусад улс, үндэстэн, нийгэм соёлоос ямар онцлогтой байгаа;

Эдгээр нийгэм-соёлуудын дотоод гэр бүл, хувь хүн гэх мэт талбарт “үнэт зүйл” гэх энэхүү ойлголтыг хэрхэн ойлгож, үүгээрээ хэрхэн өөрсдийн орон зайгаа бүтээж байдаг эсэх;

Мөн ийнхүү олон талбарт хэрэглэгдэж, тайлбарлагдаж байдаг “үнэт зүйл” гэх ойлголт хоорондоо төсөөтэй, нэгдмэл зүйл байгаа эсэх зэрэг асуудалд хариулахаар дамжиж тус судалгааг гүйцэтгэх юм.

Ойлголтын тодорхойлолтууд:

Үнэт зүйл (Value)

“Value” буюу “үнэт зүйл”, “үнэлэмж” хэмээх ойлголт маш өргөн утгатай бөгөөд үүнийг өрнөдийн философид эртнээс авч үзсэн байдаг хэдий боловч (Баатартогтох, 2000) XIX зуунаас л тусгайлчлан “үнэлэмж”-ийн тухай судалж эхэлсэн байдаг. (Соёлмаа, 2020; Гомбосүрэн, 2008). Харин философийн ухаанаас гадна XX зуунаас эхлэн эдийн засаг, сэтгэл судлал, социологи, антропологийн салбарт нэлээд сонирхон судалсан байна. Эдгээр салбаруудын судалгааны арга зүй, чиг баримжаанаас хамаарч тухайн “value”-г янз бүрийн өнцгөөс, янз бүрийн утгаар авч үзсэн байдаг. Тэр олон дотроос бидний энэхүү судалгаатай хамгийн их холбоотой нь “cultural value” буюу “соёлын үнэт зүйл” эсвэл “соёлын эрхэм зүйл” бөгөөд энэ талаар голчлон авч үзэх тул онолын чиг баримжааны талаар түлхүү авч үзлээ.

Германы сэтгэгч, социологич, философич Макс Вебер (Max Weber) шашин болон хувь хүний сонирхолд суурилсан сэдэл (motive) хоёрын ялгаатай байдалд суурилан үнэт зүйлийг судалсан байдаг (Max Weber, 1958). Тэрээр үнэт зүйлийн бүтцийг нэг талаас хувь хүний, нөгөө талаас нийгэмд хэдийнээ тогтож заншсан заншил гэх хоёр түвшинтэй хэмээн үзэж энэ хоёр нь хоорондоо хэрхэн, ямархуу харьцаатай байдаг талаар голчлон анхаарчээ. Харин Америкийн соёлын антропологич Клайд Клүкхон (Clyde Kluckhohn) энэхүү санааг цааш нарийн судлан үзэж, соёлын талын гэх үнэт зүйлийг улам гүнзгийрүүлэн судалсан байна. Улмаар энэхүү соёлын үнэт зүйлс нь тухайн соёлын бусдаас ялгарах ялгамжаатай шинж чанарыг илэрхийлж байдаг хэмээн үзжээ (Clyde Kluckhohn, 1951). Үүнээс гадна тухайн цаг үед Америкийн Харвардын их сургуулийн социологич Талкотт Парсонс (Talcott Parsons) мөн Веберийн судалгааг гүнзгийрүүлж, соёлын систем, нийгмийн үнэт зүйлс нь хүний ёс суртахууны (morality) дотоод мөн чанар болж, цаашлаад хүний зан харилцааг тодорхойлдог, чиглүүлдэг хүчин болдог хэмээн үзсэн байна (Talcott Parsons, 1964). Америкийн сэтгэл судлаач Гордон Олпорын (Gordon Allport) судалгаа хүний зан чанар болон хувь хүний төлөвшилд үнэт зүйлс нь хамгийн чухал зүйл болдгийг харуулсан судалгаа хийж, улмаар ямарваа нэгэн бүлэг хүмүүсийн үнэт зүйл хэмээн үзэж буй тэрхүү зүйлээс хамаарч тухайн бүлэг хүмүүсийн бусдаас ялгарах өвөрмөц шинж чанар бүрэлддэг гэж тодорхойлсон байна (Allport 1960). XX зууны дунд үеэс дээрх судалгаануудыг дараа үеийн судлаач нар ихээхэн шүүмжилж эхэлсэн байна. Үүний нэгэн томоохон төлөөлөгч бол Америкийн антропологич Рое Д’Андрейд (Roy D’Andrade) юм. Тэрээр К. Клүкхоны соёлын үнэт зүйлийг авч үзэж

буйг хэтэрхий бүдүүвчилсэн (ерөнхий), нийгмийн системийн цөөн хэдэн зүйлсийг л тусгасан хэмээн тодорхойлсон байна. Тухайлбал; улс төр, шашин, ураг төрөл, эдийн засгийн системийн хүрээнд л авч үзээд түүгээрээ тухайн соёлын нийгмийн онцлогийг бүрэн тодорхойлсон нь хэт ерөнхий хэмээн шүүмжилсэн байна. Харин тэрээр өөрөө соёлын үнэт зүйлсэд тодорхой тоон хязгаар огт байх боломжгүй ба аливаа соёл хэдхэн тооны бүтэц загвараар онцлогийг нь бүрэн илэрхийлчихдэг тийм хялбар зүйл биш хэдэн зуу, мянган бүтэц тогтолцоотой байдаг гэх санааг гаргасан байна (DAndrade, 2008). Улмаар Р. Д'Андрейд дээр дурдсан үнэт зүйлсийг ангилах, төрөл зүйлчлэн зохион байгуулах ажлыг хэрхэн зөв зохистой хийж болох талаар өөрийн саналыг дэвшүүлсэн байдаг. Ингэхийн тулд тэрээр эхлээд value буюу үнэт зүйлийн хэдэн янзын агуулгыг жагсааж8 улмаар өөрийн тодорхойлолтыг дэвшүүлжээ. Түүний үзэхээр хэлний value гэдэг түүний ухагдахуун дараах таван янзын агуулга байна.

1. Олон талт чанар болон хэмжээ (the amount or quality of some variable);
2. Ямар нэгэн зүйлийг чухалчлах юм уу хэрэгтэй гэх (the preference for or utility of something);
3. Ямар нэгэн зүйлийн үнэ өртөг (the price of something);
4. Чухал зүйлийн сайн сайхан нь (the goodness of something important);
5. Ямар нэгэн зүйлийн ёс суртахууны хувьд зөв байх хэм хэмжээ (the degree to which something is morally right) (DAndrade, 2008:11).

Ингээд тэрээр англи хэлний “value” гэдгийг “ямар нэгэн чухал зүйлийн сайн сайхан шинж чанар” (the goodness attributed to something important) гэж тодорхойлсон. Харин түүнийг ангилан төрөл зүйлчлэх асуудалд хандан үнэт зүйл гэдэг бол шалгуур хэмжүүрийг бий болгодог8 хоорондоо дотоод харилцаа холбоо бүхий үнэт зүйлсээс бүрдсэн тогтолцоо бөгөөд нийгэмд хүлээгдэж байдаг гэж тайлбарлаад ийнхүү зохион байгуулагдсан үнэт зүйлийн загварыг “value orientation” буюу “үнэт зүйлийн чиг хандлага” гэж нэрлэжээ. Ингээд жишээ болгон түгээмэл байдаг үнэт зүйлийн чиг хандлагуудыг нэрлэсэн байна. Жишээ нь; либерал, консерватив, индивидуалистик, хамтач, харилцаа хамаарлын, нийгэм төвтэй, бусад дээр төвлөрсөн, энэ ертөнцийн, өөр ертөнцийн, бурхан шашинд хандсан, уламжлалт, орчин үеийн, постмодерн гэх мэт. Товчоор ерөнхийлөн хэлбэл, капиталист, социалист, ардчилсан, авторитар гэхчлэн нийгмийн байгууллын институтээр нь үнэт зүйлийг нь бас ялгаж болно. Ингэж ангилан ялгах, төрөл зүйл болгох арга хэлбэрээр тэрээр хүний танин мэдэхүй дээр суурилсан бүтэц зохион байгуулалт гэж тайлбарласан байна.

Хувь хүн (individual)

Хувь хүн гэдэг бол өнөөгийн нийгмийн шинжлэх ухааны түгээмэл тайлбараар дэлхийн ямар нэгэн нийгэм-соёлд тодорхой биет байдлаар оршин тогтнож буй хүн юм. Хувь хүн нь хувь хүний төлөв байдал эсвэл чанартай гэж болох бөгөөд бусдаас онцгой, өөрийн хэрэгцээ, зорилго, эрх, үүрэг хариуцлагатай хүн гэгддэг. Биологи, эрх зүй, философи, шашин гэх мэт олон салбарт хувь хүний онцлог шинж чанаруудын тухай ойлголтыг дурддаг.

Гэр бүл (family)

Гэр бүл бол ураг төрлийн бүлгийн нэг юм. Антропологич James Watson “Kinship Organization in Late Imperial China 1000-1940”-дээ: “гэр бүл” бол улсын доторх нэгдэл, үйлдвэрлэл, хэрэглээ болон улс төрийн эрх мэдлийн үндсэн нэгж болж байдаг. Түүний гишүүн нь өдөр тутмын амьдрал дунд хамт байх бөгөөд мөн өдөр тутмын амьдрал дундаа орлого, зарлагыг хамтаар хуваалцаж байдаг”(Patrica Buckley Ebrey & James L.Watson, 1986: 4-5) гэсэн байсан.

Төр (state)

“Төр” бол улс төрийн тогтолцооны дундах хамгийн сонгодог хэлбэр, эсвэл соёл юм. Төр нь нийгмийг бодитой болгож байгаа зүйл байдаг. Тиймээс төр болон нийгмийг салгах аргагүй. Төр болон нийгмийн байгууллын ажил нь баялгийн нэгтгэл болон хуваарилалтын ажил байдаг. Үүнээс гадна төр бол олон төрлийн хүчний талбарын хооронд харилцан нөхвөрлөлцөх шинжтэй харилцаан дээр байгуулагдаж байдаг практик юм. Энэ нь нэг төрлийн ажил хийх болон ямар нэгэн сэтгэлгээний хэлбэр гэж болно. Түүнчлэн мөн нэг төрлийн засаглалын харилцаа юм. Өөрөөр хэлбэл, төр бол объект хэлбэрээр ирж, амьдралыг удирддаг, өөрийн хүчийг байгуулдаг.

Судалгааны онолын өнцөг

Тус судалгааны ажил нь “үнэт зүйл”-ийг судлахаар дамжуулан Монгол болон бүс нутгийн нүүдлийн соёлт нийгэм, соёлууд дахь ‘төр’ гэх ойлголт өрнө дахины нийгэм дэх ‘state’ гэх ойлголтоос ямар ялгаа зөрөөтэй болох, тухайн ‘төр’ нь нүүдэлчдийн нийгэм, соёлд хэрхэн бүтээгддэг тухай судлах юм. Судлаачийн бодлоор энэ хоёр ойлголтын хоорондох ялгаа зөрөө бол бидний уг ажлын турш гол болгон судалж буй эдгээр нийгмүүд, ялангуяа тэдний доторх гэр бүл болон хувь хүний талбарт яригдаж байгаа олон зүйлийн “үнэт зүйл” гэх ойлголт дээр оршдог магадгүй гэж үзэж байгаа юм. Ямар учраас тэр вэ? Энэ асуулт бол тус судалгааны ажлын нэг гол хариулах асуулт юм. Гэвч энэ асуултыг авч үзэхээс өмнө бид тус хэсэгт Евро-Америкийн нийгмүүдэд байх ‘state’-ын тухай нийгмийн шинжлэх ухааны гол гол онолуудыг судлах болно. Холбогдох нийгмийн шинжлэх ухааны онолууд дотор “state”-тэй холбоотой онолууд маш их. Хэдийгээр эрдэмтдийн судалж буй газар орон, объект нь өөр боловч бүгд л энэ ойлголт эсвэл коллективизмын тухай л анхаарч байдаг. Өөрөөр хэлбэл, эрдэмтэд юу судалдаг байлаа ч хамгийн сүүлд нь бүгд л төр эсвэл хамтын болох ойлголтын тухай л анхаардаг гэсэн үг. Тиймээс бид энд нийгмийн шинжлэх ухааны хамгийн нөлөө бүхий эрдэмтдийн төлөөлөх шинжтэй энэ талын онолуудыг дор хэсэгт тоймлон авч үзье.

Бид эхлээд Маркс, Марксистууд “state” эсвэл “state бүтээгдэх үйл явц” хэрхэн өрнөж байдгийг яаж харж, тайлбарлаж байсныг товчоор авч хэлбэл, Марксизм нь ‘state’ болон түүний илрэх “нийгмийн орон зай”-г “нэг талт ноёллын харилцаа” (one-dimensional space) гэж үзэж байсан. Өөрөөр хэлбэл, нийгмийн олон талбаруудын хоорондох эсрэгцсэн, нэг нь нөгөөгөө ноёлсон харилцаагаар бий болдог гэж үзэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, Марксийн болон Марксизмын тайлбараар “төр” бол талбаруудын хооронд оршдог. Гэвч “төрийг байгуулах” гэдэг нь талбар хоорондын мөлжсөн дарласан харилцаагаар дамждаг гэсэн үг. Мөн түүнчлэн талбар тэгш биш харилцаан дээр

байгуулагддаг гэж ойлгож болохоор байдаг. Тухайлбал, Маркс “Капитализм” дотроо төрийн бүтээгдэх үйл явц нь эдийн засгийн хүчээр дамждаг бөгөөд түүний хэлж байгаа эдийн засгийн хүч нь “Хүчирхийллийн мөн чанартай. Хүчирхийлэл бүр нь хуучин нийгмийг унагаах хүчирхийллийн харилцаан дээр төрж байдаг” (Karl Marx, 1987) гэх мэтээр өгүүлсэн байна. Үүнээс гадна онцолж хэлэх ёстой нэг зүйл бол Маркс, Энгельс, Ленин нар төрийг хоёр янзаар оршин буйг ярьсан байдаг. Тэдгээр нь нэгд, “хоосон”, хоёрт, “нийгмийн бүлгүүд дээр оршин буй” гэсэн байгаа юм. Хоёрдугаар тайлбараар бол “төр” нь бодитой оршин буй мэт. Харин нэгдүгээр тайлбараар бол “оршихгүй”, “хийсвэр” зүйл мэтээр ойлгогдож байгаа юм.

Макс Веберийн тухайд “Эдийн засаг ба нийгэм” номын дунд “нэгэн ноёрхогч бүлэг”-ийн орших хийгээд түүний дэглэм нь хэрвээ түүний захиргааны банз нь нэгэн тусгай тогтсон нутаг орны хил хязгаарын дотор физикийн хүчний сүрдүүлэлт болон хэрэглээгээр тасралтгүй хамгаалагдаж байвал түүний “улс төрийн бүлэг” гэдэг. Нэгэн улс төрийн системийн шинжтэй бүлэг улс төрийн физик хүчээр хүчирхийлэл үйлдэж, дэглэм тогтоож буй бол түүнийг “төр” гэнэ. Тэрчлэн нэгэн төрлийн үйлдэл, онцгойлон бүлгийн үйлдэл хэрвээ хүчирхийллийн үе шатны бус улс төрийн бүлгийн ноёрхолд ялангуяа улс төрийн хүчийг хэрэглэн, мөлжиж, хуваарилж, нөлөөлж байгаа үед үүнийг “улс төрийн дарангуйлал” (Max Weber, 2019:186) гэдэг. Өөрөөр хэлбэл, Веберийнхээр “төр” бол хууль ёсны дарангуйлал. Түүнийхээр төр нь цэргийн, цагдаагийн хэлбэрийн физик хөрөнгөөс гадна эдийн засгийн хөрөнгийн хуваарилалт болон нэгтгэл дээр оршиж байдаг. Хөрөнгийн тухайд тэр “Эдийн засаг ба нийгэм” бүтээлдээ “бидний хэлж буй “төр”-ийн хууль, дариу төрийг хамгаалах хууль нь зөвхөн улс төрийн хамтын тусгай нэгдэлд байгаад үл барам түүнчлэн шууд зэвсгийн хүчээр үйл ажиллагаа явуулдаг” (Max Weber, 2019:527) гэжээ. Эдийн засгийн хөрөнгийн тухай ойлголтын хувьд авч үзвэл “төр” эдийн засгийн хөдөлгөөнд оролцох оролцоо тийм ч бага биш. Гэвч хэрвээ нэгэн төрлийн хуулийн дэглэм, эдийн засгийн тогтолцоо, ялангуяа орчин үеийн хэлбэрийн эдийн засгийн тогтолцоо оршиж чадахгүй. Энэ төрлийн хуулийн дэглэмийн бие даасан тусгай онцлог нь олон нийтийн хуулийн дэглэмийн тогтолцооноос гадна хөгжилд хүрэхгүй” (Max Weber, 2019: 554) гэх мэтээр өгүүлсэн байдаг. Түүний тайлбарын дагуу эдийн засгийн хөрөнгө бол физик хүчинд баялгийг нийлүүлж байдаг. Мөн Эмил Дуркхаймын тухайд “Шашны амьдралын эгэл хэлбэрүүд” “The Elementary forms of the religious life” бүтээлдээ “ёс суртахууны дасан зохицол” ба “логик дасан зохицол” гэх хоёр ангиллыг хийсэн байдаг. Түүний бүтээлийн агуулгаас харахад “төр” бол нийгэм дэх энэ хоёр дасан зохицлын үндэс мэт байдаг (Emile Durkheim, 2001). Үндсэндээ түүнийхээр “логик дасан зохицол” нь бодит байдлыг багтаагаад нийгмийн үйлдэгчтэй бодитой төсөөтэй танин мэдэх логиктой, адил төсөөтэй хэлбэр, сэтгэл хөдлөлийн болон байгууллын бодитой хүмүүс хооронд шууд хэлцлийн хэвтэй байна. Харин ёс суртахууны дасан зохицлын хувьд үнэлэмжийн ойлголт дээр оршдог. Өөрөөр хэлбэл, түүнийхээр “Төр бол захирах ёс суртахууны ухаан” (Emile Durkheim, 1997:79) юм гэжээ.

Английн хамгийн эртний антропологичийн нэг Радклифф-Брауны хувьд “төр”-ийг “хийсвэр”, “хийсвэр шинжтэй” гэж үзэж байсан. Тэр бээр “төр” оршдоггүй, зөвхөн ард түмэн, улсын ван, ерөнхийлөгч, дарга, цагдаа болон удирдагч гэх мэт байдаг гэж үзэж байв. Леви-Строссын хувьд “төр”-ийн тухайд ярьсан зүйл бага боловч түүний

бүтээлүүдийн агуулгаас нийгэм-төрийн бүтцийн тухайд тусгайлан судалсан. Тэр “Бүтцийн антропологи” бүтээлдээ “харилцан хоорондоо холбоотой хүн болон бүлгийн нэгдэл” (Claude Levi-Strauss, 2006:271) гэж “төр”-ийг тайлбарласан. “Нийгэм” хэмээгдэгч “адилгүй бүс нутаг, орны адилгүй бүтцийн харилцан нөхвөрлөлцсөн бүрдэл” (Claude Levi-Strauss, 2006:271) дээр оршдог гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Леви-Строссын хэлж буйгаар “төр” эсвэл “нийгэм” бол бүтцийн шинжтэй зүйл. Харин Фукогийн тухайд “Аюулгүй байдал, нутаг дэвсгэр, хүн ам”-даа “Төр бол огт түүхэн хүйтэн зэвсэг биш. Үргэлж л хөгжиж, өөрчлөгдөж, сайжирч байдаг. Иргэний нийгмийг сүрдүүлж буй мэт механик зүйл. Иргэний нийгэм, эсвэл товчоор хэлбэл 16-р зуунаас эхлэн нийгмийг засагласан бөгөөд хязгаар тогтоож, хянах ийм нэг тогтолцоог төр гэдэг. Төр бол зөвхөн “засаглалын хөндлөн хэлбэрийн зүйл” (Michel Foucault, 2018: 325) гэх мэтээр тодорхойлсон байна. Түүний өмнөх үеийн эрдэмтдээс ялгаатай нь “төр”-ийг хөндлөн зүйл гэсэнд юм. Тэгвэл “төр”-ийн тухай хамгийн гүн гүнзгий судалсан эрдэмтэн бол Францын эрдэмтэн Пиерре Бурдиео билээ. Тэрбээр энэ сэдэвтэй холбоотой онол болон ойлголтын хамгийн гол нэгтгэлийг “Төрийн тухай”-даа өгүүлсэн байдаг. Түүний энэхүү бүтээл 2012 онд Францад хэвлэгдсэн. Тус бүтээлийг түүний бүхий л амьдралын турших судалгааны гол үр дүн гэж хэлж болохоор байдаг. 2002 онд түүнийг нас барсны дараа түүний гэр бүлийхэн болон хамтран ажиллагсад нь түүний 1989-1992 онд Франц коллежид уншсан түүний төрийн тухай цуврал лекцийн эмхтгэлийг гаргасан юм. Тиймээс энэ ном бол түүний судалгааны бүрэн түүвэр шинжтэй бөгөөд тус номын агуулгаас харахад түүний бүхий л судалгаа хамгийн эцэстээ төр хэрхэн бүтээгддэг үйл явцын тухай байжээ гэмээр байдаг. Тус бүтээлийн агуулга, эсвэл түүний ярьсан байдлаас харахад нийтдээ гурван гол асуудлыг дэвшүүлсэн байдаг нь: Нэгд, “төр” гэж юу вэ, хоёрт, төрийн уламжлал гэж юу вэ, гуравт, төр хэрхэн бүтээгддэг вэ гэх мэт юм. Тэрбээр төр бол нэгэн төрлийн хүчний талбарын сектор гэсэн. Түүнийхээр төр нь зарчмын хувьд нууцлагдмал, хэлбэргүй шинжтэй. Тиймээс цаг хугацааны эсвэл орон зайн шинжтэй бүтцээр илэрч байдаг. Төрийн категорын хувьд авч хэлбэл нийгмийн амьдралын хамгийн түгээмэл үйл ажиллагааны нэг нь категори хийх, бурханшуулах, канончлах гэх мэт. Үнэндээ төр бол огт оршдоггүй. Гэвч ард түмэн сэтгэлдээ түүнийг маш гүн батаар оршиж байна гэж боддог. Энэ бол түүнийг оршихын хамгийн сайн хэлбэр нь болдог. Үнэндээ төр бол блок биш. Нэгэн төрлийн талбар хоорондын зүйл бөгөөд орон зайн шинжтэй. Тоглоомын шинжтэй хүчний талбар. Түүнчлэн тэрбээр төр нь үндсэндээ түгээмэл монополын бүрдлийн салшгүй хэсэг. Соёл бол үлгэр загвар юм. Төрийн гарал үүслийг олох гэдэг бол аливаа нэг орон нутгийг бүтээх үйл явц байдаг. Түүнчлэн түгээмэл байдлыг бүтээх үйл явц байдаг. Энэ болоод бодит байдал дээрх монополийн монопол байдлыг бүтээх юм. Энэ бол түүний 1989-1990 оны хоорондох лекцийн гол агуулга юм. Өөрөөр хэлбэл, тэрээр энэ улирлын яриандаа төрийг фетишизмийн шинжтэй зүйл бөгөөд хууль, утга зохиол, түүх, эдийн засгийн байгууллага болох банк, сургууль гэх мэт олон төрлийн агентаар дамжин өөрийгөө бүтээж байдаг. Түүний үйл ажиллагааны зарчим нь өмнө хэлсэнчлэн фетишичлэл, түгээмэл болох, захиргааны болох, стандартчлал, нэгтгэх, хамтрах зэрэг үйл явцын болон хандлагатай байдаг.

Тус бүтээлийн доторх бас нэг агуулга буюу хоёр дахь гол судалсан зүйл бол “төр”-ийн судалгааны уламжлалын тухай. Тэрбээр 1990-1991 оны цуврал лекцдээ

голчлон энэ тухай ярьсан байдаг. Тэрбээр уг ойлголтын тухай нийгмийн шинжлэх ухааны эрдэмтдийн судалгаануудыг эш татан тайлбарласан байна. Тэдгээрт нь Маркс, Вебер, Дуркхайм болон бүхий л антропологи, нийгэм судлалын эрдэмтэдээс гадна түүхчдийн судалгааг ч эш татжээ. Бурдеои, эдгээр судалгаануудын бүхий л агуулгыг ярьсаны дараагаар өөрөө “төр” гэдэг бол олон төрлийн хүчний талбаруудын дунд, тэдний харилцан нөхвөрлөлцсөн уялдаа бүхий харилцаан дээр илэрч буй тусгай үйлдэгчийн байр суурь гэсэн. Мөн энэ тусгай байр суурь нь хөрөнгийн тархалт болон нэгтгэлтээр тодорхойлогдоно. Бүхий л талбарууд нь өөрийн гэсэн онцлогтой бөгөөд засгийн газар, гэр бүл, шинжлэх ухаан гэх мэт тусгай онцлогоор илэрч байдаг. Тэд өөрийн логик, тусгай хөрөнгүүдээр илэрч байгуулагдаж байдаг. Гэвч бүх талбар нь ганцаар бие даасан юмгүй бөгөөд хөрөнгийн хуваарилалтаар дамжин өөр нэг биед мөн шилжиж байдаг.

Түүний ярьсан гуравдугаар гол асуудал бол яаж “төр”-ийг үйлдвэрлэх юм бэ, эсвэл яаж байгуулдаг юм бэ гэдэг асуудал. Тэрбээр үүндээ Веберийн судалгааг эш татсан байна. Бурдиео хэлэхдээ “төр бүтээгдэх” гэдэг бол нэгэн төрлийн нэгтгэлийн үйл явц байдаг. Тэдгээр нэгтгэгдэж буй хөрөнгө нь зөвхөн Веберийн хэлсэн шиг эдийн засгийн болон физикийн хүчнээс гадна бэлгэдлийн болон соёл ба мэдээллийн хөрөнгө байгааг нэмж дурдсан. Тэрбээр “төр” бол нийгмийн бодит болголтын бэлгэ тэмдэг бөгөөд олонхдоо янз бүрийн ёслолоор дамжин илэрч байдаг. Тиймээс энэ бол нэгэн “хамтын код” юм гэсэн. Энэхүү код нь мэдлэг болон солилцооны бүтцийн шинжтэй багажийн захирах үйл явц байдаг. Тиймээс л адилгүй төрлийн баялаг болон хөрөнгийн хуваарилалт, нэгтгэл дунд “төр” бүтээгддэг түгээмэл байдлын, монополийн үйл явцын бэлгэ тэмдэг юм.

Бидний үзэж байгаагаар түүний энэ тодорхойлолт нэлээд бүрэн дүүрэн шинжтэй боловч нэг асуудал байгаа нь энэ судалгааны тохиолдолууд нь дандаа Евро-Америкийн нийгмүүд байгаа юм. Иймээс тус судалгаагаар бид Нүүдлийн гэгдэх нийгэм-соёлууд дахь үүнтэй төсөөтэй ойлголт болох “төр”-өөр дамжин уг онолыг хөгжүүлэхийг зорьж байгаа юм. Гэхдээ бидний “төр”-ийг судлах гол багаж хэрэгсэл бол эдгээр нийгмүүдэд байгаа “үнэт зүйл” гэгдэх ойлголт юм.

Судалгааны арга зүй ба бэрхшээл

Бид нэгдүгээр бүлэг болох Монголчуудын үнэт зүйлсийн талаарх хэсгийг Монгол орны төвийн болон баруун аймгуудад зохион байгуулсан 4 удаагийн хээрийн судалгааныхаа үр дүнд бичсэн ба Архангай аймгийн Өндөр-Улаан суманд сарын хугацаанд антропологийн оролцон ажиглах арга зүй болон ярилцлагын аргуудыг хослуулан судалгаагаа хийж гүйцэтгэсэн бол, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Архангай, Завхан, Увс, Баян-Өлгий аймгуудад явуулын судалгааг нийт 11 суманд хийж гүйцэтгэсэн билээ. Тухайн үедээ ярилцлагын арга зүйг гол арга зүйгээ болгон ажилласан юм. Мөн Монгол ба Дотоод Азийн зарим улс орнуудын хууль тогтоомж зэргээс тухайн улс орнуудад үндэсний хэмжээний үнэт зүйлсийн талаар авч хэрэгжүүлж буй үнэт зүйлсийн бодлогын талаар баримт бичгийн судалгаа хийсэн. Харин гэр бүл болоод хувь хүний түвшинд үнэт зүйлсийг хэрхэн авч үзэж байгаа талаар бүс нутгийн хэмжээнд судалгаа хийхэд ихээхэн бэрхшээл үүсэж байв. Казакстан, Киргизстан, Буриад, Өвөр

Монголд хээрийн судалгаа хийгээгүй тул тэдгээр улс орны ард иргэд өөрсдийн үнэт зүйлсийг хэрхэн ойлгож тодорхойлж байгаа тухай нэгдүгээр эх сурвалжийн мэдээг цуглуулж чадаагүй билээ. Тиймээс гол төлөв дам эх сурвалж буюу энэхүү бүс нутгуудад хийсэн өмнөх судалгаанууд дээрээс үндэслэн тус тайлангийн 2, 3, 4-дүгээр бүлгүүдийг бичсэн болно.

Судалгааны бүтэц

Энэхүү судалгаа нь удиртгал, 4 бүлэг, дүгнэлт, хавсралт гэсэн хэсгээс бүрдэнэ. Удиртгал хэсэгт энэхүү судалгааг хийх болсон шалтгаан, сэдвийн судлагдсан байдал, онолын чиглэл, судалгаа хийсэн арга зүй болон бэрхшээлүүд, тус судалгааны ач холбогдол зэргийн талаар авч үзсэн болно. Харин нэгдүгээр бүлэгт Монгол улс дахь Монголчуудын болон засгийн газраас хэрэгжүүлж буй “үнэт зүйл”-тэй хамаатай бодлогын тухай авч үзэв. Харин хоёрдугаар бүлэгт мөн энэ асуудлыг Хятадын төрийн жишээгээр авч үзлээ. Гуравдугаар бүлэгт Буриад монголчуудын тохиолдлыг авч үзсэн бол, дөрөвдүгээр бүлэгт Казакстан, Киргизстан, Турк Улсын иргэд болон улс төрийн бодлого дунд хэрхэн “үнэт зүйл”-ийг тайлбарлаж буйг авч үзсэн болно.

Нэгдүгээр бүлэг: Монгол Улсын Монголчуудын үнэт зүйлс

Бид энэхүү бүлгийнхээ хүрээнд Монгол дахь “үнэт зүйлс”-ийн талаар судлах ба үүнийхээ нэгдүгээр хэсэгт Монгол Улсын төрийн зүгээс үнэт зүйлс болгон авч үзэж буй зүйлсийн талаар авч үзэх болно. Чингэхдээ 1990 оноос хойш ардчилсан, чөлөөт зах зээлийн тогтолцоо бүхий үндэстэн улсыг бүтээхдээ Монголын төрийн зүгээс ямар үнэт зүйлсийг эрхэмлэн авч үзэж байсан талаар авч үзэх болно. Харин дараагийн хэсэгт төрийн эсрэг буюу нийгэм, ард түмэн, гэр бүл, хувь хүмүүсийн хувьд ямар зүйлсийг эрхэмлэн дээдэлж, өөрсдийн үнэт зүйлс хэмээн авч үзэж байгаа талаар авч үзэх болно.

“Алсын хараа 2050” ба “Үнэт зүйлс”

Европын болоод АНУ зэрэг улс төр, эдийн засгийн хувьд хүчирхэг улс гүрнүүд дэлхий дахинд өөрсдийн ноёрхол, нөлөөг тогтоох, хадгалхаар гадаад бодлогоо хэрэгжүүлж байдаг. Үүний нэг томоохон жишээ бол зөөлөн хүчний бодлого (Soft power policy) юм. Америкийн улс төр судлаач Жозеф Ние Жунор (Joseph Nye Jr) зөөлөн хүчний бодлогыг хүч, дарамт шахалт ашиглалгүйгээр бусдад нөлөөлөх чадвар хэмээн үзэж, ингэхдээ улс орнууд өөрсдийн үнэт зүйл, үзэл баримтлал, соёлоо өөр бусад улс орнуудтай түншлэл, сайн сайхан харилцааг бий болгоход чиглүүлдэг хэмээн тодорхойлсон байна (World 101, n.d.). Ийнхүү өөрийн улс орны нөлөөг тогтоох нь тухайн орны эдийн засагт үлэмж хэмжээний нөлөөг үзүүлдэг билээ. Америкийн Нэгдсэн Улс л гэхэд Холливуд буюу кино зах зээлээрээ дамжуулан өөрсдийн соёл, тэр дундаа үнэт зүйлсээ их хэмжээгээр гадны орнууд руу экспортолдог ба 2021 онд гэхэд дэлхийн зах зээлээс 7.4 тэрбум долларыг олсон байна (Wikipedia.org, 2022). Америк болоод Хятадын кино үйлдвэрлэлийн тухай авч үзэж, энэхүү харилцааны түүх нь соёлын болоод капиталын үнэт зүйлс болон хөгжлийн моделууд буюу үндэсний үзэл, онцгойруулан үзэх үзэл, соёлын давамгайлах үзэл зэрэг үзэл санаануудын өрсөлдөөн (Ying Zhu, 2017) хэмээн авч үзсэн юм. Дээрх хэсэгт дэлхий дахинд өөрсдийн соёлын үнэт зүйлс дээр тулгуурлан соёлын бодлогоо хэрхэн олон улсын зах зээлд гаргаж, өөрийн улс, үндэстнийхээ соёлын нөлөөг гаргаж бэхжүүлж буй талаар зөвхөн кино үйлдвэрлэлийн жишээн дээр тулгуурлан авч үзсэн байна. Гэвч энэхүү соёл үнэт зүйлс ба зөөлөн хүчний бодлогын холбоо хамаарал нь зөвхөн кино урлагаар хязгаарлагдахгүй бөгөөд хүний амьдралын бүхий л зүйлстэй шууд холбоо хамааралтай юм.

Харин сүүлийн үед Монгол ба Дотоод Азийн улс орнууд үнэт зүйлс гэх ойлголтыг төрийн хүрээнд ашиглах болсон байна. Монголын төрийн зүгээс “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт монголчуудын нэгдмэл үнэт зүйл гэх үзэл санааг оруулж ирсэн бол, Казакстан Улс мөн өөрсдийн хөгжлийн бодлогод ‘Үндэстний үнэт зүйл’-ээ тодорхойлсон байна. Тиймээс бүс нутгийн хэмжээнд улс орнуудын дунд хэрэглэгдэх болсон энэхүү ‘үнэт зүйлс’ гэх ойлголтыг бид антропологийн үүднээс задлан шинжлэх шаардлага тулгараад байгаа юм.

Монгол үндэстний хэмжээнд өмнө хэрэгжүүлж байсан үнэт зүйлсийн судалгаануудын дотор төрийн зүгээс үнэт зүйлсийг хэрхэн харж, хэрхэн төлөвшүүлж байгаа талаар бичсэн судалгаа хараахан байхгүй байна. Удирдлагын Академиас хийсэн судалгаанд (Хэрлэн, 2017) 1990 оноос хойших Монголын нийгэм, улс төр, эдийн засгийн

өөрчлөлт хэрхэн үнэт зүйлд өөрчлөлт оруулж байгаа талаар авч үзсэн боловч төрийн зүгээс гаргаж буй хууль, тогтоомж зэрэгт үнэт зүйлийн талаар яаж тусгагдсанг судлаагүй байна. Мөн СЭЗИС болон СУИС-аас хийсэн судалгаануудад ч авч үзээгүй байгаа ба аливаа төр гэдэг тухайн нийгэмдээ хамгийн ихээр нөлөө үзүүлж байдаг, нийгэм, соёлоо хэлбэржүүлж байдаг хамгийн том институт учир бид өөрсдийн судалгаандаа Монголын төрийн зүгээс хэрхэн монголчуудын үнэт зүйлийг авч үзэж буйг энэхүү хэсэгтээ авч судлаж үзэх юм.

Монголын төрийн зүгээс үнэт, эрхэм зүйлсийг тодорхойлж буйг Монгол Улсын хууль тогтоомж болоод Монгол Улсын элсэн орсон олон улсын гэрээ, конвенцуудаас эхлэн харах хэрэгтэй юм. Монгол Улсын Үндсэн Хууль эхлэхдээ дээр өгүүлсэнчлэн “Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж” (АИХ, 1992) хэмээн монголчуудын нийтээр эрхэмлэн дээдлэх зүйлсийг тунхаглан зарласан байдаг. Үүнээс хойш эрхэмлэн дээдлэх зүйлс, үнэт зүйлсийн талаар нарийвчлан авч үзээгүй байна. Харин 2020 оноос цаашдын хөгжлийн урт хугацааны төлөвлөгөөг баталж, түүндээ Монголчуудын нэгдмэл үнэт зүйлсийн талаар авч үзсэн байдаг. Монголын төрийн зүгээс нэгдмэл үнэт зүйлсийг хөгжлийн гол тулгуур багана хэмээн авч үзсэн байгаа нь “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгээс харагддаг. Тус хөгжлийн бодлогод “-Үндэс язгуур, төрт ёс, өв соёлоо дээдэлж, -Үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэж” (УИХ, 2020) хэмээн эрхэм зорилгоо тунхагласан байдаг ба Үндсэн хуулийн эрхэм зорилготой харьцуулан харахад үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэж хэмээх шинэ зорилгыг шинээр гаргаж ирсэн байгаа юм. Эндээс ардчилсан нийгэмд шилжсэн Монгол Улс өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд туулж өнгөрүүлсэн түүхээ эргэн харж, одоогийн Монгол хүн гэж ямар хүнийг хэлэх вэ? гэх асуултад хариулхаар хичээж байгаа бөгөөд тэрхүү хариултыг монголчуудын нэгдмэл үнэт зүйлээс олж авахаар эрмэлзэж байгаа юм.

Монгол Улсын Улсын Их Хурал (УИХ), Засгийн Газрын (ЗГ) зүгээс үндэсний нэгдсэн үнэт зүйлсийг шинжлэх ухааны нарийн судалгаан дээр түшиглэж, хөдөлшгүй баталгаа нотолгоотой, үнэн мөнөөр нь тогтоохыг зорьж байгаа юм (УИХ, 2020). Үүнийг хэрэгжүүлэхдээ 2050 оныг хүртэл үнэт зүйлсийг тогтоох, түүнийгээ төлөвшүүлэх, хэрэгжүүлэх зэргээр 3 шат, 9 алхамтайгаар хийж хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Эх хэл, Эх түүх, Өв соёл гэх гурван ойлголтыг монголчуудын үндэсний үнэт зүйлийн гол тулгуур багана болгосон нь “Алсын хараа-2050”-ын нэгдүгээр бүлгээс харагдах бөгөөд ““Эх хэл, эх түүх, өв соёлыг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар, дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно” гэж тус бүлгийн цорын ганц зорилгод тусгасан байгаа юм (УИХ, 2020). Гэвч Монголын төрийн зүгээс дээрх 3 зүйлийг өөрсдийг нь үнэт зүйл хэмээн авч үзэхгүй байгаа нэг зөрчил байгаа юм.

Монгол Улсын төрөөс үнэт зүйлийн талаар авч хэрэгжүүлж буйтай ойролцоо жишээг бидэнтэй адил нүүдлийн соёл иргэншилт Казакстан Улсын жишээн дээрээс харж болохоор юм. Учир нь 2012 онд Казакстан Улсын Ерөнхийлөгч Нурсултан Назарбаев ард түмэндээ хандан “Казакстан-2050” ба “Мәңгілік ел” хэмээх илгээлтийг илгээсэн ба үүндээ Казакстан Улсын цаашдын 2050 хүртэлх хөгжлийн төлөвлөгөөг танилцуулсан

юм. Үүгээрээ тэрээр Казакстаны үнэт зүйлийг тодорхойлж, түүндээ тулгуурлан дээрх төлөвлөгөөг боловсруулснаа зарласан байна. Энэхүү хөгжлийн бодлогын тулгуур ойлголт нь “Мәңгілік ел” ба монгол хэлээр “Мөнхийн Улс” хэмээн орчуулагдана. Казакстаны үнэт зүйлс агуулагдах бөгөөд тэрхүү үнэт зүйлсийн тулгуур ойлголт нь тэдний тусгаар тогтнол хэмээн Назарбаев ба түүний Засгийн Газраас тунхагласан юм (*Казакстан 2050*, 2012). Казакстанаас үнэт зүйлсийн талаар хэрэгжүүлж буй бодлогыг гуравдугаар бүлэгтээ дэлгэрүүлэн авч үзэх болно.

2020 оны 12 сарын 22-ны өдрийн Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын дугаар 149-р зарлигаар (Монгол Улсын Ерөнхийлөгч, 2020) “Эрдэнийн судар”-ыг дээдлэн залах тухай зарлиг гаргасан билээ. Энэхүү “Эрдэнийн судар” нь СУИС-ын “Монголчуудын үнэт зүйлсийн судалгаа”-н дээр үндэслэн Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи (ШУА)-ийн санаачлагын дагуу монголчуудын 9 үнэт зүйлсийг тогтоон СУИС-ийн дэргэдэх Хөх урланд бүтээсэн судар юм. Тус зарлигийн 2 дугаар зүйлд

“Эрдэнийн судар”-т тэмдэглэн үлдээсэн “монгол хүн”, “гэр бүл”, “төрт ёс”, “эх нутаг”, “монгол хэл”, “эрдэм боловсрол”, “ёс суртахуун”, “өв соёл”, “нүүдэлчин ухаан”-ыг хүүхдэд бага балчраас нь ойлгуулж, улмаар бүх шатны боловсролын байгууллагын сургалтын агуулгад тусган сурагч, оюутан залуучуудад танхимын болон танхимын бус сургалтаар бататган хөгжүүлэхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийт багш, сурган хүмүүжүүлэгч нарт даалгасугай(Монгол Улсын Ерөнхийлөгч, 2020) хэмээн заасан ба дээрх 9 зүйлийг монголчуудын үндэсний үнэт зүйлс хэмээн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс тунхагласан юм. Гэтэл УИХ болоод Засгийн Газраас баталсан “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт дээрх зүйлсийг үнэт зүйлс хэмээн тусгаагүй юм. Цаг хугацааны хувьд СУИС-ийн үнэт зүйлсийн судалгаа 2019 онд хэрэгжсэн бол “Алсын хараа-2050” 2020 оны 5 сарын 13-ны өдөр, “Эрдэнийн судар”-ыг дээдлэн залах тухай зарлиг 2020 оны 12 сарын 22-ны өдөр батлагдсан байгаа юм. Үүнээс орчин үеийн Монгол Улсад байгаа намаар талцах үзэгдэл хүчтэй харагдаж байгаа юм. 2020 оны сонгуулиар Монгол Ардын Нам (МАН) улиран УИХ-д олонх болж, төрийн эрхийг барих эрхтэй болсон ба энэхүү эрх мэдлийнхээ хүрээнд өмнөх Засгийн Газар болох Ардчилсан намын (АН) Засгийн Газрыг хэрэгжүүлж байсан урт хугацааны хөгжлийн хөтөлбөр болох “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг хүчингүй болгож, өөрсдийн “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг баталсан байдаг. Гэтэл 2017 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар АН-аас нэр дэвшигч Х.Баттулга Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдож, Монголын төрийн гурван өндөрлөг, эрх мэдлийн нэгийг АН-д хадгалж авч үлдсэн юм. Улмаар тэрээр өөрийн бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж тэрхүү үйл ажиллагааных нь хүрээнд СУИС-аас гаргасан үнэт зүйлсийг Төрийн ордонд дээдлэн залсан байна. Бид үүнээс МАН-ын бодлогыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс тодорхой хэмжээгээр эсэргүүцсэн байх талтай хэмээн харж байна.

Гэр бүл ба хувь хүний үнэт зүйлс

Бидний судалгааны энэхүү хэсэг нь онол болон арга зүйн хувьд хамгийн их бэрхшээлтэй тулгарсан хэсэг байв. Учир нь гэвэл антропологийн ухаанд үндэстэн, угсаатны бүхий л нийтлэг байдал буюу нийгэм, соёлыг бүхэлд нь тайлбарлах паттерн (хэлбэр), аль эсвэл структур (бүтэц)-ийг судлах хандлага ХХ зууны эхэн үед хүчтэй нөлөөтэй байв. Харин ХХ зууны хоёрдугаар хагасын дунд үеэс буюу 1970-аад оноос дээрх онолын хандлагаас антропологичид татгалзаж эхэлсэн юм. Дээр өгүүлсэнчлэн антропологийн эхэн үеийн судалгаанууд нь аливаа нийгэм, соёлын гүнд байх бүтэц (structure), үүрэг (function), хэлбэр (pattern)-ийг судалж нийгэм, соёл гэдэг хүнээс хараат бус ба хүн гэдэг өөрийн бүтээсэн тэрхүү соёлынхоо хүрээнд л сэтгэж, ажиллаж, амьдарч байдаг хэмээн үзэж байсан бол, Америкийн антропологич Геерц болон бусад аженси (agency)-ийн онолчдын үеэс нийгэм, соёлд оруулж байгаа оролцоог чухалчилж үзэх хандлага дараа үеийн судалгаануудад давамгайлах болсон юм (Д.Бум-Очир & Г.Мөнх-Эрдэнэ, 2018).

Дээрх антропологийн онол сэтгэлгээний түүхийн талаар авч үзээд байгаа нь бидний энэхүү үнэт зүйлийн судалгаатай ихээхэн холбоо хамааралтай юм. Учир нь антропологи дахь үнэт зүйлийн судалгаа нь дээр өгүүлсэн онол сэтгэлгээний түүхийн эхэн үед хамаарах судалгааны сэдэв байсан ба үнэт зүйлсээр дамжуулан тухайн нийгэм, соёлыг тайлбарлаж болох тухай хандлага нийгмийн шинжлэх ухаанд хүчтэй байсан билээ. Харамсалтай нь антропологи дахь онолын чиг хандлага өөрчлөгдсөнөөр үнэт зүйлийн талаарх судалгаа антропологийн судалгааны сэдвээс бараг л мартагдсан хэмээн үзэж болох юм. Энэ талаар Америкийн антропологич Д'Андред “Хувь хүний болоод Соёлын үнэт зүйлсийн судалгаа” хэмээх бүтээлдээ үнэт зүйлсийн талаар антропологичид болоод бусад нийгмийн шинжлэх ухааны эрдэмтдийн судалгаа, онол, арга зүйн талаар авч үзсэн байна. Тэрээр 1945-1955 оны хоорондох зурвас үед Харвардын Их Сургуулийн Нийгмийн харилцааны тэнхимд үнэт зүйлсийн тухай судалгаа ихээхэн хөгжиж байсан тухай өгүүлээд энэхүү зурвас үе нь Америкийн антропологич Клүкхон 1948-1952 оны хооронд Зуни, Мормон, Навахо, Испани америк, Тексан гэх 5 бүлгийн хүмүүсийн үнэт зүйлийг судалсан судалгааны дараагаас антропологичдын бараг л орхисон сэдэв болсон хэмээн үзсэн байдаг (DAndrade, 2008). Тиймээс энэхүү судалгааг хэрхэн, яаж хийх, үнэт зүйл гэдгээ хэрхэн тодорхойлох талаар 1970-аад оноос хойш антропологийн үүднээс судалсан судалгаа зогсонги байдалд орсон байсан тул бид судалгаа явуулахдаа өөрсдийн онол, арга зүйн хувьд хэрхэн боловсруулах тал дээр тодорхой хэмжээний асуудлуудтай тулгарч байсан билээ.

Бид соёлын үнэт зүйлс гэх ойлголтыг авч үзэхэд дараах 2 төрлийн үнэт зүйлсийн аль нь соёлын үнэт зүйлс юм бэ гэдгийг тодорхойлох шаардлага тулгарсан юм. Үүнд нэгдүгээрт тухайн соёл бие даан оршин тогтноход зайлшгүй чухал шаардлагатай үнэт зүйлс байдаг уу?; хоёрдугаарт тухайн соёлын бүтээгдэхүүнүүд буюу Монголын соёлд төрж, өссөн хувь хүмүүсийн өөрсдийнхөө хувьд үнэт зүйлсийг юу гэж тодорхойлон үзэж байна вэ?; Тухайн хувь хүмүүсийн үнэт зүйлс тодорхойлогдоход нийгэм болон соёлын ямар хүчин зүйлс нөлөөлж байдаг вэ? зэрэг асуудлууд юм. Бидний зүгээс дээрх 2 асуудалд энэ тэнцүүгээр хариулт өгөхийг хичээж ажилласан бөгөөд монголчуудын үнэт


зүйлсийг танин мэдэж, тайлан тайлбарлахад дээрх хоёр төрлийн үнэт зүйлсийн аль нэгийг нь орхигдуулахгүй авч үзэх хэрэгтэй хэмээн үзсэн юм.

Улмаар бид Монгол Улсын 7 аймгийн тодорхой тооны сумдад хээрийн судалгаа хийж хэрэгжүүлсэн юм. Ингэхдээ голчлон хөдөөний малчин айлуудаар явж, судалгаа хийв. Судалгааны ажиглалтын явцад малчдын хувьд “мал” хамгийн чухал үнэт зүйл юм байна гэсэн анхны сэдэл надад төрсөн юм. Чухам ингэж үзэх болсон шалтгаан нь хамгийн анх Хэнтий аймгийн Биндэр суманд 2022 оны 3-дугаар сард мал төллөх үеэр хийсэн тандан судалгааны үед нутгийн иргэн Мөнхнасан ахын гэрт очиж, мал төллөхөд тусалж, бэсрэг тандан судалгаа хийж, ярилцлага авсан ба энэ үед нэгэн сульдаж ядарсан ишиг нь тэнхээ орж хөл дээрээ тогтох үед Мөнхнасан ахын эхнэр аз жаргал дүүрэн инээмсэглэл тодруулан мишээж байснаас гадна, Мөнхнасан ахтай хонинд нь хамт явахад хонины бэлчээр дээр хоёр хонь төллөсөн байв. Хоёр хурга хоёулаа цовоо сэргэлэн, тамир тэнхээтэй байсанд Мөнхнасан ах асар ихээр баярлаж байгаа нь царайнаас нь тодхон харагдаж байв. Тэднийх энэ хавар төл малаа олноор алдсан бөгөөд цаг хатуу биш боловч зун болон намрын маллагааны хувьд эхнэр нь хотод жолооны сургалтад удаан хугацаагаар сууж Мөнхнасан ах ганцаараа малаа маллаж үлдсэнтэй холбоотой гэж байв. Мал маллахад хүн хүч болон хөдөлмөрч байдал чухал нөлөөтэй ба тэдний өрх гэр 4 хошуу малтай, энэ бүхэнд нэг хүний хүч хүрэхгүй байсан тул ийнхүү хаврын цагт төл малаа олноор алдах үндэс болсон байна.

Мал, Бэлчээр, Хөдөлмөр ба Залхуурал, Боловсрол, Эрх чөлөө

Малчин өрх айлын хувьд “мал” тэдний үнэт зүйл болж байгаа нь дараах хэдэн үндэстэй хэмээн таамаглаж байна. Нэгдүгээрт, мал нь тухайн өрх айлын эдийн засаг, амьжиргааны үндэс, баталгаа болдог, хоёрдугаарт, тухайн малыг маллахад малчин айлаас хүч хөдөлмөр орсон байдаг. Ингэснээр тухайн малд үнэ цэн шингэж байгаа гэж үзэж байна. Үнэ цэн шингэх буюу тухайн хүмүүсийн хувьд үнэт зүйл нь болж байгаа нь дээр өгүүлсэнчлэн тухайн хувь хүмүүсийн сэтгэлгээ, тухайн зүйлд хэрхэн хандаж буй хандлага нь болж байгаа юм. Хөдөлмөр болоод үнэ цэнийн холбоо хамаарлын тухай Маркс авч үзсэн байдаг. Тэрээр бараа бүтээгдэхүүний үнэ цэнийн талаар авч үзэхдээ, тухайн бараа бүтээгдэхүүнийг бүтээхэд хэр хэмжээний хөдөлмөр орсон байгаагаас тухайн бүтээгдэхүүний үнэ цэн тодорхойлогдоно гэсэн байдаг (Д.Бум-Очир & Г.Мөнх-Эрдэнэ, 2018: 49). Энэхүү тайлбар нь зөвхөн эдийн засгийн хүрээнд бараа бүтээгдэхүүний үнэ цэнийн талаар л авч үзэж буй хэмээн үзэж болохгүй юм. Бид өөрсдийн жишээн дээр авч үзвэл тухайн хувь хүмүүсийн хувьд эрхэмлэж буй үнэт зүйлс ч тухайн хүнээс тодорхой хэмжээний хөдөлмөр гаргаж буй зүйлс мөн хэмээн үзэж байна.

Монголчуудын хувьд мал саяхныг хүртэл хамгийн ихээр хөдөлмөр зарцуулдаг амьдралых нь гол баталгаа болж байсан ба тэр ч утгаараа соёлын хувьд хамгийн эрхэм зүйл болон бүрэлдэн тогтжээ. ХХ зууны сүүлч буюу социализмын төгсгөл үед хүртэл мал аж ахуйд түшиглэсэн эдийн засагтай байсан Монгол Улс 1999, 2000 онуудад жил дамнан үргэлжилсэн ган, зуд болсны дараагаас Улаанбаатар хот дахь хүн амын төвлөрөл ихсэж, малчин ахуйгаас хот суурингийн амьдралд шилжих шилжилтийн давалгаа эрчимтэй нэмэгдсэн нь Статистикийн Үндэсний Хорооны мэдээнээс харагдаж байгаа юм.



(Улаанбаатар хот дахь шилжилт хөдөлгөөн. Эх сурвалж: 1212.mn)

Ийнхүү бараг л 2000 оныг хүртэл цэвэр мал аж ахуй дээр түшиглэсэн соёл нь бэлчээрийн малыг нэг талаараа соёлын үнэт зүйл болгон төлөвшүүлсэн бөгөөд энэхүү үнэт зүйл эдүгээ хөдөөний малчин хүмүүс хийгээд аймаг сумын төв болоод Улаанбаатар хотод амьдарч буй хүмүүсийн хувьд ч адилхан соёлын үнэт зүйл болж, эргээд Монгол хүмүүсийн үнэт зүйл, ёс суртахууныг хэлбэржүүлж байгаа нь судалгааны явцад харагдаж байсан юм. Баянхонгор аймгийн нэгэн малчин “Мал бол малчдын хувьд хамгийн эрхэм зүйл шүү дээ. Хаврын цагт хурга, шигээ харах үед хамгийн жаргалтай байдаг” хэмээн өөрийнхөө амьдралын үнэт зүйлээ бидэнд тодорхойлон хэлсэн ба Архангай аймгийн Өндөр-Улаан суманд малчин Жаргал “Монголын соёлын хамгийн үнэт эрхэм зүйл бол нүүдлийн мал аж ахуй шүү дээ...” “Хэрвээ нүүдлийн мал аж ахуйг болиод фермийн мал маллахаар болвол хэн ч мал маллахгүй, би лав шууд явж эсэргүүцнэ...” хэмээн хэлж байснаас малчин хүний хувьд хамгийн ихээр хөдөлмөрөө зарцуулж буй малаа үнэт зүйл хэмээн үзэж болохоор байгаа юм. Гэвч “мал” үнэт зүйл болж байгаа нь малчдаар хязгаарлагдахгүй бөгөөд Завхан аймгийн Шилүүстэй сумын иргэн, олон жилийн турш сумын соёлын төвийн эрхлэгч хийж байгаад тэтгэвэртээ гарсан, бага насаа эс тооцвол бараг л бүхий л насаараа төв суурин газар амьдарч байсан Оргодол гуайн хувьд өөрийн үнэт зүйл болон Монголын нүүдлийн соёлын үнэт зүйлийг мөн л “мал” хэмээн тодорхойлсон юм. Тэрээр хэлэхдээ, “Монгол түмнийг мал л

тэжээж байна”, “Мал байхгүй бол Монгол байхгүй”, “Мал бол Нүүдэлчин Монгол” гэх зэргээр өөрийн үнэт зүйлийг тодорхойлсон юм. Ийнхүү малыг үнэт зүйл хэмээн үзэж байгаа нь зөвхөн орон нутгийн жишээн дээр илэрч буй хэрэг биш бөгөөд бид Улаанбаатар хотод тодорхой хэмжээгээр судалгаа явуулж, нийгмийн янз бүрийн давхрагын хүмүүстэй ярилцлага хийж ажилласан билээ. Ингээд Монголын Бурхны шашны тэргүүн С.Чойжамц хамбатай уулзаж, бэсрэг хэмжээний судалгаа авав. Тэрээр өөрөө бага наснаасаа төв суурин болон хөдөө хоёрын хооронд амьдардаг байсан ба зуны амралтаараа хөдөө мал дээр гардаг байжээ. Түүний эрхэм, үнэт зүйлс, амьдралын зарчим, хүн хүний төлөвшилд нь нүүдлийн соёл иргэншил үлэмж хэмжээгээр нөлөөлж байсан тухайгаа голчлон ярьж байсан юм.

...хотныхоо хүүхдүүдтэй, саахалтын хүүхдүүдтэй тоглож, морь малд явж, хонинд явж байхдаа адаглаад морь мал, хонио хариулж байгаа хүмүүстэй уулзаж байнгын мэдээлэл дунд оришиж байдаг байсан. Хөдөөний энэ амьдрал гэдэг бүх мэдээллийг солилцдог. Цаг агаараас авхуулаад зочин гийчин ирсэн зүйлийг ярилцдаг учраас тухайн үеийн хүүхдүүд мэдээллийг боловсруулж, цааши нь дамжуулдаг хэлбэр их байсан гэж боддог. Мөн хонь малдаа явж байхдаа ажил хийх, ажил даах, толгойгоо дааж ажиллах чадвар суудаг байсан ялангуяа жаахан хүүхдүүд бол...

Дээрх жишээнээс харахад мал хэмээн бидний үзэж буй үнэт зүйл нь Монгол хүний бусадтай харилцах харилцаа, ажил хөдөлмөр эрхлэх зэрэг чадамжуудыг хүүхэд байх үеэс нь эхлэн тухайн хүнд суулгаж байдаг зүйл болох нь харагдаж байгаа юм. Эндээс бид Монгол хүний хувьд ‘хөдөлмөрч зан суртахуун’-ыг эрхэмлэдэг хэмээн үзэж болохоор байгаа юм.

Малтай холбоотой хөдөлмөрч зан суртахуун монголчуудын нийтлэг үнэт зүйл болж байгаа нь мал маллах арга ухаанаас давхар харагдаж байгаа юм. Энэхүү мал маллах арга ухаан нь бэлчээрийг хуваарьтай сэлгэн отроор явах, ус бэлчээрийн соргогт тааруулан шилжин нүүдэллэж, тарга тэвээргийг сайн авхуулах тухай ойлголт юм. Бидний баруун аймгуудад хийсэн хээрийн судалгааны явцад Увс аймгийн Завхан сумын настан Б.Янжив, Баян-Өлгий аймгийн Өлгий сумын өндөр настан Н.Бааст нарын ярианаас мал маллах нь малчин хүнээс хэр хэмжээний хөдөлмөр шаарддаг талаар дүгнэж болохоор байсан юм. Увс аймгийн Завхан сумын өндөр настан Б.Янжив залуудаа малыг аажуу тааваар нь байлгахын тулд өдөрт 20-30 км явганаар хариулдаг байсан хэмээн бидэнд хэлж байсан юм.

“Аажуу тааваар нь байлгахын тулд л. Малыг тааваар нь байлгаж, хүнээс айж ичихгүйгээр сайхан тогтуухан байлгах л арга байхгүй юу. Өдөрт би 20-30 км явахад хөл, гар өвдөнө гэсэн юм байхгүй. Өөрөө би 6, 7 цагт бэлчээгээд орой 7-д л гэртээ орж ирж байгаа юм. Зун бол хязгаар байхгүй ээ. Орой ч ирнэ, эрт ч ирнэ. Малыг их тууж барих тарга тэвээрэгт их хортой, одоогийн улсууд малыг өдөртөө 20-30 км туугаад л ирж байна. Малыг тааваар нь явуулах л сайн хэмээн нэг өдөрт малаа бэлчээлгэх гэж хэр их хүч хөдөлмөр гаргадаг байсан тухайгаа дурьдаж байсан юм. Мөн тэрбээр мал маллах арга ухаан бол зуны цагт бол өглөө 4, 5 цагт бэлчээх, ус бэлчээрийн соргогт хариулах, тэгвэл тарга тэвээрэг

сайжирч, малаа онд тарган оруулах, гарсан төл нь уураг сүүндээ цатгалан байвал өсч торнихдоо бие бялдарт их нөлөөтэй” хэмээн ярьж байв.

Тэрээр зөвхөн малаа онд оруулах, төл малаа бойжуулахын тулд өглөө эрт босож, бэлчээр усыг нь тохируулах зэргээр бие бялдарын болон оюуны хөдөлмөр эрхэлдэг байсан нь харагдаж байгаа юм. Мөн тэрээр “...Бэлчээрийг хуваарьтай сонгоно оо. Хуваарьтай сонгохдоо нэг газар их олон хоног байх биш. Ер нь цөөх, цөөхөн хоногоор сэлгэж бэлчээж байвал малын тарга тэвээрэгт их сайн нөлөөтэй л дөө...” хэмээн бэлчээр нь маллахад хэр чухал үнэтэй зүйл болдог тухай бидэнд хэлсэн юм. Б.Янжив гуай 50 жил мал малласан туршлагатай, 4 төрлийн малыг голчлон өсгөж байсан бөгөөд нүүдлийн соёлын үнэт зүйл бол уламжилж ирсэн мал маллах арга ухаан гээд, түүнийг хадгалан өвлүүлэх тухай чухалчлан ярьж байсан юм. Үүнээс гадна Хяргас нуурыг тойрон Ховдын Мянгад, Дөргөн, Завхан аймгийн Ургамал, Дөрвөлжин зэрэг сумуудаар холын отор хийж өвөлждөг, 4-н улиралдаа байнга нүүдэг байсан тухай ярьсан юм. Ингэж байнга холын отор нүүдэл хийх нь газар бэлчээрээ сэргээх, өвсний гарц, тарга тэвээрэгт чухал нөлөөтэй байдаг байна.

Баян-Өлгий аймгийн өндөр настан Н.Бааст “Би намар 10 сараас эхлээд 12 сар хүртэл “Сайхан дэвсэг”, “Нуурт” гэдэг газруудаар, 12-3 сар хүртэл “Сэвс”, “Хүрэмт” гэдэг газар өвөлжөөнд хариулдаг байсан” хэмээн холын отор нүүдэл их хийдэг байснаа ярьсан юм. Н.Бааст гуай өдгөө 86 настай, 16 наснаас эхэлж төрөл бүрийн мал малласан арвин их туршлагатай хүн юм. Тэрээр ингэж их отор нүүдэл хийдэг нь газар нутгийн онцлогоос шалтгаалан хүн очдоггүй аглаг, зэлүүд газар сайн өвсөнд таргалуулж, ашиг шимийг нь үзэхийн тулд гэсэн юм. Мөн отор нүүдэл хийхдээ “Намрын цагт бол бүр доошоо Ховдын гол ороод, 10-12 сар хүртэл Шилд гарна. Ховдын гол Алтанцөгц сумын төвөөс 90 км газар явна. Олон нуур руу 70 км газар “Сайхан дэвсэг” гэдэг газар оторлуулж тарга хүч авхуулдаг”. “Манай нутаг усны онцлог бол ерөөсөө намрын цагт Ховдын гол сайхан хөдөө хөх өвсөн дээр ордог” гэж нутаг орны аль сайн бэлчээртэй газар 70-90 км холын оторт явдаг байснаа ярьсан билээ. Тийм учраас ашиг шимийг нь үзэхийн тулд малаас залхаж, залхууралгүй өдөржин хариулж, шөнөдөө чоно нохойноос хамгаалан манаж, намартаа хужир усанд цатгаж, тэвээрүүлж тэнхээрүүлдэг гэх зэргээр Монголын нүүдлийн соёл нь малаа аажуу тайван бэлчээрлүүлж, тарга хүч авхуулан онд эсэн мэнд оруулахад малчин хүнээс их хэмжээний хүч хөдөлмөр, арга ухаан гаргадаг, мөн мал маллаж буй хүн залхуурч болдоггүй хэмээн хэлж байв.

Мал болоод мал маллагаатай холбоотойгоор өөр нэгэн үнэт зүйлийн ойлголт байгаа нь ‘бэлчээр’ юм. Монгол малыг бэлчээрээс нь үл салгаж болох ба дээр дурдсан П.Жаргал гуайн ярианаас бэлчээр тэдэнд хэр чухал болох нь харагдаж байгаагаас гадна бэлчээрийн маргаан монголын нийгмийн нэгэн тулгамдсан асуудал болж байгаа нь тодорхой харуулж байна. Завхан аймгийн Цагаанхайрхан сумын нэгэн өндөр настан сүүлийн 2 жилийн хугацаанд Цагаанхайрхан суманд Завханы урд талын сумд, Говь-Алтай аймгаас отрын малчид орж ирсэн нь бэлчээрийн маргаан болох үндэс болж байгаа тухай ярьж байсан юм. Архангай аймгийн Өндөр-Улаан суманд сүүлийн жилүүдэд малын тоо толгой тэр дундаа үхрийн тоо толгой, их өссөнөөр бэлчээрийн маргаан ихээр гарах болсон тухай сумын засаг дарга Ю.Баасанжаргал болон Баянгол багийн дарга

Т.Ууганбаатар нар ярьж байлаа. Ю.Баасанжаргал гуайн хувьд засаг дарга болсноос хойших хамгийн хүнд бэрхшээлтэй, том асуудал нь бэлчээрийн асуудал болоод байгаа хэмээсэн бөгөөд бэлчээр дээрээс үүдэн Баянгол баг, Хануй багийн залгаа нутгаар амьдардаг 2 өрх хоорондоо муудалцаж, ихээхэн хэл ам болж байсан тухай ярьж байв. Бэлчээрийн маргааны асуудал зөвхөн баг, сум хоорондын асуудал биш байв. Баянгол багийн 500-аас дээш толгой үхэр бүхий 2 айл бэлчээр дээрээс үүдэн хоорондоо муудалцаж, сумын цагдаатай очиж салгаж байсан тухай Т.Ууганбаатар гуай ярьж байлаа.

Бэлчээртэй холбоотой өөр аймаг сумдын мэдээнээс авч үзвэл “Одоо малтай улсууд малаа өсгөж байна гээд л малаа 2000-3000 гаргаад л бэлчээрийн даац гэдэг юмыг бялхаагаад хаячихсан” гэж Увс аймгийн Улаангом хотыг иргэн Д.Гүнчин бэлчээрийн даац хэтэрсэн тухай ярьсан бол бэлчээр сүүлийн үед малын өсөлтөөс шалтгаалж байгаагаас гадна малчид бэлчээрийг сэлгэн нүүдэллэх хуваарилалтаа зөв хийж чадахгүй байгаагаас мөн шалтгаалж байна гэж Цэрэнчимэд гуай ярьсан юм.

Бэлчээрийн хуваарилалтаа ашиглаж чадахгүй, малын тоо толгой нэмэгдээд талхлалт нэлээн болчихлоо. Байгаль цаг уур бас гарцаагүй нөлөөлнө. Бороо ороод хур тунадас, чийг өгөхгүй байвал ингээд л шороон шуурга тавиад байх чинь болохгүй л асуудал байгаа юм л даа. Байгалийнхаа эрхшээлд ингээд байж байдаг ард түмэн шүү дээ малчин хүн. Байгальдаа залбираад л, байгаль орчноо хамгаалаад л амьдрах л учир холбогдолтой байгаа юм л даа. Хүн бүр тэрийг бас ойлгохгүй л байна.

Түүнийхээр бэлчээрийг зөв хуваарилан ашиглаж чадахгүй байгаагаас нэг газраа удаан байснаар талхлалт үүсэж бороо хур ч орохоо больжээ. Бэлчээрийн талхлалтын нөлөөгөөр үүссэн өөр нэг асуудал бол өвс ургамлын гарц муудах ажээ. Энэ талаар судалгаанд хамрагдсан нэгэн малчны ярианаас авч үзвэл:

Хавар шуурга их гарч, өвс ногоо ургахаа больж байна. Үе үе тийм гамигууд байна. Салхи шуурга, цас бас хэцүү байна. Энэ хавраас 6 сар хүртэл шуурч байна. Ногоо гэж юм гарахгүй. Голынхоо ногоонд байгаа нь л энэ. Хөдөө ногоо гэх юм байхгүй, энэ ногоороод байгаа чинь голын ногоо. Энэ юунаас болж байхыг ёстой мэдэхгүй. Байгаль дэлхийгээ сайхан хайрлаж цэвэрхэн авч явахгүйгээс л болдог юм болов уу. Ер нь малчин хүний ганц харьцдаг зүйл бол байгаль шүү дээ. Байгаль дэлхий, өвс ногоо сайн бол тэгээд боллоо. Энүүгээр шарилж, шаваг, ерхөг, борон гэх мэт шимтэй өвс гарна. Борон идвэл хар мах сайн гарна. Ерхөг идвэл тарга сайн авна. Урагшаа шивээ л их гарна.

Увс аймгийн Завхан сумын настан Б.Янжив:

...Сүүлийн үед нутаг бэлчээр их хавчигдаж байна. Дуртай газраа бууж болдоггүй, нэг газраа байж болдоггүй, хур бороо ороод нутаг дэлгэрээд байвал хаа ч байсан болохоор л байна. Байгалийн энэ бэрхшээлээс болоод хүн амьтны сэтгэл бурангуй, мал хар тарга тэвээрэг муутай, ер нь их давжаарч байна. Хүн нь ч хаашаа яаж нүүх, малаа яаж оторлох, тэр тал дээр их мухардал байна...

...Бэлчээрийн хувьд бол яах вэ, одоо бид байгалийн эрхшээлд л, ер нь монгол хүн, малчин хүн гэдэг бол байгалийн эрхшээлд л байдаг болохоор нэг талдаа төвөгтэй л дөө. Байгаль цаг уур хатуурхаад тэр жилийн ургамлын гарц, өвсний гарц муу байх юм бол мал хунар зутарна. Өвс тэжээлээ бэлдэж чадахгүйд хүрнэ, бас хэцүү. Ер нь олон ч байсан цөөхөн ч байсан мал маллаж байгаа хүмүүст байгаль цаг уур ихээхэн нөлөөлнө шүү дээ. Тэгээд яах вэ дээ, төв суурин газрууд учраас тааруухан. Нэмэгдэл тэжээл ашиглаад болгоод л байж байна...

Тийм учраас төв суурин газарт цөөн тооны үхэртэй айлууд царгас, хорголжин, багсармал зэрэг нэмэлт тэжээлийг худалдан авч хэрэглэдэг болжээ. Түүнчлэн байгалийн хуурайшилтыг дагаж гол ус, булаг шанд ширгэх болсон талаар мөн Б.Янжив гуай:

Сум орон нутагт маань байгалийн хуурайшилт маш их явагдаж байна. Бороо орохгүй. Миний бодлоор байгалийн ус нь татраад багасаад байх шиг санагдаад байгаа юм. Гол нарийсаад, булаг шанд ширгээд, хүнийг зовоож байгаа юм тэр байна. Ширгэсэн гол нь нуурын булгаас нуур руу эх авч урсдаг булаг тасраад эхэндээ нэг жаахан болчихсон, дээр нь Олон нуур чиглэлд хоёр гурван газар ус гардаг байж байгаад ийм юм боллоо, булаг шанд байсан, тэгээд ширгээд алга болсон хув хуурай. Тэгээд одоо нуур нь дотогшоо бага, бага жижигхэн болчихсон ч байна. Үүнийг одоо хуурайшилттай холбоотой юм болов уу гэж боддог.

хэмээсэн ба зарим газар булаг шанд тэр чигтээ ширгэн алга болж, голын ерөнхий түвшин илт багасаж нарийссан нь хуурайшилтаас үүдэлтэй гэж үзэж байв.

Ийнхүү бэлчээрийн гарц муудснаар тухайн малчин хүний амь зуулгын асуудал хөндөгдөж эхэлдэг ба нөгөө талаар харвал Монголын нүүдлийн соёлын оршин тогтнолын асуудал мөн хөндөгдөж байгаа юм. Учир нь бэлчээрийн доройтол, ган, зуд зэргээс үүдэлтэй хот суурин газар бараадах хандлага малчдын дунд өндөр байгаа нь харагдаж байсан юм. Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын иргэд болох Т.Мөнх-Эрдэнэ, Э.Дугар нар сүүлийн 2 жилд зуданд малаа ихээр алдаж, энэ жил 200 гаруй л тооны ямаатай, цөөн тооны малтай үлдсэнээр малыг амьдралынхаа гол эх сурвалж биш гэж харах болсон тухайгаа ярьж байсан билээ. Мөн тухайн гэр бүл болж өгвөл сумын төвдөө суурин бараадах хүсэлтэй байгаа ба суманд нь шинээр баригдаж буй сумын төвийн барилга дуусахыг хүлээж, ямар нэгэн байдлаар аль нэг нь ч болтугай ажилд орохыг хүсэж байгаа гэж байв. Мөн судалгааны явцад мал маллахаа больж, Улаанбаатар хотод 1-2 жилийн хугацаанд ажил хийж байсан малчид нэлээд байсан юм. Малын мах, ноолуурын үнэ унавал мал маллахаа болиод суурин бараадах тухай хүртэл ярих хүмүүс олширчээ.

Ийнхүү мал маллах нь өөрөө байгаль, цаг агаараас хамааралтай учир хүнд цаг үеүдэд малчдын итгэл, зориг мохож байгаа нь дээрх малчдын ярианаас харагдаж байгаа юм. Ийнхүү мал маллах малчидгүй болбол Монголын онцлог, Монгол соёл гэдэг зүйл яах вэ? гэдэг асуудал нэн тэргүүнд тавигдах нь дамжиггүй юм. Зөвхөн байгаль, цаг уурын асуудал, бэлчээрийн гарцаас гадна малчдын амьдралд нийгмээс шалтгаалах олон тооны хүнд сорилтууд тулгарч байгаа нь судалгааны явцад ч мөн харагдаж байв. Хамгийн томоор тулгамдаж буй асуудал нь *жендер болоод гэр бүлийн асуудал* байсан

юм. Дээрх асуудлууд нь *боловсролыг үнэлэх үнэлэмжтэй* холбоотой хэмээн бид үзэж байгаа юм. Монголчууд боловсролыг үнэт эрхэм зүйл болгодог нь монголчуудын олон тооны зүйр цэцэн үгсээс бэлхнээ харагддаг. 1990-ээд оны үед Монголын нийгмийн өөрчлөлтийн үр дүнд боловсролыг үнэлэх үнэлэмж нэг хэсэг буурсан бололтой. Бид ийнхүү үзэх болсон шалтгаан нь судалгааны явцад 1970-аад оноос хойш төрсөн олон малчид, 1990-ээд оноос мал маллаж эхэлсэн, тухайн үед мал маллахаас өөр сонголтгүй болчихсон байсан тухайгаа бидэнд хэлж байсан юм. Их, дээд сургуулиуд төлбөртэй болж, нийгэмд бараа хомсдол, үнийн өсөлт зэрэг эдийн засгийн асуудлууд бий болж эхэлснээр иргэд боловсролд ач холбогдол өгөх хүчгүй амь зуух гол арга хэрэгсэл нь мал аж ахуй хэмээн үзэж, мал маллах хүмүүсийн тоо нэмэгдэхэд хүрсэн байна. Харин сүүлийн үед тухайн малчдын амьдрал төлөвшин тогтсоноор өөрсдийн үр хүүхдүүдээ боловсрол эзэмшүүлэхийг машид чухалчилж байна. Тухайлбал, Архангай аймгийн Өндөр-Улаан сумын малчин Б.Мөнхбаатар ямартай бүх хүүхдүүдээ боловсрол эзэмшүүлж, дээд боловсролтой болгон хэмээн бидэнд хэлж байсан.

Боловсролыг үнэт зүйл хэмээн үзэж болох өөр нэгэн жишээ бол бага насны хүүхдээ даган сумын төвд амьдрах болсон эмэгтэйчүүд болоод малаа маллан хөдөө хотондоо амьдрах болсон эрэгтэйчүүдийн жишээ юм. 2022 оны 4 дүгээр сарын сүүлээр Өвөрхангай аймгийн Тарагт суманд судалгааны ажлаар явж байхдаа бид нэгэн айлаар айлчилхад 35-40 орчим насны 2 залуу ээжтэйгээ амьдардаг агаад эхнэрүүд нь хүүхдүүдээ даган аймгийн төвд ажиллаж амьдардаг гэж байв. Ийнхүү гэр бүл 2 талд амьдрах болсон шалтгаан нь Монгол Улсын Засгийн газраас бүх хүүхдэд ерөнхий боловсролыг эзэмшүүлэх ёстой хэмээн хуульчилсантай холбоотой юм. Мөн нөгөө талаар заавал 6 наснаас сургуульд элсүүлэх болсон нь ийнхүү гэр бүл 2 талд амьдрах үндэс болж байгаа юм. 6 настай хүүхдийг дотуур байранд суулгах, айлд суулгах зэрэгт хэтэрхий балчир гэж аав, ээж нар нь үзэж байсан ба ядахдаа 8 настайгаас нь сургуульд авдаг байвал бидэнд ч амар, хүүхдүүдээ ч санаа амар дотуур байранд нь суулгаж чадна гэж хэлэх эцэг, эхчүүд ч байсан юм.

Бид энэ хэсэгт монголчуудын байгаль, нутгийг үнэт зүйл болгож буй талаар авч үзэх болно. Энэхүү байгаль нутгийг үнэт зүйл болгож байгаагийн нэгэн илрэл бол уул уурхайн асуудал байлаа. Энэ талаар Увс аймгийн Тариалан сум болон, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумдын жишээгээр хэлэлцэх болно.

Тариалан сумын хэмжээнд тулгамдаж байгаа асуудал бол уул уурхай. Манай суманд байхгүй юм байхгүй. Алт, нүүрсний олон ордууд байгаа. Тэгээд энийг дагаад зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй янз бүрийн хүмүүс уурхайд ажиллана. Тэгээд олон хүн цуглархаар олон асуудал үүснэ. Нэг нэгнээ хөнөөх зүй бус хэрэг гарна. Энэ юунд нөлөөлөх вэ гэхээр сумын нэр гарна. Сум орон нутгийн нэрэнд их нөлөөлнө. Байгаль цаг уурын нөхцөл хүний амьдралд маш их нөлөөлж байна.

Тариалан сумын хэмжээнд алтны уурхай 2, нүүрсний уурхай 2 байдаг бөгөөд энэ сумын төсвийн ихэнх хэсгийг газар тариалан болон уул уурхайгаас олдог байна. Уул уурхайгаас үүдэлтэй мөнгөний төлөө нэг нэгнээ хөнөөх, байгаль цаг уурын өөрчлөлт зэрэг үр дагаврууд энд хурцаджээ. Тус суманд дэлхийд ховорхон байдаг усны хүчийг ашиглаж хийсэн Галданбошигт хааны үеэс өвлөж ирсэн уламжлалт гар усалгаатай газар

тариаланг нийт хүн амын 90 гаруй хувь нь эрхэлж ямарч гантай жилд ургацаа бүрэн авч чаддаг боловч хэт их талбайд тариа, ногоо тарьснаас ашигтай бэлчээрийн хэмжээ багасаж хуурайшилт болон бэлчээрийн талхлалт үүссэн бололтой. Миний ажигласнаар сумын төвд ойрхон айл болгон 20-иод км Хархираа голоос шуудуу татаж гэрийнхээ хажууд урсгажээ. Аймгийн төвөөс Тариалан сум руу 30 км очих замд Хархираа голын том мөлгөр чулуунууд энд тэндгүй хэвтэх ба зарим газраар Хархираа гол ширгэсэн болох нь харагдсан юм. Тариалан суманд очиход ихэнх айлууд мөнөөх Хархираа голын том жижиг чулуудаар хашаа, хороо барьсан байлаа. Эндээс харвал энэ суманд уул уурхайгаас гадна, газар тариалан хуурайшилт, бэлчээрийн сийрэгжилт, эвдрэл, доройтолд том нөлөө үзүүлж байгаа бололтой.

Харин Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хувьд уулын судаг бараадаж аль алт олдох газраар бичил нинжа нар алт ухах асуудал үүсчээ. Тухайлбал Есөнбулаг сумын малчин М.Лхагвасүрэнгийн өгүүлснээр Уул уурхай гайгүй, бичил нинжа алт ухдаг. Одоо хүмүүс хувиараа маш их алт ухдаг. Энэ буруу л юм байгаа юм. Дандаа энэ уулын судгуудыг нь дагуулаад юу ч үгүй болтол ухчихдаг гэсэн бөгөөд энэ нутагт гол усны суваг, шуудууг ухсанаас булаг шанд ширгэх болжээ. Бас ийм жишээг Баян-Өлгий аймгийн иргэн Д.Гүнчин

Тэгээд л дуртай газраа алт малтаад л харгай майргаийг нь унагаагаад л. Энэ их харгай мод унагааснаас усгүй болж байна. Намайг багад хүнхэртэл гүйж байсан булаг ширгээд таг болчихоод байгаа. Ус гол багассан. Орчлон мөхлийн байдалд орчихоод байна шүү дээ. Энэ машинаар эргэдгийн наана их улаан харгана байсан. Чөдөртэй морь алга болоод би хэцүүдэж байж олж авч байсан. Одоо ширхэг ч харгана алга. Тэр чинь мөхөж байгаа байдал байхгүй юу гэж алтны уул уурхайгаас болоод гол ус алга болж, зарим өвс ургамал үгүй болсон хэмээн халаглаж байсан юм.

Монголчууд 1990 оноос хойш малыг мөнгө гэж харах болсноор бэлчээрийн даацыг ихдүүлэх, мөн уул уурхайн чиглэлээр амар хялбар аргаар мөнгө олох нөхцөл бүрдсэн нь гол ус ширгэх, бэлчээрийн талхлалт, газар нутгийн эвдрэл доройтол, өвс ургамлын гарц муудсанаар малын ашиг шим муудах гэх мэт асуудлуудыг үүсгэжээ. Тийм учраас Монголчуудын мөнгөний төлөөх хүсэл эрмэлзэл эргээд малчин хүний, Монгол хүний оршин тогтнох хамгийн үнэт зүйл болох байгалийг үнэгүйдүүлжээ.

Дээрх бүгдээс нэгтгэн харваас Монголын нүүдлийн соёл, мал аж ахуй нь мал дээр суурилсан хөдөлмөрийн хуваарь, өдөр тутмын амьдралын дадал, хэвшил, өөрийн гэсэн мэдлэг ухааныг бий болгож түүгээрээ Монгол хүнд хөдөлмөрч байх, хөдөлмөрийн үнэлэх эерэг үнэлэмжийг бий болгож тэрхүү үнэлэмж нь Монгол хүний нэгэн үнэт зүйл болгон хэлбэржин тогтсон байгаа юм. Нөгөө талаас Монгол хүн залхуу зан суртахууныг үнэлдэггүй болох нь бидний судалгааны явцад мөн харагдсан юм. Архангай аймгийн Өндөр-Улаан суманд нэг сарын хугацаанд хээрийн судалгаагаар амьдарч байх хугацаанд нутгийн нэгэн малчин саахалт айлынхаа хүүг залхуу хойрго хонь малаа ч хаана явж байгааг мэдэхгүй, өглөө эрт босдоггүй зэргээр ярьж байсан ба тэдний гэр хороо нь ч бохир заваан залхуу хойрго айл хэмээн ихэд дурамжхан ярьж байсан юм. Тус малчны хувьд маш хөдөлмөрч бөгөөд өглөө нар гарахаас өмнө босч хонио бэлчээрт гаргадаг,

намайг байх хугацаанд хаваржаандаа байсан ба хаваржааныхаа хашаа хороогоо байнга цэвэрлэж, үхрийн баас, бог малынхаа хэвтэрийг байнга өдөр болгон хусан цэвэрлэж, хаваржаандаа байх хугацаандаа хонио ноосолчихвол зусландаа буухад цэвэрхэн шинэ зуслан бохир, заваан болдоггүй хэмээн өдөр өдөрт их, багаар ямар нэгэн байдлаар хонио ноосолж байв. Тухайн үед Өндөр-Улаан сумандаа хөдөлмөрч хэмээн бусаддаа хүндлэгддэг нэлээд хэдэн айлууд хаваржаандаа хонио ноосолж байхдаа таарсан. Энэ нь зарим хүмүүсийн хувьд цэвэрч байх нь тэдний хувьд үнэт зүйл болж байгаа нь харагдаж байсан бол зарим айлуудын хувьд энэ нь тийм ч үнэт зүйл биш байв. Дээрх жишээнээс эргүүлэн харвал зарим айлууд цэвэрхэн байхыг төдийлөн тоохгүйгээр зусландаа буусан байх ба цэвэрч айлууд болоод цэвэрч бус айлуудын хувьд тэдний ялгаа нь хашаа хорооноос авхуулаад гэр доторхоороо хүртэл эрс тэрс ялгаатай харагдаж байсан билээ.

Нүүдэл, Уламжлал, Бахархал ба Өөрчлөлт,

Уламжлалт буюу хөсөг тэрэг, тэмээн нүүдлийг судалгаанд оролцож байсан хүмүүс эрхэмлэж байсан нь харагдаж байсан юм. Архангай аймгийн Цахир сумын иргэн Мөнхбат одоогоос 4, 5 жилийн Архангай аймгийн Хангай суманд явж байхдаа үхэр тэргээр нүүж байгаа нүүдэл харсан ба тухайн үедээ тэрхүү нүүдлийг хараад асар их бахархал төрж, өөрийн мэдэлгүй нулимс дуслуулж байсан талаараа хэлж байсан ба мөн 1990-ээд оны үед фермийн нүүдэл хийж байхыг хараад өөрийгөө Монгол хүн болж төрсөнөөрөө бахархаж байсан тухайгаа ярьсан билээ. Тэрээр өөрийн ахтайгаа үхэр хийдэг байсан ба социализмын үед Хангай сумын 'Ардын зориг нэгдэл'-д Дизельд¹ ажиллаж байгаад 1990 оны дараагаас сумын соёлын төвд техникч, галч, гэрэлтүүлэгч хийж байсан төв суурингийн хүн юм. Түүний хувьд нүүдэл хийж байх үед гардаг дуу чимээ, тэрхүү байдал нь ийнхүү өөрт Монгол хүн байх сайхан, бахархалтай гэх үнэлэмжийг бий болгосон байгаа юм. Энэ нь миний бие өөрөө фэйсбүүк дээрээс Ховд аймгийн Зэрэг суманд тэмээнд нуруу ачиж нүүдэл хийж буй 15 орчим минутын бичлэгийг үзэж байхдаа төрж байсан мэдрэмжтэй адилхан санагдсан юм. Би өөрөө тийнхүү хөсөг тэрэг, тэмээгээр нүүдэл хийж байгааг биеээрээ үзэж байгаагүй ч тэрхүү нүүдлийн бичлэгийг үзэж байхдаа асар ихээр Монголоороо, Монголын нүүдлийн соёлоороо бахархах мэдрэмж төрж байсан юм.

Судалгаанд оролцсон хүмүүсийн ихэнх нь таван хошуу малаа тэр дундаа тэмээ, үхэрийг уналга эдэлгээнд нь бүрэн ашиглах, нүүдлээ хийх нь жинхэнэ уламжлалт соёл мөн гэсэн юм. Сүүлийн 10-аад жилээс эхлэн малчид тэмээгээр нүүхээ бараг больж нүүдэл суудал, өдөр тутмын хэрэглээндээ машин техник хэрэглэх болсон байна. Гэвч орчин үежилт, даяарчлалын нөлөөгөөр тэмээгээр нүүдэг уламжлал бараг үгүй болж байгаа тул түүний энэхүү өөрчлөлтөд Монголчууд сөрөг үнэлэмж өгч байсан юм. Увс аймгийн Завхан сум нь аймагтаа тэмээний тоо толгойгоор тэргүүлдэг сум бөгөөд 2021 оны байдлаар 11 мянга гаруй тэмээтэй (Үндэсний Статистикийн хороо, 2021) 1973, 1989, 2020 буюу гурван удаа түмэн тэмээний баяр тэмдэглэж байсан сум юм. Тус сумын иргэн Цоозол гуай 10 мянгаас дээш түмэн тэмээтэй болж баяр хийсэн нь манай сумын жинхэнэ

¹ Дизель гэдэг социализмын үед сумын төв, нэгдэлийг гэрэл, цахилгаанаар хангадаг ажил байсан байна. Төвийн эрчим хүчинд холбогдоогүй байсан тэр цаг үед дизель мотор ашиглан сумын төвийг цахилгаан эрчим хүчээр хангадаг байсан ба энэхүү ажлаа дизель хэмээн нэрийддэг байжээ

өв соёл гэж би боддог тухай бидэнд хэлж байсан ба тэмээний үр шим, ашиг тусын тухай бидэнд хэлж өгсөн билээ. Цоозол гуайн 1988 оноос хойш 30-аад жил сумандаа эх баригч, сумын эмчээр ажиллаж байжээ. Түүнийг ажиллаж байх үед Завхан гол маш их олон салаатай, их гүнзгий байдаг байсан гэх ба хавар 4, 5 сард сумын 2 баг 14 хоног усанд хаагдах үед машинаар гол гатлах аргагүй болж зөвхөн тэмээгээр л усаар гаталдаг байсан байна. Тэрээр

Одоо техник хөгжчихсөн учраас уналга ачилга бага хэрэглэдэг болчихож. Яг тэр үед бид уналга ачлаганд тэмээгээ л хэрэглэдэг. Малчид гэрээ, хүүхдээ ачаад л усаар хөвүүлээд гарна. Би бол тэмээгээр их олон хүний амь аварч байсан. 1992 онд техник хэрэгсэл маш их ховор байсан үе. Тэр үед малчид тэмээгээр тэмээнийхээ ноос, ноолуураа ачиж ирж энд худалдаа бэлтгэлийн анги гэж байсан түүнд тушааж өгдөг байлаа. Түүнийгээ тэмээгээрээ сайхан ачиж барина. Машин байхгүй учраас эндээс тэр баг руу тойроод бүтэн 360-370 км явж очиж байж нэг эх дээр хүрдэг, тийм хол байхгүй юу. Нэг ёсондоо бид нар Хяргас нуурыг бүтэн тойроод (эндээс гараад нар гарах зүгт очиж) байж бид нэг эхдээ очиж тусламж үзүүлдэг

гэж 1990-ээд оны үед техник хэрэгсэл ховор байхад нүүдэл суудал, жил албандаа тэмээг хэрэглэдэг байснаа дурсан ярьсан юм. Түүний ярианаас тэмээ гэх амьтан нь зөвхөн нүүдэл суудал хийхэд л ашигладаг бус ардчилал, орчин үежилт, техник технологийн өсөлтийн нөлөөгөөр машины тоо нэмэгдсэн 2000 оны дунд үед хүртэл тэмээ зэрэг малаа албандаа хүртэл ашигладаг байсныг харж болж байгаа юм.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын малчин Лхагвасүрэн *Хамгийн сайхан амьтан тэмээ байсан юм. Тэмээтэй байхад сайхан байсан, дуртай газраараа явна, тэмээгээрээ хөтлөж нүүнэ, бензин тос гээд байхгүй. Одоо бол айл бүр л машин унадаг болж* хэмээн тэмээгээр нүүх уламжлалт соёл уналга, ачлаганд хэрэглэхэд их тохиромжтой байсан ба орчин үежилтийн нөлөөгөөр нийтдээ энэ соёлоо орхиж машин техник хэрэглэдэг болсон гэж харамсангуй ярьж байсан билээ.

Дээрх жишээнүүдийг нэтгэн харвал үхэр тэрэг болон тэмээгээр нүүдэл хийх, уналга ачлаганд ашиглах нь ардчилал, орчин үежилтийн нөлөөгөөр бүдгэрч, мартагдаж байгаа ч түүнийг дурсаж байх үедээ түүгээр бахархаж эерэг үнэлэмж өгч байгаа бол эдүгээ энэхүү өв соёл нь мартагдаж байгаад харамсах, харуусах зэргээр сөрөг үнэлэмж өгч байгаа нь машин, техник ашиглаж нүүдэл хийхээс илүү малаа ашиглан нүүдэл хийх нь Монголчуудын хувьд соёлын талаасаа хэр чухал үнэт зүйл болох нь харагдаж байгаа юм.

Адууны соёл

Монголчуудын хувьд адууг бусад малаас илүүтэйгээр чухалчлан үздэг байна. Адууг эрхэмлэн үнэт зүйл болгож байгаа нь төрийн сүлдэнд адууг оруулсан байдагтай хүмүүс холбон тайлбарлаж байсан юм. Ахуй соёлын талаас харвал адуу нь Монголчуудын гол уналга бөгөөд XIII зуунд адуугаар дэлхийн хамгийн хуурай газрын эзэнт гүрэнг байгуулж байсан зэрэг мөн л бахархал дээр суурилсан үнэлэмжийг адуунд өгч байсан нь адуу нь Монголчуудын нэгэн соёлын үнэт зүйл болох нь харагдаж байгаа

юм. Адууг эрхэмлэн дээдэлж байгаа нь адууны толгойг Молор Эрдэнэ хэмээн хүндэтгэн уул хайрханы овоон дээр залдаг уламжлалаас харагдаж байна. Судалгааны явцад Баянхонгор аймгийн Баянговь сумын нэгэн малчин өөрийн хамгийн хайртай адуунуудынхаа толгойг ямагт өөрийн удмын тахидаг овоон дээр гаргаж үлдээдэг тухайгаа бидэнд хэлж байв. Энэ нь адуу тухайн хүний хувьд үнэт болж байгаа нь харагдаж байгаа бөгөөд энэхүү зан үйл нь зөвхөн нэг удаагийн жишээгээр бус олон удаагийн ярилцлагын явцад Монгол орны хаана ч байдаг зан үйл болох нь батлагдсан юм.

Мэндлэх хүндлэх ёс – Зочлох ёс

Судалгааны явцад хамгийн их илэрсэн зүйл бол хүндлэл дээр суурилсан мэндлэх хүндлэх ёс, зочлох ёсонд ихээхэн үнэлэмж өгч үнэт зүйл болгож байдаг нь ажиглагдсан юм. Хүндлэх мэндлэх болон авгайлах ёсны талаар Увс аймгийн Завхан сумын иргэн Х.Цоозол гуай *Монгол зан заншил хүндлэх, мэндлэхээс эхэлнэ. Ахмад хүнийг нэрээр нь дууддаггүй. Аюуш гэдэг хүн байсан бол А багш гэх мэт дандаа тэгж хэлнэ. Одооны хүүхдүүд шиг шууд нэрээр нь хэлчихгүй. Ер нь настай хүмүүсээс нэлээн холоур явдаг. Настай хүн гэрт ороод ирэхлээр, “хүүхэд том хүний үг сонсож болохгүй, миний хүүхдүүд” гээд л гадаа гэр тойроод л байж байдаг байсан гэж ярьсан ба ахмад настнаа хүндэтгэх, нэрээр нь дуудахгүй товчилж дуудах, ах зах хүмүүсийг хүндэтгэн тэдний яриаг сонсдоггүй байсан* гэх зэргээр яриж байсан нь үнэт зүйлсээс төлөвшин гарсан хэм хэмжээнүүд бий болсон байдаг байна.

Түүнээс гадна хамаатан саднаа хүндэтгэх, зөв зүйтэй харилцах талаар өвөг дээдэс, ахмад үеэ, хамаатан саднаа сайхан хүндэлж яваарай, мэндтэй устай яваарай, зөв зантай, зөөлөн сэтгэлтэй байгаарай, битгий хүнтэй хэрэлдээрэй, зөв харилцаатай байгаарай гэдэг байлаа. “Чи зөв зантай, зөөлөн сэтгэлтэй явбал чиний үйлс бүтнэ” гэдэг байсан хэмээн судалгаанд хамардсан олон хүмүүс ярьж байсан юм.

Мэндлэх хүндлэх ёсыг эрхэмлэж байгаагийн өөр нэгэн жишээ бол Өндөр-Улаан суманд судалгаа хийж байх үед нутгийн малчин Мөнхбаатар өөрийхөн төрсөн Азарга багт орон нутгийн сонгуулиар Азарга багтаа олон хамаатантай нэг залуу нэр дэвшсэн боловч сонгогдож чадаагүй тухай тэрээр ярьж байсан билээ. Үүнд нь нам, сонгуулийн пр ажиллагаа зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байгаа боловч Мөнхбаатар ахын тайлбарлаж буйгаар тухайн залуу нь эхээс 10 гаруйлаа бөгөөд 7 гаруй нь Азарга багтаа одоо хүртэл амьдарч байгаа боловч уг хүн нь хүнтэй аятайхан мэндэлдэггүй, үг яриа зөрүүлж чаддаггүй тиймхэн хүн байдаг тул ах дүү нар нь хүртэл санал өгөөгүй илт давуу ялагдаж байсан гэж тайлбарлаж байв.

Өөр нэгэн жишээ гэвэл мөн л Архангай аймгийн Өндөр-Улаан суманд байх үед нэгэн айлын охин хөрш айлынхаа залуу өөрөөсөө 20 илүү ах аавыг нь үеийн юм шиг хүндэтгэлгүй хандаж, хоорондоо инээлдэн ярилцаж байхдаа хараалын үг ашиглан хэлж байхыг сонсоод уурлан хэрэлдэж байсан тухайгаа надад хэлж байсан билээ. Тухайн залуу нь тэрхүү харааж харьцсан хүнээсээ 20 гаруй дүү бөгөөд тэр хүнийхээ том хүүхэдтэйн жацуу нэг ангийхан хүүхэд байсан байна. Үүнээс харвал мэндлэх, хүндлэх ёс гэдэг нэг талаас нийгэм, соёлоос тогтсон үнэт зүйл болж байдаг бол нөгөө талаас хувь

хүний бусадтай хэрхэн харьцах харилцааны хэм хэмжээг тогтоож байдаг хэрэгсэл болдог нь харагдаж байна.

Мөн мэндлэх хүндлэх ёсноос гадна зочлох ёс нь Монголчуудын хувьд үнэт зүйл болж байдаг байна. Говь-Алтай аймгийн Бигэр сумын настан Х.Нансалмаа: Бусадтай сайхан харьцаж, хоол унд сайтай, сайхан угтаж байгаасай гэж боддог. Хүнд идээ тавьсан байсан ч ууттай нь тавих юм бол хүн хүрэхгүй. Сайхан задгай, дүүрэн байх юм бол буян нь хураагдаад л байдаг гэж байгаа юм. Тийм учраас хүнд аяга дүүрэн цай, таваг дүүрэн идээ тавьж байгаасай гэж хүсдэг хэмээн өөрийн үнэт зүйл нь зочиноо хүндлэн, зочилох ёс хэмээн тодорхойлсон билээ. Үүнтэй адилаар Цоозол гуай Монгол ёс заншил бол их зочломтгой. Ахмад настан, аав ээжээ хүндлэхээс эхэлнэ. Цайг дандаа хоёр гараараа өгнө. Би бол энийг яг монгол өв уламжлал гэж боддог гээд Увс аймгийн Завхан сумын зочлох ёсны хамгийн дээд илэрхийлэл бол:

Манай нутгийхан их зочломтгой, хүнийг их дайлж цайлдаг. Би яагаад зочломтгой гэсэн бэ гэхээр энэ зах зээлийн нийгэм эхэлсэн цагаас хойш тухайн нийгмийнхээ хөгжлийг дагаад явж байгаа зан заншил ёс суртахуун юм л даа. Гэхдээ тэр дотроо манай Увс аймаг бол Монгол соёлын зочломтгой зангаараа арай илүү юм уу гэж бусад газар явж байхад харагддаг. Манай нутагт суль, сулхир гэж юм гардаг. Манай нутгийн хамгийн идээний дээд ногоон цай гэж юм хийж өгдөг юм аа. Тэр манай зочломтгой хүндээ барих хүндэтгэлийн цай болж өгдөг хэмээн өөрсдийн нутгийн зочлох ёсонд ихээхэн ач холбогдол өгч байсан юм.

Тэрээр бидэнд нутгийнхаа зочлох ёсны онцлогийг тайлбарлаж өгсөн ба зочлох ёс нь аливаа нутгийн аж ахуй болон байгалийн онцлогтой шууд хамааралтай болох нь харагдаж байсан юм. Дээрх жишээ нь дээр авч үзвэл Увс аймгийн хувьд сулхиртай цай хэмээх цайгаар зочидоо дайлж цайлж байгаа нь харагдаж байгаа юм. Бид түүнээс нутгийнхан онцлог болох сулхирын ногоон цайг чанах аргыг хэлүүлж авснаа доор сийрүүлье.

Сулхирын ногоон цайг чанахдаа:

Суль, сулхир гэдэг өвсийг түүж авна. Жил болгон ургахгүй, ховор ургадаг. Хур бороо их орсон байвал намар 8 сараас эхлээд 10 сарын хооронд элсэнд ургадаг. Тэгээд л тэр хооронд 10 сараас эхлээд түүж эхэлнэ. Элсний томхон ширхэг шиг тиймэрхүү бор, шар өнгөтэй юм байдаг, сагсгар ургадаг. Том дэвсгэр дээр бухал шиг болгож бөөгнүүлээд тэрнийгээ цохино. Тэгээд тэрнийгээ уутанд хийж авна. Хогийг нь цэвэрлэнэ, элсийг нь цэвэрлэж угаагаад, хатааж байгаад хуураад, тээрэмдээд гурил болгоно. Дутуу тээрэмдэх юм уу, тариа шиг нүдээд ногоон цай гэдэг юм чанадаг. Тэрүүгээрээрээ цай чанаж гаргаад жаахан сүүл хийж жаахан хуурч байгаад, сайхан бургилуулж байгаад, 15-20 минут чанана. Бүр сайхан гоё амттай хийцтэй цай хийнэ гэвэл, сүүл дээр нь хийнэ. Ногоон цай гэдгийн учир нь сүлэх тусам ногоон өнгөтэй болдог. Шингэн цай хийвэл шар ногоон өтгөн цай хийвэл хар ногоон цай болно доо. Манай нутгийн ганц брэнд гэж ярьдаг. Бас ингэний хоормогоор их дайлна. Ер нь бүх үед л

ингэний хоормогоор зочилно доо. гэж ирсэн зочид, гийчиддээ олон шат дарааллаар бэлтгэсэн сулхирын цай чанаж өгөх тухай ярьсан юм.

Дээр өгүүлсэнчлэн зочлох ёс нь тухайн нутгийн онцлогоос хамааралтай байгаа юм. Бидэнд байгаа өөр нэгэн жишээ бол Архангай аймаг юм. Монгол орны төв хэсэгт Хангайн бүсэд хамаарах энэхүү аймаг нь өндөр уулсаар хүрээлэгдсэн өндөр уулсын бүсийн аймаг билээ. Тэр ч утгаараа сарлаг үхрийг Цагаан даваанаас баруун талын сумын малчид голлон малладаг билээ. Сарлаг үхрийн хувьд нутгийн малчдын хэлж буйгаар сарлагийн үнээ, Монголын үхрийн үнээтэй харьцуулахад сүүний гарц бага боловч илүү өтгөн тослог ихтэй байдаг байна. Тослог чанар өндөр өтгөн сүүгээр цагаан идээ борлуулах нь Архангай аймгийн бренд болсон байдаг ба цагаан идээгээр дайлж цайлах тэр дундаа ирсэн зочиндоо *гурилан тос хайлах* буюу *хайлмаг*-аар дайлах нь энэ нутгийнхны онцлог байсан юм. Хураасан өрөмөө зөөлөн галаар хайлуулан гурил хийж шар тосын ялгаж, улмаар элсэн чихэр хийж амталсанаар халуун, амттай хайлмаг бэлэн болох ба ийнхүү халуун хайлмагаар холоос ирсэн хүндтэй зочидоо заавал дайлах уламжлалтай байдаг байна. Энэ нь тэд зочидоо хүндэтгэж буй нь хамгийн тод илэрэл ба Архангай аймгийн Өндөр-Улаан суманд Сэлэнгэ аймгаас бэр болж ирсэн нэгэн бүсгүй манай нутагт зочин ирвэл хайлмаг хийж дайлна гэж байхгүй,

Монголчуудын хувьд хамгийн эрхэмлэж явдаг зүйл бол хүндлэх ёсны жишээ нь ахмад настнаа хүнлэх, мэндлэх, зөв боловсон харилцах, таваг дүүрэн идээ цагаа бэлтгэх, ирсэн гийчнийг өөрийн нутгийн онцлог хүнс, цайгаар дайлах зэргээр Монгол хүний онцлог, эрхэм зан чанарыг гаргаж ирдэг байна.

Биет өв соёл

Мал аж ахуй дээр суурилан малаас гарах ашиг шим, түүхий эдээс гарах бүхий л зүйлийг хэрэглэн хийдэг зүйлүүд нь Монголчуудын хувьд ямар нэгэн байдлаар үнэт зүйл болж байдаг байна. Тэдгээр нь аж ахуй, соёл дээрээ суурилан Монгол хүний арга ухаанаар бүтээгдсэнээрээ үнэ цэнтэй болж байгаа ажээ. Үүнд хамааруулан Монгол дээл хувцас, ахуйн эдлэл хэрэглэл, хөгжим зэргийг дэлгэрэнгүй авч үзэх болно.

Увс аймгийн Ховд сумын иргэн Цэрэнчимэд нүүдэлчин хүн гэдэг өв соёл бол бүхий л амьжиргааны төрөл бүрийн хэрэглэгдэхүүнээ ашиглаж өөрийн нөөц боломжоороо бүх юмаа өөрсдийн арга ухаанаар хийдэг гэж ярьсан билээ. Түүнийхээр өв соёл бол “бичигдээгүй хууль” ажээ.

Монголын энэ цэнхэр доор төрсөн хувьтай хүмүүс учраас онцлогтой. Өөр өөрсдийн арга ухаанаар амьдардаг. Олон зуун жил амьдарч ирсэн түүхтэй бас их сайхан хүмүүс л дээ. Тэр утгаараа өөр өөрсдийгөө ерөөсөө яаж ийгээд л бүгдийг болгодог. Монгол хүний амьдарч байгаа орчин, нэн ялангуяа энэ хөдөөгийн орчин. Тэрэнтэй уялдаад тэр хүний хийж бүтээх юм нь өөрийн сэтгэлгээгээр хийдэг, оюун ухаан нь тэр хэмжээгээр хөгжсөн ийм л онцгой чанартай хүмүүс л дээ. Морион сургаад унаж байна, хувцсаа хийгээд өмсөж байна.

Үүнээс ажин үзвэл Монгол хүний амьдарч байгаа орчин нөхцөлтэй уялдан мөн түүн дээрээ суурилан ахуйн эдлэл хэрэглэл, өмсөх хувцасаа бүтээдэг болох нь харагдаж байна. Үүнтэй ижил Увс аймгийн Улаангом хотын иргэн Д.Гүнчин:

Цагаан хөдсөн дээл өмсдөг байсан. Хонины арьсаар хийдэг, зун ямааны арьсаар дээл хийгээд 2 талаар нь өмсдөг байсан. Тэрийг өмсөхөө болиод 40-өөд жил болж байна. Тэгээд тойруулаад хоргойгоор юм уу, илгээр эмждэг байсан. Эрэгтэй эмэгтэй ялгаатай. Эмэгтэйг дээлийг цэгдэг гэдэг. Хотон хүн бас цэгдэг, тэрлэгтэй, цачмаг гэж бас байдаг. Нэг талдаа гурван алчууртай. Нэгээр нь гараа арчдаг. Нэгээр нь аягаа арчдаг, нэгээр нь хөлсөө арчдаг тийм тооцоотой байсан. Дээл хийхдээ тэр арьсыг элдээд, утаад утаа оруулна, халиаж (илүү арьснаас гарсан махыг авах, цэвэрлэх) байгаад дотроос нь хөвөрдөнө. Дотно талд нь ярж байгаад тэгж хөвөрддөг. Утахаар бороо ус сайн даадаг болдог гэж хонь болон ямааны арьсаар хөдсөн дээл хийж өмсдөг байсан тухай ярьсан юм. Хөдсөн дээлийг 1980-аад оноос хойш хийж өмсөхөө больжээ. Малын арьсаар хийдэг байсан нь өөрсдийн эрхлэх аж ахуй дээр тулгуурлан, өөрсдийн оюун ухаан, арга ухаанаар хийдэг гэсэн Цэрэнчимэд гуайн мөнхүү яриатай нийцэж байна. Дээл хувцасны жишээн дээр нэмэн өгүүлэх өөр нэг зүйл бол нутаг нутгийн онцлог хувцас гэж Увс аймгийн Завхан сумын иргэн Х.Цоозол:

Монгол үндэсний хувцас хамгийн гоё. Яг нутаг нутгийн заншилын хувцас их гоё. Монголын соёл бол дээр үеэс уламжилж ирсэн хувцас хунараас авхуулаад зан заншил ордог байх даа. Манай суманд бол голдуу Дөрвөд, Халх, хүмүүс байдаг. Дөрвөд хувцас гээд гоё цэгдэгтэй хувцас байдаг. Халх хувцас гэж манайхан тоорцог дээлээрээ л гоёдог доо. Дөрвөд хувцас бол их тусгай гоё. Цэгдэг гэж байдаг. Тэр их гоё харагддаг, малгайтай гэж Дөрвөд дээлний Монгол дээлнээс ялгарах онцлогийн талаар дурдсан билээ. Түүнээс гадна Увс аймгийн Тариалан сумын хөгжмийн багш З.Замбалов Хотон хувцасны онцлогийн талаар дэлгэрэнгүй тайлбарлаж өгсөн юм.

Хотон хувцас байна л даа. Одоо бол энгийн үед өмсөхгүй, тайзны чиглэлд л өмсөнө. Биелгээгээ хийхдээ л өмсөөд байна. Эрэгтэй нь хар эмжээртэй цагаан дээл, далтай юүдэн малгай өмсөнө. Эмэгтэй нь хар өнгийн дээл өмсөнө. Эмжээр нь улаан, шар байна. Хажуу талдаа алчууртай. Гар, нүүр, аяга шаазангаа арчина. Хотон хувцасны бас нэг онцлог нь “цэгдэг”, “цачмаг” гэж байна. “Тэрлэг” гэж байна, тэр нь дотор талын дээл. Эмэгтэй дээл бол ийм 2 юмнаас бүтэж байгаа юм. Эмэгтэй хүний хувцасны онцлог нь цачмаг гээд үсээ хийдэг тахим хүртэл урт зүйл байна. Дээр үед хамгийн үнэтэй тэмээ, бодоор худалдаж авдаг байсан. Тэрийг одоо бол шүр хуваар, дээр үед бол сувд гэх мэт янз бүрийн үнэт зүйлийг хэлхээд хийсэн байдаг

Тариалан суманд ихэвчлэн Хотон үндэстнүүд амьдарна. Замбаловын хувьд 2010 онд Соёлын дээд сургуулийг дүүргэсэн учир өөрийн үндэсний хувцас болоод бусад соёлынхоо талаар маш дэлгэрэнгүй мэдэж байлаа. Түүнийхээр өв соёл бол бусдаас ялгарах онцлог, энэ уламжлагдаж ирсэн зүйлээ өвлүүлж үлдээх нь амин чухал гэсэн юм.

Ахуйн эдлэл хэрэглэлийн жишээнд Увс аймгийн Завхан сумын иргэн Х.Цоозол өөрийн нутгийн онцлогтой уялдуулан тэмээний ноосоор хийх эдлэл хэрэглэлийн талаар

өөрийн арвин мэдлэг туршлагаас хуваалцсан юм. Хяргас нуураас урагш 70 километр орших Завхан сум бол гурван удаа түмэн тэмээний баяр хийж байснаараа алдартай, тэмээний өв соёлоор гайхагдсан сум юм.

Олс дээс, гэрийн бүслүүр, оосор, бүч бүгдийг нь хийнэ. Тэмээний зогдороор утас хийнэ. Утсаараа гэрийн эсгий, дээвэр, туурга оёдог. За тэгээд зээг хийж болно. Унины сагаг гэж байдаг тэрийг, ер нь монгол гэрт юу ордог тэр бүгдийг тэмээний ноосоор оролцуулж хийнэ. Зээг гэдэг нь зөв алгадаж, буруу алгадаж хийдэг, дээвэр туурган дээр хосолж барьж хийдэг, оосрыг хэлдэг. Тэмээний ноосоо сайхан угаагаад, угаасан ноосоо сайхан сэмлэж байгаад түүдэг гэдэг юм хийгээд алгадна даа. Алгадаад урт нарийн эсгийн дээрээ тавьж гэрийн туурга дээвэр, өрх бүгдийг нь зээглэж өгдөг. Тэгээд Монгол гэрийн сайхан дээвэр туурга, өрх гэдэг юм болдог. Бас хаяавчаа ширж хийнэ. Тэмээний ноосоор утас хийгээд хаяавчаа ширж (хээ угалз гаргаж) өгнө. Тэмээний ноосноос гадна тэмээний сүүгээр манайд айраг хийнэ, айргаа исгээд аарц хийж болно, ааруул, шимийн архи гарч болно. Ер нь л малаас ямар ашиг шим гарах уу тэр бүгд тэмээнээс яг л тэр хэмжээий бүх ашиг шим гарна

Эндээс харвал өв соёл гэдэг таван хошуу малаа л бүрэн ашиглах, үүнээсээ улбаалан ахуйн эд, эдлэл хэрэглэлээ хийдэг дээрх түгээмэл жишээнүүдтэй дүйж байна. Уг жишээтэй адил Баян-Өлгий аймгийн Өлгий хотын өндөр настан Н.Бааст гуайг авч үзвэл тэрээр залуугаасаа адууны бүхий л тоног хэрэгсэл, ахуйн бүхий л зүйлсээ өөрөө хийдэг байжээ. Өдгөө 86 настай, нүд нь аль хэдийн юм үзэхээ байсан хэдий ч өдөр тутамдаа олон зүйл хийдгээ хуваалцсан юм. Би өдөр тутамдаа малын сур элдэж жилдээ 2 үхрийн арьсаар чөдөр тушаа, морины олом, жирэм, цулбуур, хазаар хийдэг, түүнээ бас хэд гурван цаасаар өгчихдөг. Нүдний барагцаагаар хийгээд дадчихсан учраас ингээд хийдэг дээ. Бааст гуайн хийдэг зүйлсийг харвал үхрийн сурыг ашиглаж адууны тоног, хэрэглэл хийдэг нь өөрсдийн нөөц боломжийг ашиглах нэгэн хэлбэр болох нь харагдаж байлаа.

Хөгжмийн жишээнд Хотон ястны онцлог хөгжим болох ясан лимбэ, ихэл, товшуурын талаар авч үзэх болно. Энэ хөгжмүүдийн талаар Увс аймгийн Тариалан сумын хөгжмийн багш З.Замбаловын ярьснаар:

Малын ясаар лимбэ хийгээд язгуур урлагт ашигладаг тийм зүйлүүд байна. Сүүлийн үед бас цуур хөгжим хөгжиж эхэлж байна. Товиуурыг бас яг ихэлтэйгээ адилхан хэрэглэнэ. Ясан лимбийг бол сүүлийн үед л хийж байгаа. Малынхаа чөмгийг цэвэрлээд ясаар лимбэ хийнэ. Цуур бол Ховд аймгаас гаралтай ч манай нутгийн онцлогт тохироод байна л даа. Яагаад гэхээр цуур бол хад асгатай газрын уулын цуурайтсан дуунаас үүсэлтэй. Манай нутаг бас уулын бүсэд байдаг хатуу ширүүн урсгалтай голтой. Нутгийн онцлог бас нөлөөлж байна л даа. Тэгээд тэнд тохирсон хөгжим түлхүү хэрэглэх нь ихсээд байна уу гэж ажиглагдаж байна. Хүмүүст бас нутгийн онцлогоос шалтгаалаад сурахад амар байна уу гэж харагдаж байна. Товиуур болохоор яг ихэлтэйгээ адилхан хөглөгдөнө. Бас хоёрхон утастай. Хуурын симчек байхгүй. 2 хуруугаараа

татаж тоглоно. Товшуурыг болохоор ихэвчлэн магтаар (магтаал) дуу, тууль, ерөөл хайлахад хэрэглэнэ.

Энд дурдагдсан хөгжмүүдийг харвал улмжлалт ихэл, товшуураа хэрэглэхээс гадна сүүлийн үед малын ясыг ашиглаж лимбэ хийх, Ховд аймгаас гаралтай цуур хөгжим эдний нутаг усны онцлогт тохирч байгаа учир уламжлан авч хөгжүүлж буй ажээ.

Дээрх жишээнүүдийг нэгтгэн үзвэл малын арьсаар дээл хувцсаа хийх, нутаг нутгийн онцлогийг шингээн урлах, аль олон өсгөж буй мал дээрээ суурилан түүнээс гарах ашиг шимээр ахуйн эдлэл хэрэглэлээ хийх, жишээлбэл үхрийн арьсаар адууны тоног, хэрэгсэл, тэмээний ноосоор олон төрлийн зүйлс хийх, өөрийн үндэстэн, байгаль, газар нутагтаа тохируулан шинэ хөгжмийг нутагшуулах зэрэг бол мал аж ахуй дээр суурилсан Монгол хүний арга ухаанаар бүтсэн үнэт зүйлийн илэрхийлэл байна.

Монголчуудын ёс суртахуун: Монгол байх –Хүний мөстэй байх ба Тусч эрхэм чанар

Энэ хэсэгт Монгол байх ба хүний мөстэй байх зэрэг Монгол хүний эрхэмлэж явдаг зан суртахуунуудын тухай голчлон авч үзсэн билээ. Нүүдэлчин Монгол хүн байх ба орчин үеийн залуучууд, хүүхдүүдийн хоорондох ялгарч буй хүмүүжлийн ялгаа заагийн талаар энд авч үзсэн болно.

Уламжлалт гэх юм уу ойлголтоор авч үзвэл дээр өгүүлсэнчлэн Монгол хүн гэдэг мэндлэх, хүндлэх ёсыг эрхэмлэн авч үздэг нь батлагдсан билээ. Гэтэл орчин үед залуучууд барууны соёлын нөлөөгөөр энэхүү эрхэм чанараа алдаж байгаа буюу Монгол хүний ёс суртахууны алдаж байгаа хэмээн судалгаанд оролцогчид үзэж байгаа нь харагдаж байсан. Баянхонгор аймгийн Баянбулаг сумын иргэн Пүрэвсүрэн орчин үеийн залуучууд Монгол ёс заншилаа алдаж байгаа тухай авч бидэнд нэлээд шүүмжлэлтэй хэлж байсан.

Мөн хүүхдийн хүмүүжлийн жишээн дээр ажиглагдаж буй зүйл бол глобалчлалын нөлөөгөөр гар утас, компьютер, машин мотоцикл зэргийг хэрэглэх болсноор хүүхдүүд малаас хөндийрөх болсон талаар олонтоо дурдагдсан юм. Хүмүүсийн ярьж байгаагаар хаа сайгүй хөдөө мал маллах хүүхэд олдохоо больжээ. Үүнийгээ дагаад мал ахуйтай холбогдсон бусад соёл ч орхигдох тийшээ хандах болсон байна. Малаас хөндийрснөөр хүүхдүүдийн харилцаа хүмүүжилд гарсан өөрчлөлтүүдийн талаар Говь-Алтай аймгийн Бигэр сумын иргэн Г.Нансалмаа ярьсан юм.

Сайн байна уу? гэж мэндэлдэг хүүхэд алга байна. Юу байна? гэж асуух юм. Сааль хийх хүүхэд алга. Юмаа мэдэхгүй. Хөгичүүл нь харилцаа сайтай байна. Одооны хүүхэд бол “бууралдаа юм аваад ир” гэхээр “завгүй” гэж хэлээд утас оролдоод сууж байна. Ер нь хүмүүжил алга. Хүнийг хүндлэхгүй байна. Хөдөөний хүүхэд хамаагүй зөөлөн чихтэй байдаг. Хотын хүүхэд ороо хураахгүй яваад өгнө. Хөдөөний хүүхэд нүүрээ угаагаад ороо хураагаад малдаа гардаг тийм гоё.Одоо хүний амьдрал бэлэнчлээд сурчихсан байна. Дээр үед тэмээгээ хөтлөөд нүүдэг, морио унадаг, алхдаг байсан. Би гэхэд өрхөө өөрөө оёчихдог байлаа. Одооны охид, хүүхнүүд өрхөө өнгөлөхгүй байна. Утсаар тоглоод л, машин унаад л, телевизор

үзээд л сууж байна. Би бол монгол хүний эрхэмлэх ёстой зүйлийг таван хошуу малаа л гэж боддог

Түүний ярьсан жишээг харвал орчин үежилтийн нөлөөгөөр хүүхдүүд малаас илүү техник технологитой ойр болж ахмад настнаа мэндлэх, хүнлэх ёсноос эхлээд, аж ахуйн бусад соёлууд алдагдаж байгаа нь харагдсан юм. Мөн хотын хүүхдүүдээс хөдөөний хүүхэд илүү ажилсаг байна гэж байгаа нь нөгөө төлөөр мал аж ахуй нь хүүхдийг хүмүүжүүлэх чухал хүчин зүйл болохыг илэрхийлж байна. Үүнтэй яг адил зүйл ярьсан хүн бол Увс аймгийн Завхан сумын настан Б.Янжив хүүхдүүд гар утсанд маш их цаг зарцуулах болсон талаар ярьсан билээ.

Тэр зан суртахууныг л хадгалж үлдэх хэрэгтэй л дээ. Ойлгохгүй байна аа. Бид нар хэлээд л байх юм, хийгээд л байх юм. Хэлээд байхад ерөөсөө ойлгохгүй юм. Одоо хүүхдүүд утасны хоббитой болсон байна. Энэ утас гэдэг юм, тоглоом гэдэг юмыг нь болдогсон бол устачихмаар л байх юм. Хүүхдүүд утсанд донтоно гэдэг юм нь болж байна аа. Сүүлийн үед залуучууд архи дарс уугаад л, хэрэг төвөгт холбогдоод л янз янзын юм болоод байна л даа. Мотоцикл машинтай яваад, хөл гараа гэмтээж байна. Дээр үед бол тийм юм байгаагүй шүү дээ. Том ах хүнээс айдаг, үг дугардаггүй тийм байсан. Одоо ерөөсөө хүүхдийн хүмүүжил бидний сэтгэлд таарахгүй байна. Хүүхдийн эрх, хүний эрх гэж гараад ирсэн тэрнээсээ болж хүүхэд хүмүүжил муутай боллоо гэж би дотроо боддог.

Янжив гуайн яриаг нягтлан харвал хүүхдүүд гар утасны тоглоом маш их тоглох, машин мотоциклоос болж бэртэж гэмтэх, ах зах хүнээ хүндэлэхээ больсон тухай байсан нь дээрх орчин үежилт болон малаас хөндийрөлтөөс үүдсэн гэсэн жишээтэй нийцэхээс гадна Хүний эрх, хүүхдийн эрхтэй холбон ярьж байсан юм. 1990 оноос хойш манай улсад Хүний эрх түлхүү яригдаж эхлэх болсон нь мөн л глобалчлалын нөлөө болов уу гэж бодож байна. Үүний нөлөөгөөр хөдөө гарч мал маллах хүүхэд ховордож хөдөө хамгийн залуу малчид 30-40 насны хүмүүс байгаа талаар Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын малчин Лхагвасүрэн ярьж байлаа.

Намайг бага байхад ямар сайхан байсан гэнэ. Одоогийнхтой яаж харьцуулхав. Одоогийн хүүхдүүд маш залуу болчихсон, маниусын үед өглөө 6-д босоод л, саалиа аваад, малаа дагаж хариулаад л янзын сайхан байсан. Тэгэхэд одооны хүүхдүүд сааль сүүгээ авахгүй нь элбэг. Бас дээр нь хөдөө хүүхэдгүй болсон юм л даа, бидний үед хүүхэд ихтэй байсан. Энэ хавиар залуу малчид нэг үеэ бодвол их болсон, гэхдээ хүүхдүүд нь жаахан. Яахав залуу малчин гээд байгаа нь 30 гарсан, 40 гарсан хүмүүс байгаа.

Дээрх ярианаас харахад хүүхдүүд ахуйн ажилд илт хойрго болж, хөдөө ажиллах хүчний дутагдалд орж байгаа нь ажиглагдаж байлаа.

Глобалчлал болоод хүний эрхийн нөлөөгөөр жилээс жилд цэрэгт ирж байгаа залуучуудын чанар муудсан тухай Баян-Өлгий аймгийн Өлгий хотын иргэн Х.Өлзийсайхан социализмын үе болоод ардчилалсан хувьсгалаас хойших цэргүүдийн өөрчлөлтийн талаар маш дэлгэрэнгүй яриа өгсөн юм. Өлзийсайхан ах бол 1992 онд Москва хотын Хилийн цэргийн командын дээд сургуулийг төгссөнөөс хойш Баян-өлгий

аймагт дэслэгч цолтой заставын орлогчоор томилогдож ирж заставын орлогч, заставын дарга, заставын офицер, заставын ахлах офицер хийж байгаад Ховд аймаг руу шилжээд Ховд аймгийн Үент суманд даргын орлогч, хилийн тануулын тасгийн дарга, даргын орлогч, хийж байгаад Баян-Өлгий аймагт буцаж ирээд хилийн боомтуудаар ахлах ажилтан хийж байгаад 2014 онд тэтгэвэрт гарсан байна. Тэрээр насаараа хилийн боомт дээр цэргүүдтэй ажилласнаас гадна тэтгэвэрт гарснаасаа хойш ахмадын хороонд шинэ цэргүүдэд сургалт, семинар орох байдлаар цэргүүдтэй ажилласаар байгаа юм.

Одооны залуучуудын хамгийн гол юм нь цэцэрлэгийн наснаас нь авхуулад маш буруу хүмүүжсэн. Бид нар дээр үед “таван салаа боов” гээд авдаг л байлаа. Бид нарт муудсан юм байхгүй. Сургуульд явахад бас эцэг эх нь хүүхдэд юм хэлэхгүй. Ийм маягаар хүүхдийг бөмбийлж явсаар байгаад сайн сурсан ч юм биш. Цэрэгт сайн боловсролтой, мөнгөтэй хүний хүүхэд ирэхээ больчихсон. Тэгээд ядарсан хүмүүсийн, борчуулын хүүхдүүд ирдэг болчихсон. Тэгээд багаасаа тийм суурьтай хүүхэд цэрэгт ирэхээр үг даахаа байсан. Энд ирэхээр армийн амьдрал өөр, тэр зангаараа байх гээд байдаг. Сүүлийн үед “1 жилийн цэрэг, цэцэрлэгийн хүүхэд адилхан боллоо” гэж онигоо яваад байгаа. Ийм маягаас болоод залуучуудын чанар муудаж байна. Утас, компьютер тоглоно, идэж ууж байгаа юм нь бэлэн юм, хийжүүлсэн ундаа. Энэ бол нэлээн нөлөөтэй. Жил ирэх тусам намхан цэргүүд, ачаалал дааж чадахгүй, ядардаг, няцдаг болоод баайна. Яахав тэрэн дотор сайхан залуучууд ирнэ. Бүгд тийм биш. Тэрэнд аав ээжийн л хүмүүжил байна. Ийм ийм зүйлээс болоод цэрэгт ирж байгаа залуус нялцгардуу, хэт хүний эрх ярьдаг болчихсон байна. Бид нар социализмын үед 1977-1987 онд хүмүүжсэн. Бид нар чинь баатарчууд, пионер, эвлэлээр нь дамжсан хүмүүс. Бид нарт тэгэх ёстой, ингэх ёстой л гэсэн ганцхан зарчим байлаа. Багийн өмнөөс хамаагүй үг хэлж болохгүй. Юу ч байсан багш нарын зөв. Захиргаадалтын ч үе байсан. Чи ингэж сураад ингээд явах ёстой л гэсэн нэг л шугамаар байлаа. Тэр ангийн багш нар, эвлэлийн хороон дарга нар хүний төлөө маш сайн явдаг байсан. Зарим нэг багш нарт алгадуулах, зодуулах үе гарч л байлаа. 1992-1997 онд хөдөөний бадриун, үг даадаг, хүдэр чийрэг, юм хэлдэггүй, тиймэрхүү нөхдүүд байлаа. Тухайн үедээ хамтраад л юмаа хийгээд л сүүлдээ гүйцэгдэхгүй болно. Тэгж өөрийгөө дайчилдаг, цасанд явган үүрэг гүйцэтгэнэ, морь малтайгаа харьцаад биеэ даагаад явчихдаг цэргүүд байсан. Одоо шаардлага сулраад хүний эрх гээд хийлгэх юм нь багасаад улам суларсаар байна. Дарга нар нь ч цэргээс айгаад шаардлага тавихаа больчихож.

Өлзийсайхан ахын яриаг шинжилж үзвэл түүний хамгийн анх ажиллаж байсан 1992-1997 оны цэргүүд болон түүнээс хойш цэрэгт ирэх залуусыг харьцуулахад сүүлийн үеийн цэргүүдийн чанар бүх талаар муудаж ачаалал даахаа больжээ. Чанар муудсан гэдэгт орчин үежилтийн нөлөөтэй техник технологийн хэт их хэрэглээ, хүмүүжилгүй болох, буруу хооллолт, эрүүл мэндийн хувьд улам дорой болох, хэт их Хүний эрх ярьдаг болсон зэргийг хамруулсан юм. Ингэж чанар муудсан учраас дарга нар ч цэрэгт хатуу шаардлага тавихаас эмээх болжээ. Глобалчлалын нөлөөгөөр өөрчлөгдсөн өөр нэг зүйл бол Монгол хүний хамгийн эрхэм чанарын нэг хүн чанар байлаа.

Тусч чанар гэж Монгол хүнийг тодорхойлж буй энэ чанар малчин Монголчуудын хувьд хамгийн үнэ цэнэтэй ажээ. Учир нь нүүдэлчдийн амьдралд айл хоршоо, саахалтын харилцаа холбоо их нөлөөтэй юм. Мал маллах бол нэгэн айлаас гадна олон өрх айлын хамтын хөдөлмөрөөр бүтдэг байна. Сүүлийн үед энэ чанар ховор болж байна гэж судалгаанд оролцогчид хэлж байсан нь хүмүүс малаас хөндийрч буйг харуулж байлаа.

Тухайлбал Увс аймгийн Ховд сумын иргэн С.Гансүх:

Сүүлийн үеийн залуучууд зан харилцааны хувьд их өөр болсон. Дээр үед айл хоршоо байж байхад “танай мал энд байна”, “тэнд байна” гээд хэлдэг байсан. Одоо иймэрхүү юм ховорхон шүү дээ. Угаасаа монголын өв уламжлал гэж юм алдагдаад байгаа. Сүүлийн үеийн хүүхдүүд тийм юм жаахан хомсхон л болоод байгаа юм л даа. Нэг мал байвал дөхүүлээд өгдөг байсан. Соёлоо дагаад тэгдэг юм уу мэдэхгүй юм. Хүний зан чанар гэдэг юм чинь муудаад байгаа юм л даа. Би өөрөө л болж байвал болж байдаг, бусад нь хамаагүй. Гэхдээ яахав саахалт хоршоо байгаад тусладаг амьтан зөндөө л дөө. Тэгээд бас залуучууд малаас жаахан хөндийрч байна л даа. Мал малладаг хүүхэд ер нь ховор болоод байна шүү гэсэн дээрх санааг баталж байна.

Үүнтэй ижил зүйл ярьсан хүн бол мөн Ховд сумын иргэн О.Мөнхбаяр байв.

Анх дээр үеэсээ сэтгэл нь маш сайхан байсан. Одоо харьцаа, айл хоршоо байхад хоол цай авч ирээд өгөх, нэгэндээ туслах жишээтэй. Хүний чанар гэдэг зүйл маш өндөр байсан. Харин сүүлийн жилүүдээс хүн чанар гэдэг зүйл нь нийгмээ дагаад ч юм уу муудаад хүн хүндээ итгэх итгэл алга болсон. Жишээ нь одоо нэг ажил хийхээр болвол хуурмаг юм хийх ч юм уу мөнгөний төлөө, яг сэтгэлээрээ хүнд тусалъя гэсэн сэтгэл алга болчихсон. Нэг ёсондоо зах зээлд шилчихсэн. Би бол гэр бариад өгөөч гэвэл мөнгө нэхэхгүйгээр шууд очиж тусална. Ганицхан манай ард түмэн дээр үеийнх шигээ хүн чанар сайтай, харьцаа сайтай л байвал их сайн байна. Дээр үед хар буруу санаа байдаггүй байлаа. Одоо бол мөнгө л олж байвал юу ч хамаа байхгүй мэт болчихсон. Бас байгаль орчноо яг байгаагаар нь авч үлдээсэй тэгвэл ан амьтанд ч ээлтэй, үр хүүхдэд ч үнэт зүйл нь болох юм аа.

Дээрх хоёр хүний ярианаас үзвэл зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш хүмүүс илүү хувиа бодох болж нэг нэгэндээ тус болох нь багасчээ. Тусч чанар гэдгийг сайхан сэтгэл, хариу нэхэхгүй тус, аливаа зүйлийг чин сэтгэлээсээ хийх, зан харилцаа сайн байх гэж тодорхойлсон юм. Миний хувьд хүн чанар алдагдаж буй нь малаас хөндийрснөөс үүдэлтэй гэж үзэж байна.

Эдгээр жишээнүүдийг нэгтгэн үзвэл монгол хүнийг монгол хүн болгож байгаа хүмүүжил болоод тусч чанар гэдэг ойлголтууд техник технологийн хөгжлийн үр дүнд залуучууд малаас холдсоноос мөн глобалчлалаас үүдэлтэй Хүний эрх их яригдах, бусад гадны соёлын нөлөөллөөр алдагдаж байгаа бололтой.

Бүлгийн дүгнэлт

Дээрх бүгдээс нэгтгэн харвал Монгол Улсын хувьд засгийн газрын зүгээс Монгол хэл, түүх, соёл 3 зүйл дээр тулгуурласан үндэсний үнэт зүйлсийг бий болгож, түүгээрээ

эх оронч Монгол хүн, нэгдмэл нэгэн Монгол Улсыг бүтээхэд чиглэсэн бодлого баримталж байгаа нь харагдаж байна. Үүнийгээ хэрэгжүүлэхдээ Монголын Соёл Урлагийн Их Сургууль зэрэг судалгааны институци болон эрдэмтэн судлаачдыг ашиглан үндэсний зүйлийг бүтээж, түүнийгээ төлөвшүүлж байгаа юм. Харин “үнэт зүйл” нь хувь хүний төвшинд тухайн хувь хүний сэтгэл, итгэл үнэмшлийн илэрэл гэдэг нь харагдаж байгаа юм. Аливаа хувь хүн нь ямар нэгэн зүйлийг хэрхэн үнэлж түүнд эерэг болон сөрөг үнэлэмж өгч байгаа асуудал юм. Монголчуудын хувьд олон мянган жилийн турш эрхлэн ирсэн нүүдлийн мал аж ахуй, соёл нь хувь хүний төвшинд зан суртахууныг нь хүртэл төлөвшүүлдэг ба нөгөө талаар хувь хүний өөрөө өөрийгөө бүтээхдээ үнэт зүйлийг ашигладаг хэрэгсэл болох нь харагдаж байна.

Хоёрдугаар бүлэг: Өвөр Монголын нийгэм, соёл дахь “үнэт зүйлс”

Тус бүлэгт бид Өвөр Монголын² нийгэм соёлын доторх “үнэт зүйл” гэх ойлголтын тухай судлах болно. Ингэхийн тулд асуудлыг хоёр хэсэг болгож авч үзэх бөгөөд нэгд, төрийн бодлого дунд “үнэт зүйл”-ийг хэрхэн тайлбарлаж буйг авч үзэх болно. Өөрөөр хэлбэл, хятадын засгийн газар эсвэл Эв хамт нам “дундадын үндэстэн” байгуулах бодлого дотроо ямар ямар “үнэт зүйл”-ийг ард түмнийг чухалд үзэхийг уриалж байгаа байдлыг судалсан гэсэн үг. Харин тус бүлгийн хоёрдугаар хэсэгт, Өвөр Монголын монгол үндэстний дотоод гэр бүл эсвэл хувь хүний түвшинд үнэт зүйл гэдгийг хэрхэн ярьдаг тухай авч үзнэ. Өөрөөр хэлбэл, ардын өөрийн талбарт “үнэт зүйл” гэдгийг хэрхэн ойлгож, хэрхэн өөрийн хувь хүний болон гэр бүлийн талбараа бүтээж буйг судлах юм.

“Дундадын үндэстэн” ба “үнэт зүйлс”

Энэ хэсэгт бид БНХАУ-ын төрөөс хэрэгжүүлж буй үндэсний олон талт бодлого дунд “үнэт зүйл” буюу “jiazhi”³ гэх ойлголтыг хэрхэн тайлбарлаж, чухалчилж байгааг өгүүлэх болно. Гэхдээ түүний өмнө хятадын төрийн тогтолцооны тухай товч үзье. Учир

² Өвөр Монгол гэдэг нь Чин гүрний үеийн Өвөр Монгол гэсэн товчлол юм. Өвөр Монголын Өөртөө Засах Орон нь 1947 оны 5-р сарын 1-нд Вангийн сүмд (одоогийн Улаанхот,) байгуулагдсан бөгөөд энэ нь Хятадын хамгийн эртний үндэстний цөөнхийн өөртөө засах орон юм. Нийт 1.183 сая хавтгай дөрвөлжин километр талбайтай тус улсын бүх мужуудын дунд гуравдугаарт, Шинжаан, Төвдийн дараа ордог. 2015 онд нийт дүүргийн хүн ам 25.1104 сая хүн амтай байсан. БНХАУ-ын хойд хил дээр, баруун хойд талаараа Монгол, Орос улстай хиллэдэг. Монгол, Хан үндэстэн хамгийн том бөгөөд Солонгос, Хотон, Манж, Дагур, Эвэнки, Орчон болон бусад үндэстэн ч бий. Бүхэл бүтэн дүүрэг нь мужийн түвшний 9 хот, 3 аймагт хуваагддаг бөгөөд мужийн түвшний 12 хот, 17 муж, 49 хошуу, 3 автономит хошууг удирддаг. Нийслэл Хөх хот. Бугат, Чифэн, Улаанхот, Улаанхад, Ухай, Хөлөнбуйр, Тунляо, Ордос зэрэг нь өөртөө засах орны гол хотууд юм.² Нутаг дэвсгэр бүхэлдээ тэгш өндөрлөг газар давамгайлж, ихэнх нь далайн түвшнээс дээш 1000 метрээс дээш өндөрт орших тул Өвөр Монголын өндөрлөг гэж нэрлэгддэг. Гол нуруу нь Их Хянган, Алашаа уул, Вула уул, Далан хар уул юм. Зүүн талаараа өргөн уудам тал нутаг, баруун талдаа цөл талтай. Хөлөн нуур, Хонх нуур зэрэг алдартай нуурууд байдаг бөгөөд энэ нутгийн баруун урд талаас Шар мөрөн урсдаг. Энэ газар нь эх газрын сэрүүн бороотой уур амьсгалтай, өргөн уудам нутаг дэвсгэртэй учир өөр өөр газар нутаг их ялгаатай, ихэнх нутаг дэвсгэр дөрвөн улиралтай, зун нь богино, өвөл нь урт, харьцангуй хуурай, хүйтэн байдаг. Жилийн дундаж температур 1-10 хэм, хур тунадас 50-450 мм орчим байдаг. Газрын ховор элемент, нүүрс, мөнгөний асар их нөөцтэй 60 гаруй төрлийн ашигт малтмалын ордууд батлагдсан. Бэлчээрийн талбай нь хятад улсад дээгүүрт ордог бөгөөд Их Хянганы ойн бүс дэх модны нөөц харьцангуй их юм. ӨМӨЗО-ны аж үйлдвэр БНХАУ байгуулагдсаны дараа эрчимтэй хөгжиж, уул уурхай, төмөрлөг, газрын ховор элементийн үндсэн салбар болох ноос ээрэх, ойн аж ахуй, машин механизм, хүнс, барилгын материал, химийн үйлдвэрүүд бүх талаар хөгжсөн. Энэ нутаг нь улсын нэг чухал мал аж ахуйн бааз юм. Бэлчээрийн нутгийн бэлчээр элбэг. Гурван голын адуу, гурван голын үхэр, Өвөр Монголын нарийн ноост хонь бүгд алдартай үүлдэр юм. Газар тариалангийн бүсүүд нь зүүн өмнөд хэсэгт байрлах Бор тохойн тэгш тал, уулархаг хөндийд төвлөрч, улаан буудай, төмс зэрэг үр тариа, маалингийн болон чихрийн нишингэ зэрэг бэлэн үр тариа үйлдвэрлэдэг.

³ Шиюань Хао энэ хөтөлбөрийг Хятад шиг олон үндэстний улс-ын хувьд агуу ач холбогдолтой бөгөөд соёлын олон янз байдлыг "эв нэгдэлтэй соёл" болон "бүтээлч үржүүлгийн газар"-ыг бий болгоход чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Харин Майкл Гоу(2017) хятадын засгийн газар эдийн засгийн ашиг сонирхолдоо соёлын хүчийг ашиглаж байна гэж хэлсэн байсан. Тэгвэл Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааныхан бол засгийн газар барууны соёлын давамгайлалын эсрэг үйлдэл гэж онцолдог. Гэтэл Frank N. Pieke мэтийн барууны эрдэмтэд эдгээр засгийн газрын сурталчилж буй үнэт зүй бол социалист агуулага байхгүй харин күнзийн зүйл гэсэн.

нь ямар төр эсвэл засгийн газар гэдгийг ерөнхийд нь ойлгож байж, тэдний ямар бодлого хэрэгжүүлэхээр зорьж байгааг ойлгоход дөхөм байх болов уу.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс бол хоёр шатны үндэстэний тогтолцоо бүхий “үндэстэн-улс” юм. Тэр нь хятад, монгол, манж, хотон, уйгар, и, жуань гэх мэт нийтдээ 56 үндэстэн болон түүнийг нэгтгэсэн төрийн шинжтэй “дундадын үндэстэн” зэрэг болно. Тэрчлэн БНХАУ бол удирдлагын хувьд коммунист намын удирдлагатай, нэг намын тогтолцоотой улс. 1949 онд Хятадын Коммунист нам засгийн эрхийг авснаас хойш өнөөг хүртэл тус улсын бүх зүйлийг Хятадын Коммунист Нам удирдаж ирсэн. Нэг намын тогтолцоо гэдэг нь нэг эрх баригч нам улс төр, цэргийн эрх мэдлийг монополь болгох явдал. Энэ байдлаараа Хятадын Коммунист Намын Үндсэн хууль бол өнөөгийн Хятадын засгийн газрын дагаж мөрдөх ёстой хууль дүрэм болдог. Тухайлбал, Намын дүрэм дараахь байдлаар эхэлдэг нь:

Хятадын Коммунист нам бол Хятадын ажилчин ангийн манлайлагч, Хятадын ард түмэн, Хятадын үндэстний манлайлагч, Хятадын онцлогтой социализмын үйлсийг удирдан чиглүүлэх гол цөм юм. Ард түмний өргөн хүрээний язгуур эрх ашиг юм. Намын дээд идеал, туйлын зорилго бол коммунизмд хүрэх явдал юм.

Хятадын Коммунист нам марксизм-ленинизм, Мао Зэдуны үзэл санаа, Дэн Сяопиний онол, “Гурвыг төлөөлөлөх”-ийн чухал санаа, хөгжлийн шинжлэх ухааны үзэл баримтлал, Хятадын онцлогтой социализмын тухай Ши Жиньпиний шинэ эрин үеийн үзэл баримтлалыг гарын авлага болгоно (БНХАУ-Ын Коммунист Намын Тунхаг, 2017).

Тэгвэл эндээс бид тус сэдэвтэй холбоотой онцгой анхаарч ойлгох ёстой нэг зүйл бол хоёрдугаар догол мөрөнд бичигдсэн зүйлс болно. Учир нь хоёрдугаар мөрний илэрхийлэлд БНХАУ-д Марксын үзэл санаанаас гадна Хятадын Коммунист намын бүх үеийн удирдагчдын үзэл санаа болох тухайлбал, Дэн Шяопиний онол, Зян Зэмний “Гурвыг төлөөлөлөх”, Ху Жинтаогийн хөгжлийн шинжлэх ухааны үзэл баримтлал, одоогийн намын ерөнхий нарийн бичгийн дарга Ши Жиньпиний шинэ эрин үеийн Хятадын онцлогтой социализмын тухай үзэл санааг улсын засаглалын гол бичиг баримт болгоно гэсэн үг. Тэр тусамаа бидний судлан буй “үнэт зүйл” гэх энэ ойлголт засгийн газрын талбарт эдгээр удирдагчдын санаачлагаар эсвэл тэдний гол ярьж байгаа зүйлээс гарч ирдэг гэсэн үг. Тэр тусамаа онцгойлон албан ёсоор “үнэт зүйл” гэж ярьж байсан хүн бол Ху жиньтао тэргүүлэгч юм. Тэрбээр 2012 оны 11-р сарын 8-нд намын XVIII их хуралд илтгэл тавьж, албан тушаалаа дараагийн тэргүүлэгчид шилжүүлэх үедээ: “Баян хүчирхэг, ардчилал, иргэншсэн, эв найрамдал, эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс, хууль дээдлэх, эх оронч үзэл, үнэнч, шударга байдал, нөхөрсөг байдал” гэх хятадаар 24 ханзнаас бүрдсэн социалист үндэстний “үнэт зүйлс”-ийн үндсэн агуулгыг засгийн бодлогод чухалчлах ёстойг хэлсэн байдаг. Хятадын Коммунист Намын XVII Төв Хорооны нэрийн өмнөөс үүнийгээ гаргаж тавьсан. Гэхдээ эдгээрийг гаргаж тавихын эхлэл нь ялангуяа шинэтгэлээс хойшоор түүхэнд Дэн Шяопингийн үеэс эхтэй юм. 1989 онд дээд удирдагч Дэн Сяопин хэлсэн үгэндээ боловсролыг 1980-аад оны шинэчлэл, тэр дундаа үзэл суртлын болон улс төрийн боловсролын хамгийн том бүтэлгүйтэлийн шалтгаан болоод байна гэсэн. Үүний дараагаар засгийн газар ч энэ зорилгоор олон нийтийн кампанит ажил явуулахыг оролдсон боловч эцсийн дүндээ эдгээр нь үр дүнтэй

гэж тооцогддоггүй. 2011 онд Ван Юэгийн үхлийг шинэ хөтөлбөрийг өдөөгч гэж үзэж болно. 2012 онд Хятадын эдийн засгийн хурдацтай хөгжлийн үр дүнд бий болсон ёс суртахууны хямрал гэж ойлгогдож байсан зүйлийг шийдвэрлэхийн тулд “Социалист үндсэн үнэт зүйлс”-ийн тогтолцоог бий болгохыг санал болгосон бөгөөд үүнийг Ардын өдрийн сонинд “хоцрогдсон мамонизм, хэтэрсэн индивидуализм” (Zhao Xu, 2015) гэж иш татсан байна. Тиймээс 18-р их хуралд намын ерөнхий нарийн бичгийн дарга Ху Жинтао 17-р Төв хороог төлөөлж, Хятадын Коммунист Намын (ХКН) батлах гэж буй шинэ үнэт зүйлсийн агуулгыг танилцуулсан хэрэг. Тэрчлэн шинэ намын нарийн бичгийн дарга, улсын тэргүүлэгч Ши Жинпин ч:

“...Хэрэв манай 1.3 тэрбум иргэн, 82 сая намын гишүүд, мөн хилийн чанад дахь хятадууд нэгдэл хүрч чадвал бид хүчирхэг хүчин болно [...] Өөр өөр газар нутаг, нийгмийн давхаргаас гаралтай, өөр өөр гарал, ажил мэргэжилтэй хүмүүс өөр өөр сэтгэдэг гэдгийг бид ойлгох ёстой. Тиймээс бид зөвшилцлийг хаанаас олох вэ? Ялгаатай байдлаа хаана зөвшөөрөх вэ?...” (Xi Jinping, 2014) гэх мэтээр ярьсан.

Тэрчлэн 2014 онд түүний өөр нэг яриандаа үүнийгээ улам бататгаж:

“...Бид социалист үндсэн үнэт зүйлсийг эрч хүчтэйгээр хөгжүүлж, сурталчлах хэрэгтэй. Хятадын онцлог, үндэсний онцлог, цаг үеийн онцлогийг бүрэн тусгасан үнэт зүйлсийн тогтолцоог яаралтай бий болгох, мөн энэ асуудлаар тэргүүлэх байр суурийг бий болгохыг эрмэлзэнэ. Ёс суртахууны үнэт зүйлс нь үндсэн үнэт зүйлсийн дунд маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Ёс суртахуунгүй бол улс орон хөгжихгүй, ард түмэн нь босоо байж чадахгүй. Аливаа улс үндэстэн, хувь хүн өөрийн гэсэн өвөрмөц мэдрэмжтэй байх эсэх нь тэдний ёс суртахуунаас ихээхэн хамаардаг. Хэрэв ард түмэн маань өөрийн газар шороон дээр бүрэлдэн бий болсон, төлөвшсөн ёс суртахууны үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлж чадахгүй, харин барууны ёс суртахууны үнэлэмжийг ялгаварлан гадуурхаж, сохроор тоть болгож байвал улс орон, ард түмэн гэсэн тусгаар тогтнолоо гээх үү, үгүй юу гэдгийг чин сэтгэлээсээ асуух хэрэгтэй болно. Энэхүү бие даасан ёс суртахуунгүй бол бидний улс төр, оюун ухаан, соёл, байгууллагын тусгаар тогтнол дороосоо хивсээ сугалж авна...”(Xi Jinping, 2014) гэх мэтээр ярьжээ.

Үүний дараагаар бүх улс даяараа БНХАУ-ын бүх шатны засаг захиргааны хэлтэсүүд уг үнэт зүйлсийг төлөвшүүлэх, хэрэгжүүлэхийн тулд сургууль, эмнэлэг, аж ахуйн нэгж, интернет кафе, дэлгүүр, худалдааны төв, автобусны компани болон бусад нэгжүүдэд мэдэгдлийн бичиг баримт гаргаж, сурталчилах болсон. Сурталчилгааны самбар, баннер эсвэл цахим дэлгэц болон бусад мэдээллийн хэрэгслээр 24 тэмдэгт бүхий социалист үндсэн үнэт зүйлсийг бүрэн эхээр нь харуулах болов. Эдгээр үнэт зүйл нь одоо ч Хятадын эх газрын янз бүрийн хотуудын гудамж, гудамжаар социалист үндсэн үнэт зүйлсийг сурталчлах сурталчилгаа байсаар байна. Удирдагчид эдгээр үнэт зүйлийг ялангуяа боловсролын байгууллага, банк, эмнэлэг, бүх шатны хууль шүүхийн байгууллага гэх мэт бүхий л төрийн байгуулагуудаар дамжуулан сурталчилах болсон. Мөн намын гишүүдийг үлгэр болохыг шаардах болсон. 24 ханз бүхий социализмын үндсэн үнэт зүйлс нь социалист үндсэн үнэт зүйлсийн тогтолцооны гол цөм бөгөөд социалист үндсэн үнэт зүйлсийн тогтолцооны үндсэн мөн чанар, үндсэн шинж чанарыг тусгаж, социалист үндсэн үнэт зүйлсийн тогтолцооны баялаг утга санаа, практик шаардлагыг тусгадаг.

Мөн эдгээр үнэт зүйлүүд үндэстэний байгуулалын үзэл санааг ч тусгаж байдаг. Эдгээр үнэт зүйлийг чухалчлах ёстойгор Ши Жиньпин олон удаа чухал илтгэл тавьж, тодорхой шаардлага тавьсаар ирсэн. Мөн Төв Хорооны Улс төрийн товчоо нь социалист үндсэн үнэт зүйлсийг төлөвшүүлэх, сурталчлах, Хятадын уламжлалт соёлыг сурталчлах талаар хамтын сургалт явуулдаг. Мөн хятадын төрөөс “Социалист нийгмийн үнэт зүйлсийг төлөвшүүлэх, хэрэгжүүлэх тухай санал дүгнэлт” мөн гаргасан. Намын Төв Хорооноос өндөр анхаарал хандуулж, хүчтэй ажиллаж байгаа нь хүчин чармайлтын чиг хандлагыг тодорхойлж, социалист үндсэн үнэт зүйлсийн боловсрол, практикийг бэхжүүлэхэд чухал чиглэл өгч байгаа байдал гэж тайлбарласаар ирсэн. Тэрчлэн Синьхуа агентлагийн 2013 оны 12-р сарын 23-ны орой нийтэлсэн "Социалист үндэстний үнэт зүйлсийг төлөвшүүлэх, хэрэгжүүлэх талаархи санал бодол"-д өмнө дурдсан 24 ханз бүхий нийгмийн үндсэн үнэт зүйлсийг гурван түвшинд хуваажээ. Тэр нь:

1. Баян хүчирхэг, ардчилал, иргэншил, эв найрамдал нь үндэсний хэмжээний үнэт зүйл
2. Эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс, хууль дээдлэх нь нийгмийн түвшний үнэт зүйл
3. Эх оронч үзэл, үнэнч, шударга байдал, нөхөрсөг байдал нь хувь хүний хувьд иргэний “үнэт зүйл” юм.

Энэ ангилалын доторх улсын хэмжээний “үнэт зүйл” гэгдэх “баян хүчирхэг, ардчилал, соёл иргэншил, эв найрамдлыг сурталчлах, эв найрамдал”-ыг хятадын төр “эх орондоо орчин үеийн социалист улсыг байгуулах зорилго, мөн энэ нь үнэт зүйлсийн зорилтын түвшнээс социалист язгуур үнэт зүйлсийн хураангуй суурь ойлголт юм. Баян хүчирхэг нь улс орон цэцэглэн хөгжиж, ард түмэн хүчирхэг байна гэсэн үг бөгөөд энэ нь орчин үеийн социалист улсын эдийн засгийн бүтээн байгуулалтын жам ёсны байдал, Хятад үндэстний олон жилийн хүсэл эрмэлзэл, улс орны хөгжил цэцэглэлт, аз жаргалын материаллаг үндэс суурь юм. Ардчилал бол хүний нийгмийн сайхан хүсэл тэмүүлэл юм. Бидний хөөцөлдөж буй ардчилал бол ард түмний ардчилал, түүний мөн чанар, гол цөм нь ард түмэн бол улс орны эзэн байх явдал юм. Энэ бол социализмын амьдрал, ард түмний сайхан, аз жаргалтай амьдралыг бий болгох улс төрийн баталгаа юм. Соёл иргэншил бол нийгмийн дэвшлийн чухал бэлэг тэмдэг, орчин үеийн социалист улсын чухал шинж чанар юм. Энэ нь орчин үеийн социалист улсын соёлын бүтээн байгуулалтын зүй ёсны төлөв байдал, орчин үеийн өөрчлөлтөд тулгарч буй ард түмний социалист соёл, ертөнц, ирээдүй, үндэсний, шинжлэх ухаан, нийтийн социалист соёлын ерөнхий ойлголт, чухал дэмжлэг юм. Хятадын үндэстний агуу их сэргэн мандалтын биелэл болох ёстой. Эв найрамдал гэдэг нь сурч боловсрох, сургах, орлоготой ажиллах, өвчлөх, эмчлүүлэх, хөгшрөхөд түшиг тулгуур, амьдрах зэрэг амьдралын тод байдлыг агуулсан хятадын уламжлалт соёлын үндсэн ойлголт юм. Энэ нь орчин үеийн социалист улсын нийгмийн бүтээн байгуулалтын салбарын үнэт зүйлийн эрэлт хэрэгцээ, эдийн засаг, нийгмийн эв нэгдэл, тогтвортой байдал, тогтвортой эрүүл хөгжлийн чухал баталгаа юм” (Kiki Zhao, 2016) гэдэг.

“Эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс, хууль дээдлэх ёс”-ны тухайд “ илүү сайн нийгмийг тод томруун илэрхийлэл бөгөөд социалист үндсэн үнэт зүйлсийн үндсэн

ойлголтыг нийгмийн түвшинд нэгтгэсэн явдал юм. Энэ нь Хятадын онцлогтой социализмын үндсэн шинж чанарыг тусгасан бөгөөд манай намын гуйвшгүй, урт хугацааны туршлагын үндсэн үнэт зүйлийн үзэл баримтлал юм. Эрх чөлөө гэдэг нь хүний хүсэл зоригийн эрх чөлөө, оршин тогтнох, хөгжих эрх чөлөө, хүн төрөлхтний нийгмийн сайхан хүсэл тэмүүлэл, Марксизмын дэвшүүлсэн нийгмийн үнэт зүйлийн зорилгыг хэлдэг. Тэгш байдал гэдэг нь иргэдийн хуулийн өмнө эрх тэгш байхыг хэлдэг бөгөөд түүний үнэт зүйл нь үндсэн тэгш байдлыг тасралтгүй хэрэгжүүлэх явдал юм. Энэ нь хүний эрхийг дээдэлж, хамгаалахыг шаардаж, хүн бүр хуулийн дагуу тэгш оролцох, тэгш хөгжих эрхтэй. Шударга ёс бол нийгмийн шударга ёс бөгөөд хүний эрх чөлөө, хүний эрх чөлөө, тэгш эрхийг олж авах явдал юм. Улс орон, нийгмийн үндсэн үнэт зүйлийн үзэл баримтлал юм. Хууль дээдлэх нь улс орныг удирдах үндсэн арга зам, хууль дээдлэх нь социалист ардчилсан улс төрийн үндсэн шаардлага юм. Энэ нь эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх замаар иргэдийн язгуур эрх ашгийг хамгаалж, эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс, шударга ёсыг хэрэгжүүлэх институцийн баталгаа юм (Kiki Zhao, 2016) гэжээ.

“Эх оронч үзэл, үнэнч шударга байдал, нөхөрсөг байдал”-ын тухайд төр “иргэдийн ёс суртахууны үндсэн хэм хэмжээ, хувь хүний зан үйлийн түвшинд социалист үндсэн үнэт зүйлсийн хураангуй суурь ойлголт юм. Энэ нь нийгмийн ёс суртахууны амьдралын бүхий л салбарыг хамарсан, иргэдийн дагаж мөрдөх ёс суртахууны үндсэн дүрэм, мөн иргэдийн ёс суртахууны зан үйлийн сонголтыг үнэлэх үндсэн үнэт зүйлсийн хэм хэмжээ юм. Эх оронч үзэл нь тухайн хүний эх орноо гэсэн гүн гүнзгий мэдрэмж дээр суурилдаг бөгөөд хувь хүн, эх орон хоёрын харилцааг зохицуулдаг ёс зүйн хэм хэмжээ юм. Энэ нь социализмтай нягт уялдаатай бөгөөд Хятад улсыг сэргээн хөгжүүлэх, үндэсний эв нэгдлийг ахиулах, эх орны эв нэгдлийг хамгаалах, эх орондоо ухамсартайгаар үйлчлэх үүрэг хариуцлага хүлээхийг ард түмнээс шаардаж байна. Зорилго гэдэг нь иргэнээс ажилдаа үнэнч байх, хувийн сахилга баттай байх, ард түмэндээ үйлчлэх, нийгэмд үйлчлэхийг шаардаж, социалист мэргэжлийн сэтгэлгээг бүрэн шингээсэн иргэдийн мэргэжлийн ёс зүйн үнэлэмжийн үнэлгээ юм. Шударга ёс гэдэг нь үнэнч шударга, итгэлтэй байхыг хэлнэ. Энэ нь хүний нийгэмд олон мянган жилийн туршид уламжлагдан ирсэн ёс суртахууны уламжлал, мөн социалист ёс суртахууны бүтээн байгуулалтын гол агуулга болж, шударга хөдөлмөрлөх, амласан амлалтаа биелүүлэх, хүнтэй чин сэтгэлээсээ харьцахыг чухалчилдаг. Иргэд бие биенээ хүндэлж, халамжилж, бие биедээ тусалж, эв найрамдалтай, найрамдалт харилцаатай байж, шинэ хэлбэрийн социалист хүн хоорондын харилцааг төлөвшүүлэхийг эрмэлзэх ёстой” (Kiki Zhao, 2016) -г онцолж байгаа юм.

Тэрчлэн хятадын төр эдгээр “үнэт зүйл”-үүдийн ач холбогдолын тухайд төрийн тайлбар нь: “Дэлхий даяарх үзэл суртлын болон соёлын солилцоо, солилцооны нөхцөл байдлын дагуу үнэ цэнийн өрсөлдөөний шинэ нөхцөл байдал, өөрчлөлт, нээлттэй байдал, социалист нийгмийн хөгжлийн нөхцөлд үзэл суртлын олон талт байдал, өөрчлөлтийн шинэ шинж чанаруудын өмнө зах зээлийн эдийн засаг, социалист үндсэн үнэт зүйлсийг идэвхтэй хөгжүүлж, хэрэгжүүлнэ. Үзэл суртлын талбарт Марксизмын чиглүүлэгч байр суурийг бататгаж, бүхэл бүтэн нам, бүхэл бүтэн улс орны эв нэгдэл, тэмцлийн нийтлэг үзэл суртлын үндэс суурийг бататгах нь эдийн засгийг бүх талаар

хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Ард түмэн, нийгмийн бүх талын хөгжил дэвшлийг удирдан чиглүүлж, дунд чинээлэг нийгмийг бүх талаар цогцлоон байгуулж, Хятад үндэстний агуу их сэргэн маналтын тухай Хятадын мөрөөдлийг биелүүлэхийн төлөө хүчин чармайлтаа нэгтгэх практик ач холбогдолтой” гээд мөн “Дотоодын болон олон улсын нөхцөл байдлын гүн гүнзгий өөрчлөлтөд дасан зохицох үүднээс улс орон маань асар их бүтээн байгуулалт, их өөрчлөлт, их өөрчлөлтийн үе шатанд байна. Урьд өмнө байгаагүй их өөрчлөлт шинэчлэлт, хөгжил, нээлттэй үйл явц, төрөл бүрийн үнэт зүйлс, нийгмийн бодол нь төвөгтэй байдаг. Олон улсын дайсагнагч хүчнүүд манай улсын эсрэг барууны үзэл, ялгаварлан гадуурхах стратегия эрчимжүүлж, үзэл суртлын болон соёлын талбарууд нь тэдний гол бүс нутагт урт хугацаанд нэвтэрч байна. Бид социалист үндсэн үнэт зүйлсийг идэвхтэй төлөвшүүлж, хэрэгжүүлэх, үндсэн үнэт зүйлсийн нөлөөг өргөжүүлэх, улс орны соёлын зөөлөн хүчийг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна” (Kiki Zhao, 2016) гэдэг. Мөн цаашлаад “Үндэсний засаглалын тогтолцоо, засаглалын чадавхийг шинэчлэх, үндсэн үнэт зүйлсийг төлөвшүүлэх, сурталчлах, нийгмийн ухамсарыг үр дүнтэй нэгтгэх нь үндэсний засаглалын тогтолцоо, засаглалын чадавхийн чухал тал юм. Өөрчлөлтийг иж бүрэн гүнзгийрүүлж, Хятадын онцлогтой социалист тогтолцоог боловсронгуй болгож, хөгжүүлж, улс орны засаглалын тогтолцоо, засаглалын чадавхийг шинэчлэх ажлыг ахиулахын тулд үнэт зүйлийн тогтолцооны асуудлыг шийдэж, Хятадын онцлогийг бүрэн тусгасан үнэт зүйлийн тогтолцооны бүтээн байгуулалтыг түргэтгэх ёстой. Үндэсний онцлог, цаг үеийн онцлогийг төлөвшүүлж, нийгэмд эрчтэй төлөвшүүлэн хөгжүүлж, социализмын үндсэн үнэт зүйлсийг урагшлуулж, нийгмийн үзэл суртал, соёл, үнэт зүйлийг нэгтгэх чадварыг дээшлүүлж, нийгэм дэх санаачилга, ноёрхол, ярианы хүчийг мэдрэх чадварыг дээшлүүлнэ. Үнэт зүйлсийн талбар бөгөөд хүмүүсийг Хятадын замаар гуйвшгүй дагахад чиглүүлнэ. Үндэстэн, ард түмний оюун санааны орон зайг сайжруулах үүднээс язгуур үнэт зүйлс нь оюун санааны багана, үйл ажиллагааны хөтөч бөгөөд хүмүүсийн оюун санааны ертөнцийг баяжуулах, үндэсний оюун санааны өргөө байгуулахад үндсэн бөгөөд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Хүн эсвэл улс үндэстэн өөрийгөө хянаж чадах эсэх нь үндсэн үнэт зүйлсийн удирдамжаас ихээхэн хамаардаг. Хөгжингүй орчин үеийн Хятад улс илүү сайн оюун санааны амьдралыг илүү их хүсч байгаа бөгөөд илүү хүчирхэг үнэт зүйлсийн дэмжлэг хэрэгтэй байна. Ард түмний сэтгэл санааг сэргээж, бүх үндэстний оюун санааны хэлхээ холбоог бэхжүүлэхийн тулд бид социалист үндсэн үнэт зүйлсийг идэвхтэй хөгжүүлж, хэрэгжүүлж, дэлхийн улс үндэстнүүдийн дунд бие даан зогсох Хятадын сэтгэлгээг төлөвшүүлэх ёстой. Хятадын үндэсний сэргэн мандалтын мөрөөдлийг биелүүлэх агуу зорилгын үүднээс авч үзвэл, үндсэн үнэт зүйлс нь улс орны хувьд чухал тогтворжуулагч юм. Хүчтэй эв нэгдэл, сонирхол татахуйц үндсэн үнэт зүйлсийг бий болгох нь нийгмийн эв нэгдэл, тогтвортой байдал, урт хугацааны харилцаатай холбоотой юм. ‘Хоёр зуун жилийн зорилго’-ыг хэрэгжүүлэх, Хятад үндэстний агуу их сэргэн мандалтын мөрөөдлийг биелүүлэхийн тулд үнэт зүйлсийн талаар өргөн хүрээний зөвшилцөл, нийтлэг үнэт зүйлийг эрэлхийлэх ёстой. Энэ нь биднээс социалист үндсэн үнэт зүйлсийн тогтолцоо, үндсэн үнэт зүйлсийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэн бэхжүүлж, улс орны бүх үндэстний ард түмний эв нэгдэл, тэмцлийн төлөөх үзэл суртлын нийтлэг үндсийг нэгтгэж, ард түмний их сэргэн мандалтыг хэрэгжүүлэхийн тулд нэгдэхийг шаардаж байна. Бүгд Найрамдах Хятад Улс

Хятадын үндэстний олон нийтийн ухамсарыг чухалчилж, хэрэгжүүлнэ. Хятадын ард түмний ухамсарыг төлөвшүүлэх нь бүх үндэстний ард түмнийг эв нэгдэл, эд баялаг, зовлон, амьдрал үхэл, хувь тавилан гэсэн хамтын нийгэмлэгийн үзэл санааг тууштай тогтооход чиглүүлэх явдал юм.” (Kiki Zhao, 2016) гэдэг. 2021 онд болсон Үндэстний ажлын төв бага хуралд генерал Нарийн бичгийн дарга Ши Жиньпин “хоёр”-ыг хэрэгжүүлэхээс эхлүүлсэн бөгөөд “100 жилийн тэмцэл”-ийн зорилт, Хятад үндэстний агуу их сэргэн мандалтын стратегийн өндөрлөгөөс эхлэн, манай намын үндэстний ажлыг бэхжүүлэх, сайжруулах чухал санаа бодлыг иж бүрэн тайлбарлаж, Хятад үндэстний хамт олны сэтгэлгээг төлөвшүүлэхийн агуу ач холбогдлын тухай мөн тайлбарлажээ. Тэрбээр “ухамсар бол шинэ эриний намын үндэстний ажлыг өндөр чанартай хөгжүүлэх гол чиглэл” бөгөөд “Хятад үндэстний ухамсарыг нэгтгэх” гэж онцлон тэмдэглэсэн аж. Улс үндэстний хамтын ажиллагаа бол шинэ эрин үеийн намын үндэстний ажлын “хөтөлбөр” бөгөөд бүх ажил үүнд чиглэх ёстой гэсэн. Тэрчлэн Ши Жиньпин 13 дахь удаагийн Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын 5-р чуулганд ӨМӨЗО-ны төлөөлөгчдийн хэлэлцүүлэгт оролцохдоо:

“...бид дундадын ард түмний ухамсарыг төлөвшүүлэх үндсэн чиглэлийг тууштай барьж, гүнзгийрүүлэх ёстой “гэж онцлон тэмдэглэсэн юм. “Үндэстний эв нэгдэл, хөгжил дэвшлийг хүмүүжүүлж, Хятадын үндэстний хамтын нийгэмлэгийн үзэл санааг тасралтгүй бататгах үндэс суурь нь Хятадын үндэстний их гэр бүлд бүх үндэстэн ястнуудыг анар жимсний үр мэт эв нэгдэлтэй байлгах, агуу эх орноо хамтдаа байгуулах, илүү сайн амьдралыг хамтдаа бүтээнэ. Хятад улс бол олон үндэстний нэгдмэл орон бөгөөд олон жилийн түүхэнд олон талт, нэгдмэл Хятад үндэстэн бий болсон. Үндэстний эв нэгдэл бол манай улсын бүх үндэстний ард түмний амин сүнс, Хятадын үндэстний хамтын нийгэмлэгийн мэдрэмж бол үндэстний эв нэгдлийн үндэс юм. Бүх үндэстний язгуур эрх ашгийг хамгаалж, Хятадын үндэстний агуу их сэргэн мандалтыг ухамсарлан, эрх тэгш, эв нэгдэл, харилцан тусалцах, эв найртай социалист үндэстний харилцааг бэхжүүлэн хөгжүүлэх нь зайлиггүй шаардлага юм. Шинэ нөхцөл байдлыг бий болгох намын угсаатны ажил. Бид Хятадын үндэстний агуу их сэргэн мандалтын стратегийн өндөрлөгөөс шинэ эриний намын үндэстний ажлын түүхэн чиг баримжааг ойлгож, Хятадын ард түмний ухамсарыг төлөвшүүлэх түүхэн гарцаагүй, туйлын ач холбогдол, бодит ач холбогдлыг гүн гүнзгий ухаарах ёстой. Хятадын үндэстний ард түмний ухамсарыг төлөвшүүлэхийн чухлыг хатуу ухаарч, үндсэн чиглэл нь шинэ эриний намын үндэстний ажлыг төлөвлөн, сурталчлах ажлыг зохицуулж, Хятад үндэстнийг илүү өндөр түвшний хувь заяаны хамтын нийгэмлэг болгоход чиглэнэ” (Бүх Хятадын Ардын Төлөөлөгчид, 2022) гэжээ.

Хятадын үндэстний эсвэл “дундадын үндэстэн”-ий хамт олны сэтгэлгээг бий болгох үндсэн чиглэлийг хатуу ухаарах нь ерөнхий нарийн бичгийн дарга Ши Жиньпиний үндэстний ажлыг бэхжүүлэх, сайжруулах тухай чухал санааг бүрэн, үнэн зөв ойлгож, хэрэгжүүлж, намын төвлөрсөн, нэгдмэл удирдлагыг баримтлах явдал юм. Эх орон, үндэстэн, соёл, түүхийн үзэл баримтлал, Хятад үндэстний оюун санааны

нийтлэг өргөөг байгуулахын тулд мөн шинэ хөгжлийн үзэл баримтлалыг бүрэн, үнэн зөв, иж бүрэн хэрэгжүүлж, хамтын хөгжлийг ахиулах хэрэгтэй гэдэг. Цаашлаад:

“Хятад үндэстний хамт олны сэтгэлгээг бий болгох гол шугамыг хатуу барьж, Хятадын үндэстнүүдийн агуу эв нэгдлийн тугийг өндөрт барьж, бүх үндэстний солилцоо, нэгдмэл байдлыг ахиулж, бүх үндэстний ард түмнийг нэн тэргүүнд тууштай байлгахыг шаардах явдал юм. Хуулийн өмнө эрх тэгш байж, үндэстэн ястны харилцааны засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, засаглалын чадавхийг шинэчлэх төвшин нь Хятадын үндэстний хамтын нийгэмлэгийн үзэл санааг бий болгох үндсэн чиглэлийг тууштай барьж, үндэстний аюулгүй байдлын ерөнхий үзэл баримтлалыг баримтална. Үндэстний хэмжээнд томоохон эрсдэл, далд аюулаас тууштай сэргийлнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга Ши Жиньпин хэлэхдээ, үндэстний аюулгүй байдал нь улс орны тогтвортой байдлын чухал тулгын чулуу бөгөөд үндэстний аюулгүй байдлыг сахин хамгаалах нь тус улсын бүх үндэстний ард түмний язгуур эрх ашиг юм. Өнөөдөр дэлхий ертөнц зуунд үл үзэгдэх гүн гүнзгий өөрчлөлтийг туулж, үймээн самуун, өөрчлөлтийн шинэ үе рүү орж байна. Янз бүрийн угсаатны солилцоо, нэгдэлд нөлөөлж буй хүчин зүйлүүд нь нарийн төвөгтэй, олон талт хэвээр байна. Үндэстний талбар дахь үзэл суртлын тэмцэл хурц бөгөөд ээдрээтэй хэвээр байна. Бид үндэстний бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, хөгжлийн эрх ашгийг тууштай хамгаалж, бүх үндэстнийг эх оронч үзлийн уламжлалыг өвлөн уламжлан хөгжүүлэхэд сургаж, удирдан чиглүүлж, эх орон, үндэстний аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдлыг ухамсартайгаар хамгаалах ёстой. Үндэстний аюулгүй байдлын ерөнхий үзэл баримтлалыг тууштай тогтоож, үндэстэн ястны далд эрсдэл, далд аюулаас Хятад үндэстний хамтын нийгэмлэгийн сэтгэлгээг бий болгох онцгой ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч, яаралтай байдлын ухамсарыг дээшлүүлж, стратегийн сэтгэлгээг сайжруулж, олон улсын далд аюулыг шийдвэрлэнэ. Хүчирхийллийн алан хядах ажиллагаа, үндэстний салан тусгаарлах үйл ажиллагаа, шашны хэт даврагч үйл ажиллагаанаас хатуу сэргийлж, шийдвэртэй таслан зогсоож, дайсагнагч хүчний нэвтрэн орох, хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулахаас хатуу сэргийлж, эсэргүүцнэ. Терроризмын эсрэг олон улсын хамтын ажиллагаагаар эрчимжүүлж, гол улс орон, бүс нутаг, олон улсын байгууллага, хилийн чанад дахь үндэстэн ястны болон хилийн чанад дахь Хятадын бүлгүүдэд сайн ажиллана. Үзэл суртлын байр суурийг баримталж, үндэстэн ястны хүчин зүйлтэй холбоотой үзэл суртлын асуудлыг идэвхтэй, ухаалаг зохицуулж, үндэстэн ястны хагарал, шашны хэт даврагч үзэл суртлын хорыг устгаж, үндэстний эв нэгдэл, угсаатны эв нэгдлийг хамгаалах үзэл суртлын бат бэх хэрэм босгоно” гэсэн.

2020 оноос хойш “Хятадын үндэстний ухамсрыг төлөвшүүлэх” бодлого орон даяар хэрэгжиж эхэлснээс хойш олон дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд “Хятадын үндэстний ухамсрыг сурталчлах төв-ийг байгуулсан. “Хятад үндэстний олон нийтийн ухамсрыг төлөвшүүлэх” нь судалгааны гол сэдэв болсон. Ихэнх коллеж, их дээд сургуулиуд өөрсдийн их сургуулийн Угсаатны судлал, социологийн коллежид Хятадын үндэстний нийгэмлэгийн ухамсрын судалгааны төвийг

байгуулж, зарим их дээд сургуулиуд угсаатны зүй, социологийн коллежийг шууд Хятадын үндэсний нийгэмлэгийн ухамсрын хүрээлэн болгон хувиргах болно.

Хятадын үндэстний хамт олны хүчтэй сэтгэлгээг төлөвшүүлэх бодлогын эсвэл “үнэт зүйл”-ийн гол зорилго нь олон үндэстэн ястны хоорондын ялгаа, ялгааг аль болох хурдан арилгах явдал юм. Хэл, бичиг, ёс заншил, итгэл үнэмшил зэрэг үндэстний ялгааг арилгаж, эцэст нь Хятад үндэстний үндэсний онцлогийг тогтооход оршино.

Соёлын ялгаа ба “үнэт зүйл”

Энэ хэсэгт бид Өвөр Монголын нийгэм соёл дахь ардын талбар тухайлбал, монголчууд эсвэл монгол үндэстний бүлэг, хувь хүний үнэт зүйлийн тухай өгүүлэх болно. Нэн тэргүүнд хэлэхийг хүсэж байгаа нэг зүйл бол Өвөр Монголын монголчуудын үнэт зүйл бол “үндэстэн” эсвэл соёлын ялгаатай байдалтай холбоотой. Өөрөөр хэлбэл, өмнөх хэсэгт дурдсан нам-засгийн талбараас улс даяар сурталчилж буй түгээмэл “үнэт зүйл”-ээс өөрөөр өөрийн төрлөх үндэстэний соёл уламжлалыг чухалчлах нь маш хүчтэй байдаг. Ялангуяа энэ нь Өвөр Монголд байгаа Монголчуудын жишээ нь дээр хамгийн тод харагддаг. Гэвч хамгийн сонирхолтой нь энэ нь Монгол улсад байдаг монголчуудаас бас ялгаатай байдаг. Тэр нь бидний ажигласанаар Монгол улс дахь засгийн газар эсвэл бодлого боловсруулагч талбараас үндэстний соёлыг чухалчлах хандлага маш хүчтэй байх түгээмэл байдал ажиглагддаг. Шалтгаан нь юу юм бэ? Энэ бол энэ хэсэгт хариулах ёстой гол асуудал. Гэвч бид эхлээд Өвөр Монголын монголчуудын хувьд тэдний ярианы хэлэнд “хамаг чухал зүйл” гэж хэлэгддэг “үнэт зүйл”-ийн илэрхийлэл болсон “монгол соёл”-ыг онолын талаас илэрхийлэх “соёлын олон талт байдал” гэдэг ойлголтын тухай авч үзье,

Соёлын олон талт байдал гэж юу вэ?

Соёлын олон талт байдал нь орчин үеийн хүн төрөлхтний нийгэмд бий болсон соёл иргэншлийн шинэ ойлголт бөгөөд биологийн олон янз байдал, хүн төрөлхтний нийгэмд үзүүлж буй хор хөнөөлтэй холбоотой хямралыг дагаад гарч ирж буй шинэ ойлголт юм. Байгалийн хувьд экологийн тэнцвэрт байдлын үндэс нь биологийн олон янз байдал, түүний хадгалж буй биологийн гинжин хэлхээний бүрэн бүтэн байдал юм. Үүнтэй холбогдуулан хүн төрөлхтөн харьцангуй төлөвшсөн ойлголтыг бий болгож, энэ суурийг хамгаалах, сэргээх, тэр ч байтугай дахин босгох дэлхийн хэмжээний арга хэмжээ авч байна. Тэгвэл хүн төрөлхтний нийгмийн хувьд дэлхийн энх тайвны үндэс нь юу вэ гэдэг нь хүн төрөлхтөний эрин зууны туршид эрэлхийлж ирсэн нууцлаг, шийдэгдээгүй томоохон асуудал юм.

Хүн төрөлхтөн нэгдмэл, соёл нь олон янз. Хүний нэгдэл, олон талт байдал нь диалектик нэгдэл юм. Хүний нэгдлийг хүлээн зөвшөөрнө гэдэг нь хүний олон янз байдлыг үгүйсгэнэ гэсэн үг биш, харин эсрэгээр хүндэтгэх тухай асуудал билээ. Хүний биологийн утга учир, төрөлхийн физиологийн олон нийтлэг шинж чанаруудыг хүлээн зөвшөөрөх нь хүний хувьслын үйл явцын хувьд, хүний олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх нь соёлын бүтээлийн үйл явцын хувьд юм. Энэхүү ойлголт нь барууны уламжлал дахь хүн төрөлхтний гаралтай “олон ургалч үзэл”, соёлын “монизм” гэсэн ойлголтыг эсэргүүцдэг.

Хүн төрөлхтний нийгмийн тасралтгүй өөрчлөгдөх, байгуулагдаж байдаг процессын түүхээс "Жинхэнэ бүтээлч байдал нь тууштай байдалд хүргэдэггүй"⁴ гэдгийг ойлгоход хэцүү биш юм. Төрөл бүрийн угсаатны бүлгүүдийн хүмүүнлэгийн ялгаа нь угсаатны бүлэг бүрийн байгалийн тухай ойлголт, өөр өөр амьдрах орчинд өөрийгөө танин мэдэхүйн бүтээлүүд юм. Энэтхэгийн агуу яруу найрагч Тагор : “Дэлхий дээрх бүх үндэстний ард түмэнд тулгардаг бэрхшээлүүд өөр өөр бөгөөд тэдгээрийг даван туулах арга нь ч өөр өөр байдаг”⁵ гэж хэлсэн шиг гэсэн үг. Улс үндэстний амьдралын янз бүрийн орчинд тулгарч буй янз бүрийн бэрхшээлийг шийдвэрлэх арга замууд нь хүн ба байгаль хоёрын харилцан үйлчлэлийн үр дүн юм. Гол мөрөн, нуур, далайд завиар явах , цөлийн бэлчээрт мал аж ахуйн нүүдэл хийх, уулархаг ойд тайрах тариалалт, мөс, цастай туйлын бүс нутагт загасчлах, ан хийх гэх мэт. Эдгээр уламжлалт үйлдвэрлэлийн аргаар илэрхийлэгдэх хөгжлийн арга замын ялгаа нь эдгээр арга замыг бүтээгчдээс шууд хамаардаг. Экологийн антропологийн үүднээс авч үзвэл байгаль орчин, хүн төрөлхтний соёлын харилцан үйлчлэл маш ойр байдаг. Хэдийгээр эрдэм шинжилгээний хүрээлэлд энэхүү харилцан үйлчлэлийн талаар өөр өөр үзэл бодол байдаг ч биологийн олон янз байдлын бүс нутаг дахь соёлын олон янз байдал нь томоохон асуудал юм.Түгээмэл хууль.

Экологийн янз бүрийн орчинд хүмүүсийн оршин тогтнох материалын эх үүсвэр, төрөл нь өөр өөр байдаг бөгөөд тэдгээрийг олж авах, ашиглах арга замууд нь өөр өөр байдаг. Байгалийг ойлгох, ашиглах замаар бий болсон эдгээр мэдлэг, туршлага, зан үйл, технологи, үнэт зүйлс нь соёлын олон талт байдлыг бүрдүүлдэг. Хүн төрөлхтний соёлын олон талт байдалд байгаль орчны нөлөөлөл нь тодорхой боловч энэ нөлөөлөл нь соёлын эерэг ба сөрөг талуудын ялгаа гэхээсээ илүү соёлын төрлүүдийн ялгааг тодорхойлдог. Эрин үеийн туршид хүн төрөлхтөн өөрсдийн соёлын олон янз байдлын талаарх ойлголтдоо соёл иргэншлийн бус байдалд байсаар ирсэн. Ялгаанаас эмээх, ялгааг үгүйсгэх, ялгааг арилгах нь хүний нийгмийн хөгжлийн гол ухамсар болсон. Энэ практикт хэрэглэгдэж буй зарим онол, ухагдахуунууд мөн л “Газарзүйн агуу нээлт”-ээс хойш дэлхийд алдартай болсон. Барууныхны “байгаль орчны детерминизм” гэх мэт даосизм нь соёлын олон янз байдлын чанарыг шүүдэг, “арьс өнгөөр ялгаварлан гадуурхах” нь бие махбодийн онцлог шинж чанарт арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, тэр байтугай “Евроцентризм” болон Америкийн ноёрхлын бардам зан нь өнөөг хүртэл илэрч байгаа нь хүн төрөлхтний эв нэгдлийг сорьж байна. Биологи нь хүн төрөлхтний нэгдмэл байдлын шинжлэх ухааны үндэслэлийг хангалттай хангасны дараа ч хүмүүс хүн төрөлхтний нэгдмэл байдлыг хүлээн зөвшөөрдөг боловч үүнтэй зэрэгцэн үүнийг өөр өөр арьстан болгон хуваах хандлагатай байдаг. Хэдийгээр ард түмний эрхийг хүлээн зөвшөөрдөг ч зарим ард түмэн өөрийгөө илүү гэж үздэггүй. Тэр ч байтугай хүн төрөлхтний нэгдмэл байдлын биологийн баталгаа нь хүн төрөлхтний дээд болон доод үндэстний эрэмбийг ямар ч байдлаар бууруулаагүй гэж хэлж болно. Үүнээс үүдэн тодорхойлогддог соёлын үзэл, соёл иргэншлийн үзэл баримтлалд ч мөн адил хамаарна. Үүний үр дүнд дэлхийн орчин үеийн түүхэнд “Уугуул нутгийн шилдэг соёл

⁴ 【美】 E·拉兹洛:《决定命运的选择》,李吟波等译,三联书店 1997 年版,第121页。

⁵ 【印】 泰戈尔:《民族主义》,谭仁侠译,商务印书馆 1986 年,第1页。

барууны хамгийн муу соёлын нөлөөн дор үхсэн” гэх янз бүрийн эмгэнэлт явдал тохиолдсох болов. Тиймээс өнөөдөр дэлхийн орчин үеийн шинэчлэлийн үйл явцад Хятад болон барууны эрдэм шинжилгээний хүрээлэл дэх “далд далдалсан социал дарвинизмын сэргэлт” нь аж үйлдвэр гэдгийг нотлохыг хичээсээр байна. Энэхүү хуулийг хадгалахын тулд “Соёл иргэншлийн мөргөлдөөн”-ийг бүтээгчид: “Америкийн итгэл үнэмшил, барууны соёл иргэншлийг орхих нь бидний мэддэг зүйл бол Америкийн Нэгдсэн Улс төгсгөл болно. Үнэн хэрэгтээ энэ нь барууны соёл иргэншлийн төгсгөл гэсэн үг юм. ...АНУ байгаагүй бол барууны орнууд Евразийн төгсгөлд орших жижиг, ач холбогдолгүй хойгт оршин суудаг дэлхийн хүн амын өчүүхэн бөгөөд буурч байгаа хэсэг байх байсан”⁶ гэдэг. Ийм аймшигт дүр зургаар дамжуулан барууны ертөнцийн эв нэгдлийг хадгалах, АНУ-ын “нэг туйлт ертөнц”-ийн ноёрхлыг бий болгоход чиглэсэн АНУ-ын удирдлагад дэмжлэг үзүүлэх зорилгоор “модернизаци = барууншлах =” дизайн хийх зорилготой юм. Гэсэн хэдий ч “зуун цэцэг цэцэглэж”, зуун сургуулиар тэмцэлдэж буй газар соёл иргэншил цэцэглэн хөгжихийг түүх харуулж байна. Хэрэв та өөртэй чинь санал нийлэхгүй, хамтран ажиллаж чадахгүй байгаа хүмүүсийг тэвчиж чадахгүй бол” тэд, соёл иргэншил буурах болно. Хүний нийгмийн бодит хөгжил энэ теоремыг үргэлжлүүлэн батлах болно. Иймээс соёлын олон янз байдлыг олон улсын хамтын нийгэмлэг улам бүр хүлээн зөвшөөрч байна.

Эв нэгдэл нь ижил зүйл биш бөгөөд эв нэгдэл гэдэг нь арьсны өнгө, үндэс угсаа, соёл, нийгмийн нэг тогтолцоо гэсэн үг биш юм. Орчин үеийн ертөнцөд хүн төрөлхтний нэгдмэл байдлын тухай ойлголт нь биологийн утгаар ойлгохоос гадна соёлын олон янз байдлын талаар бүх хүн төрөлхтний өнцгөөс сэтгэж, соёлын олон янз байдлаас хүн төрөлхтний нэгдмэл байдлыг эрэлхийлэхийг шаарддаг. Хүмүүс энэ ертөнцөд өөр өөр соёлын үзэл бодол, үнэт зүйлийг бий болгодог үндсэн байр суурийг хүлээн зөвшөөрөх нь зөв бөгөөд зайлшгүй шаардлагатай юм. Хүндлэл нь дэлхийн энх тайван, оршин тогтнох үндсэн урьдчилсан нөхцөл юм гэдгийг ойлгох хэрэгтэй. Энэ бол бүх хүн төрөлхтний өмнө тулгардаг үзэл баримтлал бөгөөд Марксизм ч эртнээс дэвшүүлж ирсэн ойлголт юм. Байгаль дахь төрөл зүйлийн олон янз байдал нь экологийн тэнцвэрт байдлыг хадгалж чаддаг. Хүний нийгэм, соёлын олон талт байдал нь яагаад зайлшгүй хоёрдмол байдал, зөрчилдөөнд хүргэдэг вэ? Хүний нийгмийн соёлын олон талт байдал яагаад дэлхийн энх тайвныг сахиж чадахгүй байна вэ? Асуудал нь төрөл зүйлийн олон янз байдал хоорондын харилцаанд биш юм. Харин соёлын олон талт байдал ба ангиллын ялгаа, асуудал нь хүн гэдэг ойлголтодонд оршдог. Үнэн хэрэгтээ “Европын соёл-төв үзэл”-ийг өөрчлөх хүчин чармайлт үргэлжилсээр байгаа бөгөөд соёлын харьцангуй, олон соёлт үзэл бий болсон нь энэ үзэл баримтлалын өөрчлөлтийг харуулж байна. Гэсэн хэдий ч эдгээр онолууд нь өөр өөр согогуудтай бөгөөд энэ нь соёлын консерватизм, тусгаарлалт, “цэвэр ариун байдлыг” онцолсон “хөлдөлт”- рүү амархан хүргэдэг бөгөөд ингэснээр өөр өөр соёл хоорондын харилцаа холбоо, интеграци, шингээлтийн интерактив харилцааг үгүйсгэдэг. Соёлын олон янз байдлын хэтийн төлөв нь олон янз байдал нь тийм биш гэдгийг онцлон тэмдэглэдэг. Хэрэв биологийн олон янз байдлын тухай ойлголтоор дамжуулан соёлын олон янз байдал нь олон янз байдлын үнэ цэнэ,

⁶ 【美】赛缪尔·亨廷顿:《文明的冲突与世界秩序的重建》,周琪等译,新华出版社 1998 年版,第 354 页

түүний харилцан хамааралд анхаарлаа төвлөрүүлдэг бөгөөд энэ нь хүний органик эв нэгдлийг бий болгодог.

Өвөр Монголчуудын хувьд бүлгийн буюу үндэстний түвшинд ч хувь хүний түвшинд ч монгол хэл, бичиг үсэг, зан заншил, итгэл үнэмшил болон монголын уламжлалт соёлын бусад чухал бүрэлдэхүүн хэсэг нь тэдний “үнэт зүйл” буюу “хамаг чухал” зүйл бөгөөд энэ нь дэлхийн соёл иргэншлийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд монгол соёлын үндсэн үнэ цэнэ, ерөнхий дүр төрхийг бүрдүүлэх үйл явцад зайлшгүй түүхэн байр суурь эзэлдэг. Монголын уламжлалт соёл нь Хүннү, Сяньби, Түрэг, Кидан, Жүрчэн болон бусад үндэстний соёлын мөн чанарыг хөгжлийн явцад янз бүрийн түвшинд шингээж, ан агнуурын соёл, газар тариалангийн соёлыг шингээж, аж үйлдвэрийн соёл, хот суурин газрын соёлын нөлөөнд автсаар ирсэн. Сүүлдээ хятад соёлын нөлөөнд ч маш их орсоор байна. Монголын уламжлалт соёлыг уламжлан, өвлүүлэн үлдээх, соёлын гайхамшигт уламжлалыг уламжлан хөгжүүлж, шинэ практикт шинэчилж байх нь өнөөдөр бидний хувьд чухал ач холбогдолтой юм. Эв найрамдлын сүнс, хүн ба байгалийн эв нэгдэл, эрх чөлөө, тэгш байдлын сүнс, прагматизм ба анхдагч үзэл, итгэл ба зөвт байдлыг эрхэмлэх сүнс, баатарлаг байдал, өөдрөг үзэл, өөрийгөө хөгжүүлэх, тууштай байх сүнс, Монголын уламжлалт соёлоор тэжээгддэг. Иймд монголын уламжлалт соёлыг өвлүүлэн авч явах нь практик, улс төрийн чухал ач холбогдолтой юм. Энэ нь Монгол үндэстний эдийн засаг, нийгмийн хөгжил, угсаатны эв найрамдалтай харилцааг хөгжүүлэх, хүн төрөлхтний соёл иргэншлийн хөгжил дэвшилд асар их нөлөө үзүүлэх болно. Монголын уламжлалт эв найрамдалтай соёлыг шинэчлэх талаар олон талт арга хэмжээ авах ёстой. Монгол нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх, үндэстний нөхцөл байдалд тулгуурлан бүс нутгийн үндэстний өөртөө засах тогтолцоог тууштай баримталж, боловсронгуй болгох, дэлхий ертөнцийг харах, үндэстэн ястны харилцааг зөв зохицуулах, монгол соёлын авьяасыг эрчимтэй хөгжүүлж, судлах, судлах зэрэг Монголын уламжлалт эв нэгдэлтэй соёлыг сурталчлах хэрэгтэй байна.

Бүлгийн дүгнэлт

Тус бүлэгт авч үзсэн Өвөр Монголын тохиолдолд засгийн газрын юмуу төрийн талбарт нэгдмэл байдлын, ялгааг устгах байдлын, улс байгуулах хэв маягын үнэт зүйлийг чухалчилж байгаа бол Өвөр Монголын доторх монгол үндэстний тохиолд эсрэгээрээ ялгаатай байх буюу засгийн газрын чухалчилж буй үнэт зүйлийн эсрэг тохиолдолыг түлхүү ярьдаг. Өөрөөр хэлбэл, Монголто харьцуулах юм бол энд “үндэстэн” өөрөө үнэт зүйл болдог гэсэн үг.

Гуравдугаар бүлэг: Буриадын нийгэм-соёл дахь үнэт зүйл

Тус бүлэгт бид ОХУ-ны бүрэлдэхүүнд буй Буриадын нийгэм-соёл дэх “үнэт зүйл”-ийн тухай судлах болно. ОХУ бол 11 цагийн бүс, олон янзын газарзүйн орчныг хамардаг дэлхийн хамгийн том улс юм. Тус улс нь олон янзын хүмүүс, итгэл үнэмшил, үнэт зүйл, амьдралын хэв маягийг агуулдаг. Эдгээр ялгаа нь өөр өөр бүс нутаг, угсаатны хооронд ялангуяа мэдэгдэхүйц байдаг. Оросуудын дийлэнх нь хот суурин, аж үйлдвэржсэн төвүүдэд амьдардаг бөгөөд нийт хүн амын 74% нь хот суурин газар эсвэл хотод амьдардаг гэсэн тооцоо байдаг. Гэсэн хэдий ч хөдөө орон нутгийн тосгонд олон хүн ам байдаг. Тус улсын асар том газар нутаг, урт удаан, нарийн төвөгтэй түүхээс шалтгаалан Оросын аливаа тойм нь соёлыг хэт хялбарчлах эрсдэлтэй байдаг. Дараах бүлэг дэх тайлбарууд нь Оросын хүн бүрийг илтгэх зорилгогүй боловч давамгайлж буй нийгмийн үнэт зүйл эсвэл засгийн газрын талбар түүний бодлогод тайлбарлаж буй “үнэт зүйл” болон дотоод олон соёлын ялгаануудын төлөөлөл болгон Буриад Монголчуудаа жишээлэн өгүүлэх юм. Энэ утгаараа бид тус хэсэг асуудлыг хоёр хэсэг болгосон нь нэгд, Оросын бодлого боловсруулагчдын эсвэл засгийн газрын талбарт “үнэт зүйл”-ийг хэрхэн тайлбарлаж, ямар бодлого хэрэгжүүлж буйг төрийн албан ёсны бодлогын судалгаа болон энэ талаархи өмнөх судалгаанууд дээр түшиглэн авч үзнэ. Харин тус бүлгийн хоёрдугаар хэсэгт, Буриад Монголчуудын хувь хүний эсвэл гэр бүлийн орон зайд “үнэт зүйл”-ийг хэрхэн тайлбарладаг, ойлгодог тухай өмнөх энэ чиглэлийн судалгаа болон Монгол улсад Орос-Украины дайны үед ирсэн буриад иргэд болон оюутануудтай хийсэн ярилцлагууд дээр түшиглэн бичсэн болно. Учир нь 2002 оны 2-р сард эхэлсэн Орос-Украины дайнаар Орос улс даяар цэрэг татлага явагдахад түүнээс дүрвэсэн Буриад, Халимаг олон залуучууд Монголд орж ирэх болсон. Олонхи нь их сургуулийн эсвэл ажлын виз авах хэлбэрээр дайнаас дайжих байдал ажиглагдах болсон. Зарим нэг хэсэг нь монголоор дамжиж Америк, Европын улсуудад гарч ажиллах зорилготой ирсэн тохиолдол ч олон байгаа юм. Бид тус бүлгийг бичихийн тулд ОХУ-д тэр тусамаа буриадад очих ёстой боловч өнөөгийн дэлхийн нийгэм-улс төр болон ковид гэх мэт байдлын олон шалтгаанаар очих боломж хязгаарлагдмал байсан ч эдгээр хүмүүстэй уулзах, ярилцага хийх байдлаар тус бүлгийн асуудлуудыг тодруулахыг эрмэлзсэн болно.

ОХУ-ын засгийн газар ба “үнэт зүйл”

Энэ хэсэгт бид ОХУ-ын засгийн газрын бодлого доторх “үнэт зүйл”-ийг хэрхэн тайлбарлаж буйг “ОХУ-ын гадаад бодлогын үзэл баримтлал” болон төрийн удирдагчдын яриа гэх мэт улс төрийн баримт бичгүүд дээр үндэслэн тайлбарлах болно. Тэрчлэн энэ нь өнөөгийн дэлхийн улс төрийн талбарын гол сэдэв болоод байгаа Орос-Украины дайнтай ч холбоотой сэдэв. Гэвч бид энд дайны тухай ярихгүй. Харин энэхүү дайны үндсэн шалтгаан гэж ОХУ-ын засгийн газраас, Ялангуяа ерөнхийлөгч Путингийн удаа бүр байр сууриа илэрхийлээд байгаа тайлбар, мэдэгдэлд бидний тус бүтээлд судлан буй “үнэт зүйл” гэх ухагдахууныг хэрхэн авч үзэж байгааг анхаарч байгаа гэсэн үг. Ингээд бид доорх хэсэгт ОХУ-ын улс төрийн талбарт ямар ямар “үнэт зүйл”-ийг тайлбарлаж буйг авч үзье:

Хувь хүний эрх чөлөө

ОХУ-ын засгийн эрх барьж байгаа улс төрийн талбарт “эрх чөлөө”-г хамгийн дээд “үнэт зүйл” гэж заасан байна. Тухайлбал, ОХУ-ын үндсэн хуулийн нэгдүгээр хэсгийн нэгдүгээр бүлэгт: “хувь хүний эрх, эрх чөлөө бол хамгийн дээд үнэт зүйл юм” (The Constitution of the Russian Federation , 1993) гэсэн байдаг.

Universalism, particularism ба “уламжлал”

ОХУ-ын ерөнхийлөгч В.И. Путин ОХУ-ын үнэт зүйл бол “нэгдсэн”, “тусгай”, “уламжлалт” байх гэдэг бол манай улсын гол үнэт зүйл” гэж тодотгож ярих болсон. Ялангуяа 2012 оны Холбооны зөвлөлд тавьсан яриандаа үүнийг маш илэрхий шууд хэлсэн байсан. Тэрчлэн мөн бид ОХУ-ын Ерөнхийлөгчийн баталсан ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегийг анхаарах хэрэгтэй. Үнэндээ тус стратеги нь тус улсын уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлсийн асуудлыг хурцатгасан баримт бичиг болж түүхэнд үлдэж байгаа юм. Улмаар тэрхүү аюулгүй байдлынх нь заналхийлэлийн гол эх сурвалжаа Оросын соёлыг “баруунжуулах” явдал гэж тодорхойлдогдоос энэ нь илэрхий харагддаг. Тэр тусамаа Оросын үнэт зүйлсэд АНУ болон түүний холбоотнууд, үндэстэн дамнасан корпорацууд, түүнчлэн гадаадын ашгийн бус, төрийн бус, шашин шүтлэг, хэт даврагч, террорист байгууллагууд халдаж байна гэж үзэж байгаа юм. Өмнө нь терроризм, экстремизм нь нэг талаараа “барууны” сэдвээс тусгаарлагдсан байсан бол одоо тэдгээрийг ижил түвшний аюул гэж үздэг гэсэн үг. Барууны орнуудтай сөргөлдөөн хийх үнэт зүйлсийн талбарт шилжүүлэх нь өнөөгийн Оросын засгийн газрын гол стратеги мэт харагдаж байгаа юм. Өмнө нь ийм сөргөлдөөнийг материаллаг ангиллын хувьд (батлан хамгаалах, эдийн засаг) илүү ойлгодог байсан бол одоо үзэл суртлын түвшинд илт шилжүүлсэн. Тэгвэл энэ шилжилт яагаад болсон бэ?

Үнэндээ 1990-ээд оны эхээр Оросын засгийн газрын чухалчилж буй үнэт зүйлс барууны үнэт зүйлстэй нэгдэж байсан. Гэвч 1990-ээд оны хоёрдугаар хагас гэхэд либерал идеализмаас прагматик реализм руу шилжих нь тодорхой болсон. Тэрчлэн мөн одоогийн ерөнхийлөгч В.И. Путин ч энэ үеэс төрийн удирдлагад гарсаныг анхаарч үзэх нь зүйтэй байх. 2000-аад оны эхээр Оросын сургаалд реализм эцэстээ газар авч, тэд аюулгүй байдал, гадаад бодлогыг тодорхой материаллаг заналхийллийн үүднээс авч үзсэн. Үүний үндсэн дээр гадны хүчнүүд, тэр дундаа барууны орнуудтай харилцах харилцааг бий болгосон. Энэ байдал нь одоо ч ил тод бөгөөд өмнө дурдсанчлан тэдний гадаад бодлогын үзэл баримтлал дотор илэрхий харагддаг.

Гэр бүлийн уламжлал, эх оронч үзэл

Тэрчлэн ОХУ-ын бас нэгэн чухал улс төрийн баримт бичиг бол “ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын стратеги” юм. Энэ баримт бичигт мөн “үнэт зүйл”-ийн тухай дурдсан байна. Тухайлбал, тус баримт бичгийн “Ерөнхий заалтууд”-д дараах байдлаар заасан байна. Тэр нь:

“Оросын төрийн туурга тусгаар байдал, хүнлэг ёс, Оросын хүн амыг бүрдүүлэгч олон үндэстэн/угсаатны эв найрамдалтай зэрэгцэн оршиж буй явдал, гэр бүлийн

уламжлал, эх оронч үзэл гэсэн нийтлэг үнэт зүйлсэд тулгуурлан нийгмийн эв нэгдэл бий болж байна”(ОХУ-Ын Үндэсний Аюулгүй Стратеги-2021, 2022) гэжээ.

Эндээс харахад ОХУ-ын төрөөс хэрэгжүүлж буй бодлого дундах хамгийн чухал “үнэт зүйл” бол дээр дурдсанчлан эрх чөлөө, аюулгүй байдал, нийтлэг, уламжлалт байдал гэх мэтээс гадна эх оронч үзэл болон гэр бүлийн уламжлал болон олон үндэстний соёлын эв найрамдалт байдлын тухайд байгаа юм. Энэ нь хятадын төрийн бодлоготой төстэй.

Хөгжил ба “үнэт зүйл”

Тэрчлэн бас нэг сонирхолтой зүйл нь тус “ОХУ-ын үндэсний аюулгүй стратеги”-д “хөгжил” гэх ойлголтыг барууны зүйл гэдгээр авч үзсэн нь асар сонирхолтой юм. Тухайлбал, тус стратегийн доторх “Орос ба орчин үеийн ертөнц: өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлага” гэсэн хэсэгт:

“Даяаршиж буй үйл явцын үр дүнд тэгш бус хөгжилтэй холбоотой зөрчил мөргөлдөөн эрчимжиж, баян ядуу улс орнуудын хоорондын хагарал гүнзгийрсэний үр дүнд үндэстэн улсууд туулсан. Үнэт зүйл, хөгжлийн загвар нь дэлхийн өрсөлдөөний субъект болсон.” (ОХУ-Ын Үндэсний Аюулгүй Стратеги-2021, 2022) гэсэн нь өмнө дурдсанчлан “хөгжил” гэх ойлголтын барууны уг гарлыг буруутгаж, улмаар хөгжил түүний хэмжүүр үнэт зүйлүүд нь өрсөлдөөний гол бай болж байгааг онцолсон нь тус үзэл баримтлал бүхэлдээ барууны эсрэг байх нь тэдний үнэт зүйл мэтээр тайлбарлаж байгаа хандлагатай юм.

“Монгол биш, Буриад: хувь хүн- гэр бүл

Бид өмнө хэсэгт Оросын төрийн бодлого доторх “үнэт зүйл”-ийн тухай авч үзсэн. Харин энэ хэсэгт өмнө дурдсанчлан Оросын доторх олон үндэстэн, угсаатаны бүлгийн нэг болох Буриад Монголчуудын хувьд тэр тусамаа хувь хүн эсвэл гэр бүлийн түвшинд “үнэт зүйл” гэх ойлголтыг хэрхэн тайлбарлаж байгааг авч үзэх болно.

Эрх чөлөө

“Эрх чөлөө” гэх ойлголт нь Буриад Монголчуудын хувьд улсын үндсэн хуулиар батлагдсан нэгэн чухал үнэт зүйл юм. Хэдийгээр өнөөдрийг хүртэлх тэдний туулж ирсэн туршлага дээр тэд үүнийг бодитой байлгах нөхцөл тийм амар байгаагүй ч энэ нь тэдний хамгийн чухал нэг “үнэт зүйл” гэдгийг ярилцлагад оролцогчид болон өмнөх судалгаануудад нотолж байна.

Буриад хэл

Буриад Монголчууд бол Монголчуудын ертөнц дэх олон Монголчуудтай харьцуулбал барууны соёлд хамгийн эрт орсон төдийгүй өнөөгийн түвшинд “Монгол” гэхээс илүү “Буриад” гэх ижилсэлт нь хамгийн хүчтэй бүлэг юм. Энэ нь юунаас илүү анхаарагдсан бэ гэвэл бидний судалгааны явцад 2022 оны 2 сард эхэлсэн Орос-Украины дайнд ОХУ даяар бүх нийтээр дайчилсан цэрэг татах ажиллагаа өрнөж, үүнээс зугатсан олон Буриад, Халимаг залуучууд Монгол улсад орж ирэх байдал болсон юм. Үүнийг ажигласан Монгол улсын монголчууд “монгол элэг нэгтнээ хайж ирлээ” гэх мэтээр хандаж байсан. Гэвч бидний ажигласанаар Монголд ирсэн буриадууд монголчуудын

байдал маш олон талтай байсан юм. Зарим нь үнэхээр монголчуудын хэлсэнчлэн угсаа гарал нэгтэй гэдэг байдлаар зорьж ирсэн бол зарим нь зүгээр л газар нутгийн ойр байдлаас улбаатай ирсэн ч бий. Зарим нь энд эхний ээлжинд ирээд энд хэсэг хугацаанд амьдарч, эсвэл сурч байгаад үргэлжлүүлээд Америк эсвэл Европын улсад үргэлжлүүлэн суралцах төлөвлөгөөтэй ч байгаа юм. Гэвч шалтгаан нь ямар байлаа ч тэдгээр иргэдтэй уулзаж явахад ажиглагдсан зүйл бол өмнө дурдсанчлан тэд буриад гэж өөрийгөө үзэх, буриад соёл нь тэдний үнэт зүйл болж байдагыг онцолж байгаа юм. Хэлний асуудал дээр тэдний энэ байдал хамгийн тод илэрч байгаа юм. Тухайлбал, бидний судалгааны явцад бидэнтэй ярилцага хийсэн нэгэн 21 настай буриад залуугийн хэлж байгаагаар “буриад хэл бол тэдний үнэт зүйл”⁷ гэсэн юм. Түүнээс биш тэдний бодож байгаагаар энэ нь “монгол хэлний “тухай асуудал биш юм. Түүний ярианаас болон бусад оролцогчдын ярианаас ажиглахад Буриадад дунд сургуульд зааж байгаа хэл бол “буриад хэл” болохоос биш Монгол улсад эсвэл Өвөр Монголд зааж байгаа “монгол хэл” гэдэг нэрийдэлтэй хичээл байдаггүй байна. Гэлээ ч тэдний нийтлэг байдлаас харахад хэл тэр тусамаа буриад хэл бол тэдний бүлгийн эсвэл гэр бүлийн эсвэл хувь хүний чухал нэг үнэт зүйл болж байдаг.

Гэр бүл

Гэр бүл бол буриад монголчуудын хувьд хамгийн чухал нэг үнэт зүйл. Ярилцлагад оролцогчдын дунд хэрвээ “миний гэр бүлд асуудал тохиолдвол буцаж очоод байлдан”⁸ гэж зарим нь өгүүлж байсан юм. Тэдний энэ тайлбар нь хэрвээ бид байлдахдаа хүрвэл Орос улсын төлөө гэсэн үг биш, харин өөрийн гэр бүлийн төлөө гэсэн тайлбарыг хэлж байгаа юм.

Шударга ёс

Шударга ёс бол Буриад Монголчуудын чухал үнэт зүйл бөгөөд Орос нийгэмд амьдрахад энэ н чухал ач холбогдолтой гэдэг. Эхэндээ энэ нь хүмүүсийн нийгмийн тэгш байдал гэж ойлгогдож, газартай холбоотой эрчүүдийн эдийн засгийн тэгш байдал дээр суурилдаг байв. Нөхөрлөлийн гишүүд газар эзэмшиж, түүний бүх баялгийг тэгш хүртэх эрхтэй байв. Ийм шударга ёс нь Буриадын ард түмний амьдарч, хүсч байсан үнэн байв. Үнэн ба шударга ёсны тухай алдартай маргаанд сүүлчийнх нь ялдаг. Буриад хүн энэ нь ямар байсан, бодит амьдрал дээр байгаа эсэх нь чухал биш, харин энэ нь ямар байх ёстой вэ гэдэгт санаа тавьдаг.

Тэвчээр, хатуужил

Мөн буриад монгол хүний хувьд тэвчээр бол үндсэн үнэт зүйл юм. Тэд дараалсан түдгэлзэх, өөрийгөө хязгаарлах, бусад хүмүүсийн төлөө тасралтгүй золиослох зэрэгтэй хамт байдаг. Үүнгүйгээр хүн гэж байхгүй, эргэн тойрны хүмүүсийн статус, хүндэтгэл ч байхгүй. Тиймээс буриадуудын өөрийгөө танин мэдүүлэх, нинжин сэтгэлийг хөгжүүлэх, төлөвшүүлэхэд шаардлагатай дотоод эрх чөлөөг олж авах хүсэл эрмэлзлээс үүдэлтэй юм. Эцсийн эцэст, золиослол, тэвчээр, өөрийгөө хязгаарлахын тусламжтайгаар ертөнц

⁷ 21-настай Т-тэй 2020 оны 10 дугаар сарын 15 нд Улаанбаатар хийсэн ярилцагаас

⁸ 35 настай И-тэй хийсэн ярилцлага 2022 оны 10 дугаар сарын 20-нд Улаанбаатарт хийсэн ярилцлагаас

оршин тогтнож, урагшилдаг гэдэгт итгэдэг. Тэрчлэн өнөөдрийн нөхцөл байдлаас харахад Буриад Монголчуудын соёлын үнэт зүйлс нь түүний ямар нэгэн өндөр, трансцендент мэдрэмж рүү чиглүүлж байгааг байнга харуулж байна. Тэдний хувьд энэ дээд утгыг хайхаас илүү сэтгэл хөдөлгөм зүйл байхгүй. Үүний тулд зарим хүмүүс гэр, гэр бүлээ орхиж, дайны зугатааж байна.

Аюулгүй байдал

Тэрчлэн ярилцлага болон бусад төсөөтэй судалгаануудаас харахад Буриад Монголчуудын хувьд өнөөгийн тэргүүлэх ач холбогдол өгч байгаа гол үнэт зүйл бол аюулгүй байдал юм. Энэ нь өмнө дурдсанчлан засгийн газрын талбарын “үнэт зүйл”-тэй төсөөтэй ч тэдний хэлж байгаа аюулгүй байдал бол хувь хүний юмуу эсвэл “гэр бүлийн аюулгүй байдал” юм. Харин засгийн газрын талбарын аюулгүй байдал бол “эх орны” эсвэл “ОХУ” -ын гэх аюулгүй байдал бөгөөд энэ нь өнөөгийн түвшинд гэр бүлийн эсвэл хувь хүний талбарт цэрэг татлагын жишээ дээр сөргөлдөж байна гэсэн үг юм.

Гедонизм, Стимуляци

Тэрчлэн өмнөх судалгаануудаас харахад буриадууд эсвэл Буриадын тэр тусамаа Оросын нийгэм соёлд амжилт, уламжлал, эрх мэдэл зэрэг үнэт зүйлс оросуудын дунд харьцангуй тогтвортой байдаг байсан гэдэг. Гэвч “2006 оноос 2016 он хүртэл Гедонизм, Стимуляци зэрэг эсрэг тэсрэг үнэлэмжүүд ихээхэн нэмэгдсэн” (Lebedeva & Tatarko, 2018) гэсэн судалгаанууд ч бий.

Шашин ба эдийн засаг

Тэрчлэн шашин мөн Буриад Монголчуудын үнэт зүйлд тэр тусамаа эдийн засгийн асуудлуудад хандах хандлагад нөлөөлж байгаа зүйл ажиглагдаж байгаа юм. Тэрчлэн буриад нь олон шашны орон зай бөгөөд зарим судалгааны үр дүнгээс харахад христэд итгэгчид болон Лалын шашинтнуудын үнэт зүйлс нь эдийн засгийн хандлагын хувьд өөр өөр үр дүнг харуулсан гэж хэлж болно. Христэд итгэгчдийн үнэт зүйлс нь бүтээлч байдал, цаг хугацаа гэх мэт бусад нөөцтэй харьцуулахад мөнгөний ач холбогдол бага байгааг харуулж байна. Нөгөө талаас мусульманчуудын үнэт зүйл нь тэднийг эдийн засгийн үйл ажиллагаа, бие даасан байдал, санхүүгийн зан үйлийг ихээхэн дэмжсэн байдлын үнэт зүйлтэй байдаг байхад буддын шашинд итгэгчид нь эдийн засгийн зүйлсийг тийм ч чухал үнэт зүйл болгохгүй байгаа тал ажиглагдаж байгаа юм.

Бүлгийн дүгнэлт

Тус хэсэгт судалсан Буриад Монголчуудын жишээнээс харахад тэдний гэр бүлийн юмуу хувь хүний орон зай дахь “үнэт зүйл”-ийг тайлбарлах байдал бусад нийгэм соёлын хүмүүстэй адил байна. Гэвч соёлын талаасаа харвал тэд мөн л Өвөр Монголын тохиолдолтой адил өөрийн бүлгийн “үнэт зүйл”-ийг чухалчилдаг. Гэвч тэр нь “Монгол” гэдэг дээр бус харин “Буриад” гэдэг дээр төвлөрдөг. Тэрчлэн ОХУ-ын дотоод талбартаа авч үзвэл аюулгүй байдал гэдэг ойлголт дээр засгийн газар эсвэл төрийн бодлоготой нэг “үнэт зүйл”-ийг өгүүлж байгаа ч жирийн иргэдийн хувьд энэ нь гэр бүлийн талбарт авч үзэж байгаа юм.

Дөрөвдүгээр бүлэг: Казакстан, Киргизстаны үнэт зүйлс

Энэ бүлгийн хүрээнд хэдийгээр угсаа гарал, хэлний хувьд өөр боловч адил нүүдлийн соёлоос улбаатай Казакстан, Киргизстан улсуудын нийгэм-соёл дахь “үнэт зүйлс” гэх ойлголтын талаар судласан талаараа ярих юм. Олон зуун жил Оросын Хаант Улс, Зөвлөлт Холбоот Улсын харьяанд байсан эдгээр улсууд нь 1989 оны өөрчлөн байгуулалтын үрээр анх удаагаа тусгаар тогтносон, бүрэн эрхт улсууд болсон билээ. Тэр ч утгаараа эдгээр улсууд нь өөрсдийн үндэстэн улсыг шинээр бүтээх шаардлагатай болсон ба үндэстэн улсаа бүтээн байгуулахад ямар үнэт зүйлсийн тухай ярьж буй талаар судлах юм.

Засгийн газар ба “үнэт зүйл”

Казакстан

Казакстаны соёлын өв нь нүүдэлчдийн урт хугацааны уламжлалыг агуулдаг. Нүүдэлчин малчид олон мянган жилийн турш Их талын өвөлжөө, халуухан зундаа зөөврийн байшингаа хээ угалзаар шүтэж, нарийн хээ угалзыг мод, төмөр багажаар сийлсээр иржээ. Яс, арьс шир, морины үс болон бусад бүх зүйл гар урлалын хэрэгсэл, чимэглэлд ашиглагдаж байв. Сүүлийн үеийн археологийн олдворууд МЭӨ I мянганы үед Казакстаны нутаг дэвсгэрт скиф, сак, савромат, хүннү, усун, кангли, хожим Түрэг, карлук, овог аймгууд нүүдлийн соёл хийгээд, суурин соёлыг хоршуулан амьдарч байсанг батлан харуулдаг байна.

Газар нутгийн хувьд хойд талаараа Орос, зүүн талаараа Хятад, баруун өмнөд хэсэгт Перс, Исламын соёлтой холбоотой эртнээс байсан энэхүү бүс нутгийн ард иргэд нь хамгийн их соёлын холбоо хамаарал бүхий улсууд нь нүүдлийн соёл иргэншилээрээ нэгэн адил Монголчууд юм. Олон зуун мянган жилийн турш зэрэгцэн болон нэг нэгнээ ээлжлэн эрхшээлдээ оруулж ирсэн эдгээр ард түмнүүд ЗХУ-ыг түүхийн тавцанд гарж ирэх хүртэл нүүдлийн соёлоо уламжлан хадгалаж ирсэн байдаг. 1920-оод оноос аж үйлдвэрийн хувьсгал, ЗХУ-ын хөгжлийн хөтөлбөр хэрэгжиж Казакууд нь нүүдлийн соёл иргэншилээс суурин соёлт улс орон болсон байна. Харин 1989 онд Тусгаар тогтносон Казакстаны Засгийн газраас өөрсдийн үндэстэн улсыг бүтээх ажлыг хийж эхэлсэн байна.

Казакстаны зүгээс нүүдлийн соёл гэхээсээ илүү тал нутгийн соёл (Үлы дала мэдениеті) гэх нэр томъёог ашиглаж байгаа нь харагдсан ба энэхүү ойлголтоороо Казакстаны уугуул соёл түүний үнэт зүйлсийг зааж байгаа юм (Жапсарбай Куанышев, 2019). Казакстан улсын хувьд 2050 он гэхэд хөгжлийн хувьд хөгжингүй 30 орны тоонд багтах томоохон зорилготойгоор урт хугацааны хөгжлийн хөтөлбөр болох Казакстаны Стратеги-2050-ийг билээ. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах үе шаттай хэрэгжүүлэх нэгдэх үе шат 2030 он хүртэл, хоёрдах үе шат 2030-2050 он хүртэл байх юм. Стратеги-2050-ийг боловсруулахдаа Казакстаны төрийн зүгээс 7 зүйлийн үнэт зүйлсийг өөрсдийн үндэстний үнэт зүйлс хэмээн зааж өгсөн байдаг.

Казакстаны тусгаар тогтнол болон Астана хот.

Үндэсний эв нэгдэл, энх тайван, манай нийгмийн эв эе.

Иргэнлиг, өндөр оюунлиг нийгэм.

Аж үйлдвэржилт, шинэчлэлийн үндсэн дээр эдийн засгийн өсөлтийг хангах.

Бүх нийтээр ажил хөдөлмөр эрхлэх нийгэм.

Түүх, соёл, хэлний нэгдэл.

Үндэсний аюулгүй байдал, дэлхийн болон бүс нутгийн асуудлыг шийдвэрлэхэд манай орны оролцоо(*Казакстан 2050*, 2012).

Эдгээр 7 үнэт зүйл тусгаар тогтнол дээр зангидагдаж байгаа ба Засгийн газар танигдахуйц өөрийн улсын өвөрмөц брэндийг бий болгохын тулд Казакстанд соёлын өвөрмөц дүр төрхийг бий болгох сонирхолтой байна. Үүнийгээ тэд Соёлын үнэт зүйлс дээрээ тулгуурлан хийж буй бөгөөд түүнийг зохицуулах, хамгаалах эрх зүйн орчинг бий болгож улмаар дэлхийд үнэлдэхүйц үнэлэмжийг бий болгохоор ажиллаж буй юм.

Казакстан улс хэд хэдэн түүхэн дурсгалт газруудаа ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд бүртгүүлсэн ба эдүгээ тэдгээр газруудынхаа эргэн тойрон дахь дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэн ажиллаж байна. Энэ нь ирээдүйд Казакстаны соёл, үнэт зүйл дээр суурилсан аялал жуулчлалын газруудыг бий болгоход чиглэж байгаа нь харагдаж байгаа юм. Жишээлбэл: Астана Опера дуурийн теартыг 2010 оноос 2013 оны хооронд бүтээн байгуулсан ба нээлтийн тоглолтоор Казах домогоос сэдэвлэсэн “Биржан-Сара” дуурийг тоглосон байдаг байна (Wikipedia, 2022b).

Тэр үеийн Соёлын яам болон Казакстаны Соёлын судалгааны хүрээлэн нь Казакстаны соёлын бодлогын талаар дугуй ширээний ярилцлага хийж, үндэсний үзэл баримтлалын төслийг боловсруулахад өргөн хүрээний мэргэжилтнүүд, иргэний нийгмийн бүлгүүд, салбарын мэргэжилтнүүд, бүтээлч эвлэлүүд, эрдэмтэн судлаачид, соёл, урлагийн нэрт зүтгэлтнүүдийг татан оролцуулсан байдаг. Казакстаны бусад салбар, улс төрийн байгууллагуудын хамтаар Казакстаны соёл хөгжил дэвшил дунд байна. Улс үндэстний бүтээн байгуулалтын үйл явц нь зөвхөн олборлолт, худалдаа арилжаа дээр тогтож болохгүй, учир нь үндсэндээ тухайн нийгмийн урлаг, соёл нь тухайн нийгмийн үнэт зүйлийн тусгал болдог. Үнэт зүйлгүй бол материал нь үнэ цэнэгүй, нийгэмд түүнийг холбох үзэл сурталгүй болно.

Бүгд Найрамдах Казакстан улсад тогтолцооны өөрчлөлтүүд явагдаж, иргэний нийгэм, нийгмийн төрийн анхны ардчилсан институтууд бий болсон. Ийнхүү иргэний нийгмийг бүрдүүлэх явцад нийгэм соёлын үнэт зүйлс, өнгөрсөн үеийн оюун санааны өвийг чухалчлан хөгжүүлэх, улс орны үнэт зүйлсийг дахин үнэлэх хүнд хэцүү, тууштай бус үйл явцад онцгой анхаарал хандуулсан.

Зах зээлийн эдийн засагт суурилсан нийгмийн бүх улс төрийн тогтолцоог эрс өөрчлөх арга руу шилжих нь хүнийг бүхэлд нь харамлахыг даван туулах, төрийн нийт дарамтыг даван туулах боломжийг олгох үйл ажиллагааны хэлбэрийг хөгжүүлэх, тухайлбал. иргэний нийгмийн институтууд.

Эдийн засагт зах зээлийн шинэчлэлийн үед бүрэн харилцаж, улс төрийн тогтолцоонд ардчилсан, үзэл суртлын хүрээнд олон ургальч үзэл баримтлалыг даван

туулах нь либерализмын үнэт зүйл болох чөлөөт хөдөлмөрийн үнэлэмжийг эрхэмлэн дээдлэх, бүтээлч чадварыг илчлэх, улмаар хөгжүүлэх хэрэгцээг бий болгосон. Өмчлөлийн мэдрэмж нь өмчлөгч нь хүн төрөлхтний амьдралын материаллаг сайн сайхан байдлын үндэс болгон өөрийн бүтээлийг бий болгож, түүний үндсэн дээр өвөрмөц бөгөөд нийгмийн оюуны болон оюун санааны чадавхийг бий болгож чаддаг.

Казахстан-Өрнөдийн туршлагыг өөрчлөх үндсэн өөрчлөлтийн тогтолцоог хэрэгжүүлэх, түүнчлэн даяаршлын эрин үед Казахстаны хөгжлийн тодорхой түүхэн нөхцөл байдлыг харгалзан үзэх. Тиймээс Казахстанд иргэний нийгмийг хөгжүүлэх, хувь хүний бүтээлч чадварыг илчлэх нь бидний өнгөрсөн үеийн Зөвлөлтийн болон уламжлалт аль алинд нь эерэг боломжуудыг ашиглах нь чухал бөгөөд тэдгээр нь зөвшилцөлд хүрч, цаашдын үнэ цэнийг бий болгосон. иргэний нийгмийн институцийг бүрдүүлэх.

Хувийн өмчийн ашиг сонирхлыг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх, газар дээр хувийн өмчийг нэвтрүүлэх, хувь хүн үзлийг хөгжүүлэх, өмчлөх, өмчлөх мэдрэмжийг бий болгох - энэ бүх асуудал нь уламжлалт нийгэмд ийм нөхцөл байдал байгаагүй, үзэл сурталтай холбоотой юм. Зөвлөлтийн нийгэм түүхийн туршид Казахстанд ардчилсан үнэт зүйлийг бий болгоход шаардлагатай зүйлийг практик, нийгмийн ухамсараас устгасан. Судлаачдын үүрэг бол орчин үеийн эдгээр шаардлагад хариу өгөх чадвартай, өнгөрсөн үеийн нийгэм, соёлын үнэт зүйлсийг сэргээх явдал юм.

Өнөөгийн Казахстаны нийгэмд улс төрийн хөгжлийн сонгосон чиглэлээ амжилттай хэрэгжүүлэхийн тулд иргэний нийгмийн төлөвшлийн хүрээнд сэргэсэн өнгөрсөн үеийн үнэт зүйлсийг нэгтгэх шинэчлэлийг үзэл суртлын болон суртал ухуулгын дэмжлэгийг нэмэгдүүлэх, бэхжүүлэх шаардлагатай гэж миний бодлоор нийгэм, нийгмийн эрх зүйн төр.

Уламжлалт казах нийгэмд "бид" гэдэг ойлголт "би"-ээс илүү хүчтэй байсаар ирсэн. Нэгдэлчлэлийн зарчмыг чухалчилдаг өмчийн харилцаа ч мөн адил байсан. Гэсэн хэдий ч газар ашиглах механизмын нарийн төвөгтэй байдлыг үл харгалзан газар өмчлөлийг тодорхой зохицуулдаг. Өмнө нь Казахстанд өмчийн гурван үндсэн хэлбэр (хувийн, нийтийн болон нийгмийн бүлэг) тодорхойлогддог. Хамтын болон хувь хүний ашиг сонирхлыг уялдуулах нь объектив нөхцөл байх ёстой. Иргэний нийгмийг хөгжүүлэхэд холимог эдийн засгийг бий болгох нь чухал. Зах зээлийн механизмаар зохицуулагддаг тэгш, олон талт өмчийн хэлбэрүүд нь эдийн засгийн үйл ажиллагааны хэлбэр, аргыг чөлөөтэй сонгох, эдийн засгийн эрх чөлөөг эдэлдэг. Хамтын өмчийг (хоршоо, корпорац, түрээс) хөгжүүлэх үйл явцын жинхэнэ хамтын, объектив үндэс суурийг сэргээх шаардлагатай байна.

Казахстанд шинээр бий болж буй иргэний нийгмийн гол үнэт зүйл бол тусгаар тогтнол, эрх чөлөө бөгөөд эв нэгдэл, эв нэгдэл, хүлээцтэй байдал, хөгжил цэцэглэлт нь үндсэн үнэт зүйл болох эрх чөлөө нь хүн бүрт өөрийгөө танин мэдүүлэх боломжийг олгодог. Нүүдэлчин угаасаа эрх чөлөөг хайрлах сэтгэлтэй байсан. Эргэн тойрон дахь орон зайд онцгой хамааралтай эрх чөлөөний мэдрэмжийг төрүүлж, цоо шинэ ертөнцийг бий болгож, дэлхийг гүн гүнзгий сонирхохыг бий болгосон.

Иргэний нийгэм нь өөр төрлийн соёл иргэншил, үндэсний, хөдөлмөрийн, нутаг дэвсгэрийн болон бусад эвлэл, холбоо, хамт олныг төлөөлдөг бөгөөд тэдгээр нь жинхэнэ өөрийн гэсэн үндсэн дээр ажилладаг. Бид Казах тосгонд нэгэн цагт уламжлалт эрх мэдэлтэй зэрэгцэн оршиж, олон нийтийн "ахмад"-ын гишүүдийг сонгосны үр дүнд бий болсон өөрийгөө удирдах нэг төрлийн байгууллага байсныг түүхээс мэднэ. хамтарсан амьдрал овгийнхон. Энэхүү өөрийгөө удирдах орчин үеийн хэлбэрээр судлаачид үнэний үр тариа, түүнийг орчин үеийн нийгэмд ашиглах боломжийг олж хардаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Бүх казахуудын соёл, сэтгэл зүй, түүхэн өнгөрсөнд гүн гүнзгий үндэс суурьтай үндэсний үзэл санааг нэгтгэх үндсэн дээр казахуудын нийтлэг эх оронч үзлийг төлөвшүүлэхгүйгээр иргэний нийгмийн ардчилсан институцийг бий болгох үйл явц боломжгүй юм. Уламжлалт казах нийгэмд эх орноо хайрлах, түүнийг шүтэх, хүндэтгэх, ахмад настнуудыг хүндэтгэх зэрэг хүчтэй үнэт зүйлс байсан.

Биднийг өнгөрсөн үеэс өвлөж авсан нэгдмэл үнэлэмжийн дунд үндэстэн, шашин хоорондын эв найрамдал, нийгэм-улс төрийн тогтвортой байдал онцгой ач холбогдолтой юм. Эдгээр нь Казахстаны олон үндэстний нийгмийг нэг үнэ цэнийн үндэс болгон төлөөлдөг бөгөөд үүнтэй уялдуулан Казахстанд ардчиллын үнэт зүйлсийг гүнзгийрүүлэх боломжтой бөгөөд тэдгээрт тулгуурлан иргэний нийгмийн институцууд бий болох ёстой.

Шашны хүлцэл, казах ард түмний түүхэн уламжлалд шашны шүтэн бишрэгч, түрэмгийлэл байхгүй, бусад ард түмний оюун санааны эрх чөлөөг хүндэтгэх нь шашин хоорондын үр дүнтэй яриа хэлэлцээг хөгжүүлэх, шашныг үндэстэн гэж хүлээн зөвшөөрөхөд чухал ач холбогдолтой сайн бөгөөд чухал үнэт зүйл юм. иргэний нийгмийн чухал элемент.

Ийнхүү тоталитаризмын үед төөрсөн Казахын соёл, оюун санааны сэргэн мандалт, нийгэм, улс төрийн өөрчлөлтийн хүрээнд казах гүн ухааныг уламжлалт соёлын орчлон ертөнцтэй уялдуулан хөгжүүлэх нь оюун санааны хэрэгцээг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Казахстаны эрх чөлөө, тусгаар тогтнол нь дэлхийн хөгжлийн нөхцөлд үндэсний ухамсрын өсөлт, ард түмнийг нэгтгэх, ард түмний үндэсний болон соёлын өвөрмөц байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Казах, орос хэл дээрх хувь хүний дахин боловсруулсан нийтлэл, ярилцлага болон бусад материалд үндэслэн бичсэн энэхүү номонд Казахстаны тогтолцоог шинэчлэх үйл явцад казах ард түмний оюун санаа, соёлын өвийг чухалчлан хөгжүүлэх талаар дурджээ. даяаршлын эрин үе, Казахстаны загвар иргэний нийгэм, халамжийн төрийг байгуулах үүднээс манай улсыг дахин үнэлэх. Өнгөрсөн үеийн үнэт зүйлстэй харилцах нь хямралын дараах Казахстаны дэлхийн харилцааны соёл, оюун санааны аюулгүй байдлыг бэхжүүлэх чухал хэрэгсэл юм.

Тусгаар тогтносон Казахстан улс үүсч хөгжих үйл явцын үндэслэл, үнэт зүйлсийн шинэ тогтолцоог тодорхойлсон. Орчин үеийн казах нийгмийг шинэчлэх, өөрчлөх үйл явцад манай улсын үндсэн үнэ цэнэ, Ислам ба Ортодокс Христийн шашны оюун санааны

үнэт зүйлс болох үзэл баримтлалын шинжилгээний бие даасан байдалд онцгой анхаарал хандуулдаг.

Киргизстан

Киргизстаны төрийн үнэт зүйлс нь Киргизстаны 2018-2040 он хүртэлх урт хугацааны хөгжлийн стратегит үнэт зүйлийн талаар нэлээд их орсон байна. Киргиз хэлэнд үнэт зүйлийг "баалуулук" хэмээн хэлдэг байна. Киргизстаны засгийн газраас 2018 онд "2018-2040-жылдары КЫРГЫЗ РЕСПУБЛИКАСЫН ӨНҮКТҮРҮҮНҮН УЛУТТУК СТРАТЕГИЯСЫ" Киргизийн Бүгд Найрамдах Улсын 2018-2040 оны Үндэсний Хөгжлийн стратегит хэмээх урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан баталсан байдаг. Энэхүү хөгжлийн хөтөлбөрт Киргизстан Улс өөрсдийн үндэстэн улсыг бүтээхэд ямар үнэт зүйлсийг өөрсдийн үнэт зүйлс хэмээн үзэх талаараа тусган өгсөн байдаг.

2040 он гэхэд хөгжилд чиглэсэн хувь хүний шинэ дүр төрх Киргиз улсад түгээмэл болж, түүний чадавхи нь түүнд өөрийгөө болон гэр бүлийнхээ амьдралын зохистой түвшинд хүрэх боломжийг олгоно. Тэрээр Киргизийн ард түмний түүх, соёл, уламжлалд тулгуурласан оюун санааны үнэт зүйл болсон шударга нийгэмд амьдрах болно. Хувь хүн өөрийн үйлдлийнхээ төлөө нийгмийн өмнө хариуцлага хүлээх бөгөөд нийгэм нь хүлээн зөвшөөрөгдсөн дүрмийг зөрчих, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах явдлыг үгүйсгэх болно. Хөгжил, боловсрол, эрүүл мэндийн үнэт зүйлд чиглэсэн хүний амьдралын хэв маягийг ирээдүйдээ хөрөнгө оруулах арга хэлбэр болгон өргөнөөр ашиглах болно.

Киргизийн иргэн бүрийн хувьд гэр бүл нь сүнслэг байдал, боловсрол, хүмүүжил, хүний амьдралыг хамтран зохион байгуулах, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх зайлшгүй элемент болно. Уламжлалт иргэний, гэр бүл, оюун санааны болон соёлын үнэт зүйлсийн үүрэг нь хойч үеийн залгамж чанарыг дэмжих нь дэлхийн хурдацтай харьцуулахад эдийн засаг, технологийн хөгжлийн динамикийг алдагдуулахгүйгээр Киргизийн үндэсний өвөрмөц байдлыг хадгалах боломжийг олгодог.

Төрийн бодлого нь бүтээлч, шинжлэх ухаан, сурган хүмүүжүүлэх хамтын нийгэмлэгийг идэвхжүүлж, уламжлалт үнэт зүйлстэй хүн төрөлхтний соёлын дэвшилтэт ололтыг хослуулсан оюун санааны хувьд баян улс орныг бүрдүүлэхэд бүтээлч иргэдийг татан оролцуулна. Киргиз улсыг бүс нутгийн урлаг, урлагийн салбар, уламжлалт оюун санааны төв болгох, тэр дундаа жуулчдыг татах арга хэмжээ зохион байгуулахад чиглэсэн ирээдүйтэй төслүүдийг хэрэгжүүлэх нь чухал юм.

Үнэт зүйлийг хөгжүүлэх нь соёл, соёл судлал, соёлын социологи-түүх, соёлын антропологи, соёлын эдийн засгийн шинжлэх ухааны иж бүрдэл, хэрэглээний судалгаанд тулгуурлана.

Хэвлэл мэдээллийн гол үүрэг бол улс орныхоо тухай бодитой мэдээллээр улс орны хүн ам, олон улсын хамтын нийгэмлэгт хүргэх, ард түмний соёл, түүхийн баялаг өв, үндэсний үнэт зүйл, уламжлал, нийгмийн амьдралын янз бүрийн салбарт ололт амжилтыг сурталчлах явдал юм. .

Шашны байгууллагын үйл ажиллагаанд төрийн зохицуулалт илүү идэвхтэй, үр дүнтэй болно. Уламжлалт шашин-Ханафи шашны болон үнэн алдартны шашны үнэт зүйлсийг дээдлэн, орчин үеийн иргэний болон эрх зүйн төрийн зарчмыг сурталчлах, мэдээллийн орон зайд төрийн байгууллагуудын ноёрхлыг хангах зорилгоор төсвийн санхүүжилт олгоно.

Гэр бүл, хувь хүн ба "үнэт зүйл"

Исламын шашин

Монгол Улстай харьцуулахад Казакстан болоод Киргизстан нь ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан угсаажилтын хувьд зөвхөн нэг угсаатны бус улсууд юм. Казакстан улс л гэхэд 2009 оны байдлаар 63,1% нь Казакууд бол 23,7% нь Оросууд, Узбек болон Украйнууд 2-3%-ийг эзэлдэг байсан (Kenneth Kumitai, 2019) бол 2021 оны байдлаар Казакууд 70%, Оросууд 15,5%, Узбекууд 3,2%, Украйнууд 2% (Wikipedia, 2022a) эзэлж байна. Харин Киргизстаны хувьд 73,3% нь Киргизууд бол Узбекууд 14,6%, Оросууд 5,6% (Ferdinand Vada, 2019) байдаг байна. Эдгээр 2 улс нь одоогоор нийт хүн амын 70 гаруй хувь нь уугуул угсаатнаасаа бүрэлдсэн улс байгаа нь харагдаж байгаа боловч нийт хүн амынхан багагүй хувийг ялангуяа Казакстан Улсын хувьд Оросууд эзэлж байна.

Энэ 2 улс 1990 он хүртэл 80 орчим жилийн турш ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан ба улмаар ЗХУ-ын бодлогын дагуу шашин шүтэх эрх чөлөө нь хязгаарлагдамал байсан. 1990 оноос шашны эрх чөлөө нь нээлттэй болсноор шашин сэргээж эхэлсэн. Хоёр улсын хувьд ЗХУ Хаант Орос Улсыг түлэхэн унагаж болшвекууд төрийн эрхэнд гарахаас өмнө Исламын шашинтай байсан дахин шашин сэргэснээр өөрсдийн исламын шашнаа сэргээж эхэлсэн нь дамжиггүй. Мөн бидний судалгаандаа авч үзэж буй улсууд нь Исламын шашин дотроо Сүннитийн Ханафи⁹-н чиглэлийг шүтдэгээрээ адилхан байна. Тэдний голлох шашны хувьд Исламын шашин нь төрийн ч хийгээд, ард иргэд, хувь хүмүүсийн хувьд ч үнэт зүйл нь болж байдаг бололттой. Яагаад гэвэл Казакстан улс л тусгаар тогтнолоо зарласанаасаа хойш эдүгээ 2900 нь исламын шашны мечеттэй болсон байна.

Хоол хүнс – Зочлох ёс

Казакстан

Казахстаны зочломтгой зан заншил нь дорно дахины бусад соёлтой ижил төстэй зүйл бөгөөд бүгд зочдод хүндэтгэлтэй ханддаг. Эрт дээр үед казахууд зочноо зохих ёсоор хүлээж аваагүй (урилгагүй хүн ч гэсэн) маш хатуу зэмлэл хүртдэг байсан. Зочдыг хүлээн авах нь мэндчилгээгээр эхэлсэн бөгөөд дараа нь зочдыг өргөөний хамгийн хүндэтгэлтэй газар (ихэвчлэн төв, арын хэсэгт) суулгав. Үүний дараа зочдыг кумис, төрөл бүрийн зууш, махаар дайлсан. Зарим тохиолдолд тэдэнд бэлэг гардуулж, хүндэт зочдод ихэвчлэн шапан (дээл) өгдөг байв.

⁹ Ханафи – Hanafi нь Исламын шашны Сүннитын урсгалын хамгийн анхны 4 сургаалын нэг юм. VIII зууны үед Куфаны Абу Ханафи тус урсгалыг үүсгэж IX зууныг гэхэд Аббасидын эзэнт гүрний дэмжлэгтэйгээр одоогийн Ирак орчимд бэхжин тэлсээр одоогийн Казакстан, Киргизстан зэрэг улс орнуудад тархсан байдаг.

Казахын ард түмний зочломтгой зан заншил нь нөхцөл байдал, зочны статусаас хамааран олон янзын зан заншлыг агуулдаг.

- Мингизип шапан жабу бол зочдод морь, дээл бэлэглэдэг дээд хүндэтгэлийн заншил юм.
- Бата – зочин явахад ерөөл өгдөг, ялангуяа зочин холын аянд явж байгаа бол. Ихэнхдээ энэ уламжлалыг яруу найргийн сайхан хэлбэрээр илэрхийлдэг.
- Белкотерер бол ахмад настнуудад анхаарал халамж, хүндэтгэлийг бэлэгддэг өндөр настай зочдод зориулсан амттан юм.
- Бесжаксы - энэ нь "таван бэлэг" гэж орчуулагддаг бөгөөд ат мингизип шапан жабутай адил юм. Таван бэлэг нь тэмээ, морь, хивс, ганзага, үслэг дээл юм.
- Коримдик - зочдод залуу бэр эсвэл шинэ төрсөн хүүхдийг харах эрхийг өгдөг бэлэг.
- Конакаси - зочдод, тэр ч байтугай энгийн эсвэл урилгагүй хүмүүст үйлчлэх ёстой амттан. Хэрэв гэрийн эзэн конакасийг танилцуулаагүй бол зочин тосгоны ахмадад гомдол гаргаж болох бөгөөд гэрийн эзэн морь эсвэл бусад мал хэлбэрээр торгууль төлөх ёстой.
- Конаккаде – зочноос гэрийн эзэнд өгөх бэлэг нь ихэвчлэн дуу, шүлэг хэлбэртэй байдаг.
- Шашу бол хуримын ёслол, нөхөрлөх үеэр болон бусад ижил төстэй арга хэмжээнд зочдод чихэр, мөнгө өгөх заншил юм.
- Ерулик бол овог, тосгонд шинээр ирсэн хүмүүст одоо байгаа оршин суугчидтай уулзахдаа тэднийг орон нутгийн амьдралд дасан зохицоход нь туслах зорилгоор материаллаг тусламж үзүүлдэг эртний зочломтгой заншил юм (Advantour, 2022).

Киргизстан

Киргиз ард түмэн эрт дээр үеэс нээлттэй, эелдэг, хүндэтгэлтэй, зочломтгой зангаараа алдартай. "Киргизийн гол сонирхол юу вэ?" Гэсэн асуултын талаар ярихад: Энэ нь барилга байгууламж, хөшөө дурсгал, тодорхой газар биш, харин Киргизийн домогт зочломтгой байдал юм. Эцсийн эцэст энэ нь Киргизүүдийн цусанд байдаг. Киргизээр аялахдаа, ялангуяа хөдөө орон нутагт нутгийн иргэд таныг цайнд урьж, янз бүрийн амттангаар дайлдаг байна.

Киргизүүд "Зочин бол гэртээ аз жаргал" гэсэн зүйр үгтэй байдаг тул гэрт байгаа бүх сайн сайхан бүхнийг зочдод зориулдаг байв. Хэдийгээр тэд өөрсдөө идэх юмгүй байсан ч зочин хэзээ ч дутахгүй, байгаа бүхнээ хуваалцдаггүй байв. Киргиз улс руу аялан тоглолт хийхээр төлөвлөж байхдаа таныг бараг хаа сайгүй хүлээж авах болно гэдэгт бэлэн байгаарай. Учир нь өнөөг хүртэл энэ ёс заншил хадгалагдан ирсэн бөгөөд тэд зочдыг хүлээн авахдаа анхааралтай бэлтгэж, хамгийн сайн хоолыг ширээн дээр тавьж, хувцас, мал, үнэт эдлэл болон бусад зүйлийг бэлэг болгон өгдөг.

Киргиз улсад аялах үеэр жуулчид Киргизүүдийн өгөөмөр сэтгэлийг тэмдэглэдэг. Уригдсан ч бай, уригдаагүй ч бай зочны үзүүлж буй хүндэтгэл үнэхээр сайхан. Алслагдсан бүс нутгуудад сайн зочид буудал, зочны байшин, дэд бүтцийг олох нь тийм ч хялбар биш боловч нөгөө талаас зочин бүрийг хүлээн авах сайн хүмүүстэй уулзах

болно. Хэл мэдэхгүй байх нь асуудал биш, учир нь хүмүүс гар, хөлөөрөө тайлбарлахад бэлэн байдаг тул бие биенээ ойлгоход хэцүү байх болно. Танд юу ч тохиолдсон тэд чамайг ганцааранг нь орхихгүй, харин бүх талаараа тусалж, дэмжлэг үзүүлэхийг хичээдэг байна (Travel land, 2022).

Бүлгийн дүгнэлт

Тус бүлэгт дурдсан Казакстан, Киргизтаны тохиолдолд шашин нь тэдний нийгэм, соёлын гол үнэт зүйл болж, талбарын байгуулж байдаг. Засгийн газрын талбарын тухайд бодлогуудаас нь харахад тусгаар тогтнол, эрх чөлөө гэх мэт ойлголтуудыг чухалчилж байгаа ч шашин бол тэдний бүх талбарт хамгийн гол үнэт зүйлүүдийг бүтээж байдаг байна. Мөн эртний нүүдэлчин уламжлалын дагуу мэндлэх хүндлэх, дайлж цайлах зэрэг олон ёс заншил нь тэдний хувьд эдүгээ ч үнэт зүйл болон хувь хүмүүс, гэр бүлийн түвшинд тэдний зан суртахууныг хэлбэржүүлж өгжээ.

Дүгнэлт

ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.3.4. Монгол болон Дотоод Азийн улс орнуудын оюун санааны нэгдмэл үнэт зүйлийн жагсаалтыг бэлдэх ажлын хүрээнд Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай зэрэг аймгуудын 20 суманд хээрийн судалгааны ажлыг хийж, нийт 50 орчим ярилцлага, судалгаа гүйцэтгэсэн байна.

Бидний хийж буй энэхүү судалгаа нь Монгол Улсын Засгийн газраас баримталж буй “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт багтсан Үндэсний үнэт зүйлс бүлгийн хүрээнд Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр нарийвчлан судалж, хөдөлшгүй бодит баримтад үндэслэсэн “эх хэл, эх түүх, өв соёлыг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар, дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно (УИХ 2020) хэмээх нэгдүгээр бүлгийн зорилгыг биелүүлэхэд тус болохуйц антропологийн судалгааг хийхэд чиглэж буй ба тус нэгдүгээр бүлгийн Зорилт 1.2. Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно; Зорилт 1.4. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон монголын түүх, хэл, соёл, ёс заншил, нүүдлийн соёл иргэншил, шашин, гүн ухааны судалгааг хийж нийтийн хүртээл болгон хэвшүүлж, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ гэх зорилтууд болон Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно хэмээн заасан байгаа нь энэхүү судалгааг хийх зайлшгүй хэрэгцээ шаардлага байгааг харуулж байгаа хэмээн үзсэн буй тул дээрх судалгааг хийсэн юм.

Бидний энэхүү судалгааны зорилго нь юуны түрүүнд Монгол Улсын соёл, оюун санааны нэгдсэн үнэт зүйлсийг судлан гаргаж ирэх ба түүнийгээ Дотоод Азийн бүс нутгийн бусад улс орнуудын үнэт зүйлстэй харьцуулан антропологийн өнцгөөс судлах явдал байсан юм. Улмаар тус судалгааг энэ жилийн 4 сарын сүүлээс эхлэн эхлүүлж эдүгээ дараах дүгнэлтүүдэд хүрээд байна.

Монголын үнэт зүйлсийг төрийн зүгээс Монгол хэл, соёл, түүх гэх 3 зүйл дээр тулгуурлан бүтээхэд чиглэсэн төрийн бодлого хэрэгжүүлж байгаа нь харагдаж байгаа юм. Монгол Улсын хувьд нэг үндэстний улс тул төрөөс Монгол хэл, нүүдлийн соёл, түүх дээрээ тулгуурласан цаашлаад бахархал дээр суурилсан Монгол Улсыг бүтээхэд энэхүү үнэт зүйлс гэх ойлголтыг ашиглаж байгаа юм. Үүнээс гадна Үндэстний үнэт зүйлсийн талаар төрийн бодлогод эрдэмтэн судлаачдын талбар хамгийн ихээр нөлөөлж буй юм. СУИС-аас хийсэн Монголчуудын үнэт зүйлийн социологийн судалгаанд үндэслэж 9 зүйл бүхий үнэт зүйлийг ‘Эрдэнийн судар’-ийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн хэмжээнд залсан зэргээс харж болохоор байгаа юм.

Монголчуудын үнэт зүйлсийн талаар төрийн бодлогоос гадна гэр бүл, хувь хүн зэрэг нийгмийн дотоод бүтцийн хүрээнд үнэт зүйлийг хэрхэн авч үзэж байгаа талаар авч

үзсэн юм. Энэхүү хувь хүн, гэр бүл зэрэг ниймгийн анхдагч, микро давхаргын хүрээнд үнэт зүйл буюу тухайн хүмүүсийн хамгийн эрхэмлэж явдаг зүйлс нь төрийн бодлогоос илүү олон талт, ялгаатай байгаа юм. Ард иргэдийн хувьд Монгол хэл болон түүхийг төдийлөн эрхэмлэн үзэхгүй байсан бөгөөд харин уламжлал, нүүдлийн соёлыг ихэнхи тохиолдолд эрхэмлэн үзэж байсан юм. Тэр дундаа хөдөлмөрч, тусч, ахмад настнаа хүндэлдэг зэрэг зан чанаруудыг эрхэмлэн үзэж байсан юм. Эдгээр зан чанарууд нь өөрөө эргээд нүүдлийн соёл нь хэлбэржүүлэн бий болгосон зан чанарууд байгаа нь харагдаж байсан юм. Нүүдлийн соёлын хамгийн чухал элементүүд болох мал, бэлчээр, нүүдэл, байгаль, цаг уур, орчин нөхцөл зэргээс улбаатайгаар нүүдэлчин, малчин хүн малаа эсэн мэнд өсгөн бойжуулахын тулд өглөөнөөс шөнө хүртэл малаа бэлчээрлүүлэн хөдөлмөрлөх шаардлагатай болсон. Улмаар энэхүү малаа дээрээ суурилан олон янзын зан заншил, хэм хэмжээ, хөдөлмөрийн хуваарь зэрэг бий болж хот, саахалт айлууд харилцан бие биедээ туслах зэргээр тусч занг эрхэмлэж байгаа юм. Эдгээрээс харвал ниймгийн микро төвшинд ч үнэт зүйл гэдэг өөрийгөө бүтээдэг хэрэгсэл болох нь харагдаж байгаа юм.

Хятадын төрөөс үнэт зүйлийг Хятадын 56 үндэстэнг нэгэн үндэстэн болгох хэрэгсэл болгон ашиглаж байгаа нь Хятадын Засгийн газрын зүгээс баталсан 3 төвшин бүхий нийт 24 ханз үнэт зүйлсүүдээс харагдаж байгаа юм. Олон үндэстэн угсаатны Хятад улсын хувьд үнэт зүйлс нь төрийн хэмжээнд нэгтгэх, нийлүүлэх, онцлог ялгаатай байдлыг устгах хэрэгсэл болж байхад Өвөрмонгол зэрэг бага тоот үндэстэн угсаатны хувьд Хятадын төрөөс өөрсдийн ялгаатай байдлыг харуулах гол хэрэгсэл болж байгаа юм. Тэд Монгол гэх ижилслийг өөрсдийн үнэт хэмээн бодож тухайн үнэт зүйлсэд нь халдсан Хятадын бодлого зэргийг эсэргүүцэх зэргээр өөрсдийн үнэт зүйлээ хамгаалж байгаа юм.

Орос Улсын хувьд эх орныхон бүрэн эрхт аюулгүй байдал хамгийн чухал зүйл хэмээн төрийн зүгээс үзэж байгаа нь харагдаж байгаа юм. НАТО, Европын холбоо зэрэг барууны хүчнээс өөрсдийн улсыг хамгаалах нь тэдний хувьд хамгийн эрхэм зүйл болж байгаа бол Орос Улс доторх Буриад зэрэг өөр угсаа гарал бүхий үндэстнүүдийн хувьд тэдний гэр бүлийн болоод өөрсдийн амь нас, эрүүл мэнд зэрэг аюулгүй байдал нь үнэт зүйл болох нь бидний судалгаагаар харагдаж байгаа юм. Тэд гэр бүлийнхээ болоод өөрсдийн аюулгүй байдлын төлөө Монгол зэрэг улс орнуудруу дүрвэн гарч ирж байгаа боловч эх оронд нь үлдсэн гэр бүлийнхэн аюулгүй байдал адлагдахад хүрвэл буцан очиж хамгаалан байдлах болно зэргээр өөрийнхөө гэр бүлийн аюулгүй байдлыг хэр чухал, үнэт зүйл болохыг харуулж байсан юм.

Казакстан, Киргизстан зэрэг 1990 оноос хойш тусгаар тогтнолоо олж авсан улсуудын хувьд тусгаар тогтнол нь хамгийн эрхэм зүйл болж байгаа юм. Ялангуяа Казакстан Улсын хувьд тусгаар тогтнол гэдэг зүйл нь үнэт зүйл хэмээн бодлогын хүрээнд тунхагласан бол Киргизстан Улсын хувьд өөрсдийн соёлын өвөрмөц онцлог шинжийг чухалчилж авч үзэж байгаа юм.

Энэ бүхнээс нэгтгэн дүгнэхэд үнэт зүйл гэдэг нь нийгмийн хамгийн жижиг нэгж болох нэг хувь хүнээс авхуулаад хамгийн том нүсэр бүтэц болох төр хүртэл бүхий л талбаруудад өөрсдийгөө бүтээхэд ашигладаг багажны шинжтэй (instrumentalist) зүйл

гэдэг нь харагдаж байгаа юм. Энэхүү багаж нь тухайн бүтээж буй зүйлийн онцлог шинжийг илэрхийлж байхаас гадна талбар бүрт нийтлэг ба ялгаатай зүйлийг бий болгож тэр нь нийгмийн нөхцөл байдлаас хамааран тасралтгүй хувирч өөрчлөгдөж байдаг зүйл юм.

Ном зүй

- Advantour. (2022). *Hospitality Traditions in Kazakhstan*. Advantour.
<https://www.advantour.com/kazakhstan/traditions/hospitality.htm#:~:text=The%20EE%80%80hospitality%EE%80%81%20traditions%20of%20the%20Kazakh%20people%20include,if%20the%20guest%20is%20going%20on%20a>
- С. Соёлмаа. (2020). *Философийн үндсэн мэдэгдэхүүн*. Соёмбо принтинг.
- Claude Levi-Strauss. (2006). *Structural Anthropology-1* (Zhang Zujian, Ed.; Chinese edition). Renmin University of China Press.
- Clyde Kluckhohn. (1951). Values and Value-Orientations in the Theory of Action: An Exploration in Definition and Classification. In Talcott Parsons & Edward A. Shils (Eds.), *Toward a General Theory of Action* (pp. 388–433). Harvard University Press.
- DAndrade, R. (2008). *A Study of Personal and Cultural Values: American, Japanese, and Vietnamese (Culture, Mind and Society)* (1st edition). Palgrave Macmillan.
- Emile Durkheim. (1997). *Le-cons de sociologie*. Presses Universitaires de France - PUF.
- Emile Durkheim. (2001). *The Elementary forms of the Religious life*. Oxford University Press.
- Ferdinand Bada. (2019, January 8). *Ethnic Groups Of Kyrgyzstan*. Worldatlas.Com.
<https://www.worldatlas.com/articles/ethnic-groups-of-kyrgyzstan.html>
- Karl Marx. (1987). *The Capital* (Chinese edition). Economic Science Press.
- Kenneth Kunitai. (2019, July 31). *Ethnic Groups Of Kazakhstan*. Worldatlas.Com.
<https://www.worldatlas.com/articles/ethnic-groups-of-kazakhstan.html>
- Kiki Zhao. (2016, September 1). China’s “Core Socialist Values,” the Song-and-Dance Version. *The New York Times*. <https://www.nytimes.com/2016/09/02/world/asia/china-dance-socialist-values.html>
- Lebedeva, N. M., & Tatarko, A. N. (2018). Basic Values in Russia: Their Dynamics, Ethnocultural Differences, and Relation to Economic Attitudes. *Social Psychology*, 11(3), 36–52. <http://psychologyinrussia.com/volumes/index.php?article=7341>
- Max Weber. (1958). *The Religion of India_ The Sociology of Hinduism and Buddhism (1958)*. The Free Press.
- Max Weber. (2019). *Economy and Society* (Yan Kewen, Ed.; Chinese edition, Vol. 1). Shanghai People’s Publishing House.
- Michel Foucault. (2018). *Security, Territory and Population* (Han Qian & Xiaojing Chen, Eds.; Chinese edition). Shanghai People’s Publishing House.
- Patrica Buckley Ebrey, & James L.Watson. (1986). *Kinship Organization in Late Imperial China 1000-1940*. SMC publishing.
- Talcott Parsons. (1964). *Social structure and personality*. The Free Press.

- Travel land. (2022). *Hospitality as the main symbol of Kyrgyzstan*. Travel Land Kyrgyzstan Is a Tour Operator in Central Asia. . <https://trvlland.com/blog/hospitality-as-the-main-symbol-of-kyrgyzstan>
- Wikipedia. (2022a, October 17). *Ethnic demography of Kazakhstan*. Wikipedia.Org. https://en.wikipedia.org/wiki/Ethnic_demography_of_Kazakhstan
- Wikipedia. (2022b, November 10). *Astana Opera*. Wikipedia.Org.
- Wikipedia.org. (2022). *Film industry*.
- World 101. (n.d.). *What Is Soft Power?*
- Xi Jinping. (2014). *How to Deepen Reform Comprehensively*. Foreign Languages Press.
- Ying Zhu. (2017, July 5). *Film as soft power and hard currency: The Sino-Hollywood courtship*. Theasiadialogue.Com.
- Zhao Xu. (2015). *Competition and Compassion in Chinese Secondary Education* (1st edition). Palgrave Macmillan.
- АИХ. (1992, January 13). *Монгол Улсын Үндсэн Хууль*. <https://legalinfo.mn/mn/detail/367>
- Б. Түвшинзаяа, Ц. Булган, Б. Дэлгэрсайхан, Г. Нарантунгалаг, & А. Одгэрэл. (2015). *Монголчуудын Үндэсний Үнэт Зүйлийн судалгааны тайлан*.
- Б. Хэрлэн, Ш. Түдэв, & Ч. Санжмятав. (2017). 5. 2017 - *Mongolchuudiin unet zuiliig Shvartsiin argachlalaar todorhoiloh ni N -005*.
- БНХАУ-ын Коммунист Намын тунхаг, (2017).
- Бүх Хятадын Ардын Төлөөлөгчид. (2022). 13 дахь удаагийн Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын 5-р чуулганы эмхтгэл. *13 Дахь Удаагийн Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын 5-р Чуулган*.
- Б.Энхтүвшин. (2011). *Нүүдэлчдийн соёл: Үнэт зүйлс, Хөгжлийн чиг хандалга*.
- Д.Бум-Очир, & Г.Мөнх-Эрдэнэ. (2018). *Нийгэм-соёлын хүн судлалын онолын үүд (хоёрдах хэвлэл)*. МУИС пресс.
- Жапсарбай Куанышев. (2019, April 8). *Ұлы Дала мәдениетінің қайнар көздері және тарихи сана ренессансы*. Memleket Tarihy Institutу.
- Монгол Улсын Ерөнхийлөгч. (2020, December 22). *“Эрдэнийн судар”-ыг дээдлэн залах тухай*. Legalinfo.Mn.
- Казакстан 2050*, (2012) (testimony of Н.А.Назарбаев).
- The Constitution of the Russian Federation , (1993).
- УИХ. (2020, May 13). *“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО*.
- ОХУ-ын үндэсний аюулгүй стратеги-2021, (2022).

Үндэсний Статистикийн хороо. (2021). *МАЛЫН ТОО, төрлөөр, улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, багаар, хороогоор, жилээр*. Үндэсний Статистикийн Хороо. http://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1001_021V1&BAG_select_all=0&BAGSingleSelect=_185_18513_1851351_1851353_1851355_1851357&TYPE_OF_LIVESTOCK_select_all=0&TYPE_OF_LIVESTOCKSingleSelect=_0105&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2021&viewtype=table

Ц. Баатартогтох. (2000). *Монголчуудын үнэлэмжийн судалгааны философийн асуудал*.

Ц.Гомбосүрэн. (2008). *Философи, сурах бичиг* (3 дахь хэвлэл). МУИС хэвлэх үйлдвэр.

Э. Сонинтогос, Ч. Алтанцэцэг, Р. Дарьхүү, Ж. Долгорсүрэн, Г. Чулуунбаатар, & А. Цанжид. (2019). *Монголчуудын үнэт зүйл судалгааны тайлан*.

ЮНЕСКО. (2005, October). *Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенц*.

Хавсралт

Баярмангай, Архангай Өндөр-Улаан

- **Одоо энэ адууны соёл монголчуудад хэр эрхэм үнэтэй зүйл байдаг юм бол?**

- Энэ чинь үнэтэйгээс үнэтэй, эрхмээс эрхэм зүйл байдаг байхгүй юу. Угаасаа хэзээний монгол хүн морио хайрлаж, адуугаа дээдэлж, төрийнхөө дээр сүлдэнд залж ирсэн. Тийм учраас энэ бол ямар ч хамаагүй аргаар авч үлдэх ёстой тийм зүйл.

- **Та сая ямар ч хамаагүй аргаар авч үлдэх ёстой гэлээ, тэгвэл залуу хүний хувьд яаж, ямар аргаар авч үлдэх ёстой вэ?**

- Одоо энэ залуучууд морь унахаа болиод, яг эргэлт хийсэн хүн гэвэл онгирсон болох байх, зүгээр хэлэхэд би яг залуучуудыг нутагтаа байлдан дагуулсан хүн байхгүй юу. Би цэргээс ирээд Сүхбаатарын залуучуудыг хараад, яасан сайхан морь унадаг, ямар ч гоё эмээл, хазаар эдэлж хэргэлдэг залуучууд вэ гэж бодсон. Тэгсэн манай эндэхийн залуучууд мотоцикл унаад л хаазлаад байна. Би цэрэгт байхдаа, нарийн зангилаа зарим гоё сүлжээснүүдийг сураад бас сийлбэр хийж сурсан. Тэгээд за би энийг халагдаж очоод заавал нутагтаа хэрэгжүүлнэ гээд хийсэн. Нутгийн залуучуудыг тэгмээр байна, ингэмээр байна гэсэн миний үгэнд ч орсон. Бид хэд орон нутгийн сонгуулиар бөөнөөрөө морьтой орсон. Тэгэхэд хүмүүс юу болов оо яав, ийв гээд гайхаж сонгуулиар

- **Хэчнээн залуучууд байсан бэ?**

- Баянгол багийн 12, 13 залуу байсан. Орой нь галын наадам зохиосон. Сайхан галаа тойроод бүжиглэж бариад, араас нь адуучин тэмцээн зохион байгуулсан. Тэгсэн чинь нөгөө цар тахлын хүрээнд гээд бид нар чинь яах вэ өөр багийн залуучууд оруулахгүй, зөвхөн баг дундаа гайгүй байр шагналыг нь өгье, багийн залуучууд алалцах юм чинь гэж бодоод түрүүлсэн хүнд нь манайх өөрөө даага өгсөн. Хоёрт нь есөн алдтай сайхан суран бугуйл, гарав дөрөвт нь манай энэ нутагт арай нийлдэг, хүндэлдэг Дугарчогдов, Алтангэрэл гээд хоёр ах сайхан хазаар, давхар олом өгсөн. Хөдөөгийн залуучууд тэрнээс илүү яах юм. Угаасаа өөр илүү, дутуу юм хэрэггүй шүү дээ.

- **Тэгээд өгч байгаа байр шагнал нь хүртэл адууныхаа юмыг л, адуугаа сэргээх холбогдолтой тээ?**

- Тийн, Би яг тэгж бодсон байхгүй юу. Манай ах нар дэмжсэн, найзууд дэмжсэн. Бид нар бүгдээрээ гоё зохион байгуулсан. Тэнд ирсэн хүмүүс сэтгэгдэл маш өндөр буцсан. Тэд удалгүй Азарга адуучин тэмцээн болсон тэр бол надад таалагдаагүй. Тийм адуучин гэж юу байхав, би тийм юм үзээгүй, жоохон байхдаа зурагтаар ч үзээгүй. Очоод уурга ташуур шүүрүүлээд, тэгэнгүүтээ сэлгээ морь явж байгаа юм, унаж ирсэн морьтой нь уралдуулаад, уралдаж ирсэн мориных нь амьсгаа нь дарагдаагүй байхад шууд хооронд нь барилдуулж байгаа байхгүй юу, муусайн юмнууд. Тийм адуучин гэж юу байдаг юм. Би уур хүрээд морио машинаас уячхаад, машин дотроо ороод унтаад өгсөн унтаад өгсөн. Тэгээд дууслаа гэхэд нь эмээл хазаараа авч, морио дүү нартаа өгөөд ахынхаа морийг алдчихгүйхэн шиг хөтлөөд явчхаарай гээд яваад өгсөн. Тэгээд улсууд чинь хооронд нь харьцуулна шүү дээ, эднийх юугаараа өөр байв гээд ерөөсөө тэр чинь бригадын, юуны нээлт энэ тэр гээд давхар тиймэрхүү юм болсон. Монгол бахархал төсөл гээл ТТБ оччихсон зураг авалт болсон. Тэр нээрээ л илүү байсан байх, миний хувьд бол Азаргынх бол хаана ч хүрээгүй гэж боддог.

- **Танай дээр юу, юу зохион байгуулагдаж байсан бэ?**

- Манайх уурга, ташуур бариулаад, тэгэнгүүтээ сэлгээ яваад,

- **Одоо хоёр морин дээрээ сэлгэж үү?**

- Тийн. 100 метрийн зайнд хэдэн удаа сэлгэх үү, цагийн хараад тоолчихно. Тэгээд явган бугуйл яваад, эмнэг сургах гээд дөрвөн төрөлтэй. Холоос зориод ирсэн өөр багийн залуучуудыг чинь урмын хугалахаар ууцыг нь хугал гэж дараа нь бооцоо тавиад алалцуулж байна юм. Манайх анхнаасаа зар тавиагүй юм чинь уурлах хэрэггүй ээ, манайхыг дууссаны дараа хэдүүлээ зүгээр бооцоо тавиад үзье гэсэн тэр нь шударга шүү дээ.

- **Бооцоотой тэмцээнд нь юу, юу орсон бэ?**

- Аа тэр чинь орой болчихсон дараа дараагийн ажлууд тулаад шууд уурга ташуур шүүрүүлээд, сэлгээ явчихсан юм. Манайх чинь дуусах даа адуу, мадуу булгиулаад, хамаг адуу нь ииш тийшээ явчихсан байгаа юм чинь булгиулах адуу байхгүй тэгээд хоёр төрлөөр явна гэсэн манай багийн дарга, хурлын дарга хоёр чинь сайхан сэтгэлтэй шууд тэр нь дундуур дахиад өөр тэмцээн зохиогоод, хөгшин залуу гэлгүй за нэг багт нэг хөгшин хүн хоёр хөгшин хүн гэдэг ч юм уу шууд хооронд нь холиод тэнцүү хуваасан. Тэгээд олс таталт, дардас шидэлтийн тэмцээн зохион байгуулсан юм, Тэрнээс хойшоо залуучууд их морь унадаг болсон байна билээ, ер нь зүгээр хараад явж байхад хүртэл.

- **Энэ тэмцээнийг багийн захиргаанаас дэмжсэн гэсэн үг үү?**

- Тийн. Одоо энийг чинь ингэнэ шүү дээ. Би адуучин тэмцээн зохиох гэж байгаа бол эхлээд хэдэн найзуудтайгаа яриад, ингэе, тэгье гээд юмнуудаа хоорондоо болгочоод, багийн дарга дээрээ давхиад очно. За ахаа бид нар ийм, ийм юм хийх гэсэн юм та батлаад дарга, марга засаг дарга даа хэлээд өг гээд шаталсан маягаар хэлнэ. Засаг дарга цар тахлын хүрээнд гадны хүн оруулахгүй яг баг дотроо чимээгүй зохион байгуулчих гэсэн.

- **Хэдэн онд зохиогдсон бэ?**

- Өмнө жил, хорин нэгэн оны 8 сарын 18-нд. Наадам болоогүй болохоор зөндөө хүмүүс ирсэн бас их сайхан болсон. Тэр олон хүмүүс сэтгэгдэл өндөр буцсандаа.

- **Цар тахлын улмаас хэдэн жил наадам болсонгүй. Монголчууд тэгэхлээр найр наадам үзэх, тийм юман дээрээ их сонирхолтой гэж ойлгож болох уу?**

- Сонирхолтой гэхээсээ урдаар тэр чинь хэзээний байсан юм учраас цусан даа байна гэдэг чинь тэр байхгүй юу.

- **Анх танаас гадна ямар хүмүүс энэ тэмцээний санааг гаргасан бэ? Найзууд тань хэдий насны залуучууд байв?**

- Манай үеийн дөрөв, таван залуу бас Бөмбөр, Дугар ах (Алтангэрэл, Дугарчогдов) хоёр.

- **Бас эмээл, хазаар хийдэг хоёр хүн үү?**

- Үгүй ээ, хийхгүй

- **Энэ хавьд та л ганцаараа хийж байна уу?**

- Тийм ээ.

2022 он 6 сарын 19-нд, Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Баянгол багийн төв. Ууганжаргал (мориных нь уяан дээр)

- Адууны соёл, уяа, хурдан морины талаар залуу хүүхдийн бодлыг сонсох гэсэн юм. Хэдэн оных билээ?

- 2004, одоо 12 дугаар анги, 18 нас хүрч байна.

- Өмнө нь морь унадаг байсан уу? Яагаад хурдан морь сонирхож, уяа сойлго хийдэг болов?

- Манай өвөө морь уядаг хүн байсан. Тэрнээс хойш манай нагац ах морь уядаг. Тэгээд ахынхаа морийг унадаг байж байгаад 7 дугаар ангиасаа хойш мориноос хусагдаад, тэрнээс хойш туслах уяач хийж байна.

- Одоо бол өөрөө биеэ даагаад морь унаж байна уу? Хэдэн морь уяж байна вэ?

- Тийн. Энэ жил есөн морь уяж байна.

- Одоо хурдан морь уяж, сойж байгаа мэдлэг ухаанаа хаанаас сурч авсан бэ? Энэ хурдан морь уяна гэдэг чиний хувьд ямар утга учиртай вэ?

- Ер нь зүгээр хобби л юм даа. Би чинь 8-р ангиасаа хойш сумын алдарт уяач Агваанжамц гэдэг хүн дээр хоёр жил туслах уяач хийсэн. Тэрнээс хойш аймгийн алдарт уяач Шаравжамцын Бадамжунай гэдэг ах дээрээ гурван жил туслах хийсэн. Энэ жилээс өөрөө тусдаа гараад морио уяж байна.

- Морь уяхын юун чамд сайхан санагддаг вэ?

- Тэгээд л одоо морь уяж хурдлуулаад, ер нь адуу гэдэг чинь өөрөө хийморьлог амьтан. Хар багаасаа морь, мал унаад өсчихсөн юм болохоор морь уях гээд байдаг.

- Чиний ирээдүйн мөрөөдөл юу вэ? Тэр зүйлийнхээ талаар ярьж өгөөч?

- Нэгэнт шийдээд морь, мал уяж яваа юм чинь уяачийн дээд цолонд хүрэхийг мөрөөдөж байна.

- Уяачийн дээд цол нь юу билээ?

- Монгол улсын тод манлай уяач.

- Тод манлай цолонд хүрэхэд ямар шаардлага байдаг вэ?

- За байз, зургаан түрүү, арван хоёр айраг билүү дээ.

- Ингээд морио уяад цаашаагаа явна гэж шийдсэн байгаа юу? энэ жил ЭЕШ өгсөн үү?

- Тийн. Одоо 23-нд ЭЕШ өгнө.

- Оюутан болох уу? Ямар мэргэжлээр сурна гэж бодож байна вэ?

- Тиймээ. Өөрөө морь мал уядаг юм чинь малын эмч л болдог юм билүү гэж бодож байна. Хажуугаар нь хурдан морио хаяхгүйгээр уяна даа.

- Морио уралдахад бэлэн болгоход ямар, ямар шат дамжлага байдаг юм бол?

- Ер нь тэгээд жилийн дөрвөн улиралд л эдэлж, харж ажиглаад уралдана. бүтэн жилийн хөдөлмөр шүү дээ. Нэг морь уяалаа гэхэд 12 сараас хашаан дотроо оруулаад өвсөлж, унана. Бага адуу бол тэгсхийгээд бага багаар зөөлөн унаад таргалуулна. Том адууг бол тэжээхгүй унаж байгаад, тарга хүчийг нь буулгаж бүүр тураана. Тэгээд буцаад тэжээлд нь оруулаад хавраас хойш давхиулна. Ногооны үеэр нэг сайхан цатгана.

- Ногооны үе гэдэг нь ямар үеийг хэлж байна вэ?

- Ногоо ургах яг тэр үеэр морьдоо амраана. Тэгээд яг наадам болохоос өмнө сарын нарийн уяа шаардана. Өдөр болгон барьж уяад нэмнээд, хөлсөлнө. Сайхан биеэ аваад хөнгөрөөд ирэхээр нь давхиулна. Тэгээд сунгаанууд эхэлнэ дээ, нэг тиймэрхүү.

- Хөлслөх гэж нэг үе байдаг байх нь дараа нь сунгаа хийж болно. Тэгээд наадамд уралдуулна гэсэн үг үү?

- Тийн байнгын бэлтгэл, эдэлгээтэй байна.

- Хэдэн төрлийн хөлснүүд байдаг гэж сонсож байсан тэрний талаар хэлж өгөөч?

- Ногооны үеэр тарган байгаа морийг давхиулаад хурдлуулна гэсэн юм байхгүй. Тодорхой хэмжээнд тоо авна. Ер нь таргалсан байхад нь өөхийг нь хайлуулаад хар махан дээр нь болгоно доо тэрийг хөлслөх гэнэ. Тэгээд уяанд орчихсон их хөлслөөд ирэхээрээ давс, хужраа их хэмжээгээр алдаж байгаа гэсэн үг. Юу, юу гэдэг билээ дээ, тэрийгээ нөхөхийн тулд морь чинь шороо иднэ. Шороо идсэн морь бол тэгээд давхиулахад хөлс нь дан андашгүй шороотой хөлс гардаг. Тэрийг нь шороон хөлс гэнэ.

- Тэрний дараа өөр ямар хөлс гарна гэх вэ? Хөлснийх нь нэр өөрчлөгдөх үү?

- Одоо өөр чинь юу гэмээр юм. Яах вэ хөлс олон төрөл байгаа л даа. Хөлстэй тар гэж нэмнээд ойр явахын хооронд хөлсийг нь их гаргаж ер нь бүтэн хөлсийг нь гаргаад, давхиулна гэсэн үг. Хөлслөхдөө бол зүгээр нэмнээд давхиулахгүй дан сайхан ергөөд, хатирна.

- Хэдэн километр вэ?

- Нэг талдаа 7-10 километрийн хооронд юм уу даа. Илүү хол ч байж болно. Мориноосоо шалтгаалаад янз, янз.

- Өдөр болгон хөлсөлж байна уу? Хэдэн удаа хөлслөх вэ?

- Өдөрт нэг удаа хөлсөлнө. Угаасаа энэ морьд чинь нэг л ажил хийнэ. Өнөөдөр хөлсөллөө гэхэд түүнээс өөр ажил хийхгүй, маргааш нь давхиулах ч юм уу тиймэрхүү. Яах вэ уяа эхэлж байхад өдөр болгон хөлсөлнө. Энэ морьд чинь одоо хөлслөөд болчихсон, уралдсан морьд юм. Зарим нь хоёр, гурав уралдчихсан, уралдах арай болоогүй морьд бас бий. Мориныхоо онцлогоос болно доо.

- Сунгаа гэдэг нь ямар учиртай вэ?

- Тэр нь мориндоо бол бараг наадам гэсэн үг юм уу даа. Наадамд уралдах хэмжээнээсээ арай бага зайд уралдана гэсэн үг.

- Нас наснаасаа шалтгаалах уу? Хэдий хэр зайнд уралдах вэ?

- Улсын наадмын стандарт хэмжээ бол азарга 22, их нас 24 километр билүү, тэр хавьцаа. Сумын наадам адилхан л даа яах вэ эхний сунгаа нь 5-6 километр байна. Дунд сунгаа нь 12,13 километр. Харин сүүлийн сунгааг ойрхон хийнэ. Гэхдээ олон уралдаж байгаа морьд болохоор ковидын улмаас наадам болоогүй, энэ жил овоо тахилгын гээд их болсон учраас сунгаангаа наадмуудаар явж хийгээд байгаа.

Парт2

- Хэдэн оноос хойш тахиж байгаа вэ?

- Ах нь тэр оныг нь сайн мэдэхгүй байна. Дараа нь настай хүнээс асууж өгье.

- Хуучин тахидаг байсан юм болов уу?

- Ер нь дээрхэн үеэс 1990-н хэдэн он гараад л тахиж эхэлсэн юм шиг байна билээ. Тэрнээс өмнө бол шашин машин хаалттай байсан үед бол тахидаггүй байсан. Ардчилал гарахаас өмнө дээр үед лам нар, Манай Өндөр-Улааны хөгшид чинь нэг айлдаа цуглаж, өрхөө тэгшилж байгаад зул мулаа өргөдөг, тийм заншилтай байсан гэдэг. 1990 онд л хүний эрх ярьж, дураараа явдаг цаг нь эхэлсэн. Тэр үеэс өмнө бол засгийн малаас ганц хонь идэхэд л хуулийн дагуу шороонд орно, бас төлүүртэй тийм хатуу үе байсан. Тэгээд малаа түрээслүүлдэг, одоо бол "бадрал нэгдлийн үе" гэж л ярьдаг юм. Тухайн үед сум орон нутагт малын тоо бүртгэгч гээд бараг дарга шиг албан тушаалтай ажил байсан юм шиг байна билээ. Бас зовуут гээд байсан сүү хуваарилдаг юм. Тэдэн грамм сүү, аарц тэгж өгөх ёстой гээд олон ферм байгуулж байсан гэсэн. Ардчилал гараад хувьцаа гэдэг юмаар чинь ам бүлийн тоогоор нь ардчиллын мал гээд хуваачихсан гэж байгаа юм.

- Овоо тахилга дээрээ ямар нэгэн идээ ундааны шүүс гэж өргөдөг юм болов уу?

- Шүүс гэж ууц тавина. Яг хонь хэвтэж байгаа юм шиг, 2 гуя, хааг нь урд нь тавиад, толгойг нь өргөдөг ёстой гэсэн. Мөн толгой, өвчүүг нь овоондоо заавал өргөж байх ёстой. Ерөнхийдөө бууж ирээд ууцаа хуваасны дараа бол ламдаа эсвэл хүндэлдэг хүмүүстэй найрын ёсоор шүүсээ тараадаг. Дараа нь овооны наадам хийж байгаа чулуу байдаг Цанжинбаваа билүү дээ, тэрэндээ ном уншаад сүү өргөдөг.

- Хаана байдаг чулуу вэ?

- Наадам хийх гэж байгаа газартаа, овооных нь доор, талд байдаг юм. Овоо босгочихсон, чулуугаа тахиж байгаа зан үйл хийдэг юм билээ. Их мундаг чулуу гэж ярьдаг юм.

- Хаанаас лам нар ирдэг вэ? Та тахилгад нь оролцдог уу?

- Тиймээ. Орон нутгийн лам нар ирнэ. Хүн хүний сэтгэл өөр учраас ноднин зарим "гачаа хүмүүс"03:45 ? нь хот мотоос лам нар авчирдаг юм.

- Ямар хүмүүс тахиулдаг юм бэ?

- Жил жилийн нутгийн улсууд тахиулаад байдаг. Ураг төрлөөрөө нийлээд тахина. Баасанжав дарга гэхэд л ураг төрөл ах дүүгээрээ нийлж байгаа байхгүй юу.

- Аль баг нь түлхүү тахиж вэ?

- Бэлх тэгээд Баянгол баг. Ер нь харж байхад Бэлхийнхэн их бас Азарга гарч ирнэ. Донгоогоос ганц нэг улс байна.

- Түүрүүн толгой өвчүү өргөдөг гэсэн. Өргөх гэдэг нь яадаг юм бол?

- Овоо тахисан дараа аргадаж, сүүгээ өргөн нэг ёсондоо даатгаж байгаа хэрэг.

- Сархадаар өргөдөг үү?

- Ном уншихдаа заавал овоо, хангай гээд орон нутгийнхаа бүх юмыг даатгаад сэржим өргөдөг ёстой юм шиг байна билээ. Миний бодож байгаагаар бол энэ " Намдаг сан" гэдэг номыг л их уншдаг юм даа.

- Аль ч хайрхны овоон дээр энэ номыг уншиж болох уу?

- Болно. Дэлгэрэнгүй байхгүй юу.

- Ер нь тухайн хайрхан, хангайд зориулсан ном гэж байдаг уу?

- Өө байна. Архангайн бурхан хайрханы сан гэж бас байна. Орхон аймаг гэхэд л Баян - Өндөр сан, Баян-Өндөр хайрхандаа, Баян-өндөр, Баян цагаан, Бүрэн бүст гээд таван хайрхантай. Манайх ч гэсэн ялгаа байхгүй. Булган уулын сан гэж бас тусдаа байдаг. Жанчивчол хангайжалвуу06:02 ? гэсэн тийм сан Төвд үгээр биччихсэн хоёр хуудас ном байдаг. Ер нь Архангайн лам нар уншдаг юм.

- Тахилгын ном байхгүй бол Намдаг санг уншдаг юм уу?

- Тийн. шашин хөгжөөд дэлгэрэнгүй болчихсон. Намайг лам болсны дараа манай багш хэлж байсан юм. Хүнд буян хишгийн даллага авч өгөхөд тухайн үедээ Алтангэрэлийн даллага авдаг ном нь байхгүй бол Дашжирвын даллага аваад өгчих ялгаагүй буян гэдэг.

- Ариусах гэдэг нь мөн үү ?

- Тийн. Дотроо Ариун сан, Хийморийн сан гээд таван сан нь бүгд орчихдог. Эхлээд багшдаа (бурхандаа) Итгэл уншаад араас нь Гандан лавжаа гээд ном уншина. Тэгээд Дашжин сан, Намдаг санг бас Гурван гөрөм гээд ном уншигдана. Ойр зуурын Дарь эх, Цагаан шүхэрт, Дашзэвэг зэрэг номуудыг үргэлжлүүлж уншигддаг.

- Хамгийн сүүлд нь Намдаг сангаа уншдаг гэсэн үг үү?

- Дундуур нь уншина даа, ер нь Дашжин сангийн дараа уншдаг юм. Зарим энэ нутгийн улсууд тусдаа сан байгаа гээд янз бүрийн л юм яриад байдаг. Би бол мэдэх мэдэхгүй юм уншина гэж ярьж байхаар номдоо байгаа мэддэг юмаа уншвал хамаагүй хүртээл ихтэй болвуу гээд дэлгэрэнгүй номыг нь уншина гэсэн бодолтой л явдаг.

- Баянхайрханы 14-нд болсон тахилга дээр иймэрхүү зан үйл болсон уу? Өөр онцгой юм байдаг уу?

- Тийн. Ер нь хоорондоо адилхан байдаг. Онцгойлсон тийм юм байхгүй. Зарим лам нар жоохон өөр ном уншиж байдаг. Өмнө нь 2018 онд Зүйр гэгээн хамба Дамбажав гуай ирж

байсан. Алтайн хүн байхгүй юу. Зүгээр Дашживын сан тавиад боочхож байна лээ. Тэгээд Намдаг сан энэ тэрийг уншихгүй байсан болохоор нь хамба хүн өөр байлгүй дээ гэж бодож байсан юм. Би заримдаа нэгэнт тахиж байгаа юм чинь эхээр нь сайхан уншаад өгье гэсэн бодолтой байдаг.

- Тахилга эхлэх цаг гэж байдаг уу? Хэдэн цагаас хөдлөх ёстой байдаг вэ?

- Байдаг. Манайх 6 цаг гэхэд овоон дээрээ гардаг. Тахиулж байгаа хүмүүс нь өөрсдөө шийдээд гардаг. Нар мандаж байхад л тахиж байх ёстой байдаг. Манай багш эртхэн байвал сайн гэж тахидаг байсан. Урд зүгт, Өгий нуур луу тахиж байхад 11 цагт л гарч байсан даа. Манай энд бол наадам болоогүй болохоор чинь жоохон эртхэн тахина гэсэн бодолтой байдаг юм шиг байна билээ. Батцагаан овоон дээр эрт гараад, эрт буувал зүгээр байдаг. Ер нь дараах үйл ажиллагаа нь их юм болохоор 6, 7 гэж гараад цуглаж буух гэсээр байтал 8, 9 гээд буучихдаг юм.

- Наашаа ер нь гол, ус, нуур тахидаг тийм тахилга байдаг юм уу?

- Өө ховор шүү дээ. Ер нь нээх тахиад байдаггүй. Гол тахихдаа юу билээ дээ нэр нь орж ирдэггүй, цагаан шашны дэлгүүрт байдаг юм л даа тэрийг тахиж байгаа овооноосоо бууж ирээд гол усандаа хийж, ер нь тахиж байхдаа сайн хийж байх ёстой гол заншил нь юм гэнэ лээ. Тэрийг хийснээр гол ус нь ариусаж байдаг утга учир нь тэр гэж манай багш нар хэлдэг байсан. Мөн Лүнбийн гарав, Лусын сан ман гээд төрөл бүрийн ном байна шүү дээ.

- Маргааш тэр нь дээр нь нэмээд лам ирэх үү?

- Энд Баянжаргал гээд Өндөр-Улааны лам байдаг. Тэр ламаас гадна өөр ганц нэг гаднаас лам ирэх байх. Өнөөдөр бол засаг дарга лам ирэх талаар хэлээгүй л байна.

- Хоорондоо яарьж тохироод унших номоо ярилцдаг юм уу?

- Нэгэнт л шашны нэг хүмүүс юм чинь тохирсон номоо уншаад л явчихна.

- Одоо 23-нд Ханууд гээд буган чулууны тэнд бөөгийн нэг академиас зохион байгуулж байгаа улсын тахилга юм гэнэ лээ. Олон хүн ирээд аягүй гоё юм болно гэж манай иргэдийн хурлын дарга хэлж байсан.

~ **Батсуурь** ~

-Нэг үеэ бодоход овоо болчхоод байна. Зах зээлд ороод мал, идээгээ өсгөөд янзын болж байна.

-Хувьчлалын үед яг юу, юу болж байсан бэ?

-Хувьчлалын үед яах вэ дээ. Хүүхэдтэй улсууд нь хүүхдийнх нь тоогоор хувааж өгч байсан. Мань хэд яах вэ дээ. Өөрийнх нь маллаж байсан малыг хэд ч хувааж өгч байсан юм. Мэдэхгүй, ямартай ч арван хэдэн үхэр малтай л үлдэж байсан юм. Сүүлийн үед бол малаа маллаад, ажлаа хийгээд бас малын худалдаа наймаа хийгээд байж байна.

-Та хувьчлалын үед хэдэн тооны мал авч байсан бэ?

-За одоо хүүхдийнхээ тоогоор болохоор хориод мал байсан болвуу даа Үхэр, адуу, хонь гээд Таван толгой мал бүгд л

-Тэмээ байдаг байсан юм уу?

- Тухайн үед байсан юм. Дээр үед намайг хүүхэд байхад бригадаас хүмүүс тэмээ унаж ирээд нядалгаанд өгөх нь өгдөг байсан. Сүүл рүүгээ тэмээн сүрэг гэдэг юм байхгүй болчихсон. Бусад мал нь бол бий.

- Баянголоор ямар мал голцуу маллалдаг байсан бэ?

- Голцуу бод мал их байсан. Бог мал бол цөөхөн айлд л байсан.

- Та ер нь хэзээ наашаа нүүж орж ирсэн бэ?

- Манай аав, ээж амьд байхад 1968 онд орж ирсэн. Намайг сургуульд байхад энэ хойно Бөхөнгөөс (Азаргаас) манай аав өөрөө 03:40 фирм дээр ажиллах болоод нүүж ирсэн. Дээр үед чинь ерөөсөө удирдлагаар л явдаг байсан юм. Та нар тийшээ тэр фирм дээр очиж ажил гээд явуулчихдаг. Хоорондоо бол хамаагүй л солигддог байсан юм. Донгоод хүн ам цөөхөн байсан болохоор эндээс нэг хэсэг нь явж байсан. Одоо энд настай хүн гэдэг чинь цөөхөн болчих шиг боллоо доо.

- Хөгшчүүд нь сумынхаа төв рүү орчихдог юм шиг байна тээ?

- Тийм ээ, хамаагүй илүү олон хүн төв дээр байдаг шүү дээ. Энд бол ер нь цөөхөн. Малчин өрхийн тоо зуу хүрэхгүй, жаран хэд л байгаа байх. Ихэнх нь сумын төвд байгаа болохоор тэрүүгээрээ хурал цуглаанаа хийчихдэг. Дуулсан хэд нь явж очдог л байх.

- Та Баянголын хүн гэж явдаг уу? Бас сүүлд энэ нэрээр нэрлэсэн юм шиг байна тийм үү?

- Тийн. Өмнө нь Дэлийн гол гэж л нэрлэдэг байсан юм. Бид хоёр 1980 онд нийлсэн, тэрнээс хойш л амьдарч байна даа.

- Та нутаг, усныхаа талаар ярьж өгөөч?

- Манай Баянгол дээрээсээ гурван ангальнхаа тэндээс урсаж орж ирдэг. Манай энэ урдуур газар доор ороод, ганц модны тэрүүгээр гарч ирнэ. Дундаа хэд тасардаг. Хойноо Лаг булаг гээд миний мэдэхэд л байсан нэг булаг одоо ч урсаж байна. Энэ гурван амны бүр ар талыг нь Товчоо, дундхыг нь Салаа, урд талын энийг нь Сонгинот гэдэг юм. Ийм л газар байгаа юм даа. Дээрхэн үед бол энэ голоор л голцуу зуншдаг байсан. Одоо Одгэрэлийн байснаас цааш хэсэг. Хойно байсан булаг нь байхгүй болчихсон юм.

-Та төрсөн газар, нутгаа санадаг уу?

- Аймар санаад байдаггүй ч гэсэн бодохдоо бодогддог л юм. Хүүхдүүд чинь энд өсчихлөө, сургууль соёлд эндээс орсон болохоор төрсөн газар нь энэ болчихсон шүү дээ. Миний төрсөн газар бол Азарга.

- Та төрсөн нутаг Азаргаа санаж байна уу ?

- Өө саналгүй яах вэ. Азаргаа илүү санадаг. Миний жаахан даа өвлөж байсан газар тэнд бий. Тэр Зоогийн даваа гэдгийн тэнд, доод өвөлжөө өвөлжөөгөөр ч бас бий. Морь анх унаж, сургуульд анх тэндээс орж байсан юм. Зоо халзан, Дашлан, Хөндлөн, Нураг гээд тийм газруудад аав маань нутаглаж явсан.

- Бэлх чинь одоо Цагаан булагтайгаа ойрхон уу?

- Тийм. Манайхаас ч гэсэн ойрхон. Энэ талаараа ч тэр, тэр талаараа ч тэр явчихаар ойрхон газар. Тиймэрхүү л байна даа. Манай энэ хүүхдүүд тэгээд мал маллаж байна даа.

- Танайд бог мал байгаа юу?

- Бод, бог хоёулаа бий.

- Та Азаргаа илүү санадаг гэлээ. Азаргын юун тийм, таныг тэгж бодогдуулаад, санагдуулаад байдаг вэ?

- Гол нь яах вэ дээ. Хүний төрсөн нутаг гэдэг нь тэр. Хүн чинь ер нь төрсөн нутаг гэдгээ дандаа бодож, санаж явдаг юм биш үү. Нас ахиад ирэхээр тэгж л бодогдох юм. Манай аавын нутаг л даа. Ээжийн нутаг бол Цагаан булаг талаараа байдаг.

- Танд нэг тийм амьдрахад сайхан газар байдаг уу?

- Өө манай энд чинь хаана ч сайхан байна даа. Би ёстой сайхан л амьдарч байна. Одоо хамгийн сайхан нь Бургасны уулын тэнд байсан юм. Би нэг хэсэг ид залуу байхдаа амьдарч байсан юм. Мал усаар ангана гэж байхгүй. Өвс, ус тэгшхэн, мод, чулуу их, байнгын харзтай тийм газар байгаа юм. Өвлийн цагт бол тэр Зуун модноос цаашаа аажуу буудаг. Өвлийн гурван сарыг л авчиж байгаа юм. Нэг газраа удаан байхаар хангай дэлхий нь хүртэл дутмагдуу, ургаж барих нь ховор болчхоод заримдаа бороо хур нь хүртэл бага орох юм байна шүү дээ. Одоо тэгээд хувьчлагдсанаас хойш хүн болгон малтай, жалга болгон хашаа, айлтай болчихсон. Нутгийн улсууд л хоорондоо зохицоод юмаа хийгээд байгаа болохоос биш бараг газаргүй шахуу болчхоод байна даа. Уг нь энэ хойно Тариат, Хангайгаар отор нүүдлийнхэн их явдаг байсан. Одоо больчхоод байна. Сүүлийн үед энэ урагшаа Баянцагаанаар отрын малчид явдаг юм шиг байна лээ.

- Отрын малчид орж ирэхлээр ямар нэгэн маргаан үүсдэг үү?

- Өө тийм юм байхгүй. Зарим улсууд л тэглээ барилаа гээд байдаг юм.

- Ирээд суучихвал яах вэ?

- Одоо тэгээд яах вэ дээ. Адилхан л явж байгаа хүмүүс. Хэнийг нь суу, хэнийг нь яв гэхэв дээ. Миний хувьчлаад авчихсан газар биш. Би тэгж болохгүй л дээ. Хэрвээ хувьчлаад авчих юм бол нөгөө бие биеэсээ эрх мэдэл гаргана гэдэг нь тэр дээрээ гарах байлгүй дээ. Сүүлийн жилүүдэд цаанаасаа хөөгдөж бариад байхаар орж ирэхээ байчхаад байгаа юм. Түүнээс ирдэг л дээ, бүр аргаа бараад зарим нь гуйдаг. Дэлхий өмчилчихсэн биш дээ, сайндаа тэд нар чинь нэг, хоёр сар болоод явна. Манайх ч гэсэн өөрсдөө тэгээд явна шүү дээ. Таних танихгүй газарт очихлоор чинь гаралгүй дээ. Манай өвөлжөөний тийшээ, хаваржааны тэнчээ буулаа барилаа гээд тиймэрхүү яриа бол зөндөө гарна. Монгол хүмүүс хоорондоо ярьж байгаад зохицох л хэрэгтэй.

Ер нь бол хүн болгон малаа өсгөчихсөн чинь бод бол ихдээд байна. Аль ч газар ихдээд байгаа болохоор хэн хэнийгээ хэлэх вэ дээ. Тааралдсан газраа буугаад явж байхаас өөр яах вэ.

- Хуучин нийгмийн үед ийм бэлчээрийн асуудал гарч байсан уу?

- Юу ч байгаагүй. Бэлчээр нь задгай байсан. Нэгдэл бөөгнүүлээд ажил хийлгэж байсан болохоор дан журмын дагуу машин хэдэн давхиж ирээд л ачна. Эхлээд трактораар бид

нар чинь нүүж байсан. Сүүл рүүгээ машин болоод, тэгж байтал нэгдэл тарчихсан даа. Тэгээд нялх нойтон хүүхэдтэй улс, орой хүйтэн орох үед явахад хэцүү. Хатуу хэцүү юм энэ хөдөөгийн амьдралд их тохиолдоно шүү дээ. Малчид даван туулаад л явж байна. Зуны цагт бол наранд халаад л өглөө, оройдоо үнэгээ саана. Суурины дарга чинь өөрөө тэргэнд хөллөөд л авчирч өгнө. Хайнагийн үнээний нэг саам нь найман литр гарна. Мундаг шүү дээ. Тэгээд Зуунмодын норм нь өндөр, өдөрт 450, 500 литрээс дээш.

- Та нээрээ фермийн дарга байсан гэсэн. Ямар ферм байсан бэ?

- Сарлагийн ферм байсан. Монгол, сарлагийн ферм гэж тусдаа.

- Монгол үнээний ферм нь хаагуур байсан юм бэ?

- Өө бараг л холилдсон байдаг нэгнийхээ захад байсан. Ханугаас орж ирээд буцаад явчихсан.

- Таны хувьд сайн малчин гэж ямар, ямар шинжтэй хүнийг хэлэх вэ?

- Хэзээд өөрөө малаа сайн маллаж чаддаг. Тийм малчныг л сайн малчин гэж хэлнэ. Доод тал нь бог мал гэхэд гурван зуу, дөрвөн зуугаас дээш маллаад явдаг. Тэгээд мянга хүрж байна, зарим нь мянга гарчихсан. Тийм малчид бол зөндөө л байна. Өмнө нь ч тийм байсан. Баг сум, аймаг, улсын сайн малчид зөндөө л гарч байсан. Би чинь өөрөө тусгай тэгж малаа авч өсгөж үзээгүй. Яах вэ, хэдэн хүн хариуцаад л, голцуу төлөө авсан хэдэн саальчидаа шагнаж, урамшууллыг нь гаргаж өгөөд итгэл дааж л явж байсан юм. Бод малыг бол хээр гадаа отор нүүдэл хийгээд л зөндөө маллаж байсан.

- Мал маллаад явж байхад хамгийн жаргалтай, сайхан үе нь ямар үе байдаг вэ?

- Үгүй ээ яах вэ дээ. Өөрөө малаа маллаад сайхан явж байвал тэр нь жаргал. Тэр болгон малаасаа ашиг шимээ авч чадаад байвал болно шүү дээ, Бог мал гэдэг чинь өөрөө хүний мөнгө гэсэн үг. Байнга мөнгө нь бэлэн байна. Бод мал нь ч гэсэн одоо үед бол ялгаа байхгүй л дээ. Хэрэгцээний хувьд бол арай хурдан нь бог мал юм даа.

- Нөгөө талаараа мал маллахад шантармаар, халширмаар тийм юм байдаг уу?

- Нэг их шантраад байх юм байхгүй дээ. Яах вэ, бог малтай хүн бол шантарч болох л юм. Маллаж байгаа хүнээсээ л болно байх. Түүнээс бол мал маллаж байгаа хүн бол шантарна гэж юу байх вэ. Түрүүхэн үед бол бие биеийгээ дуурайгаад сайн малладаг байсан. Одоо ч гэсэн сайн маллаж байна л даа. Одоогийн залуучууд түргэн хугацаанд малаа өсгөж, сайн ажиллаж байна. Зарим нь юм болгож алдартай болж байна.

- Таны хувьд амьдралдаа эрхэмлэж явдаг зүйл юу вэ?

- Бод малаа л эрхэмлэж явсан. Адуунд л их сонирхолтой хүн байсан юм. Адуу харин нээх маллаж үзээгүй. Ганц жил л маллаж үзсэн.

- Адуунд яагаад тэгж их татагдаж байсан юм бол?

- Адууны хорхойтой, өөрөө бас морь уяна.

- Одоо морь уях уу?

- Одоо хүүхэд байхгүй болохоор уяхгүй. Уяа гэвэл ч уяна л даа. Олон жил морь уяж үзлээ бас давхиулж ч үзлээ. Аймаг, улсад бол явж үзсэнгүй. Бусад газраар бол зөндөө явж үзсэн.

- Адууны юу тийм таны сонирхлыг татдаг байсан юм бол?

- Адуу гэдэг чинь өөрөө тэгээд эр хүний сонирхол нь байдаг юм шиг байгаа юм. Унахад их сайхан. Би чинь одоо тувтан л морь хэрэглэж байна. Машин, мотоцикл барих л байсан бариагүй ээ.

- Одоо та малдаа мориороо явах уу?

- Явна шүү дээ. Өөрийн угаасаа сонирхол юм даа. Түүнээс бол анги юманд сонирхолтой бол унаад явна шүү дээ

- Хуучин нийгмийн үед энэ Өндөр-Улаан, Баянголоор адууны соёл хэр байсан юм бол?

- Бага байсан даа.

- Одоо ингээд уяа, шошго ихтэй, хүмүүс морь их уядаг болсон байна. Хуучиндаа тийм байсан уу?

- Хуучин бол тийм байсан юм. Сүүлийн үед энэ улсууд урд зүгээс морь их худалдаж авч уяад, аль ч бригад багуудаар авч яваад уралдуулаад байна.

- Жилд хэдэн наадам болдог байсан бэ?

- Түрүүхэн жилд бол наадам цөөхөн байсан даа. Бараг жилд ганцхан сумын наадам нэг, улсын гэж хийнэ. Бригад болгон яах вэ хийдэг л байсан юм.

- Овоо тахилга гэж ингэж хийдэг байсан юм уу?

- Овоо бол нээх аймаг хийж байгаагүй бага хийдэг, бараг хийдэггүйдээ шахуу. Тахилга хийж байхад нээх морь давхиад байдаггүй байсан. Сүүлийн үед энд тэндгүй овоо тахидаг болоод байна. Лам нар ихэдсэнийх юм уу, юуных юм. Эсвэл урд урдхаа гаргаж ирж сэргээж байгаа гээд л байгаа юм. Би бол учрыг нь олохгүй байгаа. Хоёр жил короно гээд хумигдчихсан байсан. Бургасны эх гэж энэний цаад талд байдаг газар. Энүүгээр бол хуучин давдаг морин замтай зун, өвөлгүй явдаг байсан юм. Одоо ч гэсэн байгаа л даа, мориор явдаг хүн байхгүй болчихоод байна. Одоо нэг үеэ бодоход машин техник нь ихэдчихсэн.

- Мал маллахад энэ машин техник ихдэх нь сайн, муугаар яаж нөлөөлж байна вэ

- Сайн гээд ч яах вэ, муу гээд ч яах вэ, адилхан хэрэглэж байгаа улс. Уул нь яг харвал муу байх. Морь унаад явж байгаа хүн ховор, дандаа мотоцикл унаж байгаа харагддаг.

- Энэ машин техник бэлчээрт нөлөөлнө гэж байдаг болов уу?

- Бэлчээрт юундаа нөлөөлөв гэж дээ. Байдаг юм болов уу, хэн мэдэх вэ. Иймээ тиймээ юм ярихгүй л байна. Одоо морь чинь тэгээд аргамжаатай байсаар дасчихсан даа

- Одоо би танаас дуу чимээний талаар асууя, малтайгаа дуу, авиа гаргаж харилцдаг уу?

- Тэгнэ шүү дээ, малтайгаа яваа хүн чинь исгэрэх ч юм уу янз, янзын дуу чимээ заавал гаргана. Бог малтай хүн бол доод талын хэмжээнд исгэрнэ, хаая гэж орилно. Бод тууж яваа хүн чинь хаа, хөж гэж дуу чимээ гаргана. Адуу чинь хүртэл өөрөө шогшиж хөлөөрөө чимээ гаргаж явна.

- Сааль сүүгээ авч байх үедээ малтайгаа дуу, чимээ авиа гаргаж харьцах тохиолдол байдаг уу?

- Тэрийг чинь одоо сааж байгаа хүн нь мэднэ дээ. Хүн бол дуу гаргахгүй байна гэж байхгүй. Бороо, Халзаа гээд нэр өгчихсөн юм чинь дуудаж л байгаа.

- Одоо нөгөө үхэр туйлдаг даа

- Тийн, туйлж байгаа юм чинь хаа хүү гээд тэгнэ шүү дээ,

- Тэгэхээр ер нь жоохон номхордог гэсэн үг үү?

- Аа тийн, одоо малдаа дуугаа сонсгуулж байх заншил юм уу даа.

- Та түрүүн нэрээр нь дууддаг гэлээ, Тэгэхлээр зөвхөн эзнийхээ дууг таних уу? Өөр хүн нэрээр нь дуудвал ирэх үү?

- Зарим нь ирнэ, зарим нь гарч ирэхгүй. Дассан хүний хоолой өөр байх. Хүний дуу авиа бас шингэдэг байх, үнээндээ нэр өгөөд саагаад байгаа юм чинь дасдаг байлгүй дээ.

- Малыг эрэгтэй, эмэгтэй хүн ондоогоор дуудна гэж байх уу?

- Байлгүй яах вэ, эмэгтэй хүнийх нарийн, эрэгтэй хүнийх чинь арай бүдүүн, чанга байж таараа. Гаргаж байгаа авиа нь өөр болохоос хэлэх нь бол адилхан байна гэсэн үг.

- Малаа хариулахдаа өөр дуу чимээ гаргадаг тийм юм ашиглах уу?

- Шилүүр гээд нэг богинохон юм хийчихсэн байдаг юм. Тэрийг гуядахаар чад, над гээд дуугарна. Аргад аваад чаа, өөе гэд шидэж болно. Малаа хариулаад явж байгаа хүнд өөр нээх гаргаад байх дуу чимээ байхгүй дээ.

- Малаас өөр шувуу, мэргэч ч гэдэг юм уу тийм ан амьтадтай дуу чимээ гаргаж харилцах уу?

- Ээд дээ цөөхөн байх. Ер нь дуу чимээ гаргаж харилцахгүй дээ. Тогоруу явж байна даа, тэнд тарвага байна даа л гэж ярина.

- Тарвага хошхируулахад дуу чимээ гаргадаг юм уу?

- Гаргадаг л гэсэн. Зарим агнадаг улсууд нь янз янзаар гаргадаг л байх. Манай энд тарвага ховор.

- Та тогоруу бүжиглүүлдэг гэж сонсож байсан уу?

- Үгүй, тогоруу яах вэ дугардаг юм гэнэ билээ. Тогоруу хөөрхөн, тоодог муухай, эргэн эргэн цамаан харай гэхлээр дээшээ хөөрч буугаад, үсэрч харайгаад л, далавчаа дэлгээд гүйгээд байдаг юм. Тэгж тоглодог юм байлгүй.

- Та яг харж байсан уу?

- Зөндөө харсан. Бид нар хүүхэд байхдаа тогоруу хараад орилж гүйнэ, тогоруу чинь янз, янз болдог байсан.

- Ан гөрөө хийж байхдаа өөр яаж, ямар амьтадтай харьцав?

- Би өөрөө тэгж явж байгаагүй болохоор мэдэхгүй байна.

- Та анчдаас тийм юм дуулж байв уу? Чоно үргээнэ гээд байдаг яаж үргээдэг юм бол?

- Үгүй дээ, модонд үргээдэг юм билээ. Хэдэн хүн явж очоод тэр модыг тэгж татаарай гэж хэлээд өөрсдөө янз, янзын дуу гаргаад гаргаж ирдэг юм билээ.

- Танай энд ямар амьтадын дуу, чимээ сонсогддог вэ?

- Гөрөөс бархирах гэдэг билүү дээ, яах гэдэг юм дээ дугарч байдаг юм. Намар яах вэ, бүүр булаан дээр гарвал буга дугардаг л юм билээ. Хангайн амьтан бол манай энд ховор, чоно бол орой үдэш дугарч л байдаг.

- Одоо дөрвөн улирлын шинжийг ямар нэгэн амьтны ч юм уу, малынхаа дуу чимээгээр таньж болох уу?

- Тэрийг ёстой мэдэхгүй юм даа. Намар аажуухан болбол өвөл нь богинохон болоод хавар уртсах нь гэх зэргээр улирлаа шинжинэ. Зуны эхэн сар гараад ирэхлээр хөхөө шувуу донгодно, хавар бол тарвага ичээнээсээ гараад, сүүлд нь буга, согоо чинь тугаллана гэж ярихуу даа, тийм юм бий. Гахай бол зун тооройгоо гаргадаг, намар нь том болчихсон байдаг юм. Өвөл ичээний амьтад нь ичээндээ орчихно.

- Шувуу хэзээ буцдаг юм бэ?

- Намар 9 сарын 20-доос хойш, 10 сарын эхээр буцна. Хүйтрээд ирвэл эрт, хүйтрээгүй байвал аажуу буцна. Хөхөө 5 сард, зуны эхэн сарын шинийн 7, 8 гээл гарч ирнэ. 3 сарын 15-аас хойш тарвага, ичсэн амьтад гарч ирнэ. Сүүлд нь 4, 5 сарын алдад буга, согоо нь дуугарч барьдаг.

- Төллөж байхдаа янз бүрийн дуу чимээ гаргадаг уу?

- Гаргалгүй яах вэ, хангайн амьтан чинь өөрөө янз янзаар дуу гаргаж явдаг.

- Энэ хавиар ямар, ямар шувуу байдаг вэ? Аль сар ямар шувуу илүү үзэгддэг вэ? Та тэгж ажиглаж байв уу?

- Манай энд усны шувуудаас ангир, тогоруу хоёр ирнэ. Хавар хамгийн түрүүнд турлиах 50:17 гээд аяны шувуу хөхөөнөөс өмнө ирдэг. Сүүлд нь шаазгай тэр хоёр хөхөөгөө явж авчирдаг гэсэн домог байдаг юм билээ.

- Шаазгай монголд байнга байдаг юм уу?

- Шаазгай өвөл ч гэсэн байж байдаг юм,

- Шаазгайтай холбоотой янз, янзын яриа байдаг даа, шагшрах ч гэдэг билүү? Та тийм юм та мэдэх үү?

- Намар сэрүүн орохоор бөөн бөөнөөрөө шагшраад байдаг. Ер нь шувуу болгон цугларч барихлаараа тэгдэг юм байна билээ. Намар буцахаа болохоор тогоруу энэ тэр чинь бөөн бөөнөөрөө одоо жагсана гэж ярих байхдаа, тэгж буцдаг.

- Та түрүүн хэлсэн домгоо дэлгэрүүлээд ярьж өгч болох уу?

- Улсууд л тэгж ярьдаг юм. Би сайн мэдэхгүй. Алаг шаазгайны хүзүүн дээр хөхөө мордож ирээд, буцахдаа бас тэгж явдаг.

- Турлиах гэж ямар шувуу байдаг юм бэ?

- Хүзүүгээрээ цагаан алагтай, хар цоохор, шаазгайтай төстэй гэдсээрээ цагаантай шувуу байдаг. Гэхдээ шаазгай нь арай урт сүүлтэй. Жижигхэн, хар хөх л гэж хэлмээр юм даа.

- Шөнө орой болсон хойно ямар дуу чимээ ер нь их сонсогддог вэ?

- Хааяа нэг хангайн амьтан л ульж барьж байдаг. Голын ус бол мөнхийн, янзын их шуугина.

- Шөнө унтахдаа малынхаа дуу чимээг чагнаж унтах уу?

- Тэгнэ шүү дээ, хонио үргэж барихнуу гээд чагнаж хононо, Үргэж барих юм бол гарч орилно, гэрэл гэгээ тавьж, бөөгнүүлээд ойртуулна. Бороо шороонд бол майхан сав барьчихсан улсууд нь манаж хонодог. Үс ноосыг нь авчихсан ширүүн бороотой үед бол хонь цуваад явахлаараа осгоно, хэцүү. Тэрийг чинь тогтоож, хоргоож явуулахгүй байвал осголт багатай байдаг. Нэг, хоёр бороонд хороод чичрэгээ нь гараад даарахгүй.

- Ноосоо ямар дараалалтайгаар, хэдийд авдаг вэ?

- 3 сарын 15-наас хойш 4 сар гаргаад ямааны ноолуур гэж эхлээд, дараа нь үхрийн хөөврөө аваад, сүүлд нь хонио тэнхрүүлээд, хөөрөөд ирэхлээр нь 6 сар гаргаад авна. Ногоо эрт гарах юм бол 5 сард авна. Эхлээд сувай гээд эр малаасаа авна, дараа нь эм ямаагаа оруулж аваад сүүлд нь борлонгоо авна. Үхэр ч гэсэн ялгаагүй, эр үхрийнхээ хөөврийг нь самнаад, араас нь тугалтай үнээ, бяруугаа самнана. Хонь бас ялгаа байхгүй эр сувайгаа эхэлж хяргаад, сүүлд нь хургаа хяргадаг. Зарим айлууд хургаа хяргачихсан тарга тэвээргийн бодоод янз, янз байдаг юм. Хөөрнө гэж байхгүй ургасан үсийг нь хачиг, шалзнаас нь болоод л хяргана. Унадаг, унадаггүй гээд жил жилээс өөр байдаг юм шиг байгаа юм.

- Энэ жил хэр байв?

- Энэ жил гайгүй байлаа. Бараг байхгүй байсан. Энэ тарианы нөлөө бас байна байх.

- Ямар тариа вэ?

- Өвөл урьдчилж хийж байна гээд шүлхийний вакцин хийсэн.

- Хаагуур шүлхий гарсан бэ?

- Энэ Донгоо, Бэлх, Азарга гээд хойноос орж ирсэн. Манайх гайгүй урьдчилаад тариа хийчихсэн байсан.

- Өвчин гарчихсан айлууд нь малаа яаж маллалдаг юм бол?

- Тусгаарлаж маллалдаг юм гэсэн.

2022\6\30 Одгэрэл ахын гэрт

- Та өөрийгөө танилцуулна уу

- Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Баянгол багийн малчин Өндөр овогтой Цэрэннадмидын Одгэрэл гэж хүн байна. Энэ Баянгол багтаа 1970 онд төрсөн. Би чинь эхээсээ есүүлээ. Манайх хоёр охин, долоон хүүтэй. Сумын төв дээр байгаа Тодгэрэл ахын банди нь Ууганбаатар гээд багийн дарга хийдэг юм. Улаанбаатарт Найманжин, Долоонжин гээд эгч нар бий. Манай том эгч Долоонжин хотын гүйцэтгэх захиргаанд насаараа ажилсан хүн байдаг. Хоёр ах бас хотод хоёулаа жолооч хийдэг.

- Та айлын хэд дэх хүүхэд бэ?

- Би айлын найм дах хүүхэд. Манай дүү Отгонгэрэл манайхтай айл энд суудаг юм. Дээшээ Сонгинотын амд манай ах Содгэрэл мал дээр байдаг. Энэ жил эхнэр нь улсын аварга саальчин болсон юм.

- Та багадаа хаагуур нутагладаг байсан бэ?

- Багадаа Зүүн дэнжээр нутагладаг байсан. Манай аавд хийж үзээгүй ажил энэ суманд байхгүй. Хамгийн дээд талийх нь ажил сумын нарийн бичгийн дарга, багийн дарга хийж байсан 04:34 Сүүлд галч, сахиул ч гэсэн хийж байсан юм билээ. Биднийг бага байхад нэг үхэр тэрэгтэй аагинат хийнэ, аагийн шарыг нь тэжээгээд, түүхий эд нь цуглуулдаг байсан.

- Аагина гэдэг чинь худалдаа билүү?

- Аагина гэдэг чинь сумынхаа захаар явдаг, нэг ёсондоо жижигхэн дэлгүүр л гэсэн үг.

- Тэгээд явуулаар явдаг байсан юм уу?

- Үгүй ээ явуулаар явахгүй, явуулаар явах нь болохоор дээр үед үхэр тэргээр түүхий эд цуглуулдаг байсан юм. Шөлний тос, мос гээд айлуудаасаа янз, янзын юм цуглуулна. Тэгээд тэрийг чинь худалдаа бэлтгэлийнхээ ангид тушаагаад саван энэ тэр хийдэг гэж хүүхэд байхад ярьдаг байсан юм. Би нэг алдаг, оног цэцэрлэгт сууж байсан байх. Тэгээд арван жилээ төгсөөд, аав ээж хоёртойгоо 1990 онд хувьчлалаас өмнө "түрээсийн гэрээ" гэж нэг юм байсан юм. Тэрүүгээр би чинь азарга адуу түрээсээр аваад нэг жил болж байтал нэгдэл тарсан. Хамаг юм хувьд шилжсэн болохоор түрээсийн гэрээ больсон юм. Тэгээд аав, ээж хоёртойгоо цөөхөн хэдэн малаа маллаад гарсан даа. Одоо гуч гаруй жил олж байна. Би 28 настай байхдаа энэ хойд хаваржаанд хуримаа 11 сард хийж байлаа. Одоо гурван хүүхэдтэй, малаа маллаад сайхан амьдарч байна. Тэмээнээс бусад нь дөрвөн хошуу малтай. Мал маллах сайхан гэхдээ хайрлаж, дурлаж хийх хэрэгтэй юм билээ. Тэгж байж ажил үйлс нь бүтдэг. Зарим хүмүүс чинь уйдаад ирэхээрээ малаа өгье, нутгаасаа ч холдох гээд байдаг. Тэгвэл ер нь бүтэхгүй л дээ. Би хангай даа дурлаж, нутгаа шүтэж, баясаж амьдардаг. Одоогийн хүмүүс тэгэхгүй маягтай л байдаг шүү дээ. Адаглаад нэг чулуу ховхорчихсон байхад байранд нь хийгээд оруулчих зүгээр шүү дээ. Би бол тийм бодолтойгоор хангай дэлхийгээ хайрлаж, залбирч явдаг юм. Манай энэ нутаг их сайхан газар өвс, ус нь тэнцүүхэн, жалга болгон нь устай, уул болгон нь модтой

хаа ч явсан морь, малаа услаад явчихна. Зарим газарт аймар ажилтай хүмүүс байдаг юм билээ. Худгаас усаа авч малаа усална. Манай хангай газарт бол тийм юм байхгүй шүү дээ. Ийм байхад л зарим хүмүүс хичээхгүй байна. Энэ бол их буруу. Тэгэхэд говийн хүмүүс их ажилтай, ганц гэрээрээ хол буучихсан байдаг. Манайх овоо олон жил ганц гэрээрээ явж байна. Тэгээд яаж ганц гэрээрээ явдаг юм бол гэдэг шүү дээ. Яах вэ ажил төрөлтэй үед хэцүү нэг талдаа малдаа сайхан. Ганц гэрийн мал их ижилсдэг байхгүй юу, миний бодлоор их гэр амьтай болчихдог. Одоогийн хүмүүс чинь биеийн амраа хараад, үхрийг бол саагаад саалиа аваад залчихдаг юм. Хэд хоноод эргүүлээд л тэгж маллалдаг болчихсон. Одоо цас орох нь бага болчихсон болохоор бараан голцуу, морь унах дургүй.

Түлхүү мотоциклоор явчхаж байна. Түргэн үед сайхан л даа, мань шиг ганцаараа малд явдаг хүнд бол зарим талаараа ашигтай. Морь бол хамгийн сайхан эд, биед амар, ямар ч мөнгө зарлагдахгүй. Орчин үеийн хүмүүс чинь өдөр болгон мөнгөөр л мал маллаж байгаа гэсэн үг. Яагаад гэхлээр дан машин, мотоцикл явна. Бүр зарим хүмүүс чинь машинаар хараад байна шүү дээ. Тэр чинь буруу ч гэх нь хаашаа юм тийм сонин болчихсон. одоо бензин ямар үнэтэй билээ дээ, мөнгөөр хараад байна гэсэн үг л дээ. Одоо үхэр тэрэг ховордчихлоо, түүнээс хайнаган шар гэдэг чинь ингээд өвсөө авчихна, мод руу ороод түлээгээ аваад, гишүүгээ янзын их ачаад ирнэ. Тэр тал нь устаж байна даа. Тэрийгээ байя гэхэд морио жаахан унаад байвал мөнгөөрөө малаа хариулахгүй юм даа.

- Одоо ингээд мотоцикл унаж, явахаар бэлчээрт нөлөөлдөг юм болов уу?

- Уул хяраар явахад нөлөөлнө шүү дээ. Адаглаад энэ чулууг их ховхолж байна. Ямар буцааж хэвэнд нь хийх биш. Одоо энэ залуучууд чинь 14:55 шумбанг хамаагүй туулж байгаа. Гарахгүй гээд яах вэ, морь байхгүй юм чинь явган явахаараа залхуурна. Адаглаад энэ хавар морьгүй мотоциклтой хүмүүс нь цас орохоор малаа аваачиж чадахгүй байна. Морьтой хүмүүс бол шууд морио унаад л хярд очоод сайхан халуун хоол ундаа хийгээд идчихнэ. Тэр талаараа янзтай ашигтай байгаа биз, угаасаа зохицчихсон байдаг байхгүй юу.

- Та ямар нэгэн бэлчээр ашиглалтын холбоо энэ, тэрэнд бүртгэлтэй байдаг уу?

- Байхгүй ээ, зүгээр сайн дураараа бэлчээр, булаг шандаа хайрлах малчин хүний сэтгэлээр явж байна.

- Монголын бэлчээр ашиглалтын нэгдсэн холбоо билүү дээ тэр ер нь наашаа орж ирсэн юм уу?

- Ногоон алт гээд орж ирсэн. Манай суманд тэр Батсүхийн цаад талын дэлгүүрийн тэнд нэг байшин барьчихсан байгаа. Орж ирээд овоо хэдэн жил болж байна. Тэгээд юу болов, мэдэхгүй. Намайг хүртэл манай найзууд, намын гишүүд өндөр цалинтай хийхгүй юу гээд тэгж байсан. Би малаа хаяад яаж хийх вэ дээ. Иргэдийн хурлын дарга 4 жил хийж байсан юм.

- Хэдэн онд вэ?

- За байз, хэдэн онд билээ. Дараа нь иргэдийн хурлын төлөөлөгчөөр хоёр удаа сонгогдож, найман жил төлөөлөгч хийсэн. Тэр талаараа нэг жил Отгонбаатар дарга дуудаад тэгж байсан юм. Одоо Дамчиг гээд Баруун дэнжийн нэг хүүхэн ажиллуулдаг юм гэсэн. Ууг нь Азаргын нэг залуу байж байгаад больчихсон байна билээ.

- Яг хийсэн юм гэж хэлэхээр юм байдаг юм уу?

- Тэд нарын одоо хийсэн юмыг ах нь бол сайн мэдэхгүй байна. Их л юм хийгээд, тайлан, тооцоо гээд яриад байдаг.

- Сургалт хийж байсан уу?

- Хийсэн байж магадгүй ээ, ах нь сууж байгаагүй. Уул нь энэ тэрүүгээр сургалт их болдог. Би нэг хөөврийн сургалтад сууж байсан. Хамгийн анх сарлагийн хөөвөр авах гээд, тэгсэн тэр хавийн айлуудын сарлагийг хашчихсан ингэж самнадаг гээд янзын хэлж өгч байсан. Тэгээд бид нар чинь зав гарвал самнаад тушаадаг болсон шүү дээ. Манайх бяруугаа хоёр өдөрт зав муутай самнаад 18-аар өгөхөд л 500-600 мянган төгрөг хийчхээд байсан. Энэ жил ноолуур, юмны ханш их унаад байна.

- Өмнө нь самнадаггүй байсан юм уу?

- Тийн самнадаггүй байсан. Энэ гэхдээ Ногоон алт биш өөр төсөл байсан юм.

- Хуучиндаа бүр самнадаггүй байсан гэж болох уу?

- Дээрхэн үед самнадаг байсан байх. Миний мэдэхийн үед бол нээх самнадаггүй байсан. Уул нь бол социализмын үед чинь аймар юм хийж байсан үе шүү дээ

- Та тэгвэл 1990 оноос хойш мал дээр гарсан юм байна. Тэрнээс өмнө хүүхэд байхдаа мал маллаж байв уу?

- Би зүгээр малд их дуртай хүүхэд байсан. Сумын төвтэй ойрхон хааяахан адуу хашдаг, хувьдаа малтай хүн тэр үед цөөхөн. Тэгээд би гүйж очоод адуунаас нь хашилцаад, ноцолдчихдог байсан юм. Сумын төв дээр цөөхөн хэдэн настайчууд морь уяна. Сайн дураараа очиж мордоод, хөлсөлж өгдөг хүүхэд байсан юм. Манай ахынх малчин байсан болохоор хааяахан очно.

- Тэгээд түрээсийн малаа хувьчилж авсан гэсэн үг үү?

- Хагас дутуу авч байсан. Ногоон таслуур гээд юм байсан учраас бүгдийг нь авч болохгүй л дээ.

- Та хэдэн тооны мал авч байснаа сандаг уу?

- Цөөхөн дөө, азарга адуу гэдэг чинь 24 адуу авч байсан юм. Тэрнээс тараагаад 10 дотор байсан болвуу. Тэгээд ганц бяруу, тугалтай үнээ авсны дээр аав ээжийнхээ өвлөж өгсөн малыг өсгөөд өдий дайнд хүрж байна. Мөнгөтэй хүмүүс чинь худалдаж аваад л малаа өсгөчхөөд байна. Ах нь бол тэгээгүй ээ.

- Одоо танд хэдэн тооны мал байна вэ? Мянгат болчихсон уу?

- Мянгат болоогүй. Одоо бол мянган мал байж л байна. Ах нь өөрөө хэл амны нэмэр гээд мянгат болох дургүй. Мал өсөөд ирэхээр газрын гарц муу гараад, бэлчээрийн даац хүрэхгүй болохоор малчид бие биеэ ад үзээд, сонин болоод байна. Тэгээд мал өсгөхлөөр хэн хэндээ дараатай болоод ах нь барьчихдаг юм.

- Та яаж барьдаг вэ?

- Жишээ нь үхэр 300 гараад ирэхлээр зун болоод жилд нь 50-60 үхэр зах зээлд оруулчихна. Жилд 70-80 үнээ тугаллаа гэхэд 50-60 тооны үхэр зарна. Тэгэхгүй өсгөнө гэвэл хангай сайхан байгаад зуд болохгүй бол дороо өснө. Зуд болбол хэцүү. 2000 онд айхтар зуд болж байсан. Тэгэхэд амьтад их сүйдсэн дээ. Манай аав бас анчин хүн намайг ан хийхдээ ганц, нэг удаа морьтой дагуулж, явахдаа Бор усны цуурай гэх зэлүүд газрыг сайхан газар гэж хэлж байсан юм. Би тэр жил хадам аавтайгаа мэдэхгүй явж, явж очиж буугаад гайгүй давсан.

- Нөгөө морьтой хүн явж байгаад цуурай яасан ч гэлээ, нэг шүргэж мүргээд гээд нэг тиймэрхүү юм сонсож байсан тэр мөн үү?

- Тэрийг хэн ярьж байна?

- Мөнхбаатар ахын ээж.

- Аа тэгвэл магадгүй. Ах нь тэрийг нээх сонсоогүй. Тэгж зуд давснаасаа хойш өвөлжөөгөө болгочихсон, борог ихтэй, дулаахан, сайхан газар. Зуунмодоор даваад цуурайн даваагаар гарч буудаг юм. Одоо 11 сард идшээ идээд явна. Манай эндээс ахынх, дүүгийнх гээд цөөн айл ордог.

- Баянголдоо ордог юм уу? Азаргадаа ордог юм уу?

- Тийн, Азаргадаа орно. Дөнгөж давж ороод хэсэгхэн газар тав, зургаахан айл байгаа тэр нь Баянголынх гэж нутагладаг юм. Тэгсэн хэр нь одоо Азаргынхтай булаацалдах маягтай байдаг. Одоо угаасаа аймар болчихсон.

- Ер нь тэр зудыг өнтэй давснаасаа хойш өвөлжөөгөө болгосон гэж ойлгож болох уу?

- Тиймээ болно. Тэрнээс өмнө энэ хаваржааны газар чинь манай дээр үеийн өвөлжөө байсан. Одоо энэ Баянголд Гангийн өвөлжөө, Сонгинотын өвөлжөө, Товчоо өвөлжөө тэгээд манай энэ Шарунхын27:31 өвөлжөө гээд цөөхөн өвөлжөөтэй байлаа.

- Одоо энэ хаваржаа, өвөлжөөний ялгаа юундаа байдаг юм бол?

- Өвөлжөө газар бол дулаахан, нөмөртэй. Малчин хүнд бол ондоо л доо.

- Яаж сонгодог вэ?

- Идэш ууш, бэлчээр нь арай ахиу, дулаахан, хад үүр сайтай газар байгаа юм. Тэрнээс энэ хангай газар чинь цайдамдуу, нүцгэн уултай, нөмөр багатай. Жишээлбэл энэ доод уулын хаваржаанд өвөлжинө гэж байхгүй. Манайхаас дээшээ 2, 3 хаваржаа байна. Цас дарчихдаг болохоор өвөлжиж болдоггүй юм. Зуд болохгүй л бол энэ хаваржаандаа өвөлжсөн ч болно л доо дээр үеэс том хүмүүс өвөлжиж байсан. Би хавар ирэхэд дээр гээд бэлчээрээ нөөцлөөд явдаг. Явсан хойгуур үлдсэн хавын малчид оторт явахгүй, идээд ялгаагүй болгочоод байх юм.

- Ямар малчид вэ?

- Энэ төвийн малчид бас их адуутай болж байна. Төв тойрсон айлууд чинь төвөөсөө малаа аваад манай энэ ууланд залчхаад долоо, арав хоноод эргүүлчихнэ. Мань мэт нь хол газар тууж, хүйтэн нойтонд даарч хөөрөөд л отроо хийгээд жинхэнэ малчид явж байгаа байхгүй юу. Өвс нь сийрэг байг, талхлахгүй гээд бэлчээрээ гамнаж жинхэнэ

малчин хүн чинь нүүж байгаа юм шүү дээ. Тэгэхэд араар нь малчин гэхэд ч хэцүү, суурин газар суучихсан улс үхэр, адуугаа маллаж байгаа гээд энэ хавиар битүү байна. Ирэхэд ёстой халцгай болчихсон байгаа юм чинь. Тэглээ гээд эндээ суугаад байлтай биш, яваад сайхан газар очно гээд явдаг юм.

- Та малаа туугаад ч юм уу, хот суурин газар бараадах гээд нутгаасаа хол явж үзсэн үү?

- Үгүй ээ, тэгж явах сэтгэл ахд нь байхгүй. Гэр амьтан хүүхэд гэдэг шиг нутаг амьтай хүн. Яадаг ч байсан нутагтаа залбираад л байдаг. Хүмүүс ийш тийшээ сайхан газар байна явах уу? гэж ярьдаг л юм билээ.

- Отор хийж нүүе гээд үү?

- Тийн, гэхдээ одоо бол тийм газар ховорхон болсон. Манай эндээс өнгөрсөн намар Сүхбаатар луу 2,3 айл шилжээд явсан.

- Та төрсөн нутагтайгаа их холбоо хамааралтай бололтой. Нутгийн тань юу нь тийм онцгой санагдаад байна вэ?

- Манай нутаг бол надад онцгой, онцгой. Хүмүүс юу гэж боддог юм, хэн мэдэх вэ. Шөнө орой үдэш явж байсан ч айх аюул байхгүй, нам жим сайхан нутаг шүү дээ. Тэгээд хүмүүс залхуураад өвсгүй байна, энэ тэр гээд юм яриад байдаг. Үнэндээ тийм биш. Мал маллахад бол хамгийн боломжтой нутаг. Ард түмэн сайхан, сумын төвтэйгөө ойрхон, залуучууд мал маллаж болохоор байна шүү дээ. Усгүй газарт хүмүүс малаа маллах гээд л амьдраад байхад ийм сайхан газрыг хайрлаж, хамгаалж, малаа маллахгүй бол ямар хэрэг байх вэ. Хүн ер нь ямар ч юманд дурлаж байж амьдардаг юм байна. Би одоо Шарунхад^{34:16} дурласан. Хүмүүс аягүй бол буруу ойлговол бараг солиорч байна гаж бодох байлгүй. Дурлана гэдэг чинь их шүтэж байна гэсэн үг. Тэгэхээр чинь сэтгэл өег, тайван сайхан, стрессгүй амьдарна. Тийм учраас нутагтаа хайртай мал ч сайхан өсөж байна. Худалдаж авсан мал байхгүй. Би яах вэ хурдан азарга, сайн бух, сайн хуц ухна л авдаг. Манай аав чинь эхээс арван хэдүүлээ, дүү охиныг нь Бэлх багийн Балжинням гэдэг хүн авч сууж байсан юм билээ. Сүүлдээ бүр баян Балжинням гэдэг нэр авсан. Манай сумын гоц малчин хүн, цэрэгт явж ирээд л мал малласан юм гэсэн. Тэр үеэр яаж ч зохицуулж байсан юм хэдэн тооны малтай байсан юм. Одоо өөд болчихсон, цаанаасаа малын төлөө заяагдсан, малаа хайрладаг, чанаржуулж чаддаг, янзын сайхан малчин хүн байсан даа. Тэр хүнээс Бөөрөнгийн хээр гээд хээр азарга авч байсан юм. Настай хүн байж унтахгүй шөнөжин надтай хуучилдаг. Намайг тоож ярина гэдэг надад их сайн байсан байгаа юм шүү. Яагаад гэвэл ах нь гарын дүйтэй, мужаан хүн. Өөрийгөө магтаж байгаа ч юм биш дээр үеийн энэ авдар, савыг, шүүгээг яг дээр үеийнхээр нь хийдэг байсан юм.

- Та энэ авдруудаа өөрөө хийсэн гэсэн тээ?

- Тийн, гэрийнхээ авдар хаалгыг, дүүгийнхээ гэрийн авдар, хаалгатай нь хамт малынхаа хажуугаар дан өөрөө хийсэн. Яг энэ зуслан дээрээ зун нэг илүү гэр барьчхаад мужаанаа хийдэг юм. Хүмүүс гадуур сэлгүүцэж явахад ах нь аль хэзээний малаа хариулчихсан хэр нь мужаанаа хийнэ. Дээр үеийн монгол шүүгээ, чанартай гоё авдар, ^{38:19} бурхны гүнгэрваа хийдэг байсан.

- Одоо та хүн гуйвал хийж чадах уу?

- Ахыг нь хүн гуйж байгаа гэж зөндөө, зав болохгүй бас залуу биш болохоор хийж чадахгүй байгаа. Гэхдээ өөрсдөдөө, хүүхдүүддээ хийе гэж бодоод байгаа зав таарахгүй юм. Амьхандаа хэдэн сайхан хушан банз хадгалаад л байна.

- Та хүүдээ зааж өгч байна уу?

- Зүгээр хөрөөдөж барихыг л зааж байна.

- Та энийг бүр хадаасгүй хийсэн гэсэн тийм үү?

- Тийн, модоор хадаасаа хадна. Энэ эмээлийн хус39:37 сүхний бариулын хусаар хаддаг байхгүй юу, хадаас нь тэр тэгээд цавуу өөр юм хэрэглэхгүй. Дээр үеийн мужаан нар чинь шүүгээний нэг хаалгыг юуг нь яахад 40:05 нөгөөх нь онгойдог, тийм ямар ч хий гарах юмгүй, нүх сүвгүй хийдэг байсан. Балжинням гэдэг хүн чинь өөрөө бас гарын дүйтэй. Надаар шүүгээ, гүнгэрваа гээд бүх юмаа хийлгэсэн. Мужаан хүн чинь хоёр гартай гэдэг. Би хүн хулхидаж чаддаггүй, тийм балай онцлогтой. Хийвэл яг л өөрийнхөө сэтгэлд таарснаар хийдэг байхгүй юу. Яах вэ гараас жаахан удаан гардаг юм. Гарахаараа бол зуурсан юм гардаг байхгүй юу. Тэгээд тэр ах надад их сайн байсан юм. Би одоо халгадаг юм уу яадаг юм тойроод яваад байдаг юм. Тэгээд нэг бариад авах юм бол яг хийнэ, хүн орж ирээд хажууд суулаа бол хийж чадахаа байчихдаг. Анхаарал сарниад хийж байгаа юмаа хийж чадахаа байчихна, сонин зантай шүү. Манай Содгэрэл ахын Тооройбанди гээд эхнэр нь багш, ах нь Алтангэрэл гээд захиргаанд жолооч хийдэг хүн байдаг. Тэднийд нэг шүүгээ, хоёр авдар хийж өгсөн. Чи завтай бол тэрний хийцийг нь үзвэл янзын шүү дээ. Би мөнгө олохын тулд биш хоббигоороо хийдэг болохоор их дуртай. Тэр эв нийлүүлж хийнэ гэдэг их ажил ордог.

- Та хааяа хот хүрээ орохоороо хэдий хугацаанд нутгаа эргүүлээд санаж байна вэ?

- Удахгүй шүү, дан ханаж явна. Нутгаа мартана гэж байхгүй.

- Та хотод хамгийн ихдээ хэр удаж байсан бэ?

- Ах нь нээх удаан байж байгаагүй. Эмчилгээ хийлгэвэл эмнэлэгт 7,8 хоног болно. Ойрын 2,3 жил өвчин гээд явсангүй. Харин 10 төгсөөд, манай эгч хүрээд ир гээд нэг жолоонд 6 сар бас Толгойтын авто сургуулийг чи бараг мэдэх байхаа тэнд давхар экскаваторын курст сурч байсан юм. Тэгж л нутгаасаа хол удаан байж үзсэн.

- Тэгэхэд та нутгаа санаж байсан уу?

- Өө санана шүү дээ. Харимаар байна гэж бодогдоно. Одоо бол явахаар мал, идээндээ татагдаад бүр их санана. Санахгүй гээд ч арга байхгүй.

- Та нутагтаа эргэж ирээд юу эхэлж бодох уу?

- Зун ирэхэд бас бороо орж байвал шууд хийморь сэргэнэ. Хэдэн онд ч юм дээ, хүүхдүүд жоохон байхад нэг зун дүүдээ малаа орхичоод гэр бүлээрээ хот орсон юм. Хаваржаан дээр иргээд ирэхэд 2,3 өдөр бороо орсон. Тэгэхэд дулаахан, шиврээ бороо орохлоор хивс шиг халиурсан юм. Тэр мөн их хийморь сэргээсэн дээ. Миний нэг хээр морийг барьж аваад уячихсан байсан юм. Тэгээд гөлчийтөл үсээ хаяад, самсаатай болчихсон адуугаа харахаар өөрийн эрхгүй сэргэнэ. Тийм гоё таашаал авдаг. Тэр зун их янзын болсон. Өдөр шөнөгүй шиврээ бороо 2, 3 өдөр тэгж орж байхад нь л ногоо ургачихдаг юм шиг билээ.

Цэл ногоон өнгөтэй яг л хивс шиг байсан. Нутгаа харахаар хэний зохиосон дуу билээдээ "ийм сайхан нутагтаа ингэж амьдрахгүй яах вэ дээ" гээд тэр бодогдоод байдаг юм.

- Ер нь малчин хүн яг ямар шинж чанар, мэдлэг ухааныг эзэмшсэн байвал сайн малчин болдог юм бол?

- Ах нь улсын аварга малчин энэ тэр биш ч гэсэн сайн малчин гэвэл Балжинням ах шиг хүн гэж хэлнэ. Цол өгөөгүй байх л даа, одоо хүүхдүүд нь сайн эцгийн буянд сүүлд 2 жилийн өмнө нэг хүү нь сарлагаараа мянгат болсон. Тэр аймар их хөдөлмөрлөсөн хүн байгаа биз. Тэр хүн чинь малаа сайхан бэлчээрт гаргаж, сайхан усалж л байвал сэтгэл нь ханадаг. Ер нь малчин хүн гэдэг чинь өглөө эрт босож, шөнө, орой унтана. Өглөө малаа хаашаа бэлчээх вэ гэдгээ өөрөө ч мэднэ, мал нь ч мэднэ. Манай мал бол өглөө хаашаа бэлчихээ өөрсдөө мэддэг юм. Өнөөдөр хангай ямар байна гэж байгаад тиймэрхүү байвал тийшээ оруулна гээд бодчихдог. Гайгүй өдөр байвал харж байгаад урагшаа явах маягтай байвал урагшаа нь явуулчихна. Хэрвээ цасан шуурга тавихаар байвал нөөчихсөн нөмөртэй газартаа оруулна. Ах нь сайхан модтой, өвстэй газраа нөөчихдөг юм. Одоо чинь хүмүүс сонин болчихсон, залааныхаа налаар идүүлэх гээд байна.

- Залааны налаа гэдэг нь юу юм?

- Нөгөө залсан сарлаг гэдэг шиг, тэрүүгээрээ идүүлэх гээд байдаг юм. Нэг өдөр нь нэг тийшээ явуулаад нөгөө өдөр нь өөр тийшээ гэж тэгж явуулбал дээр байдаг. Тэгээд ээрч маллавал, малчин хүн юм уу гэж боддог доо. Хол явуулахдаа явуулалгүй яах вэ, гэхдээ одоо үед бол хүний бэлчээр лүү явуулаад байдаггүй тийм малчин зүгээр. Өвлийн цагт бол нээх хол явуулах шаардлага байдаггүй юм билээ. Өвстэй л байвал гэрээ тойруулаад ойрхондоо ээрээд л маллавал, гэдсийг нь амархан цагтана. Их холхиод байвал малд муу гэж боддог. Ер нь мал сурц, сурцаараа яг эзнийхээрээ л байдаг даа. Зарим айлынх сайхан өвстэй газар идүүлнэ гээд цувж явуулаад их хол очно. Тэгээд мал нь сурчихсан байдаг юм.

- Тэгээд эзэнтэйгээ холбоотой болчихсон байдаг гэсэн үг үү?

- Тийн, ямар ч мал холбоотой болно. Адуу хүртэл адил. Манай нэг адуу бол энэ Сонгинотоос холдохгүй зун болохоор гэрийнхээ гадаа ирчхээд, өвөл болохоор нэг газар очоод өвөлжихдөг. Хавар бол тэгсхийгээд л байна. Манай нэг морьдтой эх адуу бол ус ууна, бараа орно, эргээд гэр рүүгээ яг энд ирнэ. Тэгээр хонхроосоо гарахгүй. Үхэр бол бүр явахгүй тэгсхийгээд л байна. Ер нь яг маллаад байхаар нэг газраа байршдаг байхгүй юу. Зарим хүмүүс нэг газар байхаар мал уйдаад, тогтвор муутай байна, өөр тийш нь жоохон явуулахгүй бол гээд байдаг. Миний бодлоор тэр худлаа, мал нь биш хүн нь уйдаад байна гэж боддог. Одоогийн хүмүүс нэг тийм юм яриад байх юм. Өвстэй л бол нэг газартаа малаа байлгаад байх тусам тогтвортой болдог байхгүй юу. Хүн нь сэтгэлээрээ уйдаад байдаг тэр малчин хүнд их буруу. Ах нь л тэгж боддог юм. Жинхэнэ малчин хүн чинь өглөө эрт босоод л, морио унаад, малаа тогтоож хариулаад орой, орой унтана. Яах вэ олон жил маллахаар ядраад байдаг юм. Хүн чинь бас ядарна, уйдна шүү дээ. Гэхдээ ер нь манай мал, манай нутаг уйдаадаггүй. Дээр үед сайн малчин их байсан.

- Одоо танд хэлчихээр нутаг, усанд тань байгаа сайн малчны шинжтэй хүн байна уу?

- Өө байна, дурдаад яах вэ дээ. Олон дотор тиймэрхүү хүмүүс зөндөө, хэний хүүг ялгаж хэлхэв. Гэхдээ ер нь ховор болж байна шүү. Залуу малчид бас ховордож байна.

- Залуучууд юунаас болоод яагаад мал маллахгүй байна вэ?

- Одоо мэдэхгүй юм даа, янз, янз болвуу. Зарим хот суурин газар мэргэжилтэй эхнэр аваад байхаар тогтвор суурьшилгүй болчхож байна. Нэгдээд ирэхэд сумын төвд эхнэр нь ажилтай, хоёрдоод ирэхэд 6 настай хүүхдийг суулгаачихаар малчин хүнд хүүхдээ гэхүү, малаа гэхүү гээд өөрчлөлт их орно. Хаашдаа 7 настай болоод байсан юм чинь 6 настай буруу л байгаад байгаа юм. Одоо юм нь өөр болчихсон юм даа. Бид нарын үед цэцэрлэгт суухгүй байсан. Манайх л лав 3 хүүхдээ гэртээ үсгийн зааж өгөөд, уншуулж, бичүүлээд, хөөрхөн зохих хэмжээний бодлого бодуулаад, оруулчихдаг байсан. Одоо чинь заавал цэцэрлэгт суулгах ёстой. 5 настай цэцэрлэгт суулгахгүй бол 6 настай сургуульд авахгүй гээд нэг сонин юм гарчхаад, залуу малчид хүүхдээ авч сумын төв орчхоод малаа маллахгүй жоохон хөндийрөөд ховор болоод байх шиг байна. Хүн болгон сургууль зорчдог болохоор эхнэр олодохгүй нэг тийм тал бас байх шиг.

- Одоо энэ монголын хахир, хатуу, хүйтэн эрс тэс уур амьсгал залуу малчдыг халшрахад хүргэж байгаа бол уу?

- Манай нутагт бол бараг байхгүй. Малчин хүнд чинь хангай муудах бол байдаг л эд шүү дээ. Тэгж халширтал цасан шуурга тавиад л ган гачиг болоод, мал идээ нь таргалахгүй, зуд болоод л үхэж үрэгдээд байгаа юм гайгүй. Тэр 2000 оны зуднаар л жаахан гэвдэж, туршлагагүйтэж малаа үхүүлснээс биш зуд гэж хүмүүс мэддэг ч үгүй байсан. Аль түрүүлж бараан газар очсон нь онодог юм билээ. Зудад гайгүй байх гээд малаа авч суусан нь малаа үхүүлнэ. Сарлаг чинь багцаа өвстэй, бараан байхад л гайгүйдээ. Их цас ороод байвал их л хурдан хооллохгүй бол жаахан хэцүү. Хонь бол их тэснэ. Цасанд дороо сарлагийг алдчих гээд байдаг байхгүй юу. Олон сарлаг бол алдана.

- Хавартаа хэр байдаг вэ?

- Хавар шуурах үедээ шуурна. Хооллуулахгүй 2,3 өдөр шуурдаг үе бий. Энэ хавар бас тийм чанга өдрүүд байсан. Мал цагтаа орчихоор гайгүй л юм байна.

- Сарлаг хавартаа тэсвэртэй юу?

- Хавар дулаан орчихсон болохоор гайгүй. Эрт дүү бол хэцүү л дээ.

- Та монгол (монгол үхэр) маллаж үзсэн үү?

- Нээх маллаагүй. Би эхнэр аваагүй, аав, ээжийгээ байхад 5 монголын бяруу авч байсан. Тэгээд томруулсан, эр голцуу байсан болохоор өсгөөгүй л дээ. Ууг нь өсгөсөн бол монгол сайхан мал, сарлагтай ч гэсэн ижилсдэг юм билээ. Манай тэд нар сарлагийн үхрээсээ гардаггүй байсан.

- Одоо монгол байхгүй юу?

- Одоо байхгүй, хайнаг чиг байгаа. Дан сарлаг.

- Таны хүүхэд байх үе болон одоо үеийн мал маллаж байгаа арга барилаас өөрчлөгдөж байгаа зүйл байна уу?

- Байгаа байгаа.

- Яг юу, юу нь өөрчлөгдөөд байна вэ?

- Одоо мал маллахад техникээр голцуу болчихоод байна. Мотоциклоор их маллана. Энэ чинь аймар өөрчлөлт. Тэгээд өвс, ургамал нь тачир болчихсон. Намайг залуу байхад энэ намаржаа тэр авчихсан байгаа зураг шиг байсан. Одоо тэгсэн ургаад, ургаад энэнээс илүү гарахгүй. Гэхдээ ах нь бол мал нь ихдээд, гишгэлүүр болгоод ургуулахгүй, гарсныг нь идчихээд байна уу гэж бодоод байгаа.

- Энэ нөгөө манай төхөөрөмж мөн үү?

- Биш, биш. Наа чинь хангайн амьтан үргээдэг анивчдаг гэрэл.

- Энэ ч бас тэгвэл өөрчлөлт л юм байна даа тээ?

- Тийн. Одоо айлууд янз, янзын их гэрэл тавьж байна. Гэхдээ наа гэрэл чинь сайн юм түүнээс тэр цагаан гэрэл онцгүй юм билээ. Гэрэлгүй болчихоор хонь нь үргээд тогтохгүй байна гэсэн. Орчин үедээ дасаад гэрэлгүй болохоор унтаж чаддаггүй юм байна. Хангайн амьтнаас үргээж байгаа нэртэй буруу хэвшилтэй болгочхож. Тийм юм яригдаад байгаа тэр үнэн байх. Одоо бие биеийнхээ үхэр, малыг хөөдөг болчихоод байна. Ойрын хэдэн жил бэлчээрийн даац хүрэхгүй байгаа нь мал маллахад төвөгтэй болгох гээд байгаа юм. Бусдаар бол гайгүй. Өвс нь ховордох нь ховордолгүй л яах вэ. Ургац нь жоохон муудах нь муудаж байгаа. Монголын мал арай л өсчхөөд байгаа муу даа тэгээд газрын гарц жил жилдээ муудаад байх шиг.

- Ер нь энэ нүүдэлчин, малчин хүмүүсийн хамгийн чухал юм нь юу байдаг юм бол?

- Мал маллах арга ухаанаа хадгалж үлдэх л юм даа. Одоо бол үе дамжсан монгол малчин байлгах л чухал.

- Монгол малчин гэж таны хувьд яг ямар шинжтэй хүн байх вэ?

- Жинхэнэ монгол малчин гэхээр дээр үеийнхээ мал маллагаагаар маллахыг хэлнэ дээ. Одоогийн малчин чинь морио эмээллээд, хониндоо явахгүй, туучаад л айлын мал руу шахаад байхаар чинь монгол малчин биш болчихоод байна шүү дээ. Тэгээд л төв яваад өгнө. Нууцгүй ярихад энэ хавийнхан чинь тийм байна. Тэгээд монголоороо сайхан маллаад сууж байхад чинь эзэнгүй мал ирээд, нийлчих гээд давхар мал маллаж таарах юм.

- Тэгэхээр морьтой хүнд татагдаад байна гэсэн үг үү?

- Үгүй ээ, морьтой хүнд татагдсандаа биш. Манайх морьтой малаа маллаад явж байхад, нөгөө саахалтын айл чинь бас морио унаад, хонио маллаад, бэлчээртээ гарна даа тэгээд ойр ойрхон бэлчээрлэж болно шүү дээ. Хоёр хониныхоо голд суугаад, мал идээгээ яриад хуучилдаг байсан байхгүй юу. Дээр үед чинь тийм байсан юм. Тэгсэн чинь одоо тийм юм байхгүй болчихсон. Энэ талаас ч эзэнгүй хонь гарч ирнэ, тэр талаас ч эзэнгүй хонь гарч ирнэ. Зайлуул харж байгаад эргүүлэхгүй бол хонь чинь ирж нийлчихдэг. Мал дээрээ байгаа хүн чинь харж байгаад нийлүүлэлтэй нь биш айлын хонийг эргүүлнэ. Тэгээд айлын хонийг гэр рүү нь биш өөр тийшээ туухгүй юм чинь давхар хариулчхаж байгаа юм. Тэгж ярихад ер нь өөрийнхөө малыг маллахгүй, өөр айлын малыг давхар хариулдаг тийм хүн сайн малчин болчихоод байна. Одоо чинь гаргаж туучаад л Одгэрэл ахаа манай үхэр, хонь хаана байна гэсэн юм яриад байж байх юм.

- Ер нь малчин хүмүүс бэлчээр дээрээ уулзаад юу, юу ярьдаг юм бол?

- Уулзаад малаа л ярина. Тарган сайхан зусаж байна уу? гэж эхлээд л малынхаа тараг тэвээрэг, мал идээгээ сурч л асууна. Ингэж л малчин хүн дээр үеэсээ тийм л байсан шүү дээ.

- Одоо яаж байна вэ?

- Одоо ер нь мотоциклтой ирээд л адуу байна уу? ахаа гэгчхээд л давхиад явчихна.

- Бэлчээр дээрээ уулзаж байгаа хүмүүс хөөргөлдөг юм уу?

- Дээр үед хөөргөлдөг байсан байх. Одоо үед хөөрөг авч явахгүй юм чинь ямар юмаараа хөөрөглөх вэ дээ. Манай энд арай л жаахан соёл муудаад байгаа бололтой байдаг. Ер нь хөөрөг гэлтгүй, яриа хөөрөө, мэндлэх ёс ч гэсэн. Энэ Төв аймаг, Өвөрхангайн малчин хүмүүс нь сайхан байдаг юм байна гэж ах нь очиж үзээгүй хэр нь тэгж бодсон.

- Та юунаас болоод тэгж бодсон юм бэ?

- Манай нэг хүргэн Өвөрхангайнх байхгүй юу. Тэр нэг ахынхаа яриаг сонсоход, адаглаад гоё, гоё үг хэлнэ шүү дээ.

- Юу гэж байх юм?

- Аятай юу? тохитой юу? гэх нь хөдөөгийн хүнд их давгүй яриа.

- Зарим газарт бие ажил сайн уу? гэж мэндэлдэг юм билээ. Наашаа ингэж мэндэлдэг үү?

- Манай энүүгээр сонин сайхан юу байна, сайн уу? л гэж голцуу мэндэлдэг дээ. Манай сумынхан ер нь тийм.

- Мэндлэх чухал уу?

- Чухал даа. Одоо юу байна? гэдэг болчихсон. Энэ буруу шүү. Адаглаад сайн уу? сонин сайхан юу байна? гэх хэрэгтэй.

- Юу байна? гэдгийн яг юу нь танд эвгүй санагддаг вэ?

- Угаасаа л буруу мэнд. Одоо тэгээд ер дасах тийшээгээ л байна даа.

- Ямар насны хүмүүс голцуу ингэж мэндэлж байна вэ?

- Залуучууд л голцуу байна даа.

- Хүнтэй сайхан мэндлэхийн юунд нь тийм утга учир байдаг юм бол?

- Одоо тэгээд дув дуугай ирээд суултайн биш мэндлэх л ёлтойлдоо. Хаана ч таних танихгүй хүнтэй таарсан ч гэсэн. Гэхдээ энэ хөөрөг гэдэг бол дугарахгүй хүнийг дугаргадаг эд юм байна. Их хэрэгтэй эд юм. Хөөрөггүй хүн бол гар мухар л юм билээ. Тэгээд их хурлын гишүүн энэ тэр том хүмүүс ирээд хөөрөглөхөөр дугараад байгаа шүү дээ. Хөөрөглөхгүй бол гар барилтайн биш малчин хүмүүст бол жаахан эвгүй л байна. Хөөрөг бол дээр үеийн хүнтэй юм ярьж, хуучлах ганц түлхүүр юм бишүү. Тэр тал дээрээ их чухал

- Хөөргөө барих, хөөрөглөх ёс гэж байдаг уу?

- Дээр үеэсээ хөөргөний толгойг эрхий хуруугаараа дарж өгөхгүй. Хэрвээ тэгвэл чамтай тооцоотой, яриатай гэсэн утгаар өгдөг.

- Тооцоотой гэхээр бараг өстэй гэсэн үг үү?

- Бараг тийм утгатай юм шиг байна билээ. Эсвэл чамтай нууц яриатай уулзъя гэсэн үг ч байж болно. Тэгээд заавал хөөргөний толгойг дээшээ харуулж султгаж өгдөг.

- Тэгж султгадаг нь ямар учиртай байна вэ?

- Ямар утгатай юм байгаа нь ямартай ч тэгж болдоггүй л гэдэг.

- Одоо танайд холоос зочин ирвэл яаж угтаж авдаг вэ?

- Сайн явцгааж байна уу? гээд л тосож угтаж авна даа. Нэг ёсондоо хүндэтгэж байна гэсэн үг л дээ.

- Ямар идээ, ундаагаар дайлах вэ?

- Хөдөөгийн хүн чинь тэгээд цай, тосоо хольж өгнө дөө. Дараа нь хоол хийхдээ бууз хийж өгнө. Яах вэ хорхог бас банштай цай хийдэг.

- Одоо ойроос мал, адуугаа сураад ч юм уу хүн орж ирвэл тос хольж өгөх үү?

- Хийх үе байвал хийж өгөлгүй яах вэ. Ойр дотны ч юм уу таньдаг хүн бол хийж өгнө.

- Холоос ирсэн гийчинтэй ихэвчлэн ямар сэдвээр ярилцдаг вэ?

- Хот хүрээний сониныг асууна, хөдөөгийн хүн бол энэ хавийнхаа сонин хачныг асууж, мал идээний тарга, тэвээрэг, газрын гарц, жимс жимсгэнэ ярина даа.

- Энд ямар жимс ургадаг вэ?

- Хад,нэрс, үхрийн нүд, бас тошлоо бага зэрэг ургадаг юм.

- Тошлоо гэж ямар жимс байдаг юм?

- Хаданд ургадаг жимс байдаг юм.

- Та энэ эмээл, олмоо өөрөө хийсэн юм уу?

- Үгүй ээ, энийг захаас авсан. Харин сурыг нь өөрөө хийсэн юм. Энийг бас өөрөө будаад, цагаан модоор хийсэн.

- Цагаан мод гэж хус юм уу?

- Тиймээ. Энэний жирмийг нь авсан маргааш олмыг нь хийж эхэлнэ дээ. Наадмаас өмнө хийгээд морьтой явах гээд байгаа юм.

- Та өөрөө юу?

- Үгүй ээ, хүүдээ юм.

- Залуучууд морь их унадаг болсон байна тээ?

- Ноднингоос манай сум эргэж морио унаад сайхан болчхоод байгаа юм.

- Саяны Батцагаан овооны наадам дээр сайн харлаа. Дан залуучууд нь морьтой, хөгшчүүл нь мотоциклтойгоо, машинтайгаа явна билээ. Таныг хүүхэд байхад хэр морь унадаг байсан юм бэ?

- Машин ховор байсан юм чинь голцуу морь их унадаг байсан. Ойрын 4,5 жилээс эхлээд машин, мотоцикл ихсээд ийм болсон доо. Тэгээд айлын гадаа чинь машин, мотоцикл байнга болчихлоо. Одоо бензиний үнэ нэмэгдээд, малчид мөнгөө бензинд өгөөд таарч байх шиг байна даа. Мотоциклийн банк чинь гайгүй 20 мянганд хийгээд дүүрчихдэг байсан бол одоо 40, 50 мянга хүргээд байх шиг байна. Тэгээд мах энэ жил жаахан өсөхгүй юм яриад байна. Энэ жил хэдэн үхэр өгчих санаатай харзнаад л байна.

- Малчдын амьдралын эх үүсвэр нь юу, юу болоод байна вэ?

- Намар болохоор махаараа, хавар болохоор ноолуураасаа л хэдэн төгрөгтэй залгаж байна. Тэгээд цалингүй юм чинь өр тавиад оюутны төлбөр, идэж, уух хэрэгцээндээ зарцуулна. Малчин суваг дээр Отгонбаатар малчдын дуу хоолой ч билүү нэг тийм нэвтрүүлэг хийж байсан. Тэр нь дээр та нар малчдыг юу гэж боддог юм, сар болгон ноолуураа самнаад мөнгө авчдаг гэж бодоод байдаг юм уу? гээд тэр үнэн л хэлж байсан. Жил болж байж ноолуур нь гарна. Сайн гарсан ч энэ жил автоматаар унагаалаа. 160 мянгатай гарж ирээд 80,90 мянга руу унасан. Гол нь 1,2 мянгаар унадаг байсан бол 10,20 мянгаар огцом унагаасан. Энэ жил ченжүүд хэдэн цаас хийсэн байх. Ингэж унах ёсгүй байдаг байхгүй юу. Энэ жил нэг хил ноос 500төгрөг болсон байсан. Нэг модтой чихрийн үнэд хүрэхгүй болохоор малчид яах уу, арай л хэтэрхий.

- Нэг хониноос хэдэн хил ноос унах уу?

- Шалихгүй дээ, 2-3 хил ноос унана. Ойрын хэдэн жил ууг нь үнэтэй болоод, ноосны урамшуулал энэ тэр нэмэгдээд их хонь малчид чинь янзтай мөнгө авдаг байсан.

- Ер нь ноос, ноолуур, махаараа хэдий хэр төгрөг дунджаар хийдэг юм бэ?

- Мэдэхгүй. Манайх овоо хөөрхөн хэдэн юм хийчихдэг юмаа. Цэвэр ашиг нь 15,16 сая төгрөг.

- Ноолуураараа юу?

- Тийн. Янз янз л байна байх. Ямааны тоо, ноолуурын гарц, тэр жилийнхээ ханшаас шалтгаална даа. Хонь ихтэй хүмүүс бол догь хийчихдэг байсан юм.

- Өвөл яаж мөнгө олдог юм бол?

- Өвөл мөнгө олохгүй шүү дээ, хавар ноолуур хүртэл хэрэглэхээ нөөцөлнө. Тэгээд цагаан идээгээ зарахдаа зарах ч гэлээ амьтантай адил тэгж ихээр зардаггүй. Сүүг нь тугалд нь зориулж томруулдаг юм. Айлууд чинь багаар нь саачхаад тэжээж байгаа нэртэй тугалаа хатанхай болгочихдог. Тэгээд 5-7 сая, их саадаг нь 10 сая хийдэг л юм билээ. Тэгээд 5 бяруу үхүүлчихээр авсан 10 сая нь гарчхаад байгаа юм. Тэр утгаараа шамдаад байдаггүй. Ах дүү нар, ирсэн хүмүүстээ өгөөд илүүгээ л зохих хэмжээнд зарна. Манайх тос их хийж иддэг ч гэлээ зөөхий тосоо зардаггүй. Хавар болтол, сая л хүргэж дуусдаг.

- Тосоороо юу хийх үү?

- Цагаан тос, ээзгийтэй холиод иднэ шүү дээ. Манайх өвөлжингөө иднэ. Зарим малчин айлууд иддэггүй л юм.

1. Архангай аймаг, Ихтамир сум, Эрдэнэтолгой баг Н.Цэрэннадмид, 27 настай

- **Та Монгол нүүдэлчин хүний хувьд юуг хамгийн их эрхэмлэж явдаг вэ?**

Ер нь гэрээ л байх даа, гэрээ л хайрлаж хамгаалж явах байх даа.

- **Танайх хаагуур нүүдэллэдэг вэ, өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа хаана, ямар нэртэй газар байдаг вэ?**

Хойшоо гараад тэмээн чулуун гэдэг газар өвөлжинө, ерөнхийдөө том том хад асга, уул хадаар хүрээлэгдсэн. Хаваржаа болохоор тал руугаа буугаад Нүхт-Улаан гэдэг газар. Хавар салхи ихтэй болохоор нөмөр ихтэй газар хааж нөмөрлөж буудаг. Зуслан нь болохоор голоо бараадаад Хоёр-тээг гээд эндээ буудаг. Тээг гэдэг нь дараалсан уулыг хэлж байгаа юм. Намаржаа хийдэг газар нь Хужирт гэж байгаа. Наашаа орж ирэхгүй бол тэндээ зусаад намаржчихдаг. Эсвэл том Дэл уулаа бараадаж буудаг. Бууриа сэлгэж бууна.

- **Бууриа сэлгэж буухад юу нөлөөлж байна?**

Бэлчээрээ бодно, хамгийн гол нь малаа бодож нүүж байгаа учир бэлчээр сайн тусмаа малд сайн.

- **Бэлчээрээ хэрхэн сонгосон бэ? Энэ газруудыг сонгоход юу нөлөөлсөн бэ?**

Угаасаа энэ чинь манай өвөөгийн, бас нөхрийн багаасаа л байсан газар.

- **Та хоёр гэрлэснийхээ дараа мал худалдаж авсан гэсэн үү?**

Бид хоёр ерөнхийдөө залуу гэр бүл учраас нэг их малтай байгаагүй. 2 талаас нийлсэн л мал байсан. Суусны дараа хамаатан садан, айлчин гийчин нэмж мал өгсөн. Тэгээд ерөнхийдөө малжсан л даа. Тэгээд сарлаг худалдаж авсан. Сарлаг, Монгол хоёрыг ер нь л ижилхэн маллчих санаатай байгаа.

- **Сарлаг, Монгол хоёрыг маллахад ялгаа байдаг юм уу?**

Сарлаг болохоор сүүний чиглэлийн, өтгөн сүүтэй, монгол үхэр болохоор шингэн сүүтэй. Яг идэш иднэ гэвэл Монгол үхрийн мах хамаагүй илүү чанартай гэсэн үг. Сарлаг нь болохоор хязаалан болсон үед л махална уу гэхээс наана нь шүдлэн үедээ бол туранхай байдаг. Туранхай ч гэж бас сарлагийн мах хар өнгөтэй, шөл гарахдаа муу байдаг.

- **Ингэж олон нүүж байгаагийн шалтгаан нь юу вэ?**

Хамгийн гол нь нүүж, буудал сэлгэж л байвал мал чинь тарга тэвээрэг сайтай л байна. Тарга тэвээрэг сайн авна гэдэг чинь өвөлдөө ер нь сайн орно гэсэн үг.

- **Отор нүүдэл хийдэг үү?**

Хийнэ шүү дээ. Одоо ингээд л мал төллөж дуусаад ногоо ургахын багцаанд хаана ногоо ургаж байна тийшээ л явна. Хаана ногоо сайн байна тэр лүү л малаа аваад явдаг. Тэгээд ногоо ургаад ирэхээр муудсан малын хөл нь хүртэл чангараад ирдэг. Хавартаа ер нь бол отор нүүдэл хийх сайн. Хаа сайгүй л явна.

- **Отроор нэг явахдаа хэр хол зайнд явдаг вэ?**

Нээх хол явахгүй шүү.

- **Нүүдэл хийж байгаагийн цаана ямар нэг шалтгаан байгаа юу? Бэлчээрээ бодох ч юм уу?**

Бодно шүү дээ. Ерөнхийдөө бол өвөлжөөнийхөө тэр хавиар байгаа өвсийг намартаа хадчихдаг. Бага зэрэг хадчихдаг. Хадсан өвс чинь ургаад эхэлдэг юм, тэгээд

ургаад эхлэхээр нь тэндээ өвөлжчихдөг. Сайн ургасан тохиолдолд хадланг бол сайн хадаж авдаг. Тэгээд өвөл цас их орсон байх үед тугал тэгээд муу малдаа хаяж өгдөг. Бас манайх хажуугаар нь солоом тарьдаг. Авах тусмаа сайн юм билээ.

- **Хаана тарих уу?**

Манайх энэ жил өвөлжөөн дээрээ тарьж үзсэн л дээ. Гэхдээ тэр нь сайн ургахгүй байна гэсэн. 1.5 га-д тарьж үзсэн. Ноднин бол шинэвтэр газар байсан учраас 4-5 тэвш л гарсан. Энэ жил би арвин гарчих байх л гэж бодоод байгаа.

- **Танайх нүүж суухдаа өдөр хардаг уу?**

5 дахь өдөр нүүж суудаггүй, гэр буудаггүй өдөр гэж ярих юм билээ. Манайх тэгж цээрлэдэггүй, хүн амьтан байгаа дээр нүүдэл суудлаа хийчих юмсан гэж боддог.

- **Мал хөнгөлөх ч юм уу, унага тамгалах өдрөө өдөр судар хардаг уу?**

Ер нь бол унага тамгалах мал хөнгөлөх үедээ өдөр хардаг. Хэрвээ цээрлэдэг өдөр мл гаргачихвал дараа нь мал үхэж үрэгдэх зэрэг тиймэрхүү юм болох гээд байдаг. Тэгэхээр нь жаахан цээрлэх гээд байдаг.

- **Гаргаж болохгүй цээртэй өдөр малын гаралтай юмаа л цээрлэдэг үү эсвэл өөр зүйл бий юу?**

Мал, цагаан идээ гаргаж болохгүй. Тиймэрхүү юмыг л хардаг.

- **Яг ямар өдөр харах уу?**

Дашням, балжиннямтай өдрийг л хардаг.

- **Малаа имнэхдээ өдөр харах уу?**

Харна. Ер нь малынхаа бүх юман дээр л сайн өдөр судар харна.

- **Малаа хөнгөлчихөөд гэрээсээ ер нь гаргадаг юм болов уу?**

Ерөөсөө гэртээ оруулаад ирсэн цагт юу ч гаргахгүй. Цагаан идээ ч гаргахгүй. 3 хоног гэрээсээ юу ч гаргахгүй. Зарим үрээ зэрэг том мал хөнгөлсөн тохиолдолд 7 хоног гэрээсээ юм гаргадаггүй.

- **Цээрлээд байгаа нь ямар учиртай юм бол?**

3 хоногтоо янзлахгүй бол мал муудаад эхэлдэг байхгүй юу. Жижигхэн юмнаас эхлээд л ямааны хөл хугарах, хонины хөл бэртэх зэрэг сэвтээд зүгээр байж байгаад хонь ямаа үхэх гэх мэт юм болдог.

- **Одоо тэгээд жаахан сэвтээд ирвэл ном уншуулах ч юмуу, тиймэрхүү зүйл хийдэг үү?**

Би болохоор ламын өгсөн утлагаар малын хашаагаа утчихдаг.

- **Жилдээ нэг удаа цагаан сарын үеэр засал ном хийлгэхдээ малдаа ном уншуулдаг уу?**

Уншуулдаг. Засал хийж байгаа ламдаа малаа даатгуулья гэж хэлдэг.

- **Мал зарахдаа дэл сүүлнээс нь авдаг уу?**

Авдаг шүү. Зарсан малынхаа дээжээс нь авдаг. Тэр чинь өөрийнхөө маллаж байгаа малыг хүнд өгч байгаа тохиолдолд дээж гэж дэл эсвэл сүүлнээс нь авдаг. Ерөнхийдөө том малаасаа л авдаг.

- **Календарь хардаг гэсэн шүү дээ. Ямар календарь хардаг вэ?**

Тэрбиш

- **Одоо танайх гүү барьж байгаа, тэгээд зэлээ татахдаа өдөр судар хардаг уу?**

Хамгийн гол нь нохой өдөр бариад бар өдөр тавьдаг. Будаа, арц тиймэрхүү юмаар зэлээ утсаны дараа гүүгээ саачихаад зэлээ мялаадаг. Зэлээ мялаана гэдэг нь хамгийн түрүүнд

саасан гүүний сүүгээр зэлээ тойруулж өргөхийг хэлж байгаа юм. Хамгийн гол нь 2 шон байгаа түүнийгээ будаа арц сүүгээрээ мялааж байгаа юм.

- **Та Монголоо алдах гэдгийг юу гэж ойлгодог вэ?**

Манайд сая говиос хүн ирсэн юм. Тэгсэн чинь үнээ ивэлгэнэ гээд явсан юм. Тэгсэнээ тугалаа татаад байранд нь хийчих гээд байх юм. Манайх болохоор тугалаа татаад хашаанд нь хийчих гэж ярьдаг. Тэр чинь одоо Монголоо алдсан гэсэн үг биз дээ. Байранд нь хийчих гэдэг чинь.

- **Хүн чанар, хүний мөс сайтай хүн гэж ярьдаг шүү дээ. Тэрийг та юу гэж ойлгодог вэ?**

Бодвол сэтгэл муутай хүнийг л хэлдэг байх даа. Ямар ч юманд сэтгэлгүй ханддаг.

2. Баянхонгор аймгийн Баянговь сум 3-р баг Б.Өсөхбаяр, 35 настай

- **Таныг хэн гэдэг вэ?**

Батцэнгэлийн Өсөхбаяр. Ургийн овог Ренчиндорж.

- **Та энэ нутгийн хүн үү?**

Тиймээ, энэ нутгийн уугуул.

- **Та цэрэгт явж байсан уу?**

Явсан. Өмнөговьт хил дээр байсан. Застав дээр байсан.

- **Та хэдэн оноос мал маллаж эхэлсэн бэ? Танайх малтай айл байсан уу?**

Тэгсэн. 4 төгсөөд л, арван хэдэн наснаасаа мал малласан. 1997 оноос хойш мал малласан.

- **Танайх хаагуур хаагуур нүүдэллэдэг вэ?**

Өвөлжөө нь Сэртэн, Хаваржаа, Намаржаа, Зуслан

- **Ойролцоогоор нэг буурь сэлгэх газар хэдэн км вэ?**

За нэг арав дотор л байгаа.

- **Танайх отор хийдэг үү?**

Гандуу бол ийш тийшээ ойролцоо газар явдаг. Тэгэхдээ тийм хол явахгүй.

- **Одоо энэ бууц сэлгэж нүүж байгаагийн учир нь юу юм бол?**

Зун нь өвөлжөөн дээрээ байж болохгүй биз дээ. Өвөл нь зуслан дээрээ байгаад байж болохгүй. Байнга л нүүнэ. Нэг буудал дээрээ байнга байгаад байвал малд хэцүү л дээ. Өвс тэжээл, ургамал муудна.

- **Тэгэхээр бэлчээрээ бодож байгаа хэрэг үү?**

Тийм. Өвөлжөөний чинь бэлчээр зундаа бас сэлгээд нүүчихвэл сэргэнэ. Тэрийгээ дагаад мал таргална.

- **Наашаа ер нь бэлчээрийх нь онцлог ямар вэ? ямар өвс ургамал ургадаг вэ?**

Манай энд говь газар болохоор хөмөл, таана, багалуур л голцуу ургана даа.

- **Энэ ургамлууд ямар малд илүү тохиромжтой юм бол оо?**

Ерөнхийдөө адуунаас бусад мал иднэ л дээ. Тэгэхдээ тэмээнд л илүү тохиромжтой.

- **Танайх нүүдлээ юугаар хийж байна?**

Машинаар л хийж байна.

- **Хуучин юугаар хийдэг байв?**

Тэмээгээр дандаа нуруу ачиж л нүүдэг байсан.

- **Таныг хүүхэд байх үеийн нүүдэл одоо үеийн нүүдэл юугаараа ялгаатай байна?**

Одоо бол тэмээгээр нүүж байгаа айл байхгүй. 2000-аад оны үеэс л больсон байх.

- **Та одоо тэмээгээр нүүж чадах уу?**

Чадна.

- **Ер нь наашаа айлууд ямар мал голчлон өсгөдөг вэ?**

Ер нь ямаа л элбэг дээ. Тэмээ бий л дээ.

- **Ямааг нь ер нь хүмүүс яагаад их өсгөөд байна вэ, ашиг шимийх нь хувьд уу? ноолуур уу? эсвэл энэ бэлчээр нь ямаанд илүү тохиромжтой байна уу?**

Ямаа ч илүү тохиромжтой байдг байх. Ноолуур ч бас ашиг шим нь их байдаг байх.

- **Таныг хүүхэд байхад л их ямаатай газар байсан уу?**

Тэгсэн.

- **Энэ нутгийн таны хамгийн их бахархдаг зүйл юу вэ?**

Энэ уулынхаа өвөрт төрснөөрөө л бахархдаг. Энэ Баруун-богд. 2-3 жилийн өмнө төрийн тахилгатай уул болсон. Зүүн Богд уул нь болохоор Өвөрхангайдаа ордог.

- **Танайх нүүдэл хийхдээ өдөр судар хардаг уу? Ямар өдөр нүүдэг юм бол оо?**

Сарын айхтар муу өдөр биш, өөрсдийн харш өдөр биш гайгүй түвшин өдөр харж байгаад л нүүнэ.

- **Цээрлэдэг өдөр байдаг уу?**

Манайх 2 дахь, хагас, бүтэн сайн өдөр л нүүдэггүй.

- **Хагас, бүтэн сайн өдөр яагаад нүүдэггүй юм бол?**

Сайн мэдэхгүй байна. 2 дахь өдөр миний час өдөр болохоор нүүдэггүй. Бүр өвөг дээдсээсээ л амралтын өдөр нүүдэггүй байсан.

- **Цагаан идээ, мал гаргахгүй өдөр гэж бас байдаг уу?**

Бас л 2 дахь, хагас бүтэн сайн өдөр гаргадаггүй.

- **Мал доройтно гэсэн юм байдаг уу?**

Санаагаар тэгдэг юм уу тийм өдөр мал гаргах, идээ гаргахаар мал нэг жаахан өвдөж барих асуудал гардаг.

- **Мал өвдөж доройтвол яаж тэрийгээ аргалж байна?**

Малдаа засал ном хийлгэнэ. Малын банзрагч уншуулна. Гэртээ лам авчраад галаа тахиулж даллага авхуулдаг.

- **Таны ойлгож байгаагаар малын хишиг буян гэж юу юм бол?**

Малыг хүн амьтанд зарж үрэхээрээ хишиг буянгаас нь авч байгаа гэж үснээс нь авч үлддэг. Тэр үсээ гэрийхээ чагтгандаа хийдэг.

- **Ямар малаас авах уу?**

Бүх малаас авна. Цагаан нь хонины л ноос. Тэр нь адууных. Ямаанаас хялгаснаас нь авна.

- **Өөр малын хишиг буян доройтно гэж цээрлэдэг зүйл байдаг уу?**

Шөнө орой бас мал гаргахгүй.

- **Таны хувьд мал маллахын хамгийн сайхан зүйл нь юу вэ?**

Хөдөө мал маллаад л тааваараа байх сайхан.

- **Нөгөө талаар халширмаар зүйл байдаг уу?**

Ган, зудтай үед хэцүү л дээ.

- **Өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны бууцнуудаа хэрхэн сонгодог вэ?**

Нөмөр нөөлөг, идэш, тоос тэрийг нь л сайн харна. Ус унд малдаа аль нь тохиромжтой байна тэрийг л харна.

- **Хаваржааны гаазар ер нь ямар байх ёстой юм бэ?**

Хавар хүйтэн болохоор нөмөр нөөлөгтэй, ус унд сайтай газар харна.

- **Хаваржаа, өвөлжөө хоёр тэгвэл юугаараа ялгаатай вэ?**

Өвөлжөө бол хамгийн гол нь хэвтэр сайн дулаахан байх хэрэгтэй.

- **Зуслан, намаржаа бол юуг нь харах уу?**

Бас л ус, идэш харна. Усандаа ойрхон, ногоо сайн гардаг газар зусна.

- **Зуслан намаржааны ялгаа нь тэгвэл юу вэ?**

Намар жаахан сэрүү ороод ирэхээр нөмөртэй байвал зүгээр байдаг.

- **Наашаа ер нь унагаа тамгалж найр хийдэг үү? Ер нь хэзээ тамгалдаг вэ?**

Найр нээх хийгээд байхгүй. Унагаа намар тамгална.

- **Унага тамгалахдаа өдөр судар харах уу?**

Бар, морь, нохой гурав хоорондоо ивээл учраас бар, нохой өдрийг харж байгаад барина.

- **Эндхийн айлууд гүү барих уу?**

Гүү барина аа. Гэхдээ сүүлийн үед нэг их барихаа байсан.

- **Гүүгээ барихдаа ямар өдөр харж барих уу?**

Бас л нохой өдрийг ивээл өдөр гэж харна.

- **Гүүн зэлээ татахдаа ямар нэг зан үйл хийдэг үү?**

Гүүн зэлээ татаад арцаар л утдаг.

- **Ууган унагаа түрүүлж барьдаг гэсэн тийм зүйл бий юу?**

Тийм. Ууган унагаа эхэлж бариад зэлний хамгийн эхэнд уядаг. Хадаг зүүдэг.

- **Хурга ишгээ имнэхдээ ер нь өдөр судар хардаг юм уу?**

Харна. Хөнгөлөхдөө бас харна. Зуны эхэн сард гайгүй өдөр харж байгаад имнэнэ.

- **Өдрөө юунаас харах уу?**

Тэрбиш гуайн календараас хардаг.

- **Ус ноос авах, ямаагаа самнахдаа бас өдөр судар харж байна уу?**

Ямаагаа самнах, хонио ноослохдоо ч бас харна. Адууны дэлийг хавар, намар засна.

- **Монголоо алдах гэж хүмүүс ярьдаг шүү дээ, тэрнийг та юу гэж ойлгодог вэ?**

Ёс жудаггүй, ёсоо алдсан тийм улсуудыг л хэлэх байх.

- **Жишээ нь ямар үйлдэл гаргавал жудаггүй байна гэж та харах уу?**

Нэг нэгэнтэйгээ жаахан эв муутай байх. Монголчууд эвтэй байхдаа хүчтэй гэж ярьдаг шүү дээ.

- **Хүний мөс сайтай хүн гэж бас хэлдэг. Тэр нь таны бодлоор ямар хүнийг хэлэх вэ?**

Хүний мөс гэж хүнтэй сайхан харьцдаг хүнийг л хэлэх байх. Ядарсан бас нэг нэгэндээ тустай тийм улсуудыг хэлнэ.

- **Одоо энэ ойр хавийн айлууд нэг нэгэндээ туслах нь хэр вэ?**

Одоо ер нь тийм юм нэг их байхаа байсан. Дор бүрдээ л хувь хувьдаа өөр өөрсдийнхөө л ажлыг хийж байна.

- **Монголчууд юмыг дандаа нар зөв хийдэг дээ. Тэрнийг яагаад тэгж хийдэг юм бол?**

Тэрлэг дээл, зулын гол ороох гээд л олон юмыг нар зөв хийдэг. Гэрийн бүслүүр татахдаа бас нар зөв тойруулна. Цаанаасаа утга учиртай л байдаг байх.

3. Баянхонгор аймаг, Баянговь сум, Залаа баг, С.Энхамгалан 39 настай

- **Танайх ер нь хаагуур хаагуур нүүдэллэж байна вэ?**

Манайх энэ хавиараа хойшоо урагшаа 20 гаран км нүүдэллэж байна даа.

- **Жилд хэд нүүх үү?**

Идэш тоосоо бараадаад л, сумын хаана ногоо гарч байна тийшээ л нүүнэ. Цаг сайхан байгаад байвал зуслан, өвөлжөө, хаваржаа, дээрээ бууна. Зуслан дээрээ намаржчихдаг. Энэ бэлд нэг өвөлжөө бий. Энэ цахирт бас 2,3-н өвөлжөө бий. Өвөлжөө нь Цагаан толгой, Хулангийн хөв, Цармын ягаан. Зуслан байгаа газар Хорголжийн Бор Нуруу.

Хаваржаа нь Хулангийн хөв, Цагаан толгой.

- **Айлууд нь хоорондоо ийм зайтай байгаа нь цөөхөн айлтайд байна уу? эсвэл өөр онцлог байна уу?**

Нутаг усны онцлог байна л даа. Ойр ойрхон өвөлжөө, зуслантай айлууд өчнөөн байгаа. Нэг хошуу тойроод л байгаа.

- **Өвөлжөө, хаваржааны бууц ямар байх ёстой юм бол оо? Ямар газрыг өвөлжөөгөөр сонгоод байна вэ? Танд 3 өвөлжөө байгаа, ямар онцлогтой юм бэ?**

Өвөл мал бэлчихэд дулаан бэлчээртэй, хадтай, салхи бага ордог, шороо тоос бага босдог тийм л газар өвөлжөөлнө. За тэгээд хавар нь бас нэг жаахан уужимхан тайван талдуу газар сонгоно. Өвөлжөө хаваржаа гэдэг чинь бэлчээрийнхээ онцлогоор л байгаа юм. Өвөл хавар хоёр л их нөмөр бараадна. Тэгээд зун, намар бас гайгүй.

- **Танд өвөлжөө хаваржааны газар өв уламжлагдаж ирэв үү? эсвэл та өөрөө сонгов уу?**

Нэг нь өв уламжлагдаж ирсэн. Бусад нь бид хоёр айл гэр болсноос хойш сонгож барьж худалдаж авсан. Хуучин өвөлжөө байсан газрууд. Хулангийн хөв гэдэг газар шинэ өвөлжөө хийчихээд байгаа.

- **Тэгэхээр та шинэ газар бууц хийхдээ шав тавих ч юм уу, тийм зан үйлийн юм хийж байсан уу?**

Өө тэгээд л ган болоод явж байгаад л тэндээ буугаад яваандаа хашаа саравч барьсан. Одоо ч хөдөө тохижуулаад суурин газраас ялгаагүй сайхан болсон. Утас, шөрмөс хөгжлөө.

- **Нүүхдээ танайх өдөр харж нүүдэг үү?**

Өө тэгэлгүй яахав.

- **Ямар өдөр нүүдэггүй юм бэ?**

Календарь харж байгаад л сайн гэсэн өдөр л нүүнэ. Бар өдөр хөдлөхгүй. Гайгүй төлөв хонь, морь өдөр л нүүнэ дээ. Могой өдрийг бол цээрлэнэ. Могой ер нь олон нүүдэл хийдэг учраас сунжраад явчихна гээд цээрлэнэ. Манайх бол могой өдөр, 2 дахь хагас сайныг цээрлэнэ. Бусад нь бол гайгүй дээ.

- **Шинэ газар буулаа гэхэд ямар нэгэн зан үйл хийх үү?**

Байна шүү. Шинэ газар буухдаа, арц хомоолоор ч юм уу утна. Ядахнаа мал тогтвортой хэвтдэг байхгүй юу.

- **2 дахь, хагас сайн өдрийг ер нь яагаад цээрлээд байгаа юм бол?**

Ерөнхийдөө 2 дахь өдрийн аян зам бас нүүдэл суудал хийхэд тааруухан гэдэг. Хагас сайн өдөр болохоор миний час өдөр байдаг.

- **Нүүхдээ ер нь хэзээ нүүх вэ?**

Өглөө эрт сэрүүнд нүүж эрт амжуулахыг бодно.

- **Танайх мал хөнгөлөх, имнэх, самнах янз бүрийн малтай холбоотой зүйл хийхдээ өдөр хардаг уу?**

Харалгүй яахав. Тэр чинь л жинхэнэ харна шүү дээ хө. Ямаа самнахыг бол үс ноос хяргахад сайн өдөр хардаг. Имнэхдээ мал имнэх өдөр харна. Хөнгөлөхдөө бол нохой, туулай зэрэг хөнгөн өдөр хөнгөлчихдөг. Хөнгөлөхөд тэр засаагаа гадагшаа гаргахгүй л дээ. Мал хөнгөлөхөд 3 хоног даллага авсан мэт байдаг. Малын буян хишиг байна гэж үзээд гэрээс гаргахгүй. Тэр битгий хэл барахгүй байвал баруун хатавчиндаа булдаг гэж ярьдаг. Ерөөсөө гэрээс гаргахгүй малын буян хишиг алга болдог гэдэг. Тогоо шанаганыхаа угаадсыг хүртэл нохойд өгдөггүй. Илүү гарсан юмнуудаа заавал булдаг. Малын засаа гэдэг чинь тийм л нандин зүйл байдаг. Хүн ирээд идэхэд бол зүгээр.

- **Өөр малын буян хишиг доройтно гэж цээрлэх зүйл бий юу?**

Гүү барихад бар өдөр. Адуу мал барьж уяхад цагаан луу, цагаан бар, цагаан туулай өдөр барьдаг.

- **Морь уяж байхад юуг цээрлэх үү?**

Уяан дээрээ гадны хүн очуулахгүй, эмэгтэй хүн шонгийн эхэн дээр алхуулахгүй, бие засуулахгүй, малын амийг уяач нь тасддаггүй. Морь уяж байгаа тохиолдолд амьтны амь тасдаад байдаггүй. Өөрөө сайн сайхныг бодож цагаан зам татуулж уралдаж байгаа учир улай үзэхгүй. 5 дахь өдөр малын хишиг өдөр. 5 дахь өдөр гадагш мал гаргахгүй, зарахгүй. 5 дахь өдөр хүнс ч гаргахгүй. Хүн ирэхээр бол идээ будаа, хүнс хоолоо урьд орой нь гаргаад тавьчихаар болдог. Зөвхөн малын л юмыг тэгж цээрлэдэг.

- **Гүүн зэл татахдаа яах вэ?**

Идээ будаагаа засаад л ойр орчмын хүмүүсээ дуудна. Сайн цагтаа гадсаа хатгаад зэлээ татна. Тэр өдрийн сайн цагийг харна. Тэгээд ууган унагаа бариад зэлээ ариулна. Шон зоохдоо сүү дусааж газраа аргадна. Хэцээ тогтоогоод будаа хийнэ. Ууган унагаа бариад мялаана.

- **Ууган унагаа барьдаг нь ямар учиртай юм бол?**

Мал хөнгөлсөн ч ууган хурга ишигнээсээ эхлээд л ууган мал гэдэг утгаараа хүндэлж байгаа юм. Ууган унаганыхаа толгой, хөндлөйг нь сүүгээр мялаана. Наашаа 8 сар гаргаад л хүүхэд цуглахаас хэд хоногийн өмнө л унагаа татна даа. Унага сайхан махалсан үед л унагаа уяна.

- **Малаа зарж үрэх болохоор яаж буян хишгийг нь авч үлдэх үү?**

Дэл, сүүл, ноос, үснээс нь авч үлддэг. Ямааны үс, ноолуурнаас нь авна. Тэмээний зогдорноос нь авна. Тэрийгээ аваад тоононыхоо чагтганд хийгээд хадгалчихдаг.

Ер нь ууган малд хишиг буян байдаг гэсэн үг үү?

Тийм ууган малдаа байна.

- **Нийт малын алинд нь тэр хишиг буян байх уу?**

Эцэг малдаа л байна, гэрийн эзнээс ялгаа байх уу.

- **Танайх хишиг буянаа тогтооно гэж янз бүрийн зан үйл хийдэг үү?**

Даллага авхуулах, лам авчрах зэрэг юм байна.

- **Даллаганыхаа уутандаа юу хийх үү?**

Арц, тариа, будаа л байдаг. Жилдээ нэг удаа лам авчраад галаа тахиулж, даллага авхуулж, ном уншуулдаг. Бүгдийг нь нэг дор хийлгэчихдэг.

- **Малдаа зориулж ном уншуулдаг уу?**

Малын банзрагч уншуулдаг.

- **Галаа яаж тахиулах уу?**

Галдаа халбага дүүрэн шар тос, бөөрний өөх хийдэг. Ерөнхийдөө малаас гардаг түүхий эдээр буюу малынхаа буянаар хийдэг.

- **Галаа ингэж хүндэлж байгаа нь ямар учиртай юм бол?**

Тэр айлын гол ноён нуруу галд байгаа учир галыг их ариун байлгах учиртай. Тэр утгаар л байдаг байх.

- **Танайд буян хишиг доройтно гэж цээрлэх зүйл бий юу?**

Одод түгсэн хойно хүнс мал гаргахгүй. Од гарсан байхад амьтны амь бүрэлгээд яахав гээд л яарна.

- **Монголчууд яагаад адууг бусад малаас илүү дээдэлдэг юм бол оо?**

Халуун хошуутай мал бас төрийн сүлдэндээ залсан болохоор хамгийн дээд гэж үздэг юм шиг байна лээ. Мөн эр хүний унаа хийморьтой амьтан.

- **Хийморь гэж таны бодлоо юу вэ?**

Монголчууд олон дайн байлдаанд адуутай учраас ялж байсан. Тэр утгаараа төрийнхөө сүлдэндээ залчихсан байгаа болохоор дээдэлдэг байх. Тийм учраас бэлгэдэж дээш нь залдаг байх.

- **Монголчууд юмыг дандаа нар зав хийдэг шүү дээ. Тэр ямар утга учиртай юм бол?**

Ямар ч юман дээр эсрэг загнах гэж байгаа юм шиг буруу хийхгүй байх л даа. 4-н эргүүлгийг татахад хүртэл нар зөв татдаг шүү дээ.

- **Нар зөв хийдэг юмнууд юу юу байна вэ?**

Морь үсэргээд ирсэн ч нар зөв тойруулна. Айлын гадаа гэхэд л нар зөв тойроод бууна. Юмыг нар зөв хийнэ гэдэг чинь цаанаа зөв, сайн сайхныг л бэлгэдэж байгаа юм.

- **Тэгвэл Монголоо алдах гэдгийг та юу гэж ойлгодог вэ?**

Морь мордохдоо буруу талаас нь мордох гэх мэт түрүүний нар буруу хийж байга юмыг хэлэх байх даа. Эсрэг зүйлийг л хэлэх байх даа. Монгол ёс заншлаа мартаж гажуудаж байгаа зүйлийг л хэлэх байх даа.

- **Хүн чанартай, хүний мөс сайтай хүн гэж ямар хүнийг хэлэх вэ?**

Ядар явж байгаа хүнд тус болдог, сайхан санаатай, ямар ч зүйл дээр хүн чанартай л хүнийг хэлэх байх. Хүн хулхиддаггүй, хүнээс юм авчихаад цаашаа зугтаадаггүй хүнийг л хэлэх байх даа.

- **Хөдөөний улсууд бие биедээ туслах нь хэр их байдаг вэ?**

Одоо ховор болсон шүү дээ. Найз нөхөд ах дүү садан л гэхгүй бол гэр барьж байхад ирж туслахгүй шүү. Залуучууд бол ажилгүй болсон. Хүн чанар гэдэг чинь тэр шүү дээ. Одооны хүүхдүүд залхуу болсон. Өөрөө л болж байвал өрөөл хамаагүй болсон. Хүнд туслая гэсэн сэтгэлтэй улсууд цөөхөн болсон. Мал чинь тэнд, энд байна гэж хэлэх тийм зүйл бол байдаг.

- **Бэлчээрээс болоод наашаа маргаан хэр гардаг юм бол?**

Танай мал манай бэлчээр лүү орж ирлээ ч гэдэг юм уу тиймэрхүү хэрүүл гардаг. Малын тоо толгой олдсоноос болж байна. Мал олон болсон учраас гарц муу болж байна.

- **Отрын мал хэр зэрэг наашаа орж ирэх үү?**

Ойрхон сумаас орж ирнэ. Зуны цагт бол гайгүй, өвлийн цагт өвөлжөө бууц гээд л асуудал үүснэ. Бас нэг боломжийн өвөлжөөтэй хүн байвал өвөлжөөгөө түрээслэх юм байна. Түрээсэлж байгаа айлынх нь ойр хавийн айлууд дургүйцдэг. Манайх бас нүүж сууж хөөгдөж зовлон үзэж байлаа.

- **Та нүүдлийн соёлоос салгаж болохгүй юмыг юу гэж боддог вэ?**

Салгаж болохгүй зүйл нь одоо хүн чанар л юм болов уу даа. Монголчууд дээр үеэсээ нэгнийгээ нүүгээд явж байхад аяга халуун цай, тавгийн юм дөхүүлээд өгдөг байсан. Тэр заншил бас байна лээ шүү. Ноднин бид нар энэ хойд ууланд нүүгээд явж байхад нэг хөгшин эмээ нэг хлуун савтай цай, тортой юм барьчихсан хазганаад хүрээд ирж байгаа юм. Тэр чинь одоо настай хүмүүст л үлдсэн байна. Залуучууд бол хажуугаар гараад л давхиад байна. Тэгэхээр тийм уламжлал бараг мөхөж байгаа юм шиг байна лээ.

- **Мал маллахын хамгийн сайхан зүйл юу вэ?**

Тааваараа цаг сайхан байвал малынхаа хоол нь бэлэн, ашиг шимийг нь хүртээд л сууж байх юм даа. Мал хариулж байгаа хүн ган зуд болохгүй л бол асуудалгүй. Цаг нь л сайхан байвал таван малынхаа буянд өмсөхөө өмсөнө, эдлэхээ эдэлчихнэ. Манайх таван хүүхэдтэй. Улмжлалаа дагаад нэг хоёрыг нь малчин болгоно гэж бодож байна. Бусдыг нь бол бас олонтой нийлүүлж сургууль соёлд явуулна. Бүгдээрээ сумын төвийнх болчихвол хэдэн хүүхдийнхээ хоолыг бэлдээд л сууж байх байлгүй дээ.

4. Баянхонгор аймгийн Баянговь сум, 5-р баг Сангидорж, 73 настай

- **Та Монгол хүний хамгийн эрхэм зүйлийг юу гэж боддог вэ?**

Отор нүүдэл. Дээр үеийн улсууд чинь тэмээгээр нүүдэг байсан. Одоогийн улсууд машинаар нүүдэг болж. Бид нар хар бага наснаас тэмээгээр унаж байсан.

- **Та хэр их отор нүүдэл хийдэг байв?**

Би тэмээ хариулж байсан. Ийш тийшээ их олон явж байсан даа.

- **Жилдээ хэдэн удаа отор хийх үү?**

Жилд ер нь хавар тэмээгээ тууж гараад намар орж ирдэг байсан. Тэгээд ингээ саагаад л явдаг байсан.

- **Отроор хаашаа явах уу, явах газраа хэрхэн сонгох вэ?**

Хойшоо явна. 50-60 км явна. Нэгдлийн тэмээ хариулж байсан.

- **Та хувьчлал гарсны дараа ямар мал хариулж байсан бэ?**

Хувьчлал гараад л нэг наст мал хариулж байсан. 1990 онд сумын сайн малчин болсон.

- **Танайх хаагуур хаагуур нүүдэг вэ? Танай бэлчээрийн онцлог юу вэ?**

Манайх одоо бол энэ хавьдаа байна. Залуу байхад энэ уулын хойд үзүүр, ар луу тойроод л явдаг байлаа. Тэгэхэд хүүхдүүд ч өсөөгүй бага байсан. Тэмээгээ хариулаад л явдаг байсан.

- **Одоо тэмээтэй юу?**

Байгаа. Тэмээ, адуу, хонь, ямаа бий. Отор нүүдэл хийдэг байсан гэж байна.

- **Яагаад ингэж их хийдэг байсан юм бол?**

Нэгдлийнхээ хэдэн малыг таргалуулах гээд тэмээг ерөөсөө хонь шиг дагаад өдөр усалж явуулаад орой хураагаад л, тогтохгүй бол шөнөжингөө хураана шүү дээ. 3 шөнө хураагаад л явахаа байчихдаг юм.

- **Ер нь нэгдлийн мал хариулдаг байхад отроор их явдаг байгаад хувьдаа мал хариулах болсноос хойш багассан юм уу?**

Одоо бодоод байхад тэмээ хариулсан хүн отроор их явдаг байжээ. Бог мал бол тэгж их явахгүй. Дээр үеийнх шиг тэгш хол отроор явдаг юм байхгүй.

- **Та яагаад отроор явах нь багассан гэж бодож байна?**

Дээр үеийн дарга нар сүрхий ч байсан юм уу даа. Мал таргалахгүй байна гэж дандаа ярьдаг байсан. Ер нь 7 хоноод л давхиад ирнэ. Мал яаж байна, юу дутаж байна, юу хэрэгтэй байна гээд л. Нэг цас ороод л шуурга шуурвал өвс ачаад хүрээд ирнэ. Одоо бол тийм юм байхгүй шүү дээ. Дээр үед тийм л гоё байсан юм даа.

- **Танайх нүүж буухдаа янз бүрийн зан үйл хийдэг үү? Өдөр судар хардаг уу?**

Өө харна. Дээр үед мэддэггүй байсан. Одоо бол хардаг. Одоо дашням, балжиннямтай өдөр нүүгээд байна.

- **Ямар өдөр нүүхгүй вэ?**

2 дахь, хагас сайн, бүтэн сайныг цээрлээд байдаг юм.

- **Яагаад?**

Дээр үеийн лам нар, бас ээжийн сургааль. Хагас, бүтэн сайн өдөр мал хүнд өгөхгүй 2 дахь өдөр мал гаргахгүй гээд л тэрүүгээр явдаг. 2 дахь өдөр бол ерөөсөө мал гаргадаггүй байсан. Шинийн 15, 25 нд мал гаргахгүй.

- **Ингэж цээрлээд байгаа нь цаанаа ямар учиртай байна?**

Буруу өдөр мал хүнд өгвөл мал нь цаанаа очоод үхэж үрэгдэх юм уу ямар нэгэн юм болдог гэж байгаа юм. Мал хуй урууддаг бас тийм тал байна. Сайн өдөр хүнд мал өгвөл мал нь өлзийтэй явдаг. Хагас сайн, бүтэн сайныг бол хүн болгон цээрлэдэг юм даа.

- **Өөр гүү барих, унага тамгалах, хурга ишиг хөнгөлөх зэрэгтээ өдөр судар хардаг уу?**

Харна. Гүүгээ нохой өдөр бариад бар өдөр тавьдаг байсан.

- **Бар өдөр барих нь яадаг юм бол?**

Хамгийн хүчтэй, хамгийн сайн гээд л. Нохой өдөр нь мал нохойд ордоггүй. Хурга ишгээ туулай өдөр хөнгөхөн өдөр гээд хөнгөлнө.

- **Хурга ишгээ хөнгөлөхдөө янз бүрийн цээрлэдэг зүйлүүд байдаг уу?**

Өө байлгүй яахав. Хамаагүй хутгаар авахгүй. Будаа тариа, арц хүж гээд бүгдийг нь тавина. Тэгээд нэг эсгий дэвсэж байгаад авна. Тэгээд тохсон юмаа босгон доороо 3 хонуулаад авдаг заншилтай. Хутгаа тэр дор нь угааж цэвэрлэхгүй бол соёгдоно. Соёгдоно гэдэг нь цус гоожоод хүндрэхийг хэлж байгаа юм. Арц хүжээрээ хутгаа ариулна. Авсан төмсөө дор нь чанаад гэрээс гаргахгүй иднэ. Гаднаас ирж хүн идэж болно. Гадагш нь бол гаргахгүй.

- **Өөр тэр үедээ цээрлэдэг юм байдаг уу?**

Байлгүй яахав. Зөндөө байгаа. 2 дахь, хагас сайн, бүтэн сайн өдөр мал хөнгөлөхгүй. Гэрээс ч юм гаргахгүй.

- **Та гүүгээ барихдаа өдөр хардаг байсан гэсэн дээ?**

Өө тийм. Лам авчраад ном уншуулна. Идээ цагаа засаад гүүгээ саагаад, лам ном уншина.

- **Түүрүн та мал доройтдог гэсэн шүү дээ. Тэгэхээр доройтохоос нь сэргийлж юу хийх үү?**

Ламдана. Ном уншуулна. Малын банзрагч уншуулна. Таван хошуу малын даллага авхуулах сайн шүү. Ямар нэг өвчин зовлон гарахгүй. Даллага авхуулах чинь дээр үеийн л уламжлалтай. Даллага авхуулахаар 3 хоног юм гаргахгүй.

- **Малын буян хишиг гэж юу вэ? Юундаа байдаг юм бол?**

Малын буян хишиг чинь мал болгондоо байхгүй. Ганцхан малд байдаг юм билээ. Тэр буян хишигтэй малыг буруу өдөр мэдэхгүй хүнд бариад өгчихвөл мал урууддаг. 5 хошуу малд тавууланд нь бий. Тэр малаа авч үлдэхийн тулд сэтэрлээд л тавьчихна. Тэр малаа ялгахын тулд ламаар мэргэлүүлнэ. Танайд тийм зүсмийн мал байна гэж хэлнэ. Тэр дээр үеийн заншил. Тэр малыг тэгээд сэтэрлэсэн байхад малд чоно орно гэж байхгүй шүү.

- **Одоо та тэгж сэтэрлэсэн байгаа юу?**

Байлгүй яхав.

- **Таныг хүүхэд байхаас чинь Монгол хүн гэж ийм хүн байдаг гэж захиж хэлж байсан зүйл бий юу?**

Дээр үед зарим дээр үеийн настай хүн бс лам нар хэлдэг байсан. Ах хүний дээгүүр гардаггүй юм, ах хүнийг хүндэлж яв гэдэг байсан. Тэр хөгшин улсуудыг хараад бид нар ухаан алдчихна. Дээр үеийн улсууд жинхэнэ малчин ч улсууд байсан тэрний хүчин л хүмүүжсэн.

- **Та олон жил мал маллж байна. Мал маллахын яг юу нь сайхан байдаг юм бол оо? Та яагаад төв бараадахгүй байна вэ?**

Мал шиг сайхан юм байхгүй. Мал харсан газар элбэг дэлбэг.

- **Нөгөө талаар мал маллахад халширмаар зүйл бий юу?**

Өвлийн хүйтэнд даарч хөрнө. Дээр үед одоогийх шиг сайхан хувцас байдаггүй байлаа. Нэг муу уранхай цагаан дээлтэй. Тэмээний ширээр хийсэн гуталтай тийм л өссөн.

- **Монголоо алдах гэдгийг та юу гэж ойлгодог вэ? Ямар хүнийг монголоо алдсан гэх үү?**

Буруу л гэж бодож байна.

- **Хүний мөс сайтай хүн гэж таныхаар ямар хүнийг хэлэх вэ?**

Хүнд тусгүй хүнийг л хүн чанаргүй гэж ойлгоно. Тийм хүн байдаг шүү дээ. Нүүж суухад ачаа малд туслах хүн ч зөндөө байдаг.

- **Хөдөөний хүмүүс бие биедээ туслах нь хэр их байдаг вэ?**

Өвөлжөө бууцаа засах, нааш цаашаа явах зэрэгт хөдөөний улсууд тусална шүү.

- **Та морь уядаг уу?**

Олон айраг түрүү авсан. Аймгийн алдарт уяач.

- **Адууг ер яагаад Монголчууд бусад малаас илүү дээдэлдэг юм бол оо?**

Адуу чинь их сэргэлэн амьтан. Адуу шиг хүчтэй хийморьлог амьтан хаа байх уу.

- **Хийморь гэдэг нь юу юм бол?**

Адууны цаанаасаа сэргэлэн байгааг л хэлэх байх даа.

- **Монголчууд дандаа юмыг нар зөв хийдэг шүү дээ. Тэрийг яагаад тэгж хийдэг юм бол?**

Тэр чинь зөв шүү дээ. Ямарваа нэг юмыг нар зөв хийнэ. Ерөөсөө дээр үеэсээ бүх юмыг нар зөв хийдэг байсан. Нар буруу эргэж болохгүй гэдэг байсан. Ямар нэгэн гай таарах болов уу гэж би дотроо боддог юм.

Арьяа, Шилүүстэй, Завхан аймаг

Таны нэр хэн билээ?

Арьяа.

Та хэдэн онд төрсөн бэ?

1940 он.

Хаана төрсөн бэ?

Энэ нутагтаа. Өндөр Цохио.

Та сургууль, цэрэгт явж байсан талаараа ярьж өгөөч?

Би бага наснаасаа эцэг эхийн гар дээр байж, Шилүүстэй сумын бага сургуульд суугаад, сургуулийн дөрөвдүгээр ангийн боловсролтой байж байгаад 1962 онд цэргийн албанд татагдаад цэрэгт яваад Улаанбаатар хотод 032-р ангид хүндэс харуул байсан. Гурван жил. 1965 онд цэргээс халагдаад шууд цагдан сэргийлхийн эргүүлд ажилд орсон.

Нутагтаа хэзээ буцаж ирсэн бэ

1968 онд ирсэн байхаа. Аавын бие муудаад ар гэрийн гачигдлаар нутагтаа буцаж ирсэн. Ирснээсээ хойш хэдэн жил мал маллаад, тэгээд сумын нэгдэлд мал маллаж байгаад 1973 онд авто сургуульд яваад тэнд жолооч болоод, тэндээсээ жолоогоо төгсөөд Шилүүстэй сумандаа буцаж ирсэн.

Жолоогоо хаана сурсан бэ

Улаанбаатар хотод. Ерөөсөө хотод л ганц сургууль байсан юм. Сангжав захиралтай.

Жолоочоор төгсөөд нутагтаа ирээд та жолоочоол ажилласан юм уу?

Энд ирээд нэгдлийн даргийн жолооч байсан.

Хажуугаар нь та нэгдлийн мал малладаг байсан уу?

Маллалгүй яахав, жолооч хийхийн хажуугаар малтай. 50 толгой малтай байдаг байсаншд тэр үед нэгдлийн гишүүн. Тэр багцааны. Нэгдлийн адуу хариулж байлаа, хонь хариулж байлаа, үхэр хариулж байлаа тэрүүхэн хугацаанд. Тэгээд нэгдлийн даргийн жолооч байж байгаад Худалдаа бэлтгэлийн ангид Авто мухлагийн жолооч болсон. Автомухлагийн жолоочоор 15 жил ажилласан. Дараа нь 1990 оноос ардчилал, зах зээл эхлээд, мал аваад гарч байсан.

Хэчнээн мал авч байсан юм бол?

50 хонь түрээсээр авч байсан. Тэр хонио хариулаад эргүүлж өгдөг. 1990 оноос хөдөө гараад, үндсэндээ өдий хүртэл мал маллаж байна. Би зургаан хүүхэдтэй. Мал маллаж байгаа нь 2, 3 нь байна уу даа. Манай мал хүргэнийд байдаг юм. Тангадын бараан гэдэг газар тэндээ өвөлжөөтэй. Хаваржаа нь өвөлжөөнөөсөө жаахан доошлоод. Хангайруугаа 100-аад км нүүнэ. Өвөлжөөнөөс хаваржааруу 10 гаруй км. Зуслан нь Өргөн ширэг, Өвөр гол. Манай сум чинь говь хангай хосолсон тогтоцтой.

Жилдээ хэд нүүж байна вэ?

Түр буудаг газруудтайгаа 20 орчим нүүнэ.

Ингэж олон нүүж байгаагийн шалтгаан юу байдаг юм бол?

Нутаг. Малаа таргалуулах.

Малаас ямар ашиг шим хүртдэг юм бол?

Сүү цагаа, арьс шир, бүгдийг л ашигладаг. Сүүлийн үед малын арьс шир, малаас гарч байгаа юм үнэгүй болчихоод манай амьдралд нилээн дутагдалтай байна. Одоо энэ хогийн хонхороос дүүрэн арьс. Үнэ байхгүй, үнэгүй болчихоод.

Мал маллах арга ухаан социализмын үед мал маллаж байснаас өөрчлөгдсөн үү?

Өөр юу байхав. Мал хувийн өмч л болсон. Хувийн өмч гэдэг чинь асар их нөлөөтэй. 1990 оноос хойш мал дээр гараад энэ сум хоёр гурван жил тэргүүлж мал тоолуулж байсан. Малаа өсгөөд. Сүүлд нь олон намын ялгаа их болоод амжилт бодоод явж байсан чинь нэг нам солигдоход нөгөө амжилт нь буурах үндэс болоод явчихдаг. Нэг намынхаа хийсэн юмыг хийдэггүй, бас нэг өөр юм баримтлаад. Дандаа тийм юм болж байна. Ард түмнийг маш их хохироож байна. Өөрийнхөө намыг дээш. Бодлого нэг л байх хэрэгтэй. Урд талынхаа хийж байсныг муу буруу юм байвал орхино биз, цааш нь үргэлжлүүлэх хэрэгтэй. Ерөөсөө энэ намын ялгаа ард түмнийг гутааж байгаа.

Тэгэхээр намын ялгаа нь мал маллахад нөлөөлж байна гэсэн үг үү?

Нөлөөлж байна. Сум орны ажилд ч дээр, дооргүй нөлөөлж байна. Сумын дарга нь энэ манай намынх, хөдөлмөрчид нь энэ манай намынх гээд хоорондоо хорсоод л байгаа. Тэр бол ард түмнийг зутрааж байна. Урд хүмүүсийнхээ хийж байсныг үргэлжлүүлбэл хөгжих байх. Хамгийн халуун талд халуунд халж хүйтэнд хөрч үдэш алгасахгүй таван малынхаа дэргэд гадаа хэвтэж байгаа муусайн малчиддаа 300,000 цаасны тэтгэвэр өгчихөөд өөрсдөө хэдэн тэрбумаар нь иддэг. Ямар хөдөлмөрөөр тэрбумыг авсан юм. Малчид ерөөсөө хүн биш. Тахианы мах ямар үнэтэй вэ. Тахиа, хонь, үхэр ямар ялгаатай вэ. Монгол хүн тахиа идэж өсөөгүй, махаа идэж өссөн. Гахай тахианы мах хорь гучин мянга гарахаар авч идчихээд, хонины мах өсөхөөр үнэтэй байна гээд юм хэлээд байдаг.

Махаа хэрхэн яаж зардаг юм бэ?

Чэнжүүдэд л өгдөг. Эндээс малыг аваачаад эмээлтэд нядалдаг гэнэ, дэлчилдэг гэнэ. Тэнд хятадад аваачаад өгчихдөг. Тэр ямар олиг байх вэ. Монгол хүн малаа тэгэж нядалдаггүй, даанч харамсалтай, тэнд адууг яаж алж байна. Монгол хүн морио магтаж явдаг, гэтэл тэнд адууг гайхалтай муухайгаар алдаг юм гэнэ гэж яриад байна. Ачаад байна, ачаад байна.

Сүүлийн хэдэн жил байгаль байсан бэ?

Өнгөрсөн жил манай энд зундаа гантай байсан. Намар жаахан бороо орж, газар дэлгэрч мал жаахан таргалсан. Өвөл гайгүй, энэ жил онцгой гоё өвөл боллоо. Хавар ч гайгүй.

Баянхонгорын ган болсныг бодоход манай энд арай дээр. Хавийн хүн манай энүүгээр шавчихсан.

Оторлож ирсэн болон энэ нутгийн иргэдийн хооронд маргаан гарсан тохиолдол бий юу?

Хэрэлдээд л байсан. Арай л нэгнийгээ алж хядчихгүй юм. Ер нь бол нутгийнхан дургүй, өөрснөө багтахгүй байхад, өөрснөө мал нь газартаа багтахгүй байхад гаднаас олон юм ороод ирэхээр. Мал олон, бэлчээр хүрэлцэхгүй. Мянга хүрэхгүй малтай айл цөөхөн байна.

Айлууд малаа ингэж олон болгоод байгаа нь ямар шалтгаантай вэ?

Амьдрал. Мянган малын түшиг гэдэг чинь асар их. Мал олон байж ашиг арвин гарна. Малыг чанар, үүлдэр угсааг сайжруулбал малын тоо цөөн байж болохоор байна. Малчид аминдаа л малаа чанаржуулаад байгаа. 30 литр гардаг үнээ Хэнтийд ороод ирчихсэн ажиллаж байна. Тэрнээс ганц үнээ манай хорь гучин үнээнээс гарч байгаатай адил ашиг авах гээд байна. Тэрийг аваад ирвэл мань мэтэд маш их хэрэгтэй байна. Гэтэл авдаг мөнгө алга, аваад ирэх чадал алга. Бэлчээрийн ая даадаг зохицсон мал байх хэрэгтэй. Одоо тэгээд бензинээ нэмээд байдаг, нэмээд байдаг, бид чинь 350 мянган тэтгэвэр авахад юмны үнэ өдөртөө л өсөөд байх юм.

Та туувар хийж байсан уу?

1960-аад онд Хятадруу адуу туусан. Эндээс гараад Эрээнээс цааш, Дорноговийн Улаан-уул сумаас вагонд суугаад буцаж байсан юм. Эндээс 7 сард аваад намар 11 сард очиж байсан. Есүүлээ явсан, нэг хүн 50 адууны нормтой, нэгдлийн агт туусан.

Одоо мал маллах, нэгдлийн үед мал маллах хоёрын аль нь илүү дээр байсан гэж та бодож байна?

Одооных нь төр нээг их зохион байгуулаад сайхан болж байгаа юм алга. Хувийн аж ахуйтай болохоор малчид чадлынхаа хэрээр зөв зохион байгуулж байна. Хүн зөв заавал зөвдөнө, буруу заавал буруудана.

Мэндлэхдээ хэлдэг ямар үг хэллэг хэлдэг вэ?

Дөрвөн улирлынхаа онцлогоор. Хавар бол тарган сайхан хаваржиж байна уу, тарган сайхан өвөлжиж байна уу, гэх жишээтэй мэндэлдэг юм. Сүргийн тараг сайн авч байна уу гээд онцлогоос шалтгаалж.

Эсгий хийх ч юм уу, зарим үйлийн үед мэндчилгээ өөр байх уу?

Яахав, ерөөл л хэлнэ дээ. Яснаас хатуу цаснаас цагаан бол гэдэг. Магтаал ерөөлийн үгнүүд. Хонь хяргаж байгаа айлд очвол хайч хурц бол гэх жишээтэй. Ямаа ноослож байвал ноолуур арвин болог гэж.

Гэрлэх ёсны талаар ярьж өгөөч, ямар ёс заншлаар, ямар үг хэллэг хэлдэг вэ?

Яахав, урьд өмнөх ёсоо баримтлаад л. Урьд бол оргуулаад аваад явчихдаг байсан, одоо бол ярьж хөөрөөд тохироод хадаг самбайгаа хүргэж өгөөд. Урьдаар нэг хүн ирээд танай

охиныг тэдэн сарын тэдэнд гуйж хадаг самбай өгнө шүү гэж цаг өдрөө товлоод тэгээд авж өгдөг.

Авгайлан ёсны талаар?

Газар газар янз янз л даа. Энд ааваа ээжээ, ахаа эгчээ гэж дуудна. Багшид шавь орсон хүн бол багшийнхаа нэрийг хэлхийг цээрлэдэг.

Танай сум ямаагаа самнасан уу?

Самнаагүй, одоо эхлэж л байна. Улирлын байдлаас шалтгаалаад цаг агаар сайхан дулаахан, мал идээ тарган орсон тийм үед арай эрт самнана. Нэгдлийн үед бол 3 сарын 15 гээд албан хүчээр самнаж байсан юм. Одоо бол аль өндөр үнэтэй чэнжид л ноолуураа өгнө.

Ченжүүд ноолуурын чанарт үнэлгээ хийдэг үү?

Хийлгүй яахав, танай ноолуур шороотой байна, хялгастай байна гээд аль болох л доош нь чихэх үг хэлээд байдаг.

Танай нутагт тахилгатай уул овоо бий юу?

Байна. Мянган хайрхан гэж байна. Тэнд манай нэг хувилгаан хүнийг нутаглуулсан. Тэрийг байнга тахиж байна, бас төрсөн газрыг нь тахидаг. Манай нутаг хутагт хувилгаадын өлгий нутаг гэж явдаг.

Та барилддаг байсан гэсэн, тэр талаараа?

Аа барилдана. Улсад ганц хоёр гарч байсан.

Хэдэн онд барилдсан юм бэ?

Би цэрэгт байх хугацаандаа гурван жил гарсан. Нэгийн даваанд гараад унадаг. Аймагт яахав, аймгийн начин цолтой, сумандаа сумын заан цолтой. Энэ сумаас гадагшаа гарч барилдаагүй, цэрэгт байхдаа л барилдаж байсан. Сэргийлэхэд байхдаа ноцолдож байсан. Миний үеийн улсууд гэвэл Баянмөнх, Мөнхбат, Сэрээтэр, Сосорбарам, Чойжилсүрэн, Жамц, Дэмүүл гээд.

Монгол хүн гэж таны бодлоор ямар хүнийг хэлэх вэ, бусад улсаас юугаараа ялгардаг бол?

Монгол хүн бол ухаан гаргууд. Гадаадад гайхалтай авьяасыг үзүүлээд ирж байгаа хүн олон байна. Нүүдлийн соёл иргэншил гэдэг чинь л монгол юм шүү дээ. Таван хошуу мал нь байж байвал эмийн ургамал идэж байгаа малын мах нь эм болж байгаа юм шүү дээ.

Мөнх-Эрдэнэ Баянхонгор аймаг Хүрээмарал сум

С: Таны нэр алдар хэн билээ?

М: Мөнх-Эрдэнэ

С: Овог тань юу билээ?

М: Туяагын Мөнх-Эрдэнэ

С: Эхнэрийн тань нэрийг?

М: Дугар гэдэг юм.

С: Овог нь?

М: Эрдэнэ-Очирын

С: Та хоёр хоюулаа энэ нутгийн хүмүүс үү?

М: Би болохоор Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын одоо энэ нутагт ирээд бид чинь хуримаа хийгээд 11 жил болж байна. Энэ нутагтаа 11 жил л болж байна Хүрээмарал сумандаа. Тэгээд л байж байна.

С: Та энэ нутгийн хүн юм байна тэ?

Д: Тийн, Хүрээмаралдаа л төрж, өссөн.

С: Хэдэн оны хүн билээ та чинь?

М: Би 1987 оных, 11 сарын 27-нд төрсөн.

С: Ургийн овог?

М: Сэргэлэн харчууд

С: Сэргэлэн харчууд гэсэн үү?

М: Тийн

С: Эгчийн юу билээ?

Д: 1991 оны 6 сарын 3

С: Ургийн овог нь юу билээ?

Д: Шинэчүүл

С: Та одоо хаагуур нутагладаг вэ?

М: Манайх доогуур говь талаараа л нутагладаг.

С: Урагшаа гэсэн үг үү? зүг нь?

М: Баруун талаараа

Б: 3 дугаар баг гэсэн тэ?

М: Норивлон 3 дугаар баг

Б: Хэр зайтай вэ эндээс?

М: Энчээнээс нэг 45 км байдаг юм нэг талдаа. Тэгээд л наашаа цаашаа яваад л.

Б: Танайх тэмээтэй юу?

М: Тэмээтэй

Б: Тийм болохоор тийшээгээ байна тэ?

М: Тэмээгүй хүмүүс ч хамаагүй байж байдаг.

С: 5 хошуу малаа маллаж байна уу?

М: Ноднин зуд муд болоод мал цөөрсөөн. Зуд болоод зарахын зараад, нүүж бууж чадаагүй тэгээд энэ жил мал цөөхөн бог голцуу л маллаж байна.

С: Хонь, ямаа?

М: Хонь, ямаа

С: Адуу, үхэр байхгүй юу?

М: Адуу, үхэр цөөвтөр цөөвтөр л байгаа.

Б: Та Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын хүн гэсэн тэндээ өмнө нь мал маллаж байв уу?

М: Тийн, аав ээжтэйгээ малаа маллаж байгаад л ер нь эхнэр дээрээ энэ нутагт ирээд Хүрээмарал, Дэлгэр 2 залгаа сумууд юм тэгээд наашаа энд ирээд л энчээ тэгээд хуримаа хийснээсээ хойш энчээ л байж байна 11 жил болж байна.

С: Анх та 2 яаж танилцаж байв?

М: Залгаа сумууд тэгээд тэрүүхэн тэндээ ойрхон байх дээрээ л танилцаж байсан. Энэ Хүрээмаралын айл, манайх наашаа нүүж ойролцоо буугаал танилцаж байсан.

С: Та цэргийн алба хаасан уу?

М: Хаасан.

С: Хаана?

М: Хотод Сонгины 120 дугаар ангид

С: Юуны анги вэ?

М: Их бууны

Б: Сонгины гэхээр хотын баруун захруугаа юу?

М: Баруун захруугаа, их бууны артлерийн 120 дугаар анги гээд байдаг.

Б: Шувуун фабрикийн тэнд мөн үү?

М: Яг тийн, яг тийн зөв.

С: Нэг жил хаасан уу?

М: Тийн

С: Тэгээд нутагтаа ирсэн үү?

М: Тийн 2018 онд цэргийн албаа хаагаад ирсэн.

С: Их сургуульд сурсан уу?

М: Үгүй ээ, их сургуульд суугаагүй 8-р ангиа төгсөөд л мал дээр гарсан.

С: Яагаад малчин болохоор шийдсэн бэ? Хот хүрээ орж үеийн хүүхдүүдтэй сурч явья гэж бодож байгаагүй юу?

М: Үгүй ээ, тэгээд малд дуртай. Анхнаасаа мал дээр гарах сонирхолтой байсан. Тэгээд тэр үед миний үед хүүхдүүд голцуу сургууль завсардчихдаг байлаа. Мэдэхгүй тэгээд нэг мэдсэн чинь л мал дээр гараад тэгээл малчин болоод одоо хүртэл амьдарч байна. Ажил төрөл хийгээд хот хүрээ явья гэсэн ч дургүй байдаг. Тэгээд ерөөсөө малаа маллаад цөөхөн ч гэсэн малаа маллаад байж байвал болох байх гэж бодоод малаа маллаж байна.

Б: Дэлгэрт мал маллах, энд мал маллахад газар зүйн ялгаа байна уу? Мал маллахад нөлөөлдөг?

М: Энэ нутагт овоо хэдэн жил мал малласан болохоор нутагтаа арай дассан байна мал залтайгаа. Дэлгэрлүү явж нэг хоёр жил нэг жил гарантай малласан. Тэгээд ерөөсөө нутаг болохгүй, таалагдахгүй нутаг мутагт мал идээшихгүй болохоор энэ нутагтаа эргэж ирээд тэгээд энэ нутагтаа бүүр шингээд ингээд амьдарч байгаа.

С: Бүүр дасчихсан байсан юм байна.

М: Бүүр нэг л дасчихсан байсан юм энэ нутагт.

С: Энэ нутагт бэлчээрийн асуудал хэр байдаг юм бэ?

М: Өө бэлчээрийн асуудал одоо олон малтай байхад бас хэцүү байсан. Олон малтай айл одоо энээ тэрээ болоод л одоо нэг мал зал энэ жилээс, хойтонгоос юу болох юм байгаа юм. Энэ жилээс харьцангуй гайгүй байна. Бэлчээр сайтай энэ жилээс өвс мөвс жигдэхэн сайхан байна.

С: Энэ хавар, зуныг ямаршуу болох юм байна гээд харж байна уу та?

М: Өө харж байна харж байна. Энэ зун сайхан зун болно гэж бодож байна. Ямар ч байсан гангүй, гачиггүй ямар ч байсан ногоо бол одоо идэх гээл ер нь л дөхцөн байна.

С: Та яг юунаас үндэслээд гайгүй зун болохын байна гэж бодож байна?

М: Үгүй ээ, дахин дахин цас мас ороод л тэгээл чийг мийг өгөөл ямар ч байсан энэ зун ногоо иднэ л гэж бодож байна. Хэд дахин сайхан цас ороод чийг өгөөд. Чийгтэй болчихсон одоо ямар ч байсан ногоотой болноо л гэж бодож байна.

С: Би яагаад энийг асуугаад байгаа вэ гэхээр танай аав ээж, эмээ өвөөгөөс тань байгаль шинждэг тийм арга зааж өгж байсан уу? Зааж өгч байсан бол тэрийгээ амьдралдаа хэрэгжүүлдэг үү?

М: Өгдөг л байсан л даа. Одоохондоо ээж ааваасаа хол байна өө. Ер нь Дэлгэр мэлгэр нээх ордоггүй. Ер нь энд л байдаг манай аав бурхан болсон. Тэгээд ээж л Дэлгэрийн төв дээр байдаг юм. Тэгээд хааяа нэг ээж дээрээ оччихоод тэгээд ээжээсээ хол байна өө. Энчээнээ малаа маллаад нааш цаашаа яваад л сумандаа л голцуу байгаа.

Б: Энэ сум хэдэн хүн амтай юм?

М: Хэдэн хүн амтай билээ. 2600 гэсэн үү?

Б: Дэлгэр нь?

М: Дэлгэр одоо сайн мэдэж байгаа юм алга.

Б: Эндэхээс том уу? жижиг үү?

М: Энэ сумаас жаахан том шүү бас. Жаахан том.

С: Одоо ингээд сүүлийн хэдэн жил бэлчээрийн асуудал, зуд турхан гээд зүүн тийшээ их туувар гардаг болсон байна. Баянхонгор, Говь-Алтайгаас ингээд тийм хүмүүс хэр их явсан бэ? Тэгж тууварт явья гэж бодож байсан уу?

М: Одоо би ингээд ноднингийн ган, зудыг мэдсэнээс хойш одоо хашаа ч хамаагүй ган л болвол явья гэж боддог болсон. Түүнээс ямар ч байсан болчихно гэж хуримаа хийснээсээ хойш зуд муд болж үзээгүй. Тэгээд ирэх ноднин өвөл л ингээд зуд муд болж, ган ман болж үзсэн тэгээд ноднингоос хойш ингэсэн болохоор одоо болвол ямар нэгэн газарлуу ган л болох юм бол нүүе гэж бодож байна. Оторт гаргаад явж баймаар юм байна гэж бодож байна. Би өмнө нь болох байх өө манай дээр үед л манай өвөө, эмээ л "Зуданд нүүдэггүй юм суудаг юм. Гананд нүүдэг, зуданд суудаг" гэдэг байсан тэгээд л зуд болохоор сууж л байвал болохоор юм байна гэж бодоод байсан чинь тэгээд дэмий юм байна.

С: Ганд нүүдэг, зуданд суудаг гэсэн үү?

М: Тийн, тэгээд тэрний үгийг дагаад заа сууж байх юм байна гэж бодсон чинь болохоо байсан. Тэгээд энэнээс хойш ямар л ган болох юм бол нүүгээд л явж баймаар юм гэж бодож байна.

Б: Өөр аймаг та судалж үзэж байсан уу? Ган болвол ийшээгээ зүглэдэг юм уу гэж?

М: Нондин эндээс Говь-Алтай аймгийн Хөхморьт сумруу Жаргалан гээд энэ сумруу зөндөө айлууд нүүсэн. Тийшээ хүн амьтантай ч ярьчихсан байсан. Тэгээд нүүдэг ч юм уу гээд бодоод байсан чинь тэр тухайн үедээ энэ туранхай малыг нүүгээд хэзээ ч очих юм билээ гээд бодоод тэгээд нүүж чадаагүй юм. Тэгээд хүмүүс чинь голцуу машин тэргээр ачиж аваад энээ тэрээ болоод явчихдаг юм билээ. Мал залаа ачиж аваад том том машинуудад ачиж аваад л аваачиж буулгаад л тэгээд л нүүлгэчихдэг юм билээ.

С: Тэгэхгүй бол тэр зутруу малыг хөлөөр нь явуулахаар хэзээ ч очих юм, замдаа хэд нь ч үрэгдэх юм билээ тэ?

М: Тийн, би бас тэгж бодоод нүүгээгүй. Тэгээд бас болох байх гээд байж байсан чинь өвлийн хүйтэн ч туранхай малд үнэн хэцүү юм байна. Ерөөсөө тэгээд осгоод осгоод үхчихдэг юм байна. Ноднин манайх чинь 800 гаруй малтай байсан одоо 200 гаруйхан малтай л үлдсэн. Тэгээд болохоо байгаад эм ямаагаа 15000-д хүртэл өгж үзсэн. Тэгээд энэ жил 200-аадхан малтай тэгээд ямар ч байсан болно доо. Одоо нэг сум оронд эхнэр бид 2-ын нэг нь ямар нэгэн ажилтай болох юмсан л гэж бодож байгаа юм чинь. Нэг нь ч гэсэн ажилтай болчих юмсандаа нэг ажилд авдаг газар байдаггүй юм байхдаа гэж бодоод л дарга нартай яриад л явах юм. Зарим дарга нар нь хүлээж авах юм. Зарим дарга нь ч хүлээж авахгүй юм. Мэдэхгүй тэгээд бид 2-ын аль нэг нь л, хоёулаа ч юм уу ажилтай болох юмсан гэж бодож байна. Тэгээд манай энэ шинэ соёлын төв нээгдэх гэж байгаа юм. Энд нэг Хобоо бид 2 жаахан найзууд байхгүй юу. Би бас дуулж муулдаг энэ суманд 2 ч удаа тоглолт хийсэн юм.

С: Өө тийм үү?

М: Тийн, 2 удаа тоглолт хийгээд. Уяачид, малчид дуулж байна тэрүүнд хүртэл улсад хүртэл оролцоод ирсэн юм. Тэгээд Хобоотойгоо найзууд, Хобоогоо цагаан сараас хойш цай уулгаагүй байсан манайд нэг ирээд хоол унд идээд цай уугаач ингээд байж байсан

чинь манай ажил дээр ийм хүмүүс ирж байгаа, дарга ирж байгаа гээд би заа гээд дарга нараа чи угтчихаад ирээд цай уугаарай, хоол идээрэй гээд байж байсан юм. Тэгсэн чинь ийм хүмүүс ороод ирдэг юм.

Б: Малчид дуулж байна гэдэг чинь Тв5-аар гараад байдаг нэвтрүүлэг мөн билүү?

М: Тийн, Уяачид дуулж байна гээд, малчид дуулж байна гээд тэрүүнд хүртэл нэг оролцоод яваал ирсэн.

Б: Хэзээ орсон юм та?

М: Уяачид дуулж байна гэдгийн анхныхад нь орсон. Одоо энэ чинь 4 жил явагдаж байна.

С: Байр эзэлсэн үү та тэгээд?

М: Үгүй ээ. Байр майр эзлээгүй. Шилдэгт нь нэг орохоо алдаад тэгээд л хасагдсан. Тэр чинь мессеж саналаар юм билээ.

С: Та ажилд орох сонирхолтой байна гэж байсан тэгэхээр малаа яана гэсэн үг үү?

М: Тэгээд малаа аль нэг нь орчих юм бол малаа наашаа, цаашаа ямар ч байсан болчихно.

С: Малаа наашаа дөхүүлж ирнэ гэсэн үг үү?

М: Үгүй ээ, тэндээ өвөлжөө бууцан дээрээ тэгээд манай хадам ээж байдаг юм манайд, манай хадам ах байдаг юм. Тийн тэгээд хүүхдүүдтэйгээ наашаа цаашаа болчихно л гэж бодож байгаа.

С: Тэгэхээр та саяны зуданд жаахан шантарсан гэж ойлгож болох уу?

М: Шантарсан л даа. Цөөхөн малтай мал баталгаагүй юм байна. Энэ цөөхөн малтай яаж амьдрах вэ? заа явья хотод явья, ноднин намар хот явж ажил хийлээ нэг 2 3 сар бид 2-лаа ажил хийгээд ирлээ. 4 хүүхдээ хөдөөнөө үлдээчээд ямаа саах ч ямаагүй юм чинь бүх ямаа чинь сувай мувай орцон тэгээд ерөөсөө ишиг аваагүй ямар ч саах сааль мааль байхгүй. Тэгээд 2-лаа хот яваад ажил хийгээд ирсэн ер нь хотод бүтэхгүй юм билээ. Ер нь түгжирээ мугжирээгээс эхсүүлээд цагаар ажилладаг бид нарын ёстой шөнө ажилдаа яваад шөнө гэртээ орж ирэх юм. Тэгээд ерөөсөө болохгүй юм байна. Заа ер нь бүтэхгүй юм байна. 2-лаа нэг 2 сар тэвчиж байгаад ажил банкныхаа нэг зээлийн хүүг хийх гэж явж байсан юм. Хаан банкнаас зээл аваад тэр зээл мээлнийхээ хүүг хийгээд ирье гэж яриад л тэгээд л явсан байхгүй юу. Тэгээд ямар ч байсан нэг сарын 800 мянган төгрөгний ажил хийгээд тэгээд нэг 2 сар ажилчихаад тэгээд эргээд хүрээд ирсэн. Тэгээд ирээд малаа маллаад л байж байна.

Б: Ямар ажил хийж байсан юм та?

М: Өө нэг үйлдвэрт ажил хийсэн юм. Цагаан хоол, хүнсний, цагаан хоолтон хүмүүсийн хоолыг хийдэг нэг үйлдвэр байдаг юм.

Б: 2-лаа юу тэ?

М: Тийн

С: Яаж тэр ажлыг олж хийв?

М: Фэйсээс харж, фэйсбүүкээс хараад тэнд тийм хүн авна гээд тэгэхээр нь бүртгүүлээд анкет бөглөөд тэгээд авсан. Тэгээд тэр ажилд ороод сарын 800 мянга төгрөгний цалинтай юм билээ. Тэгээд тэнд нэг 2 сар ажиллаад ирсэн. Цагаан хоолтон хүмүүсийн л нэг боорцог шиг хатуу хатуу нимгэн нимгэн юм байх юм. Тэрийг усанд дэвтээгээл махаа тэрийгээ угаагаал тэгээл яг махны амт оруулаад яг мах шиг юм болгож гаргаж ирээд тийм хоол хийдэг газар байна лээ. Би тэр угаалаг дээр ажиллаж байсан.

С: Юу гэдэг нэртэй газар байсан бэ?

М: Бурхадын зоог гэсэн. Бурхадын зоог гэдэг газар байлаа. Тийм ажил хийгээд тэгээд хүүхдүүдээ ч санаад болдоггүй тэгээд хотод чинь тэгээд байр майрны түрээс мүрээс гээд ерөөсөө болж өгдөггүй. Байр түрээслээд сардаа байлаа. Сүүлдээ эгч ээжийн дүүгийн очиж нэг сар боллоо тэгээд болохоо байгаад л за явья явья гээд 2 сар ажил хийгээд ирсэн тэгээд ямар ч байсан нэг банкныхаа хүүг хийчээд хүрээд ирсээн. Одоо хэдэн малаа самнаал тэгээл одоо тэгээд энэнээс цааш тэгээд малаа өсгөөд л амьдрая гэж бодож байгаа.

Б: Ноднин хэдэн сард хот орсон юм?

М: Бид 2 нэг 7 сард орсон юм.

Б: Тэр үед коронагийн хөл хорио гайгүй байсан юм уу?

М: Корона гээд байсан. Хөл хорио гэж арай байхгүй байсан. 7 сарын 20-оор явлуу, 8 сар дөхүүлээд явсан юм. Тэгээд нэг ажил хийгээд явж байгаад ирсэн.

Б: Корона вирус туссан уу?

М: Ерөөсөө тусаагүй.

С: Наашаа ер нь гайгүй байсан уу?

М: Энд ирсэн шинжилгээ минжилгээ авсан тэгээд бид 2 ерөөсөө тийм юм тусаагүй. Хотод ч зөндөө тэгээд л тэр олон хүмүүс дотор хийгээл явсан.

С: Хүрээмаралаас хүн туслаа гэж сонссон уу?

М: Энд зөндөө туссан.

Б: Хөл хорио болсон уу?

М: Болсон шдээ. Бид нар чинь энэ орой дээр зогсчихоод дэлгүүрээс ойр зуурын юм аа авдаг байлаа. Вок, саван, гурилан боов, ганц нэг ундаагаа энэ орой дээр зогсон орой дээр нэг гэр барьчихсан. Тэгээд энэ орой дээр нам зогсоод 2 хүн оруулахгүй, ийш тийш нь явуулахгүй нам зогсоочихно. Тэгчихээд дэлгүүрлүү утсаар ярьна, тэгээд тэр дэлгүүрээс нэг хүн машинтай авчираад л юм захисанг нь авчирч өгнө. Нэг цагаан хувцас өмсчихсөн ам дүүрэн юм бооцон ингээл авчирч өгнө. Бид нар чинь тинчээнээс хэдэн мянга бол хэдэн мянга гээл тэндээ пос машин бариад ирнэ нөгөө картаа уншуулаад л тэгээд нөгөөдөхөө аваад цаашаа яваад өгнө. Бензин авах юм бол машин дээр чинь лац наачихдаг. 4 хаалгын лацчихдаг. Тэгээд л колонк дээр очоод зогсон гарахгүй цонхоороо нэг тэдэн литр бензин гэхихнэ нөгөөх чинь хийгээд өгнө. Картаа уншуулчихна тэгээд шууд явчихна тэгээд л тэр дээгүүр даваад явчихдаг байсан. Тэгээд тэгж 3 сар тэгж явсан шдээ бид нар чинь.

Б: Нутгийнхан хэр хандав тэрэнд үнэхээр сэжиглэж яаж тэгэв үү? эсвэл тоохгүй байв уу?

М: Ерөөсөө тэгээгүй янзын сэрэмжтэй байсан. Сэргийлээд янзын хандсан шд.

С: Бие биетэйгээ харилцах харилцаа ямар болсон бэ?

Б: Бие биенийхээрээ орж гарах тийм юм өөрчлөгдсөн үү? Айл хэсч барих?

М: Тийн ерөөсөө орж ирэхгүй. Одоо хөдөө ч гэсэн манайд орж ирдэг хүн байхгүй. Муухай юм байна лээ. Ямар хүн ч ирдэггүй, хэн ч орж ирдэггүй, одоо мал зал асуусан ч тээр тэнчээ зогсчихоод тийм мал тэгэв үү ингэв үү гээл асуучихаал яваад өгнө. Зүгээр нэг суугаад тамхи мамхи татах юм юу ч байхгүй тэгээл яваад өгнө. Тэгээд ерөөсөө тийм аймар муухай юм билээ тэр ёстой нэг муухай байдаг юм билээ.

Д: Тэгээд энэ бол ерөөсөө юмны үнэ тэнгэрт хадчихсан ерөөсөө.

М: Юмны үнэ арай дэндүү болчихсон манай сумын юм бол пүүх арай дэндүү их үнэтэй байна. Бууцагаан арай гайгүй хямд байх гээд

Д: Бензиний үнэ ч гэсэн, Бууцагаан магаан гээл арай гайгүй бензин гэхэд л 200 төгрөг дутуу байгаа шд.

М: Одоо энд түлш л гэхэд манай энд 3500 гэж байна.

С: Тэгэхээр айл саахалтын чинь хүмүүс хүртэл орж ирэхээ байсан гэсэн үг үү?

М: Тийн ерөөсөө орж ирэхгүй байгаа юм чинь. Манай сум гэрээсээ, төвийнхөө гэрээс юм аваадхья, тэгээд ингээд тэгье гэхээр чинь энэ гэрлүү ч оруулахгүй. Тийм л байсан. Энэ гэрлүүгээ ч орох эрх байхгүй.

Д: Заримдаа цагдаа дагаж явж байж бензин авхуулна.

М: Бүүр заримдаа цагдаа дагаад л явна. Гэрээсээ ороод юм аваадахья, үгүй ээ болоогүй яв, шууд яв гээд хэсгийн төлөөлөгч гадаа ирээд нам зосчихно тэгээд заа одоо яадаг билээ гэрээсээ ууг нь тийм юм авах байсан юм заа одоо төвөг төвөг гээд л шууд явчихдаг байсан.

С: Танайх одоо төвд нэг гэртэй, хөдөө гэртэй хүүхдүүд нь дотуур байранд байдаг гэсэн тэ?

М: Тийн, энд нэг гэртэй, хөдөө жижиг дөрвөн ханатай гэр байдаг. Том гэрээ ийш нь оруулчихсан.

С: Ер нь наашлах төлөвлөгөөтэй байгаа гэж ойлгож болох уу?

М: Тэгээд ер нь тэгээд ажилтай л болчихвол энчээ орж ирээд ажилгүй бол яахав

Д: Ажилгүй бол энчээ орж ирээд юу хийх юм.

М: 2 том ангийн хүүхдийг чинь хараад суугаад байлтайн биш ямар ч ажилгүй юм чинь юу ч хийхэв, хөдөөнөө очоод малаа малласан нь дээр.

С: Энэ судалгаагаар явж байхад айлууд нөхөр нь хөдөө малаа маллаад байдаг бол эхнэр нь хүүхдүүдээ аваад төв суурин газар ордог болчихсон байгаа нь анзаарагдсан.

М: Би харин найзаа Хобоо найзыгаа гуйгаад л байгаа юм. Чи энийг нэг соёлынхоо төвд манай эхнэрийг үйлчлэгчээр ч болсон ажилд аваарай оруулаад тэгээд явах манай баг 2 сургуульд сурах гэж байгаа тэгээд манай эхнэр ажлаа хийгээд 2 хүүхдээ хараад ингээд байж байг 4 хүүхдээ 4-лэнг нь энэ гэртээ хараад ингээд байж байг гээд ингээд яриад байгаа юм. Тэгээд юу болдог байгаа юм. Хэдэн үйлчлэгч авч ямар юм болох байгаа юм. Өшөө сонирхож байгаа юм алга.

Д: Өшөө юм сонирхохоор чинь нам харгалзаад замгүй юм. Нам чинь яасан төвөгтэйн.

С: Интернетийн сүлжээ орж ирсэн байна. Фэйсбүүк ашигладаг болсон байна.

Ингэхээр бусад найз нөхөд, хүмүүстэй харилцах харилцаанд илүү амар болсон, дэвшилттэй болсон ч гэх юм уу тийм зүйл байгаа юу?

М: Байгаа байгаа. Хаашаа ч хамаагүй, аймаг хотруугаа тэгээл хэрэгтэй суманд байхгүй юмаа фэйсбүүкээрээ залгаал нэг сунаж орж ирээл фэйсбүүкээр залгаал за тийм юм байна, тэгээч ингээч тийм юм олоод явуулаач мөнгө төгрөгийн хийе. Одоо тэгье ингээ гээд фэйсбүүк аймар хэрэгтэйн харагдаж байгаа байхгүй юу.

С: Хотоос юм захирад ч юм уу, машин тэрэгний юм хум ч захих юм уу тэ?

М: Тийн, машин тэрэгнийхээ юмыг захира. Ганц нэг гутал.

Д: Машиныхаа юмыг л их захих юм байна шүү дээ.

С: Та гэр орондоо янз бүрийн юм захидаг уу?

Д: Үгүй ээ.

М: Ууг нь ч манайх хэдэн сайхан малтай байхдаа янз янзын юм захиалдаг л, авдаг л байлаа. Одоо энэ жилээс тийм юм болгон чадахаа байлаа. Мөнгө төгрөг жаахан тиймэрхүү болоод мал зал цөөрөөд тэгээд тийм юм байхаа байлаа.

С: Одоо ганц хоёр жил гайгүй өнгөрчихвөл гайгүй болчих байхаа.

М: Одоо нэг хоёр жилийн дараа болвол болчихно л гэж бодож байгаа. Ямар ч байсан 2 жил ингээд нэг яачихад энэ жил ямар ч байсан 100 гаруй ямаа ашигласан, хойтонгоос 300-аад ямаа болчихно. Тэгээд болчихно л гэж бодож байгаа.

С: Цагаан сар сүүлийн 2 жил тэмдэглэсэн үү? Коронагаас болоод тэмдэглээгүй юу?

Д: Тэмдэглэсэн тэмдэглэсэн. Энд чинь бол яг л тэмдэглэдэгээрээ л тэмдэглэсэн.

М: Манайх нэг жилд сая төгрөгөөр л цагаан сар тэмдэглэдэг юм.

С: Зоглоод бие биенийхээрээ хэссэн үү?

М: Золгосон гэсэн.

С: Хамгийн анхны жил корона Хятадад гараад цагаан сар тэмдэглүүлээгүй шд. Тэрүүгээр яасан юм бол?

М: Тэр жил ёстой айлаар оруулаагүй шд. ёстой оруулаагүй. Хөдөөгүүрээ л хэд гурван айлаар орсон энэ сумын төв дээр ёстой оруулаагүй. Пост гарчихсан сумын төв орох эрх байхгүй. Хөдөөдөө 3 4-н айлаараа ингэж нэг

С: Би энэ хавийн мэндлэх хүндлэх ёсны талаар сонирхож байгаа юм. Хүмүүстэй уулзахдаа юу гэж мэндэлдэг үү? Тийм бусад газраас ялгаатай гэх ч юм уу? Хөөрөг зөрүүлэх ёс ч гэх юм уу? Би Говь-Алтайд хөөрөглөхдөө гэрт нь хүн орж ирэхээр эхнээсээ бүгд хөөрөгөө гаргаж ирээд нэг нэгээрээ хөөрөглөдөг. Тэгээд ахиж өөр хүн орж ирэхээр ахиад л эхнээсээ бүх хүмүүс хоорондоо хөөрөглөдөг гээд тийм зүйл хүнээс сонсож байсан юм.

М: Тийн, манай энд ч бас тэгнэ шд. Яг тэгнэ, цагаан сараар бүр тэгнэ, Цагаан сараар хүн болгонтой хөөрөглөн, хүүхэд мүүхэдтэй ч хөөрөглөнө. Бүгдэнтэйн хөөрөглөн.

С: Өмнө нь хөөрөглөсөн байсан ч ахиад л хөөрөглөнө гэсэн үг үү тэ?

Д: Үгүй

М: Өмнө нь тэр хүнтэй золгочихсон байсан ч дараа нь "сайхан хаваржиж байна уу?" гээд л хөөрөглөнө.

С: Янз янзын мэндлэх хүндлэх үг хэллэг юу байна?

М: Сайн байна уу? Сайхан хаваржиж байна уу? Сайхан зусаж байна уу? Тарган сайхан хаваржиж байна уу? Сар шинэдээ сайхан шинэлж байна уу? гээд яг л мэндлэх ёсоороо л мэндлээд л ингээл байдаг. Сайхан намаржиж байна уу? гээд. Үеийн хүмүүстэйгээ сонин сайхан юу байна хөө? гээд тэгээд л мэнд зөрүүлээд л тэгээд л уулздаг.

С: Тэгэхээр нас, үе ойролцоо хүмүүс ондоо, ахмад хүмүүс бас нэг ондоо

М: Тийх ондоо, Ахмад хүнийг сонин юутай байна гээл тэгэхээр муухай л даа. Тэгээд л сайн байна уу та? гээд л мэндлээд явдаг.

С: Хэрэг зоригийг нь асуух ч юм уу, тийм үед одоо юу гэж хэлэх вэ?

М: Заа тэгээд л юу байна гээд л асуулаа гэхэд тийм хэрэгтэй явж байна танайхыг зорьж явна гээд л мэндлээд л учир явдлаа яриад л сууна л даа.

С: Та ойрд уулзаагүй найзтайгаа уулзвал юу гэж мэндлэх үү? Олон жил уулзаагүй найзтайгаа аймгийн төвд гэнэт таарсан гэж бодвол?

М: Заа сайн уу хөө? сонин сайхан юу байна? сайхан хаваржиж байна уу? ажил төрөл сайн уу? хаана байна? гээд л мэндэлнэ.

С: Бүүр ахмад настай хамаатныхаа ч юм уу бас олон жил уулзаагүй хүнтэй уулзвал?

М: Сайн байна уу та? Сайхан хаваржиж байна уу? бие тэнхээ сайн уу? бие ажлаар сайн орсон уу та? юу хийж байна?

С: Юугаар сайн орсон уу?

М: Бие ажлаар та сайн орсон уу?

С: Энэ одоо яг утгаар асууж байгаа гэсэн үг билээ?

М: Бие нь сайн уу? ажил төрөл нь сайн уу? л гэсэн утгатай. Нэг бол ажил амжилттай сайн оров уу? гээд л

Б: Түрүүн энд намчирхах үзэл байдаг гээд тэгж байсан шд. Тэр та яагаад тэгж хэлэв? Намаар ялгаварладаг юм байна уу?

Д: Үгүй ээ, харин энд намаар ялгаварлан

М: Аймар ялгаварладаг шд.

Д: Одоо энэ чинь ингээд нам хуваагдцан.

М: Одоо энэ суманд ч гэсэн, захиргаанд ч гэсэн.

Д: Захиргаа махиргаа эмнэлэг мэмнэлэгт ажил мажил байна. Тэгээд яахаар өө наадах чинь ардын намын хүн гэсэн шд. Яахын яахын гээд.

М: Бид 2 ч үнэндээ ардын намын хүмүүс л дээ. Ардын намыг л ерөөсөө дэмжиж явдаг. Одоо энэ эмнэлэг гэхэд дандаа ардчилал. Ерөөсөө л ардчилалын хүмүүс. Тэгээд л манай засаг дарга гэхэд л ардчилсан намын хүн.

С: Саяын орон нутгийн сонгуулиар аль нам ярьсан бэ?

М: Ардчилсан нам ялсан.

С: Тэгээд засаг дарга нь ардчилсан намаас гарсан юм уу?

М: Тийн, өмнө жил нь ардын нам гарсан.

Д: Өмнө ардын нам дарга маргайтайгаа байсан. Захиргаанд хүртэл ажил мажил байдаг тэгэхээр өө наадах чинь ардын намын яахын ингээд ерөөсөө.

Б: Ажил байлаа гэхэд намын түрүүлж харж байна уу?

Д: Аа тийн нөгөө хүнийн харж байгаа юм. Энэ ямар нам юм гэдгийг нь тэгээд ардын намын хүн харахгүй, ардчилсан намын хүнийг авчихаж байгаа байхгүй. Ерөөсөө намын үзэл бодлоос сум орон нутаг ингээд 2 тал болчихоод дайтчихдаг.

Та хэдэн онд төрсөн бэ?

1956 он, мич жилтэй. Шилүүстэй сумандаа, Шарил гэдэг газар бий. Би 10-р анги төгсөөд 10 жил багшилсан. Олон олон хичээл зааж байсан, тэгээд 1984 онд Ховдын багшийн сургуульд яваад, төгсөж ирсэн хавраа хичээлийн эрхлэгч хийгээд, тэнд дэд захирал гэдэг орон тоо гарч ирээд, тэрнийг нэг хоёр сар хийгээд, тэгээд сургуулийн захирал хийсэн. 2000-2004 онд сумын засаг дарга хийгээд 2005 онд ахиад сургуулийн захирлаар ирээд, 2006 онд тэтгэвэртээ гарсан. 1989-2000 он хүртэл захирал хийсэн.

Та мал малладаг уу, танайх малтай юу?

Мал малладаггүй. Амьдралдаа нэг л удаа, 7-р ангид байхдаа хонь хариулж үзсэн. 10-р анги төгсөөд ирээд энд Саруул зам нэгдэл гэж байсан, тэнд штаб гэж байсан. Тэгэхэд энэ Сайхан замын штабт нэг гарсан. Улсуудын аль хонь мал муу, хурга ишиг хоргодож байгаа тэнд очиж ажиллана, тэр айлуудаа нүүлгэнэ гээд л. Тэгж ажилладаг байсан юм. Өөрөө бол одоо хувьдаа 70-аад толгой малтай. Тэр маань тэтгэвэрт гарснаас хойш юм. Тэтгэвэрт гарахаас өмнө а дансандаа малгүй, хоол ундандаа худалдаж авч иддэг байсан. Тэгээд одоо ямар ч байсан 70-аад толгой малтай.

Таны эцэг эх малчин хүмүүс байсан уу?

Манай аав энд Наробанчэн гэгээнд шавилан сууж байсан хүн. Багадаа Наробанчэн, Дилова гэгээний дэргэд унзад хэргэмтэй, гэлэн сахилтай лам хүн байсан. Тэгээд манай ээжтэй гэр бүл болоод 11 хүүхэд гаргасан. 11 хүүхдээс одоо 8 нь бий. Хоёр хүү нь нялх байхдаа үхчихсэн. Одоо манай хамгийн бага дүү 60 настай хүн байна, хамгийн том ах маань 83 настай хүн байна. 3 ах, 1 дүү маань Улаанбаатар хотод байна. Манай аав өөрөө 86 хүрээд өөд болсон. Манай ээж 104 хүрч өөд болсон. Шилүүстэйд дээр үед биднийг хүүхэд байхад Зонрой гээд нэг өвгөн байдаг байсан. Илүү сартайгаа 103 хүрч байгаа гэдэг байсан. Манай ээж 104 тэй өөд болсон. Би энэ жил 67 настай, гайгүй ээ. Зааланд ороон волейбол тоглочихоод тэгээд тиймэрхүү байна. Өөрөө бол урлаг спортын сонирхолтой. Бөх бол барилдаж үзээгүй, бага байхад сумын клубт л барилдаж үзсэн. Зургууд нь одоо бий л дээ. Урлагийн хувьд бол яахав, өөрөө тавдугаар ангид байхдаа энд манай чуулга гэж Цэдэндамба багшийн байгуулсан тэнд баян хуур тоглодог байсан. Яахвээ, би 2008 онд соёлын тэргүүний ажилтан цол тэмдэг авсан. 1981 онд бүх ард түмний урлагийн их наадам гэж болсон, тэнд Завхан аймгаас явсан, баян хуур хөгжмийн хамтлагаар. Хоёр нь дуучин. Шатарбал, Пүрэвдорж гээд. Тэр хоёр дуугаар явж, Шатарбал нь Бүх ард түмний урлагийн их наадмын алтан медал авч, тэр Пүрэвдорж мөнгөн медал авч, би хүрэл медал авч байсан. 1987 онд оюутан сурагчдын урлагийн их наадмын хүрэл медал авч байсан, баян хуур хөгжмөөр. Урлагийн гурав хоног гэж аймагт зохион байгуулагддаг, тэнд гурван удаа орж байсан. Гэр бүлийн хүн маань монгол хэл, уран зохиолын мэргэжилтэй, ардын авьяастан цол тэмдэгтэй, алтангадас одонтой, боловсролын тэргүүнтэй. Би бол өөрөө хөдөлмөрийн гавьяаны одон, алтангадас одонтой, боловсролын тэргүүнтэй, соёлын тэргүүнтэй, хөдөлмөрийн тэргүүнтэй, гурван салбарын тэргүүнтэй ийм хүн байгаа юм. Тэр алдарт дуучин Павран гэдэг чинь яг манай сумын хүн. Гэтэл тэр хүнийг Тайширын хүн болгоод, ярихгүй болхоор алдаад л байх юм.

Таны аав хэлмэгдүүлэлтийн үед хар хүн болсон юм уу?

Тийм. Хэлмэгдүүлэлтээс арай өмнөхөн юм уу даа. Тэгээд энд хөдөө хоёр гурван жил байсан байх. Тэгээд олон хүүхэдтэй болохоор сургуулийн гал тогоонд тогооч байсан, сумын захиргаанд зарлага гээч юм хийж байгаад тэтгэвэртээ гарсан.

Та сургуульд ямар хичээл заадаг байв?

Би ерөөсөө аравдугаар ангиа төгсөөд 10 жил багшилсан. Тэгэхдээ бага ангид ордог байсан, математик ордог байсан, амьтан судлал ордог байсан, орос хэл, биеийн тамир, дуу хөгжим гээд заагаагүй хичээл байхгүй бүгдийг орсон. Тэгээд гол төлөв

математикийн хичээл орсон л доо. Тэгээд бид нарыг сургуульд орох үед мэргэжил солихгүй гэдэг байсан, тэгээд математик физикийн анги төгсөж ирээд нэг ч жил багшлаагүй. Дандаа удирдах ажил хийж байсан. 10-р анги төгсөөд багшилж байхад энд оройн сургууль гэж ордог. Долоон хоногт 47 цагтай, гайгүй заах аргатай байсан. Дагва гэж бага ангийн багш байсан. Тэр үед кассеттэй магнетфоноор хичээлийнхээ таниулах, үзүүлэх юмаа гол төлөв өөрсдөө хийдэг байсан. Шрифтийн үзэг гээд хавтгай үзэг байдаг байсан. Манай энд социалист уралдаан гээд долоо хоног болгон дүгнэдэг, мэргэжлийн багш нартай халз үзээд, гайгүйд нь ороод л явдаг байлаа.

Нутаг орны ямар онцлог газрууд бий вэ?

Гарьдын даваа гэж байна. Гурван мянган уулс нь Отгонтэнгэр уулын салбар уулс л даа. Тэнд Гарьдын даваа гэж бий. Энэ Сайхан багийн нутагт Хуслуурт гэж бий. Энд бол олон төрлийн мод ургадаг, их ширүүн дошгин газар. Тэндээс мод авбал тэгээд л авсан хүн чад хийдэг, өөрийгөө хамгаалсан тийм газар бий. Цаашаа Бор бургас хавцал гэж бий. Чацаргана ургадаг тийм газар. Уг нь Шилүүстэйд байж байх ёстой юм, Жасрай сайд цаад талд нь авхуулсан. Манай нутгийн удирдлага л муу ажилласан. Мандалт нуур гэж сайхан зэгэстэй нуур бий, ойрын хэдэн жил зэгэс нь муудаж байх шиг байна. Мянганы өвөрт Номт цагаан суварга гэж байна. Энэ хойшоо Эрдэнэбадрахын худаг гэж газар байна. Наробанчэн гэгээний төрсөн нутаг, Наробанчэн гэгээний өмнөх дүр, одоогийн Наробанчэн нь Отгон сумын Буянт багт төрсөн. Гэгээн овоо гээд энэ хойшоо тахилгатай газар бий, тэр нь Наробанчэн гэгээний уламжлалт тахилгатай газар. Дилав хутагтын овоо энүүхэнд бий, тэр нь монголоос гарахдаа босгосон жижигхээн овоо бий, сүүлд нь сэргээсэн. Манай аав зааж өгч байсан юм, манай аав Дилов хутагтад шавилж сууж байсан унзад. Одоо Чандманийг Доржжигжид гээд нөхөр энэ 9-нд ирж тахих юм гэнэлээ, тэнд бүр ногоон төгөл байгуулах тийм юм ярьж байгаа. Уг нь дээрийн Дарам цорж гэж хүний цагаан суварга 2001 онд байгуулсан юм тэнд. Балгатайн чандмань, Мандалт, наадам хийдгийг тэнд Хөх овоо гээд тахилгатай. Урд уулын өвөрт бас нэг суварга бий, дээр үед байсан суваргийг нь нурааж хаяад, тэрийг нь 90 онд сэргээн босгоод, саяхан ч бас босгосон. Цэвээнлхаазал хурандаа олон ирж тахьсан. Энэ хөтөл дээрээс Богд Очирваань үзэгддэг. Богд Очирваань Завхан талаас дүгнэгэр, манай талаас шовх харагддаг.

Тахилгатай газруудыг өөр өөр өдрүүдэд тахидаг уу?

Манайд лам хуварга цөөхөн, төвийн багийн засаг дарга Тэрбиш гэж нөхөр бий, ганц тэр л байна. Бусдууд нь дандаа ийш тийш явсан. Бусдууд нь сурч л байна, энд ирээд угаасаа зах зээл нь ч алга. Энэ багийн төвийн засаг дарга хийж байгаа нөхөр манай аавын шавь юм байгаа юм. Би бол худлаа нэг багш хүн бараг толгой дээгүүр нь алхчих шахаад яваад байсан болхоос ганц юм сураагүй, сүүлд нь засаг дарга болчихоор нь амаа барьж байлаа. Ядаж “манай Балгатайн Чандманийг тийм тийм жаягаар тахидаг, тийм тийм ном уншдаг гээд” юм л сонсож судалж аваагүй. Одоо дураараа дураараа тахиж байгаа. Хэдэн сан уншдаг ч юм уу. Мандалдыг бараг л мал гаргаж, өргөж тахидаг байсан л гэдэг юм, одоо ч тийм юмгүй. Гэгээн наад цагаан овоог тахиж байсан, олон хүрээ хийдийн лам нар ирдэг байсан болохоор тэр юм уу арай гайгүй. Би бол мал аж ахуйн талаар нэг их юм ярьж

өгөхгүй. Агент гуай, Андиа гэгээн төрсөн энэ цагаан овоог намрын дунд сарын 17-нд жил алгасахгүй тахина.

Агент гуайд үзүүлдэг байсан уу?

Би айгаад уулздаггүй, аавыгаа явуулчихдаг байсан. Манай гэр бүлийн хүн савны гадуурх жирэмслэлт болоод аав очиж уулзсан чинь “тэр нөхрийг өөрийг нь явуулахад яадаг юм” гэсэн гэж байгаа юм. Хамгийн сүүлийн амьд хувилгаан энэ улсуудыг удирдаж байсан болохоор Шилүүстэй шүтлэгтэй. Одоо ардчилал гэж юм гарснаас хойш бас л. Хөдөө орон нутагт улс төр гэж үнэн заваан юм байна, хоёр хуваагдчихаад. Би бол Шилүүстэйд Монгол Ардын намын дарга хийж байсан, гэхдээ би тэр үедээ бусад хүний “энэ бол миний үзэл бодлын эсрэг хүн юм шүү” гэж боддоггүй байсан. Одоо бол сүүлийн 7, 8 жил тийм л болсон. Тэр байтугай боловсрол, эрүүл мэндийн байгууллагуудыг улс төржүүлчихлээ. Тэр хамгийн буруу, ёстой халагламаар юм тэр. Багш нар, эмч нар улс төр хийж яах юм, хөдөө орон нутаг тийм л юм болчихоод байна.

Танай нутагт бөө шүтлэгт хүн бий юу?

Манай нутагт бөө байхгүй ээ, хотруу ганц хоёр байдаг гэсэн. Яг Шилүүстэйд бол нэг ч байхгүй, тэрийг баталгаатай мэднэ.

Монгол хүн гэж таны бодлоор ямар хүнийг хэлэх вэ?

Ер нь монгол хүн болж төрнө гэдэг бол зүүний үзүүр дээр будаа асгаад тогтохын тийм хэмжээ гэж ярьдаг. Монгол улсад монгол хүн болж төрнө гэдэг асар их гавьяа, хариуцлага. Дээр үеэсээ ажилсаг, хөдөлмөрч, чин зоригтой, мал аж ахуйгаа дагнан эрхлэх байсан ийм л улс юм л даа. Чингис хаанаасаа эхлээд удамшин ирсэн хүнийг л монгол хүн гэх юм даа.

1. Увс аймгийн Завхан сум Х.Цоозол, 65 настай

Сайн байна уу, та надад өөрийгөө танилцуулаач?

Ц: Увс аймгийн Завхан сумын уугуул иргэн байна. 1958 онд Завхан сумын Шаргуу гэдэг газар төрсөн. Завхан суманд 8-н жил төгсөөд тухайн үед Говь-Алтай аймгийн Анагаах ухааны дунд сургуульд 1976-1980 онд эх баригч, бага эмч мэргэжлээр дүүргээд нутагтаа ирсэн. Төгс ч ирээд уугуул нутагтаа, одоогийн Айраг нуур багт 7-н жил багийн эмч хийсэн. 1988 оноос эхлээд 2015 оныг дуустал Завхан сумын одоогийн Эрүүл Мэндийн Төвд багийн эмч, эх баригч, салбарын эрүүл мэндийн төвийн эрхлэгч гэсэн ажлуудыг 36-н жил хийж, тэрнээс хойш энэ оны 2 сар дуустал түр хугацаагаар хөдөө багуудад 1 жил, 1 жил 6-н сараар Хяргас нуур баг, Айраг нуур багт 2022 оны 3 сарын 1-н хүртэл түр хугацаагаар ажиллаж ирлээ.

Х: Та надад гэр бүлийнхээ тухай ярьж өгөөч?

Ц: Одоо ганцаараа амьдардаг. Төрүүлсэн ганц л хүүтэй бас ах эгчээс өнчин хоцорсон хэдэн хүүхэд (төрсөн ахын 2 ач) өсгөж хүн хийсэн. Одоо хоёулаа Улаанбаатар хотод гэр бүл болж өнөр өтгөн амьдардаг. Өөрийн ганц хүү Увс аймгийн төв дээр эхнэр 4-н хүүхдийн хамт амьдардаг. Хувиараа ажил эрхэлдэг, гэрийн хүн нь цэргийн ангид ажилладаг. 3-н хүүхэд нь сургуулиар хүмүүждэг. 2 ач маань Улаанбаатар хотод байдаг. Бусад дүү нар ихэнх нь хотод амьдарч байна. Төрсөн дүү Увс аймагт амьдардаг.

Х: Та хэзээ тэтгэвэртээ гарсан бэ?

Ц: 2013 онд чөлөөндөө гарсан. Чөлөөндөө гарснаас хойш багийн эмч, бариа заслийн эмч хийсэн. 1988 оноос эхлэн 28,9 н жил эх баригчийн ажлыг хийсэн. 2008 онд 50 нас хүрээд, 1679 хүүхэд эх барьж авчихаад хийсэн ажлаа ард түмэндээ тайлагнаж гээд 1000 үрсийн баяр тэмдэглэсэн, түүнээс хойш одоо 2000 гаруй хүүхэд эх барьж авсан байна.

Х: Та Монголын соёл гэдгийг юу гэж ойлгодог вэ?

Ц: Би Монголын соёл гэдгийг Монголын өв уламжлал гэж ойлгодог. Монгол хүний өв, уламжлал, эцэг дээдсээс уламжилж ирсэн түүхийн өв уламжлалыг л Монголын соёл байх гэж ойлгодог.

Х: Өв уламжлал дотор юу, юу багтана гэж та бодож байна?

Ц: Энд бол жишээ нь зан заншил, өв соёлын түүх дурсгалын зүйлүүд байж болно, нутаг нутгийн зан заншил байна.

Х: Танай нутагт хадгалагдан үлдсэн ямар, ямар онцлог зан заншил байна вэ?

Ц: Манай сумын гол онцлог бол аймагтаа алдартай, түмэн тэмээтэй. 1973, 1989, 2020 буюу гурван удаа түмэн тэмээний баяр хийсэн. 10 мянгаас дээш түмэн тэмээтэй болж баяр хийсэн нь манай сумын жинхэнэ өв соёл гэж би боддог. За тэгээд хүмүүсийн нутаг нутагтаа яс үндсээрээ хийж байгаа хувцас хунар бол бид нарын өв соёл.

Х: Танай суманд ямар хувцас хэрэглэл өмсдөг вэ?

Ц: Манай суманд бол голдуу Дөрвөд, Халх, хүмүүс байдаг. Дөрвөд хувцас гээд гоё цэгдэгтэй хувцас байдаг. Халх хувцас гэж манайхан тоорцог дээлээрээ л гоёдог доо. Дөрвөд хувцас бол их тусгай гоё. Цэгдэг гэж байдаг. Тэр их гоё харагддаг, малгайтай.

Х: Цэгдэг гэдэг нь яг юуг нь хэлж байна вэ?

Ц: Миний ойлгосноор бол Дөрвөд дээлийг нь л цэгдэг гэдэг. Дөрвөд хүмүүсийн өөрсдийнх нь нэрлэдгээр цэгдэг. Халх хүмүүс нь энд зүгээр Монгол дээлээ өмсдөг. Монгол дээлээс чимэглэлээрээ ялгардаг. Сумын төвийн тал нь Халх. Айраг нуур, Хармагт баг хоёр тэр чигээрээ Халх, ганцхан Хяргас нуур баг, Дөрөвдүгээр баг хоёрын 50% нь Дөрвөд бусад нь дандаа Халх голдуу улсууд байдаг юм.

Х: Та сая өв уламжлалын жишээн дээр тэмээний соёлыг дурдсан, түүнийхээ талаар дэлгэрүүлэн ярьж өгөөч?

Ц: Өө, тэр ботготой ингэний дуу, ботгоо хөхүүлж байгаа байдал, тэмээ сайхан тэшиж явж байгаа мөн тэмээ бол их усч, тусч, усанд их сайн амьтан, тэр их уснаас, хүнийг ямар ч байсан авраад гарч чаддаг. Тэмээ тэшинэ гэдэг нь мориор бол хатирч байна гэсэн үг. Би өөрөө тийм хөдөлмөр хийж явж байсан учраас маш сайн мэддэг. Сайхан тэмээ унаад усан дундуур явахад чинь 1980 аад оны үед намайг хөдөө багийн эмчээр ажиллаж байх үед манай энэ Завхан гол маш их олон салаатай, их гүнзгий байдаг байсан. Ялангуяа хавар 4, 5 сарын үед бүхэл бүтэн 2 баг 14 хоног усанд хаагддаг. Тэр үед бид тэмээгээр гардаг. Одоо техник хөгжчихсөн учраас уналга ачилга бага хэрэглэдэг болчихож. Яг тэр үед бид уналга ачлаганд тэмээгээ л хэрэглэдэг. Аймшигтай хэрнээ яг тэр усаар ороод гарч байхад ер нь л гоё. Олон сайхан ээжүүдийг тэмээгээр очиж төрүүлж байсан. Малчид гэрээ, хүүхдээ ачаад л усаар хөвүүлээд гарна. Би бол тэмээгээр их олон хүний амь аварч байсан. 1992 онд техник хэрэгсэл маш их ховор байсан үе. Тэр үед малчид тэмээгээр тэмээнийхээ ноос, ноолуураа ачиж ирж энд худалдаа бэлтгэлийн анги гэж байсан түүнд тушааж өгдөг байлаа. Түүнийгээ тэмээгээрээ сайхан ачиж барина. Машин байхгүй учраас эндээс тэр баг руу тойроод бүтэн 360-370 км явж очиж байж нэг эх дээр хүрдэг, тийм хол байхгүй юу. Нэг ёсондоо бид нар Хяргас нуурыг бүтэн тойроод (эндээс гараад нар гарах зүгт очиж) байж бид нэг эхдээ очиж тусламж үзүүлдэг. Эндээс гараад шууд тэмээгээр ноос ачиж байсан хүмүүсийн тэмээг нь гуйж гурван эх авчирч (урд өдөр нь би усаар явж туулж 3 н айлд очиж эхээ бэлдүүлчихээд) өглөө таван цагаас эхлээд гурван эхээ нөхрүүдтэй нь аваад энд авчирч төрүүлж билээ. Тэгээд явж байвал нэг тэмээ нь лайванд (шавар) шигдээд эхээ ус руу унагаахгүй гэж авч байлаа. 2018 онд манай зуун тэмээгээр Сангийн далайгаас давс ачаад Увс аймгийн төв рүү (176 км газар) жин тээж ороод, эргээд тэр тэмээгээрээ тэжээл ачаад баг багаас хүмүүс нийлээд 20-иод хүн явж ирж билээ. Тэр бол хоёр жилийн өмнө болсон түмэн тэмээний баярыг угтаж хийсэн компанит ажил байсан.

Х: Танай суманд тэмээтэй холбоотой ямар баяр хийдэг вэ?

Ц: Манайх хавар болгон “Тэмээний баяр” хийдэг, ковидтой учраас сүүлийн хоёр жил хийгээгүй. 2015 оноос эхэлж тэмээний баяр зохион байгуулж хийж ирсэн, тэрнээс хойш өв уламжлал болоод жил болгон хавар 3 сард хийдэг юм. Тэмээний баяраар баг багийн хүмүүс жагсаал хийнэ. Одоогоос гурван жилийн өмнө хийсэн тэмээний баярт Тувагаас хүртэл хүмүүс ирж байсан. Гадаад хүмүүс ирж зураг хөрөг авч, болж байгаа үйл явдлыг бүгдийг нь үздэг. Тэмээ уралдах, гоё ганган хос гэж шалгаруулах, дээрээс нь тэмээний буйл, ачаатай тэмээ цаг харж уралдах, аль баг нь түрүүлж ачаагаа ачааллаж байна гэдгийг шалгаруулах, эмэгтэй хүмүүсээр олс дээс томуулах, ногт хийлгэх зэрэг арга хэмжээнүүд болдог.

Х: Буйл гэж юуг нь хэлж байна вэ?

Ц: Тэмээгээ буйллах, ацтай модоор тэмээний хамрыг хатгаад, бурантаг хийгээд, тэр бурантагнаасаа толгой гаргаад, түүнээсээ буйл гаргаад хэвтүүлж байгаад бордуулж босгодог. Буйлаа ацтай харганаар хийдэг. Буйлыг харгана аваад л зороод хийчихнэ.

Х: Тэмээний ноосоор юу, юу хийдэг вэ?

Ц: Мөн олс дээс, гэрийн бүслүүр, оосор, бүч бүгдийг нь хийнэ. Тэмээний зогдороор утас хийнэ. Утсаараа гэрийн эсгий, дээвэр, туурга оёдог. За тэгээд зээг хийж болно. Унины сагаг гэж байдаг тэрийг, ер нь монгол гэрт юу ордог тэр бүгдийг тэмээний ноосоор оролцуулж хийнэ. Зээг гэдэг нь зөв алгадаж, буруу алгадаж хийдэг, дээвэр туурган дээр хосолж барьж хийдэг, оосрыг хэлдэг. Тэмээний ноосоо сайхан угаагаад, угаасан ноосоо сайхан сэмлэж байгаад түүдэг гэдэг юм хийгээд алгадна даа. Алгадаад урт нарийн эсгийн дээрээ тавьж гэрийн туурга дээвэр, өрх бүгдийг нь зээглэж өгдөг. Тэгээд Монгол гэрийн сайхан дээвэр туурга, өрх гэдэг юм болдог. Бас хаяавчаа ширж хийнэ. Тэмээний ноосоор утас хийгээд хаяавчаа ширж (хээ угалз гаргаж) өгнө. Тэмээний ноосноос гадна тэмээний сүүгээр манайд айраг хийнэ, айргаа исгээд аарц хийж болно, ааруул, шимийн архи гарч болно. Ер нь л малаас ямар ашиг шим гарах уу тэр бүгд тэмээнээс яг л тэр хэмжээий бүх ашиг шим гарна. Тэмээнээс гадна манай суманд таван хошуу мал өсгөж байна.

Х: Нүүдлийн соёлоос хамгийн чухал нь таны бодлоор юу вэ?

Ц: Миний бодлоор малчид Монгол өв заншлаараа байх л чухал. Одоо техник нь их хөгжөөд тэмээгээр нүүдэг айл цөөхөн байна. Ер нь уналга, ачлаганд хэрэглэх, морио унах их ховордож байна. Өв соёл гэдэг чинь таван хошуу малаа ашиглах л байхгүй юу.

Тэмээг уналга ачлаганд нь бүрэн эдлэх, эмнэг хангал морийг нь сургах, гүүгээ саах, саалиа авах, бог малаа саах, ноос үс ноолуурыг нь авч ашиг шимийг нь хэрэглэх тэр өвөг дээдсээс уламжилж ирсэн өв соёл дагаж тэр нүүдлийн өв соёлыг ашиглаж явах л хамгийн чухал. Би л бол энэ монгол нүүдэлчин хүний энэ өв соёлыг хэзээ ч мартаггүй.

Х: Одоо ер нь танай энд тэмээгээр нүүж байгаа газар байна уу?

Ц: Ер нь цөөхөн. Энэ Хяргас нуурын арын ганц хоёр айл тэмээгээр нүүж байна. За бусад нь тэгээд машинаар л нүүж байна. Айл болгон бараг нэг ачааны машин, суудлын машин, нэг мотоциклтой, ийм л болчихсон. Бид нарын үеийн морио унаад, тэмээгээ унаад явж байсан ер нь л ховор болсон. Одоо голоо бирваазаар гарч ирж байна. Одоо гол бол багассан. Эндээс “Хэцүү хад” гэдэг газар руу очиход 24 км яваад бирваазаар гарна. Энэ Хармагт баг цаашаа 80 км яваад гүүрээр гарна, тэрнээс наагуур жижиг завиар гардаг. Манай сум МАА-н гурван багтай (Айраг нуур, Хармагт, Хяргас нуур) тэгээд энэ сумын төвийг Шар булаг гэдэг ингээд дөрвөн багтай.

Х: Одоо тэмээгээ юунд ашиглаж байна вэ?

Ц: Сүү сааль авч байна, уналга ачлага, ботгоо сургаж байна, ингээ сааж сургаж байна, ингэнийхээ сүү айраг, мөн өвөл болохоор хүнсэнд хэрэглэж байна. Ботгоо намар, хавар, төрснийх нь дараа түр бариад сургана, ямар ч байсан хүн ойртоход айхааргүй болгоно. Зун ингэний сааль сүү гэж хийдэггүй, намар ботгоо бариад саалиа эхэлдэг. Ботгоо уяж хоцроод, эхийг нь явуулаад, орой нь бариад, эхийг нь саана.

Х: Таны бодлоор монголын соёл, нүүдлийн соёл тусдаа ойлголт уу?

Ц: Монголын соёл дотроо, нүүдлийн соёл орох байх гэж бодож байна. Гэхдээ арай жаахан ялгаатай. Нүүдлийн соёл гэдэг нь жинхэнэ МАА дээрээ голлодог болов уу гэж бодож байна. Монголын соёл гэхээр нөгөө өв уламжлал, нутаг нутгийн зан заншил энэ бүгд орох байх гэж бодож байна.

Х: Танай нутгийн онцлог зан заншил юу вэ?

Ц: Манай нутгийхан их зочломтгой, хүнийг их дайлж цайлдаг. Би яагаад зочломтгой гэсэн бэ гэхээр энэ зах зээлийн нийгэм эхэлсэн цагаас хойш тухайн нийгмийнхээ хөгжлийг дагаад явж байгаа зан заншил ёс суртахуун юм л даа. Гэхдээ тэр дотроо манай Увс аймаг бол Монгол соёлын зочломтгой зангаараа арай илүү юм уу гэж бусад газар явж байхад харагддаг. Манай нутагт суль, сулхир гэж юм гардаг. Манай нутгийн

хамгийн идээний дээд ногоон цай гэж юм хийж өгдөг юм аа. Тэр манай зочломтгой хүндээ барих хүндэтгэлийн цай болж өгдөг.

Х: Ногоон цайгаа хэрхэн хийдэг вэ?

Ц: Суль, сулхир гэдэг өвсийг түүж авна. Жил болгон ургахгүй, ховор ургадаг. Хур бороо их орсон байвал намар 8 сараас эхлээд 10 сарын хооронд элсэнд ургадаг. Тэгээд л тэр хооронд 10 сараас эхлээд түүж эхэлнэ. Элсний томхон ширхэг шиг тиймэрхүү бор, шар өнгөтэй юм байдаг, сагсгар ургадаг. Том дэвсгэр дээр бухал шиг болгож бөөгнүүлээд тэрнийгээ цохино. Тэгээд тэрнийгээ уутанд хийж авна. Хогийг нь цэвэрлэнэ, элсийг нь цэвэрлэж угаагаад, хатааж байгаад хуураад, тээрэмдээд гурил болгоно. Дутуу тээрэмдэх юм уу, тариа шиг нүдээд ногоон цай гэдэг юм чанадаг. Тэрүүгээрээрээ цай чанаж гаргаад жаахан сүүл хийж жаахан хуурч байгаад, сайхан бургилуулж байгаад, 15-20 минут чанана. Бүр сайхан гоё амттай хийцтэй цай хийнэ гэвэл, сүүл дээр нь хийнэ. Ногоон цай гэдгийн учир нь сүлэх тусам ногоон өнгөтэй болдог. Шингэн цай хийвэл шар ногоон өтгөн цай хийвэл хар ногоон цай болно доо. Манай нутгийн ганц брэнд гэж ярьдаг. Суль гэдэг нь болохоор зүгээр нэг хар өвсийг яг тэгж түүж аваад цэвэрлээд л тэгээд сайхан хуурна, тэгээд тээрэмдээд хар саарал өнгийн сулины гурил гэж болно. Тэрийгээ бол тарианы гурил шиг зүгээр л зуураад иднэ. Гэдэс нь гүйлгэсэн хүүхдэд их сайн. Бас ингэний хоормогоор их дайлна. Ер нь бүх үед л ингэний хоормогоор зочилно доо. Хавар 4 сараас 8 сар хүртэл бас өвөл, намар ингээ барина. Айраг нуур баг бол жинхэнэ тэмээтэй газар. Тэмээ чинь хүйтэнд их тэсвэртэй, нэг их хашаа хороо барина гэж байхгүй.

Х: Тэмээгээ хэрхэн яаж малладаг вэ?

Ц: Одоо зуны цагт бол зүгээр л ноосыг нь аваад л нүцгэлээд тавиад явуулна. 7, 8 сараас эхлээд бөөнд нь цуглуулаад, бүртгээд намар л цуглуулна. Байнгын бог мал шиг хариулга гэж байхгүй.

Х: Та монгол зан заншлын талаар дэлгэрэнгүй ярьж өгөөч?

Ц: Монгол зан заншил хүндлэх, мэндлэхээс эхэлнэ. Ахмад хүнийг нэрээр нь дууддаггүй. Аюуш гэдэг хүн байсан бол А багш гэх мэт дандаа тэгж хэлнэ. Одооны хүүхдүүд шиг шууд нэрээр нь хэлчихгүй. Ер нь настай хүмүүсээс нэлээн холуур явдаг. Настай хүн гэрт ороод ирэхлээр, “хүүхэд том хүний үг сонсож болохгүй, миний хүүхдүүд” гээд л гадаа гэр тойроод л байж байдаг байсан. Монгол ёс заншил бол их зочломтгой. Ахмад настан, аав ээжээ хүндлэхээс эхэлнэ. Цайг дандаа хоёр гараараа өгнө. Би бол энийг яг монгол өв

уламжлал гэж боддог. Бид нарын ээж аавууд үс ерөөсөө задгай тавиулдаггүй, дандаа сүлждэг юм уу, хоёр боодог. Гэрт орж ирэхэд нөмгөн байдаггүй. Заавал бүс бүсэлдэг. Гудманд нөмгөн явдаггүй. Бага байхад бид нар нээх урт дээл өмсдөг байсан. Дан дээл, үстэй дээл, хөвөнтэй дээл өмсдөг байсан.

Х: Таны аав ээж “эрхэмлэж яваарай” гэж захисан зүйл бий юу?

Ц: Байлгүй яахав. Өвөг дээдэс, ахмад үеэ, хамаатан саднаа сайхан хүндэлж яваарай, мэндтэй устай яваарай, зөв зантай, зөөлөн сэтгэлтэй байгаарай, битгий хүнтэй хэрэлдээрэй, зөв харилцаатай байгаарай гэдэг байлаа. “Чи зөв зантай, зөөлөн сэтгэлтэй явбал чиний үйлс бүтнэ” гэдэг байсан.

Х: Та эхээс хэдүүлээ вэ?

Ц: Би эхээс зургуулаа байсан. Хар багаасаа эцэг эхээс өнчин хоцорсон. 5-р ангид байхад ээж минь өнгөрч билээ. Би 12 настай үлдэж байлаа. Манай аав тэр үед агент байсан. Малчин ард байж байгаад хүүхдүүдээ сургуульд оруулах гэж төв рүү (Завхан сум) орж ирсэн. Тэр үед хүүхдэд ер нь нэг их юм хэлддэггүй байсан. Одоо энэ нийгмийн сайхан юм нь бүх юм нээлттэй, ах дүү, ургийн холбоо гэдэг юмаа бүгдийг нь мэдэж авах боломжтой болсон. Биднийг бага байхад хэлж байгаагүй, залуу байсан болохоор бид нар ч мэдэх гэж хичээж байгаагүй. Тэрийг одоо л тэтгэвэрт гараад мэдэх гэж хичээж байна. “Ах дүү нартайгаа холбоотой яваарай, хоорондоо эвтэй найртай, нэгнийгээ хүндэлж бай, ялангуяа ахмад хүмүүсээ их сайн хүндэлж байгаарай, хөдөлмөр сайн хий” гэж их захидаг байсан. Манай аав “хөдөлж байж ам хөдөлдөг шүү” гэж их хэлдэг байлаа.

Х: Та Монгол хүнийхээ хувьд Монголынхоо юугаар хамгийн их бахархдаг вэ?

Ц: Монгол үндэсний хувцас хамгийн гоё. Яг нутаг нутгийн заншлийн хувцас их гоё. Тэгээд Монгол зан заншил, хүндэлж мэндлэхээс эхлээд, Монгол хүн чинь их зочломтгой шүү дээ. Бас мал аж хуй гэж мундаг гоё юм байна. Монгол нутгийг би хамгийн их амар амгалан газар гэж боддог. Сайхан цаг уур, уудам сайхан нутаг дэвсгэртэй, сайхан байгаль, нуур устай, ер нь Монголын нутаг дэвсгэр их сайхан. Энэ бүгд бол манай Монголын жинхэнэ бахархал мөн юм гэж боддог.

Х: Хүмүүс Монголоо алдсан гэж ярьдаг, тэрийг та юу гэж ойлгодог вэ?

Ц: Манайхан дэлхий нийтийн сайхан соёлыг бол авалгүй яахав, авах нь зөв, гэхдээ л монгол өв соёлыг хаяад хэтэрхий барууны орнуудыг дагах нь буруу. Монгол ёс заншил

бол алдагдаж байна. Адгийн наад зах нь ажиглаж байхад бид нар “аав, ээж харчих вий” гээд эрэгтэй хүүхдээс холуур тойрч гардаг байлаа. Энэ мэтээс хараад байхад манай Монгол ёс жаахан алдагдаж байгаа. Дор хаяж л гэр бүл салалт гэдэг юм маш ихсэж байна. Дээр үед бол том хүний үгэнд хүүхэд оролцдоггүй байсан болохоор мэдэгдэггүй байсан. Одооны залуучуудыг Монгол ёс төр, өв уламжлалаа л битгий алдаасай, илүү дээдэлж яваасай гэж хүсч байна.

Х: За танд их баярлалаа.

Ц: Баярлалаа.

2. Увс аймгийн Завхан сум, Б.Янжив, 80 настай

Х: Сайн байна уу, та надад өөрийгөө танилцуулна уу?

Я: 1942 онд Шарбулаг гэдэг газар төрсөн. Ургийн овог Бөхнүүд. Бөхнүүдийн Бадрахын Янжив. Залуудаа би багийн дарга, тоо бүртгэгч, нярав, багийн тоо бүртгэгчээр ажиллаж байсан. Багаасаа мал маллаж байсан. 1990 оноос хойш завсаргүй мал малласан. Тэмээ, адуу байсан, голчилж бог мал малласан. Манайх 9-н хүүхэдтэй, 7-н эрэгтэй, 2 эмэгтэй. Манайд 4-н малчин хүүхэд байна. 2 нь аймгийн аварга, нэг нь сумын аварга малчин, 2 нь төв дээр ажилтай, Японд нэг нь, Суданд нэг нь, хотод нэг нь амьдарч байна.

Х: Та Монголын соёл гэдгийг юу гэж ойлгодог вэ?

Я: Монголын соёл бол дэлхий дээр байхгүй сайхан соёл. Дээр үеэс уламжлагдаж ирсэн соёл гэдэг бол манай ард түмнийг сайн сайхан авч явахад зориулагдсан ийм соёл.

Х: Та Монголын соёлд юу, юу орно гэж бодож байна?

Я: Монголын соёл бол дээр үеэс уламжилж ирсэн хувцас хунараас авхуулаад зан заншил ордог байх даа. Хүнтэй харьцахдаа ах их хүмүүсийг хүндэлдэг, зөв сайхан боловсон харьцаатай, хувцас хунараа зөв сайхан өмссөн байх монгол хүний соёл юм даа.

Х: Нүүдлийн соёлын хамгийн чухал зүйл таны бодлоор юу вэ?

Я: Нүүдлийн соёл бол дээр үеэсээ Монголын ард түмэнд улмжлагдаж ирсэн. Манайх хэтээсээ нүүдэлчин айл. Хяргас нуурыг тойрч нүүдэг, өвлийн цагт бол Ховдын Мянгад, Дөргөн, Завхан аймгийн Ургамал, Дөрвөлжин сумаар нүүдэллэж ирсэн. Нүүдлийн соёл бол мал хар тарга тэвээрэг авахад их тустай, нэг газар байгаад байвал тал их сэргэмж муутай.

Х: Та надад мал маллах арга ухаанаасаа ярьж өгөөч?

Я: Мал маллах арга ухаан бол зуны цагт бол өглөө 4, 5 цагт бэлчээх, ус бэлчээрийн соргогт хариулах, тэгвэл тарга тэвээрэг сайжирч, малаа онд тарган оруулах, гарсан төл нь уураг сүүндээ цатгалан байвал өсч торнихдоо бие бялдарт их нөлөөтэй, хавар эрт цагт малыг тарга хүчтэй төллүүлэх бол өсөлт хөгжилтөнд их сайн.

Х: Бэлчээрийг хэрхэн сонгох вэ?

Я: Бэлчээрийг хуваарьтай сонгоно оо. Хувиартай сонгохдоо нэг газар их олон хоног байх биш. Ер нь цөөх, цөөхөн хоногоор сэлгэж бэлчээж байвал малын тарга тэвээрэгт их сайн нөлөөтэй л дөө.

Х: Таны хувьд мал маллахын хамгийн сайхан зүйл юу вэ?

Я: Хээр бэлчээрт гараад л малаа хариулаад л сайхан өвстэй уужим бэлчээр, устай газар малаа бэлчээчихээд л, дуран бариад л нааш цааш харж байхад, өөр малчин хүний жаргал байдаггүй юм даа. Мал маллах ер нь сайхан. Мал маллах хүний амьдралд их нөлөөтэй, сайн. Гол нөлөөлдөг юм бол нутаг ус бэлчээр байдаг, тэрнийхээ дагуу малчин хүний амьдрал сайжирдаг.

Х: Танай нутгийн бэлчээрийн онцлог юу вэ?

Я: Одоо Хяргас нуур байна. Хяргас нуур бол 4 төрлийн малд их зохимжтой, сайн. Малыг арьсны янз бүрийн шарх, сорви, ангижруулдаг. Өвс ургамал их амтлаг олон төрлийн ургамалтай. Одоо сүүлийн үед тэр олон төрөл нь багасаад цөөхөн болж байна. Газар нутаг цөлжөөд, хуурайшаад, хур бороо тасраад, гэхдээ яахав өвс ургамал гарахаараа манай энд мал сайхан тарга тэвээрэг авдаг, хужир устай ийм нутаг.

Х: Ямар, ямар өвс ургамал ургадаг вэ?

Я: Өө, шарилж, таана, хөмөл, бударгана, хужирлаг өвс бол малд их сайн. Одоо ургаж л байгаа боловч таана, хөмөл, шарилж хэтээсээ багасаад байна. Энэ юунаас болж байна гэхээр хур бороо орохгүй цөлжилт үүссэнээс л болж байна.

Х: Та Монгол хүний хувьд Монголынхоо юугаар бахархдаг вэ?

Я: Би өөрийгөө болон нутгийнхаа ард түмнийг Монголдоо төрсөндөө их сайхан хувь заяатай ард түмэн л гэж боддог. Аз жаргалтай, амар тайван, өвчин зовлонгүй ийм л нутаг л даа.

Х: Танайд сүүлийн үед тулгамдаж байгаа ямар асуудал байна?

Я: Сүүлийн үед нутаг бэлчээр их хавчигдаж байна. Дуртай газраа бууж болдоггүй, нэг газраа байж болдоггүй, хур бороо ороод нутаг дэлгэрээд байвал хаа ч байсан болохоор л байна. Байгалийн энэ бэрхшээлээс болоод хүн амьтны сэтгэл бурангуй, мал хар тарга тэвээрэг муутай, ер нь их давжаарч байна. Хүн нь ч хаашаа яаж нүүх, малаа яаж оторлох, тэр тал дээр их мухардал байна.

З: Сүүлийн үед Хяргас нуурын энэ хавиар аялал жуулчлал их хөгжиж байна, энэ давуу тал уу, сул тал уу?

Я: Энэ аль аль талдаа ашигтай тал ч байна, муу тал ч байна. Хяргас нуурыг тойроод аялал жуулчлал их хөгжиж байна. Одоо ингээд Хяргас нуурын хөвөөгөөр явж байхад дандаа гялгар цаас, уут шуудай, хаймар их гарсан байна. Лааз шил замбараагүй, хог их тарьж байна.

З: Сүүлийн үед Баруун аймгаас зүүн чиг рүү хүмүүс их нүүж байна, танай сумын хувьд хэр их хүмүүс нүүж байна, нүүх болсон шалтгаан таны бодлоор юу вэ?

Я: Манай сум нэг үе нэлээн их явсан. Зах зээл, соёлд сургана гээд их явсан. Ойрын 2, 3-н жил ер нь яваагүй. Ганц нэг хүн харин буцаж ирээд байна. Тийм л байна.

Х: Таны өвөө, эмээ юм уу аав, ээж “эрхэмлэж яваарай” гэж захисан зүйл бий юу?

Я: Өө тийм зүйл байгаа. Малыг л их сайн маллаж яваарай. Мал сайн өнгөтэй, өөдтэй маллаж явбал олон түмэндээ нүүр бардам сайхан байдаг юм. Манай аав малыг сайн маллаж яваарай л гэж хэлдэг байсан юм даа. Бадрах гэж Улсын сайн малчин хүн байсан юм. Тэгээд одоо манай 2 хүү аймгийн аварга малчин, нэг хүү сумын аварга малчин, өөр нэг хүү бас малчин, ийм дөрвөн хүү байна. Газар нутгаараа би их бахархдаг. Манай Монголын газар нутаг их уужим, тэнүүн.

З: Одоо мал маллах залуучууд их багасаж байна гэсэн, энэ тухай та яриач?

Я: Одоо мал маллах залуус багасаж байна аа. Гэхдээ яахав манай сумыхан малаас зугтаад байх нь гайгүй. Гэхдээ хот орон явах хүмүүс нь явж л байна. Малаа маллах нь маллаж л байна. Гэхдээ дээр үеийхэн шиг малыг сайхан маллаж чадахгүй л байна. Бас хөнгөн шингэн морь тэмээгээр хариулдаг байснаа болилоо, мотоцикл гээд л. Бидний үед чоно нохой ч элбэг байлаа, өдөржин л малаа эргүүлнэ. Өглөө цай уугаад л гарна тэгээд оройдоо л ирдэг байлаа. Мал сайхан тарга тэвээрэг авдаг байлаа. Одоогийн мал бас тарга

тэвээрэг авах нь тааруу болсон байна. Бог, бодгүй малын бие бялдар их давжаарч байна. Тэр байгаль цаг уурын нөхцөлтэй л холбоотой байх.

II: Малчид ямаа их өсгөж байна уу?

Я: Их өсгөж байна. Би бол хэтээсээ ямаанд дургүй, ер нь ямааг 100-аас дээш нь гаргадаггүй, хонь голдуу өсгөдөг байлаа. 70 нас хүрээд сумын төвд орж ирээд 10 гаруй жил боллоо. Залуучууд ямаа өсгөж л байна. Аргагүй юм даа, ноос ноолуур нь жаахан үнэтэй учраас. Би болохоор “ямаагаа бага өсгө, өвлийн зуд турхан даадаггүй. Ямаа их муу байдаг юм” гэдэг. “Болохгүй байна аа, амьдрал хүрэхгүй байна аа” гэж залуучууд хэлж байна. Арга ч үгүй юм даа жаахан ноолуур нь үнэтэй учраас ямаа өсгөж байна.

X: Монголоо алдсан гэж хүмүүс ярьдаг, ямар хүмүүсийг та Монголоо алдсан гэж хардаг вэ?

Я: Сүүлийн үед залуучууд архи дарс уугаад л, хэрэг төвөгт холбогдоод л янз янзын юм болоод байна л даа. Мотоцикл машинтай яваад, хөл гараа гэмтээж байна. Дээр үед бол тийм юм байгаагүй шүү дээ. Том ах хүнээс айдаг, үг дугардаггүй тийм байсан. Одоо ерөөсөө хүүхдийн хүмүүжил бидний сэтгэлд таарахгүй байна. Хүүхдийн эрх, хүний эрх гэж гараад ирсэн тэрнээсээ болж хүүхэд хүмүүжил муутай боллоо гэж би дотроо боддог.

З: Хүүхдүүдийн харилцаа их өөрчлөгдөв үү?

Я: Харин тийм. Дээр үед бол хүүхдүүд хүний урдуур явдаггүй байсан шүү дээ. Бид нар хүмүүсийн урдуур хүүхдийг явахад “цаашаа бай” гээд л хэлвэл асуудалд орох гээд л байна шүү.

З: Нийгэм солигдсоноос хойш Монгол хүнд үлдээд байгаа эрхэм зан чанар нь юу байна, энийгээ л орхихгүй юмсан гэж боддог зүйл бий юу? (зан суртахуун ч юм уу, дадал ч юм уу)

Я: Харин тэр зан суртахууныг л хадгалж үлдэх хэрэгтэй л дээ. Ойлгохгүй байна аа. Бид нар хэлээд л байх юм, хийгээд л байх юм. Хэлээд байхад ерөөсөө ойлгохгүй юм. Одоо хүүхдүүд утасны хоббитой болсон байна. Энэ утас гэдэг юм, тоглоом гэдэг юмыг нь болдогсон бол устачихмаар л байх юм. Хүүхдүүд утсанд донтоно гэдэг юм нь болж байна аа.

З: Танай сумын хүмүүс бусад сумдуудаас онцгой сонин чадвар байна уу? (Говь нутаг болоод тэр үү, онцгой сонин байрлал, сэтгэлгээ, зан байдал, царай төрхийнхөө хувьд таны анзаарснаар)

Я: Одоо ер нь тэр сумуудаас ялгараад байх юм би мэдэхгүй байна. Гэхдээ манай нутаг бол элс шороо ихтэй, хүн явж алхахад жаахан төвөгтэй. Гэхдээ ойрын хэдэн жил салхи шуурга их болсноос болж байгаа юм байлгүй манай сум их элстэй байсан, одоо сайр болж гүйцлээ. Дээр үед манайхан чинь дандаа зүтгэж, өгсөж явдаг байсан. Тэр нь гайгүй болчихоод байна. Элс шороо гэдэг юм их нүүлээ, алга боллоо.

П: Энэ нутгийн улс хаашаа нүүсэн байх вэ?

Я: Манайх чинь Завхан сумын 3-р баг, бусад 2 баг нь нүүдэл багатай, өвөлдөө отор хийнэ, манай баг бол 4-н улиралд дандаа нүүж явдаг. Өвөл болохоор энд өвөлжөө байдаггүй. Ховд, Мянгад, Завхан, Дөрвөлжин гээд л нүүгээд өвөлжинө. Энэ Увсын Цагаанхайрхан нутаг руу бас гарна. Өнөө жилийн хувьд ургамал өвс гараагүй болохоор яахыг мэдэхгүй л байна. Болдогсон бол энэ их салхи шороог зогсоогоод хур бороо оруулаад өг л гэж хэлмээр байна.

З: Өөр суманд очиход хоорондоо бэлчээрийн асуудал гарах уу?

Я: Гарна аа. Хоёр малчин хоорондоо эв зүйгээ олж л хэд гурав хонохыг бодохоос биш сум орон яваад нэг хэлэлцээр хийдэг, тэр малчид нь тэднийг авч хэлэлцдэгч үгүй. Хоёр малчин хоорондоо л зохицоод аргаар, хэд гурав хонохыг бодохоос өөр арга байхгүй. Одоо газар болгонд бэлчээр нь хомсдоод мал нь өсөөд байна.

З: Мал өсөхөөр малчин болоод тэр хүмүүсийн харилцаа өөрчлөгдөж байна уу?

Я: Өөрчлөгдөж байна шүү. Мянган малтай нүүгээд очихоор хүлээж авахад хэцүү л байна шүү дээ. 300-400 байсан бол гайгүй л харьцана шүү дээ.

П: Одоо цаашдаа ер нь Монгол залуучууд малыг хэр олон жил маллаж чадах бол эсвэл нутаг бэлчээргүйгээс болоод малаасаа уйдах юм уу, малаа маллахаа болих юм болов уу гэж та боддог уу?

Я: Тийм ээ би бодож байна. 30-40 жилийн дараа ер нь үр хүүхдүүд малаа яаж малладаг бол, ямар унаатай явдаг бол гэсэн юм бодогдоод байна. Дээр үеийнх шиг юм ер нь алга болоод байна. Монгол тэр аяараа 30-40 жилийн дараа ямархуу байдаг юм бол гэсэн юм бодогдоод л байна. Би дээр үед багийнхаа тэмээ, адуу бүх малыг мэддэг, таньдаг байлаа.

Одоо бараг тэмээгээ танихгүй шахуу л байна. Хавар нэг ноосыг нь авдаг, зун нь бэлчээрээр явдаг, хааяа нэг мотоцикл, машинаар эргэж тойрдог.

З: Тэмээний уналга, ачлага, эдэлгээ, хэрэглээ багассан уу?

Я: Ер нь байхгүй боллоо. Дандаа бид нар тэмээгээр нүүдэг байсан. Одоо цөм машин боллоо. Тэмээ, адууны эдэлгээ ер нь байхгүй боллоо. Цөм хангал, эмнэг. Хүүхдүүдэд би хэллээ. Энэ хүүхдүүдэд 2, 2 морь 2, 2 тэмээ унаад мал маллуулж сургаж ав гэж хэллээ. Хүүхэд нь тэгээд л морь унаж чадахгүй. Мотоцикл унадаг юм байлгүй.

П: Морь унах, тэмээ унахад хүний биед сайн чанар байна уу?

Я: Байлгүй яахав. Морь, тэмээ унахад хүний бие чийрэгжинэ, сул дорой байхгүй шүү дээ. Морь туйлвал унахгүй, тэгж чийрэгжих ёстой байхгүй юу. Одоо хүүхдүүд их сул байна. 7, 8 хүрсэн хүүхэд морь унаж чадахгүй л байна шүү дээ. Уралдааны морь уядаг хүмүүс л хүүхдээ сургаж авч байна.

Х: Та морь уядаг байсан уу?

Я: Морь бараг уядаггүй. Сүүлийн үед яахав ганц нэгийг уяж байгаа. Тэгээд одоо морь хөгширлөө. Одоо 18 нас хүрсэн байна. Нэг нь мотоцикл аваад ирж байлаа.

П: Морь уяж байгаа байдал хэр их өөрчлөгдөж байна?

Я: Морийг их тэжээдэг боллоо. Эмчилгээ, тариа гэх мэт. Тэр зүүн аймгуудаас их хурд авдаг боллоо. Дээр үед дандаа бэлчээрийн өвсөөр уядаг байсан шүү дээ. Одоо тийм юмгүй боллоо. Янз болгоны юм хийж байна. Жаахан чадалтай чинээтэй хүмүүс хурдан морь унахаас, дорой буурай улс уях аргагүй болсон байна. Адууны удам угсаа сайжруулж байна гээд л энд тэндээс азарга, гүү авчирч байна. Миний бодлоор бол сайжрах биш улам муужирч байгаа юм уу гэж би боддог юм. Өвлийн хүйтэн, хавсарга, шороо даахгүй, нэг өдрийн уналга даахгүй шахуу л адуунууд ирж байна. Дээр үед бидний морьд хад чулуу шиг, унаад сар болдог байсан. Урд талаас ирсэн адуунууд унаад ганц өдөр болохгүй байна шүү дээ. Ул нь цоорчихдог. Тэр сайжрах биш муужирч л байна. Ул туурай нь ерөөсөө манай нутагт таардаггүй.

П: Цаг агаарыг та ямар, ямар шинжээр мэдэх вэ?

Я: Урьд мэдэгддэг байсан. Одоо мэдэгдэхээ больсон байна шүү дээ. Яасан нь мэдэгдэхгүй л шуурга шуурдаг, гэнэт халах, гэнэт хүйтрэх, ер нь хачин болсон байна. Урьд нь гэнэтийн юм болсон ч салхи шуурга болох нь мэдэгддэг байсан. Одоо бороо

орох юм уу гэж байтал гэнэт салхи шуураад л, салхи шуурах нь гэж байтал хэдэн бороо хаяад л өнгөрөх жишээний. Өнөө жил 3-4 хуруу чийг орохгүй байна. Манай энд 4 хуруунаас цаашаа чийг орж байж ногоо хөдөлдөг болохоос 1-3 хуруунд юу ч тоодоггүй юм. Ийм л юм байна.

П: 20-30 км малыг явган хариулдаг нь ямар ач тустай байсан юм бэ?

Я: Малдаа өвс идүүлэхийн тулд л тэгж явж байсан. Аажуу тааваар нь байлгахын тулд л. Малыг тааваар нь байлгаж хүнээс айж ичихгүйгээр сайхан тогтуухан байлгах л арга байхгүй юу. Өдөрт би 20-30 км явахад хөл, гар өвдөнө гэсэн юм байхгүй. Өөрөө би 6, 7 цагт бэлчээгээд орой 7-д л гэртээ орж ирж байгаа юм. Зун бол хязгаар байхгүй ээ. Орой ч ирнэ, эрт ч ирнэ. Малыг их тууж барих тарга тэвээрэгт их хортой, одоогийн улсууд малыг өдөртөө 20-30 км туугаад л ирж байна. Малыг тааваар нь явуулах л сайн.

П: Монголчууд малаас өөр эдийн засгийн ашиг олох арга байдаг гэж боддог уу?

Я: Байх хүндээ бол байгаа. Гэхдээ Монгол хүн бол ихэнх нь малаа л маллаж амьдрах ёстой. Малгүйгээр Монгол амьдрана гэж байхгүй байх гэж би бодож байна. Мал гэдэг чинь Монголын эдийн засагт их түлхэц болж байгаа юм.

Х: За, ярилцсанд их баярлалаа.

Я: Баярлалаа.

3. Увс аймаг Улаангом, Данзаны Гүнчин, 70 настай

Х: Сайн байна уу, та надад өөрийгөө танилцуулна уу?

Г: Ургийн овог Чангас, Данзаны Гүнчин гэдэг хүн байна. Би 1950 онд төрсөн. 1970-1990 он хүртэл мал малласан. Гэр бүлийн хүн өнгөрөөд арван хэдэн жил болж байна. 3-н хүүхэдтэй. Тус тусдаа гарсан. Нэг нь Эрдэнэтэд мал маллаж байна. 2 нь энд мал маллаж байна.

Х: Та голчлон ямар мал маллаж байсан бэ?

Г: Хонь, үхэр. Тэмээ ч байна, адуу ч маллаж байгаа улс байна.

Х: Та Монголын соёл гэдгийг юу гэж ойлгодог вэ?

Г: Одоо ингээд халиаж (харж) байхад их хэмжээгээр байшин бариад л байна. Гэхдээ би дал хүрсэн хүний хувьд харж байхад энэ бага талын улс соёл, харилцаа гэсэн юм их муу байна. Урд миний багад настай хүнээс их аймтгай, дарга нараас их аймтгай, их соёлтой

харилцдаг байсан. Дан чи, ми гэсэн болж үг асуудаг, бага талын хүүхдүүд хүн хүндэлдэггүй, тиймэрхүү болж гэж л би анзаарч боддог. Ичинэ, барина гэж юм мэддэггүй, ах захаа мэддэггүй тийм болж. Мануусыг арван хэдтэй байхад машин хурдлаад давхиад ирдэг гэрээ цэвэрлэнэ, хой (хонь) гаргадаг. Энэ захад хог гэдэг юм байдаггүй байсан. Урьд бид нүүхдээ “бууриа цэвэрлэ” гэж үргэлж хэлж байдаг, тэрийгээ цэвэрлээд шатаагаад хаяж байсан. Энэ орчин чинь ямар байлаа. 1990 оноос нааш айх хүн ч байхгүй болсон, энэ орчин гэж битүү хог болсон. Хог дотор л амьдарч байна шүү дээ.

Х: Өөр танай нутагт тулгамдаж байгаа эсвэл өөрчлөгдөж байгаа асуудал байна уу? (бэлчээр, мал)

Г: Одоо малтай улсууд малаа өсгөж байна гээд л малаа 2000-3000 гаргаад л бэлчээрийн даац гэдэг юмыг бялхаагаад хаячихсан. Тэгээд л дуртай газраа алт малтаад л харгай майргайг нь унагаагаад л. Энэ их харгай мод унагааснаас усгүй болж байна. Намайг багад хүнхэртэл гүйж байсан булаг ширгээд таг болчихоод байгаа. Ус гол багассан. Орчлон мөхлийн байдалд орчихоод байна шүү дээ. Энэ машинаар эргэдгийн наана их улаан харгана байсан. Чөдөртэй морь алга болоод би хэцүүдэж байж олж авч байсан. Одоо ширхэг ч харгана алга. Тэр чинь мөхөж байгаа байдал байхгүй юу.

Х: Танайд ямар, ямар өвс ургамал ургадаг вэ? Ургахаа больсон өвс ургамал бий юу?

Г: Манайд өвс бол их ургана. Агь таанаас эхлээд л хар толгойтой шуурай ч байж байх жишээний. Тагш гэж нэг их гашуун өвс байна, тэгээд шаралжийн шавгаас нь болоод их ургана.

Х: Та монгол хүнийхээ хувьд хадгалж үлдэхийг хүсдэг үнэт зүйл юу вэ?

Г: Харж байхад бага талын хүүхэд ах захаа хүндлэх тийм юм байхгүй болоод байна, тэр л их хоцрогдож байна. Одоо манай энэ нутагт Архины дуу гэж нэг юм байсан. Айлд ороод дуулахдаа нэг шимийн архиа аваад дуулна. Одоо дуулдаг хүн байхгүй. Би дуулж л байсан л даа. Одоо дуулдаг хүнгүй болохоор дуулахгүй болчихдог юм байна.

Х: Танай нутагт жишээ нь ямар дуу дуулдаг вэ? (найр, наадам, хурим г.м)

Г: Архины дуу гэж уртын дуу дуулдаг. Жишээ нь “Арван гурван шарга” гэж нэгээс аваад арван гурван шарга байлаа. Тэрнийг дуулж байлаа. “Арван гурван хээр” гэж дуулж байлаа. “Арван гурван шил” гэж дуулж байлаа. Тэгээд “есөн зээрд таван хар” гээд л энэ

чинь өнгө ялгаж дуулна. Арван гурван шил гэдгийн заримыг би мэдэхгүй. “Өндөр заагийн шил”, “Ар хүрэнгийн шил”, “Алтай зээрийн шил” гэх мэт шилнүүдийг дуулдаг байсан. Одоо эднийг дуулдаг хүн байхгүй шүү, хоцрогдсон. Энэ дуунуудыг найран дээр дуулахдаа баруун хааяанд эрэгтэйчүүд суугаад, зүүн хаяанд эмэгтэйчүүд суугаад, ая өгнө гэж юм хэлнэ, эндээс ая өгч дуулна, нэг шаргыг би авсан бол тэрийгээ хүлээж аваад дуулаад 2 талын хаяа аваад дуулчихаад, баруун талын хаяандаа эндээс ая өгнө. Тэгэхээр нь цаанаас нь хүлээж аваад дуулчихаад ахиад нэг шаргаа тэндээс авна. Одоо тэр баруун зүүн хаяаны ая гэж юм байхгүй. Урьд манай бригадын дарга Маам гэдэг хүн Даваасамбуугийн гэр бүрлэгэнд очоод нэг ая өгч дуулж байхыг үзлээ. Түүнээс цааш үзээгүй. Жишээ нь тийм мэтээр л угсаатан чинь тийм л байсан. Одоо тэр дуунууд дуулагдахаа больсон. Хорол гэж тоглоом байсан. Бугаа нүүнэ гэдэг юм байлаа, цаасан дээр зураад чулуугаар нүүж тоглодог байлаа. Хааяа нэг даалуу нүүнэ. Үйчүүр гэж тоглоом байсан. Картон хайрцгаар хайчлаад шоогоор нааддаг.

Х: Өөр устаж байгаа эсвэл бүр алга болсон зүйл байна уу? (зан заншил г.м)

Г: Зан заншил гэдэг юм алга болж байна аа. Одоо хадамд гарахад хадмууд чинь ирж явахад хадам аав чинь юм уу хадам ах чинь танай гэрт орохоосоо өмнө гурван удаа ханиадаг. Тэгэхээр чи нүцгэн байвал орж ирэхэд нь хувцсаа өмсөөд бэлэн болоод зогсож байдаг. Тэгээд орж ирэхээр нь тэр хүнийг хүндлээд суулгаад, тэр хүний хажууд нүцгэн байдаггүй. Бас толгой нүцгэн байж болохгүй, хөл нүцгэн байж болохгүй, цамц майктай байж болохгүй, тийм диктатуртай байсан. Гурван удаа их ханиагаад хоолойгоо засахлаар тэр бэр хувцсаа өмсөж бэлэн болж байгаа гэсэн үг. Тэр бол хоцрогдсон. Одоо монгол гутал оёдог хүн байхгүй болсон. Нэг хүн оёдог, түүнээс худалдаж авдаг боллоо. Цагаан хөрсөн дээл өмсдөг байсан. Хонины арьсаар хийдэг, зун ямааны арьсаар дээл хийгээд 2 талаар нь өмсдөг байсан. Тэрийг өмсөхөө болиод 40-өөд жил болж байна. Тэгээд тойруулаад хоргойгоор юм уу, илгээр эмждэг байсан. Эрэгтэй эмэгтэй ялгаатай. Эмэгтэйг дээлийг цэгдэг гэдэг. Хотон хүн бас цэгдэг, тэрлэгтэй, цачмаг гэж бас байдаг. Нэг талдаа гурван алчууртай. Нэгээр нь гараа арчдаг. Нэгээр нь аягаа арчдаг, нэгээр нь хөлсөө арчдаг тийм тооцоотой байсан. Намайг нэг арван хэдтэй байхаас эхлээд л багасаад хэрэглэхээ болиод эхэлсэн. Дээл хийхдээ тэр арьсыг элдээд, утаад утаа оруулна, халиаж (илүү арьснаас гарсан махыг авах, цэвэрлэх) байгаад дотроос нь хөвөрдөнө. Дотно талд нь ярж байгаад тэгж хөвөрддөг. Утахаар бороо ус сайн даадаг болдог.

Х: Өөр та нутаг уснаасаа юм уу, эсвэл Монголын соёл уламжлаас хадгалж үлдэх юм сан гэж боддог зүйл бий юу?

Г: Одоо жишээ нь харгай модоо тайрахгүй, булаг усаа догшруулалгүй энэ сайхан усаа үр хүүхэддээ өгье гэдэг тийм сэтгэлтэй байхаас илүү нэг хэдэн цаас олж авья гэсэн бодолтой л тайраад малтаад л байхаар чинь газар нь догширно гэдэг юм нь болоод гандаад л, өвс гарахгүй байна.

Х: Таны аав, ээж ямар хүмүүс байсан бэ?

Г: Миний аав лам хүн байсан. Улаангомын хүрээнд их том зурхайч лам хүн байсан. Аавын багшийг буудаж алаад, манай аав гурван удаа шоронд сууж байсан. Намайг эсэргүүний хүүхэд гэж сургуульд оруулахгүй 2-р ангиас хөөж гаргаж байсан. Манай ээж жирийн малчин хүн байсан. Манайх ах дүү есүүлээ байсан. Манай гурван ах өнгөрлөө. Нэг хамгийн адгийн дүү өнгөрлөө.

Х: Аав ээж чинь таныг хэрхэн хүмүүжүүлсэн бэ?

Г: Өө, манай аав чинь хүүхдэд гар хүрдэггүй, хүүхэд цохиулдаггүй. Манай ээж их ширүүн хүн байсан. Манай ах Улаангомын эмч хүн байсан. Таван хүүхэдтэй хүнийг архи уучихлаа гэж цохиж байсан хүн. Манай нэг ах эмч байлаа, нэг ах хошууч, мөрдөн байцаагч, нэг ах Өмнөговьт цэрэгт байж байгаад нас барсан. Нэг эгч Улаанбаатарт байна. Манай аав их тайван, номхон, их цэвэрч, их нямбай. Хүрээ лам хүн болоод тэгдэг юм болов уу. Манай аав уриа нэг бүрчлэн арчаад гэрээ хувин, хувин усаар цэвэрлээд сууж байдаг, тийм их цэвэрч хүн байсан. Манай аав Улаангомын хүрээгийн толгой гэж хэлэхэд болно. Энэ Улаангомдоо хэлцээтэй хүн байсан. Бурхан тахилаа надад өгсөн байна. Би шүтэж байна. Таван хувцастай судар өгсөн. Манайх Бурхан багш, Очирваань шүтдэг. Миний шүтдэг бурхан Хаянхярваа. Нам жим гэж бас нэг бурхан байна, тэрнийг шүтнэ. Аав маань хүнтэй хэрэлдэж болохгүй, архи дарс ууж олон дотор хэв байдал их муухай болдог юм, наадам наргиантай газар архи ууж болохгүй гэж л захидаг байсан. Морио их цэвэр авч яв, унасан морио хөлөргөж өнгө алдуулж болохгүй гэж л ярьдаг байсан даа.

Х: Адууны соёл гэж хүмүүс их ярьдаг, та тэрийг юу гэж ойлгодог вэ?

Г: Манай аав чинь арван хэдэн эр голдуу адуутай, 2 гүүтэй байж л дээ. Түүн дотор хурдан морь нь ч байлаа, жороо морь нь ч байлаа. Аав морь уядаггүй байсан. Манай дүү нар, ах

нар л уядаг байсан. Манай аав миний хүүд нэг бор морь өгсөн, тэр нь харин их олон жил айрагдлаа. Би бол морь уядаггүй.

Х: Нүүдлийн соёл гэдгийг та юу гэж ойлгодог вэ?

Г: Одоо харин тэмээгээр нүүдэг айлгүй болчихоод байна. Манай энд тэмээгээр нүүдэг 2,3 хан айл байна. Манай энд морьтой хүн байтугай хүн гарахын аргагүй газар байдаг, тэрүүгээр чинь тэмээ гараад л явна. Одоо энэ Хархираа хавцлаар машинаар нүүгээд л, ус нь ихдэхлээр Улаан-Даваагаар уруудаад л бууна. Ийшээ чулуу ихтэй. Урд нэгдэл, нийгэм гэж байхад нэг айлд л ихдэлээ гэхэд 500 хонь байсан. 500-аас доош л байсан. Одоо бэлчээрийн даац хэтэрсэн. Энэ хүүхдүүд хэцүү байна. Урд би нар улайхад цайгаа уугаад гараад орой болж байхад хонио тууж ирнэ. Одоо тэр цагийн хонь хариулах өнгөрсөн. Мотоциклоор голдуу хариулж байна. Бид нар мориор хариулаад өвөлд нь хусан таяг гэдэг юм болж аваад явган хариулна. Модноос хусан таяг барьж аваад л хормойгоо шовордоод л гэртээ ирэхдээ нэг уут аргалтай ирнэ. Тийм л амьдрал байсан. Би тэгж 20-30жил амьдарсаан. Тэмээгээр нүүх, морь унах их ховор байна.

Х: Танай эндхийн газар нутаг, бэлчээрийн онцлог юу вэ?

Г: Хавартаа нүүж ирээд бэлийн Асга хотгор гэж байдаг. Эргээд энэ наад талын хөх уулын хормой бариад бууна. Тэгээд Баруун шил гэж Гурван булаг, Гурван хужирт, Гурван булаг, Бүрэг зэрэг газраар зусдаг. Түүнд Хөндлөнгийн 1-р баг гэж манай баг очдог. Хархираа гол бас Тариалан сумын айлууд очно. Тэгээд намар 8 сарын 20-оор нүүж орж ирнэ.

Х: Мал маллахын хамгийн сайхан зүйл нь юу вэ?

Г: Гоё байхгүй юу. Намарт их таргалуулсан хонь хариулаад явж байхдаа хургаа ялгана. Дан сувайгаа хариулаад явж байхад үнэн гоё. Залхуурах юм байхгүй. Манай аав, ээж хонь хариулсан хүн хүндтэй гэж хэлж хүндэлдэг байсан.

Х: Цаг агаар хэрхэн өөрчлөгдөж байна?

Г: Цаг агаар их өөрчлөгдөж байна. Өдийд бороо орох ёстой. “Ямаан-харгана” гэдэг юм ургахаа больсон. Манай ээж бид нараар ямаан-харгана түүлгээд л “гал алдалаа, бороо хэтэрлээ” гээд л байж байдаг байсан. Одоо тэгтэл бороо нь орохоо байлаа. Ганцхан өдөр бороо ороод л маргааш нь шуураад л хатаачихна. Урьд Улаантолгойн модон гэдэг юмаар морьтой хүн явах аргагүй модтой байсан. Тэр модыг хядаад юу ч үгүй болсон. Их

бүдүүн, бүдүүн харгай байсан, байхгүй болсон. Тэрийгээ дагаад л булаг ус нь ширгээд л хуурайшаад л, түнгэ ургахгүй болсон.

Х: Хүмүүс яаж өөрчлөгдөж байна?

Г: Урьд нэг тарвага алсан бол гурвуулаа хуваагаад иддэг байсан. Одоо нэг айл нь мэдчихвэл сэргийлэхэд өгчихсөн зогсож байна. Нэгнээ матах, муу хэлэх, замбараа алдсан. Байгаль их уйсаж байна, байгаль их догширч байна. Таван лус байдаг гэж байгаа. Усан лус, ургамал лус, хад чулуу лус, шороо лус, уул лус гэж таван лус байдаг. Таван лусын дарга нь могой гэж байгаа. 1990 оноос хойш соёл гэж арай загваргүй болжээ. Ардчилал гарч ирээд шашныг чөлөөтэй гэж өгсөн ганц онцлог нь л тэр юм даа.

Х: За, ярилцсанд их баярлалаа.

Г: Баярлалаа.

4. Увс аймаг, Тариалан сум, Замбалов, 34 настай

Х: Сайн байна уу, та надад өөрийнгөө танилцуулна уу?

З: Намайг Зундуй овогтой Замбалов гэдэг. Тариалан сумын Хөх-овоо багийн харъяат. Тариалан сумын Соёлын төвийн багш хийдэг. 2007 оноос хойш одоог хүртэл Соёлын төвийн хөгжмийн багшаар ажиллаж байна.

Х: Та ямар сургууль төгссөн бэ?

З: Одоо СУИС-ийн харъяа болсон “Соёлын Дээд Сургууль”-ийг 2010 онд төгссөн. 2006 онд арваа төгсөөд 2007 онд Соёлын төвд “хөгжмийн багш”, “бүжгийн багш” гэж шинээр орон тоо гарсан. 2007 онд Архангайд багшийн дээд сургуульд сурч байгаад ар гэрийн гачигдлаар сумандаа ирсэн байсан. 2007 онд Соёлын Дээдэд ажиллаж байхдаа 2008-2010 оны хооронд Соёлын дээд сургуулийг орой, эчнээ ангиар төгссөн. Ажиллангаа сураад төгссөн.

Х: Та цэрэгт явж байсан уу?

З: Дүйцүүлэх албаар 2 жил аймагтаа хаасан.

Х: Таны аав, ээж ямар хүмүүс байдаг вэ?

З: Манай аав Борноо овогтой Зундуй 2007 онд нас барсан. Монгол Улсын Ургацын Хошой Аварга, шалав-элхиний хүн байсан. Манай ээж Тоголдой 1956 онд төрсөн. Одоо тэтгэвэртээ гарсан, гэртээ байна.

Х: Танай сум Тариалан гэдэг нэртэй. Тэгэхээр тариа тарьдаг сум гэсэн үг үү?

З: Манай суманд үндэсний цөөнх хотон ястнууд амьдардаг. Энд ажиллаж, амьдарч байгаа хүмүүсийн бараг 80 гаруй хувь нь Хотдууд эзэлнэ. Түүхэндээ Хотдуудыг 18-р зуунд Галданбошигт хаан тариа, будаа тариулах зорилгоор Казахудаас тасалж ирсэн гэж ярьдаг. 1925 онд “Алтан-тээл” гэсэн нэртэйгээр анх байгуулагдсан. Хожим 1930-аад оны үед “Тариалан” гэдэг нэртэй болсон юм билээ. Тариаланд 951 өрх байна. 951 өрхийн бараг 600-аад нь ямар нэгэн байдлаар газар тариалан эрхэлж байна. Малчид, төрийн албан хаагчид хүртэл.

Х: Юу, юу тарих уу?

З: Голчлон “арвай буудай”, “царгас” буюу “хадлан”, “улаан буудай”, “овьёос” тариалдаг. Бүгд гадаргын усаар, гар усалгаатай. Одоо энэ болохоор Галдан-бошигтын суваг гэдэг нэртэй. Галдан-бошигт хаан энэ шуудууг анх малтуулаад ийшээ Унхраг гэдэг газар луу урсана.

Х: Хархираа голоос эх авч байна гэсэн үг үү?

З: Тийм. Хархираа голоос эх аваад 100 га , бараг 20-иод км шуудуу татаж ус урсгасан. Тэнд анх Галдан-бошигт хаан цэргийн хүнсний зориулалтаар тариа, будаа тариалсан.

Х: Тарьж байгаа зүйлүүдээ ийш тийш нь нийлүүлдэг үү, эсвэл өөрсдийн хэрэгцээнд л хэрэглэдэг үү?

З: Овьёос, улаанбуудайг бол ерөнхийдөө бусдад нийлүүлж байна. Арвайгаар голчлон өөрсдөө гурил хийнэ. Гурил хийснийхээ дараагаар борлуулж ашигладаг. Хадлангаа бол малчдад нийлүүлнэ. Сүүлийн 2-3 жил Завхан, Говь-алтай руу хадлангынхаа өвс тэжээлийг пресс хийлгээд ачуулж байгаа.

Х: Та эхээс хэдүүлээ вэ?

З: Эхээс наймуулаа. Уг нь 11 хүүхэд гарсан гэж ярьдаг юм. 4 эмэгтэй, 4 эрэгтэй. Манай ах, эгч нар бүгд тусдаа гарсан. Нэг ах Сэлэнгийн Баруунбүрэнд Соёлын төвийн эрхлэгч хийж байна. Эгч нар маань сумандаа хувиараа хөдөлмөр эрхэлдэг.

Х: Тариа будаа тарьдаг уу?

З: Тийм. Тариа будаа тарина. Зарим нь хувийн хэвшилд ажилтай.

Х: Та ер нь Монголын соёл гэдгийг юу гэж ойлгодог вэ? Ямар, ямар зүйлс хамаарагдана гэдэг ч юм уу?

З: Монголын соёл бол тусгаар тогтнохын үндэс. Бусдаас ялгарах онцлог байна. Дээр үеэс уламжлагдаж ирсэн соёлын биет бус өв. Өөр газар бол байхгүй шүү дээ. Тэр морин хуур, бие биелгээ, уртын дуу, магтаар (магтаал) дуу, ерөөл, ахуйн зан заншил, нүүдлийн соёл, түүхийн дурсгалт зүйлүүд байна. Хамгийн гол нь өвлүүлж үлдээх талын юмнууд байгаа юм.

Х: Хамгийн чухал нь таны бодлоор юу вэ? Хамгийн үнэ цэнтэй эсвэл өвлүүлж үлдмээр ч юм уу?

З: Яг манай нутгийн хувьд бол Хотон ястны онцлог байна л даа. Хотон ястаны зан заншлын онцлог байна. Тэгээд энэ янз бүрийн өв соёлоо сошиал ертөнц ашиглаад олны хүртээл болгож чадаж байна гэж бодож байна. Хотон хуримын зан заншил бусдад уусаад алга болох гэж байгаа юм шиг санагдаж баайна. Хотон ястаны “номын аав, ээж болох” ёсон байна. Тэр хурим найрын эхлэх төгсгөлийн ёсон байна. “Хөшиг тайлах ёслол” гэж байна. Энэ зан заншлууд бусад ёстойгоо холилдоод жаахан мартагдах гээд байгаа юм шиг байна. Бас нэг юм нь оршуулгын зан үйл байна. Манай оршуулгын зан үйл олон төрлийн дэг ёс, үйлдлүүд байна. Би бол өөрөө яг хотон, манай аав “шалав” элхин, ээж “шаавай” элхиний хүн.

Х: Шалав, шаавай элхин гэдэг нь ямар учиртай вэ, овог уу, дотроо бас үндсээрээ ялгарч байна уу?

З: Хотон ястнуудыг дотор нь долоон элхинд хувааж байгаа юм л даа. “Шалбаг”, “Шаавай”, “Оготор”, “Бүрд”, “Хольдог”, “Хаснууд”, “Хочгэлдэнэ” гээд ийм долоон элхин байдаг. Жишээлбэл энэ долоон элхинээс 2 шаавай хүн бол хоорондоо суухгүй. Хотдууд дотроо гэр бүл боллоо гэхэд заавал өөр элхиний хүнтэй сууна. Ингэснээрээ цус ойртолт гэдэг юм байхгүй гэсэн үг. Одоо жишээлбэл шалав элхиний хүмүүс бол нэг ураг овгийн хүмүүс. Тэгэхээрээ заавал өөр элхиний хүнтэй л гэр бүл болно гэсэн үг. Элхин гэдгийг ястан гэж ойлгож болно. Хотон ястан гэж явна. Элхин гэдгийг овог гэж ойлгож болно.

Х: За тэгвэл хоёулаа дээр дурдсан зан заншил, өв соёлуудын талаар дэлгэрүүлж ярих уу?

З: Яг манайд түгээмэл хэрэглэж байгаа Хотон ястаны биелгээ байна. 16 төрлийн биелгээ байна. Хотдуудын биелгээний онцлог нь Дөрвөд, Баядуудаас ялгаатай. Татлага, ая дангаараа өөр. Гараа дандаа дэлгэж, дээшээ харуулж биелдэг. Биелгээ нь болохоор нутаг усанд цацал өргөх, мөргөж байгаа иймэрхүү хөдөлгөөнтэй байгаа бол “Сэдэн залуу” гэх мэт өөр биелгээнүүдэд ахуйн үйлдлүүдээ уран сайханы маягаар хийсэн байдаг. Жишээлбэл арвай, тарианы үйлээ хийж байгаа, тариагаа татах, сэвэх тэр хөдөлгөөнүүдээ уран сайханжуулаад хийнэ. Мөн морин дээр яваа, морьтой хүний үйлдлийг харуулсан, иймэрхүү онцлогтой биелгээнүүд байгаа. Тэгээд биелгээг маш түгээмэл хэрэглэнэ. Найр наадам, концерт, урлагийн тоглолтон дээр Хотон ястаны биелгээг зайлшгүй хийдэг. Одоо ч гэсэн 8 настайгаас 80 настай хүртэл Хотон ястаны биелгээ хийж байна.

Х: Биелгээ хийснээр хүний бие болоод сэтгэлзүйд ямар ач холбогдолтой вэ?

З: Биелгээ хийснээр нэгдүгээрт, сонсгол төлөвшинө. Биеэ хөдөлгөж биелснээрээ жингийн асуудлаас аваад, хөдөлгөөний эвслээс авхуулаад маш онцлогтой. Биелгээг атар хэвээр нь авч үлдэхийн тулд бүжиг шиг дэглэхгүй байхыг л хичээж байна даа. Яг өөр өөрсдийн биеийн онцлогоос гадна ямар хэлбэрээр сурсан яг тэр хэлбэрээр сурч байна.

Х: Хуримын ёслолын онцлог юу вэ, халх хуримаас юугаараа ялгарч байна?

З: Залуу хүн болохоор, хуримын ёслолыг бас дэлгэрэнгүй сайн мэдэхгүй байна л даа. Хуриман дээр “номын аав, ээж болох ёслол” гэж юм хийнэ. Тэрэн дээр “зава” болсон гэж ярьдаг. Шинээр сурсан молдоо нартайгаа хуучин молда нар нь хамт ном уншаад зөв байна уу, гэдэг юмыг шалгаад тарни, номоо гаргах эрх олгоно. “Зава” олгоно гэдэг нь ном сурсан молда нарыгаа айлд очиж юм хийж болно гэсэн эрхийг олгож байгаа юм. Эрх олгосон тэр хүнээр “ниха” уншуулна. Тэр уншлагыг нь “ниха” гэж ярьдаг. Ниха хийлгэхээрээ “зава” болсон тэр молдоо хүнээрээ хийлгэнэ. Тэгээд бусад хүмүүс “энэ хүмүүн болов уу”, гэж асуухад “боллоо” гээд уншдаг. Ийм уншлагатай. Жишээлбэл найрыг эхлүүлэх дуу нь “Тогос баахан шарга” гэдэг уртын дуу байна. Тэр найранд ирсэн бүх хүмүүст сүү амсуулаад, дуугаа дуулаад гэр тойрдог. Тэгээд тэр найр наадам эхэлж байна гэж ойлгож болно.

Х: Өөр, хуриман дээр юу болдог вэ?

З: Өөр гэвэл “хөшиг тайлах” ёслол болдог. Тэр нь найр өндөрлөх тийшээ хандаж байгааг илэрхийлнэ. Зүүн орон дээгүүр хөшиг татсан байна. Тэр орон дээр найранд ирсэн хүмүүс хүндэтгэл үзүүлээд мөнгө тавина. Хөвгүүн, бэргэн хүмүүс хөшиг тайлах цагтаа

тааруулаад охин, хүү хоёр талын бэргэн булаацалдаж хувааж аваад охин, хөвүүндээ өгдөг. Ийм ёс байна.

Х: Хуриман дээр ямар хоол унд бэлтгэх вэ?

З: Хуриман дээр ерөнхийдөө бол мах голчилно. Махыг тавихдаа эрэгтэй, эмэгтэй талд тавих мах өөр, өөр байна. Жишээлбэл залаатай чөмөгний арыг нь авахгүй тавьж болохгүй. Охины талд өвчүү тавина. Ууц утлана гэж юм болдог. Жишээлбэл охины талын аав нь маргааш нь хөвүүний талын гэрт очоод ууц таллана.

Х: Номын аав, ээжийг хэрхэн сонгодог вэ?

З: Долоон элхин гэж би ярьсан шүү дээ. Жишээлбэл эрэгтэй нь шалав элхиний хүн байлаа гэхэд шалав элхиний хүндээ номын хөвүүн болно. Тэгээд тэр хүний эхнэр нь номын ээж нь болоод явна гэсэн үг. Эмэгтэй нь жишээлбэл шаавай элхиний хүн байлаа гэхэд шаавай элхиний хүндээ л номын хөвүүн болно гэсэн үг. Ерөнхийдөө аавын ургийн хүндээ номын охин, хөвүүн болно гэсэн үг.

Х: Тэр нь тэгэхээр нэг хүнд нэг хүн л байна гэсэн үг үү?

З: Жишээлбэл нэг хүнд хэдэн ч хүн байсан болно. Ерөнхийдөө авга талын хүндээ номын охин, хөвүүн болно гэж ойлгож болно. Жишээлбэл манай аав шалав элхиний хүн байсан. Манайх найман хүүхэдтэй гэсэн тэгэхээр манайд найман номын хөвүүн болсон дөрвөн эрэгтэй, дөрвөн эмэгтэй байна. Ингээд 16 хүүхэд болж байгаа биз. Энэ хүүхдүүдээ хооронд нь ялгахгүй. Тэгээд хүүхдүүд нь өөрсдөө номын аав, ээжээ сонгохоосоо илүү аав, ээж нь заагаад өгчихдөг. Тийм уламжлалт юм бас байна. Аавынхаа дүү, авга ахдаа болох нь их элбэг. Нэг овог, нэг элхин гэдэг талаараа авга талаа баримтлах юм их байна.

Х: Та хөгжмийн багш тэгэхээр надад хөгжмийн талаар ярьж өгөөч?

З: Манай энд 10 айлын нэгд зайлшгүй ихэл хуур байгаа. Яг ихлээрээ биш гэхэд морины толгой гаргаад урласан байдаг.

Х: Урьд нь морины толгойгүй байсан уу?

З: Морины толгойгүй байсан. Гурвалжин толгойтой, хунгийн толгойтой, ямаан толгойтой байсан. Хуур байгаа айлын ямар нэгэн хүн их бага хэмжээгээр татна. Тэрэн дээр нь бусад нь босоод биелнэ. Бүр тийм хошин яриа хүртэл байна. “10 хүн тутмын 9 нь биелж байна” гээд. Тэгээд нэг нь яаж байна гэтэл, “тэр нь ихлээ татдаг юм байгаа биз

дээ” гээд тийм яриа хүртэл байна. Биелгээндээ зориулаад ихэл хуур голчлон түгээмэл хэрэглэж байна.

Х: Орчин үед ихэл хуур хэрхэн өөрчлөгдөж байна?

З: Загвар хийцийн хувьд жаахан өөрчлөгдөж байгаа. Утсыг нь морины сүүлээр хийхээ болиод сатуркаар хийж байна. Түүгээр дуунд нь өөрчлөлт орж байна. Сайжрах тал руугаа их явж байна гэж ойгож байна. Загвар нь л бага зэрэг өөрчлөгдөөд байгаа боловч улам сайжрах тал руугаа л явж байна гэж ойлгож байгаа.

Х: Өөр Хотон ястаны хөгжим байдаг уу?

З: Малын ясаар лимбэ хийгээд язгуур урлагт ашигладаг тийм зүйлүүд байна. Сүүлийн үед бас цуур хөгжим хөгжиж эхэлж байна. Товшуурыг бас яг ихэлтэйгээ адилхан хэрэглэнэ. Ясан лимбийг бол сүүлийн үед л хийж байгаа. Малынхаа чөмгийг цэвэрлээд ясаар лимбэ хийнэ. Цуур бол Ховд аймгаас гаралтай ч манай нутгийн онцлогт тохироод байна л даа. Яагаад гэхээр цуур бол хад асгатай газрын уулын цуурайтсан дуунаас үүсэлтэй. Манай нутаг бас уулын бүсэд байдаг хатуу ширүүн урсгалтай голтой. Нутгийн онцлог бас нөлөөлж байна л даа. Тэгээд тэнд тохирсон хөгжим түлхүү хэрэглэх нь ихсээд байна уу гэж ажиглагдаж байна. Хүмүүст бас нутгийн онцлогоос шалтгаалаад сурахад амар байна уу гэж харагдаж байна. Товшуур болохоор яг ихэлтэйгээ адилхан хөглөгдөнө. Бас хоёрхон утастай. Хуурын симчек байхгүй. 2 хуруугаараа татаж тоглоно. Товшуурыг болохоор ихэвчлэн магтаар (магтаал) дуу, тууль, ерөөл хайлахад хэрэглэнэ. Нутаг усны ерөөл, хурим найр, гэрийн ерөөл. Ерөөл бол гэрт байгаа хурим найрын зүйлүүдийг ерөөдөг болохоор өөрчлөгдсөн юм байхгүй. Манайд тууль хайлдаг ганц, хоёр хүн байгаад бурханы оронд явчихлаа. Туулийг концерт, хурим, найран дээр ашиглахгүй болохоор түгээмэл хэрэглэгдэхгүй. Үр хүүхдүүддээ л үлдээж барьдаг. Морины л юмнууд ихэвчлэн байсан. Байгаль хангайтай холбоотой уул усаа магтан дуулсан тийм л юмнууд байна. Яг хотон тууль гэж бол байхгүй.

Х: Хотдууд ямар шашинтай вэ?

З: Хотдууд чинь мусульман шашинтай. Лам нарыгаа “молдоо” гэж ярина. Коран гэж судар байна. Манай энэ уншлага болохоор яг л хотон ястан молдоо нарын хэллэгээрээ байгаа. Жишээлбэл Хотон ястаны хэллэгээр “атаа” гэдэг үг нь аав гэсэн үг байсан байна л даа. “Ана” гэхээр ээж. Тэгэхээр тэр үгнүүдээ өөрсдөө хэрэглэхгүй мөртлөө уншлаган дээрээ байна. Жишээлбэл атаа болсон дээл, ана болсон Хархираа гээд сангийн номон

дээр явж байна. Тэгээд энийг орчуулахаар аав болсон дээл, ээж болсон Хархираа гэсэн юмнууд байгаа юм. Тэгэхээр Коран судар дээр тиймэрхүү юмнууд бол байхгүй гэсэн үг. Хотон ястан коранаас санаа авсан байж болох юм. Гэхдээ уншлага нь болохоор манайх гэж харагдаад байгаа юм. Молдоо нарт амаас ам дамжиж уламжлагдаж байгаа. Үр хүүхдэдээ амаас ам дамжаад заагаад явна. Хотдууд даллага авах, тавгийн сан гэж тавиулна. Мэдээж суудлаа засуулна. “Намрын цай” гэж юм чанана. Намрын цайг нас барсан аав ээжтэй хүмүүс хийлгэнэ. Аав ээждээ хоол цай өгч байна гэсэн үг. Намрын цайн дээр дандаа хонийг бол хүзүүг нь хэрчиж гаргана. “Хоньтой цай” гэж дэлхий дээдэст залбирах юм бас 3 жилд нэг удаа хийнэ.

Х: Овоогоо хэрхэн тахидаг вэ?

З: Овоон дээр бас адилхан, хоньтой очино. Манайхаас бусад овоо тахилга, овоон дээр ерөөсөө цус гаргахгүй гэдэг. Манайх бол хониныхоо хүзүүг хэрчиж байгаад цусаар нь овоогоо бүрдэг.

Х: Хэдэн хонь аваачих уу?

З: 2-3 бол гараад байдаг. Ирсэн хүмүүсээсээ л болдог. Яаж тэр хонинууд нь ирэх вэ гэхээр жишээлбэл, би гэр бүл боллоо. Тэгээд шинээр гэр бүл болсон хүмүүс хонио аваад очно. Манай гэр бүлийг даатгаж өг гээд хонио аваачиж өгнө. Тэгээд тэр хүний нэрийг хэлээд овоогоо тахина. Сумын бүх молдоо нар очно. Овоон дээр мэдээж эмэгтэй хүн гарахгүй, очихгүй. Молдоо нарын бас ахлагч байна. Молдоо нарын ахлагчийг “аахан молдоо” гэж нэрлэнэ. Тэгээд тэр хүн овооны тахилгыг удирдан зохион байгуулна. Тэгээд хониных нь цусаар будчихаад махыг нь жижиглэж чанаад, дахиад арвайн гурилаа зуурна. Овоон дээр очсон хүмүүс цай, идээ, шар тостой очно. Тэрийгээ молдоо нартаа өгөөд гэр бүл амь насаа даатгаад уншуулж байгаа юм. Суманд 5 сард тахидаг овоонууд 7 сард тахидаг овоонууд байна. 15-16 овооноос тогтмол тахиж байгаа 6 овоо байна. Голын хажуу талын овоогоо “гол орж ирээд тариа будаа их аваасай” гээд 5 сард тахиж байгаа юм. 7 сард хур бороо ороосой гээд “Хонхоо-Хоо” гэж манай сумын ганц том овоог тахина.

Х: Танай оршуулгын зан үйлийн онцлог юу вэ?

З: Оршуулгын зан үйл болохоор Дөрвөд, Баядууд одоо ч гэсэн хүнээ ил тавьдаг. Манайх болохоор хүн нас барлаа, гэнгүүт нь молдоо нар нь ирээд ерөөл авна. Тэгээд бараг цаг тутам ойр ойрхон авна. Тэгээд хамаатны хүмүүс нь ирээд тус тусдаа ерөөл авхуулна.

Ерөөл авхуулахдаа нэг шил архи, сүүтэй ирнэ. Сүү архиа тойруулаад гал дээр асгаад, тусгай уншлага хийгээд явна. Буйрлуулахдаа болохоор газрыг малтаад, газар доор оршуулна. Алтан хайрцаг нээлгэхийг манай нутагт “шинжээ татуулах” гэдэг. Шинжээ татуулаад тэрэн дээр буусан юмнуудыг хийнэ. Тэгээд 7, 21, 49, 100 хоногуудыг ёслол хийнэ. Жишээлбэл 7 хоног дээр нь малыг нь уяна, тэр нь явуулж байна гэсэн үг. Тэгээд бас энэ хоногууд дээр нь хонь мал гаргана. Бас жил болгон газар дээр нь үр хүүхдүүд нь очно. Ерөөлөө авхуулаад газарт нь нүх сүв гарсан байвал нөхдөг. Оршуулахдаа толгойн доор нь цай хийгээд, цагаан даавуугаар ороогоод хийнэ.

Х: Хотон хувцасны талаар дэлгэрүүлэн ярьвал?

З: Хотон хувцас байна л даа. Одоо бол энгийн үед өмсөхгүй, тайзны чиглэлд л өмсөнө. Биелгээгээ хийхдээ л өмсөөд байна. Эрэгтэй нь хар эмжээртэй цагаан дээл, далтай юүдэн малгай өмсөнө. Эмэгтэй нь хар өнгийн дээл өмсөнө. Эмжээр нь улаан, шар байна. Хажуу талдаа алчууртай. Гар, нүүр, аяга шаазангаа арчина. Хотон хувцасны бас нэг онцлог нь “цэгдэг”, “цачмаг” гэж байна. “Тэрлэг” гэж байна, тэр нь дотор талын дээл. Эмэгтэй дээл бол ийм 2 юмнаас бүтэж байгаа юм. Эмэгтэй хүний хувцасны онцлог нь цачмаг гээд үсээ хийдэг тахим хүртэл урт зүйл байна. Дээр үед хамгийн үнэтэй тэмээ, бодоор худалдаж авдаг байсан. Тэрийг одоо бол шүр хуваар, дээр үед бол сувд гэх мэт янз бүрийн үнэт зүйлийг хэлхээд хийсэн байдаг.

Х: Танай сум орон нутгийн хүмүүсийн сэтгэлгээний онцлог юу вэ?

З: Увс дотроо Тариалангийнхан маш ажилсаг хөдөлмөрч. Бид нар дотроо бол мэдэхгүй. Хүмүүсийн ярьж дүгнэж байгаагаар тийм л харагдаад байна.

Х: Тэр нь эрхэлж байгаа аж ахуйгаасаа болж байна уу?

З: Тийм, гар усалгаатай газар тариалан эрхлэх тийм амар ажил биш л дээ. Тэрүүгээр давамгайлж хөдөлмөр хийдэг болохоор бас тэгж харагдаж болох юм. Дээрээс нь бас бид нарыг “хараалч”, “ерөөлч” гэж хүмүүс бас ярьдаг. Хотдуудтай муудаж болохгүй. Тэгээд бас янз бүрийн домтой. Жишээлбэл малчид мал нь ирэхгүй байвал малынхаа ясыг чөдөрлөнө гэж юм байна. Салхи шуурга болж байгаа газар тогоо хөмөрч тавьдаг юм байна. Чөдөрлөнө гэдэг нь чоно нохойноос хамгаалдаг. Хүүхдийн хажууд шүдэнз, шанага тавьдаг юм байна.

Х: Танай суманд тулгамдаж байгаа асуудал байна уу?

Соёл сэтгэлгээний тал дээр бол зүгээр гэж бодож байна. Тариалан сумын хэмжээнд тулгамдаж байгаа асуудал бол уул уурхай. Манай суманд байхгүй юм байхгүй. Алт, нүүрсний олон ордууд байгаа. Тэгээд энийг дагаад зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй янз бүрийн хүмүүс уурхайд ажиллана. Тэгээд олон хүн цуглархаар олон асуудал үүснэ. Нэг нэгнээ хөнөөх зүй бус хэрэг гарна. Энэ юунд нөлөөлөх вэ гэхээр сумын нэр гарна. Сум орон нутгийн нэрэнд их нөлөөлнө. Байгаль цаг уурын нөхцөл хүний амьдралд маш их нөлөөлж байна.

Х: Таны амьдралдаа эрхэмлэж явдаг зүйл юу вэ?

З: Аав ээж маань хэлж байсан л даа. “Шаазгай шиг л алаг яваарай” гэж. Аль болох хүмүүст муу сэтгэгдэл төрүүлчихгүй юмсан, гомдоохгүй юмсан, уурлуулахгүй юмсан гэж боддог. Тэгээд байхаар нийгмээ дагаад тийм хүмүүсийг ашиглах хүмүүс гарч ирээд байна л даа. Тэгэхээр тийм хүмүүсийг ялгаж салгадаг байх нь шаазгайных нь хар болчихоод байна л даа.

Х: За, ярилцсанд их баярлалаа.

З: Баярлалаа.

5. Увс аймаг, Ховд сум, Санжийн Гансүх, 58 настай

Х: Сайн байна уу, та надад өөрийгөө танилцуулаач?

Г: Намайг Санжийн Гансүх гэдэг. 1964 онд Ховд сумын Шивэр багт газар төрсөн. 1982 онд цэрэгт яваад Хотод “Сонгинын Булан” гэдэг газар цэргийн алба хаагаад цэргээс ирээд мал малласан даа. 1990 онд цэргээс ирээд гэр бүл болсон. Тэгээд одоо болтол эндээ л амьдарч байна даа. Манайх хоёр охинтой, хоёр залуутай.

Х: Танай газар, нутгийн онцлог юу вэ?

Г: Манай нутаг чинь Хангай газар. Өвс ургамал гарсан үедээ сайхан, зарим жил гаралгүй уддаг юм. Өнөө жилийн хувьд бол бороо орохгүй байгаа учраас ногоо орохгүй байна. Шаазгай нуур, Гожуурын Хүрхрээ гэж үзэсгэлэнтэй сайхан газар бий.

Х: Энийг яагаад Шаазгай нуур гэж нэрлэсэн юм бол?

Г: Шаазгайгүй нуур л даа. Шаазгай гэдэг шувуу байдаггүй газар гэж байгаа юм. Шаазгайгүй нуур гэсээр байгаад л шаазгай нуур гэдэг нэртэй болсон. Өөр нүүдлийн шувууд бүгд ирдэг. Тэр нуурт шаазгай байхгүй.

Х: Бороо хур орох нь багассан уу?

Г: Сүүлийн жилүүдэд ер нь бороо орох нь багасаад байна. Гэхдээ бид нар нутагтаа байж байгаа юм чинь, нутаг маань сайхан даа.

Х: Таны хувьд монгол нүүдэлчин хүний үнэт зүйл гэвэл юуг хэлэх вэ?

Г: Байгаль нутгаа л хайрлаж дээдэлж явна даа. Бид нарын ганц хайрлаж явдаг зүйл тэр шүү дээ. Уул ус байгалиа дээдэлж явах, аав ээжийнхээ нутагт л байгаа, ийшээ тийшээ нүүхгүйгээр сууж байна.

Х: Та Монголын соёл гэдгийг юу гэж ойлгодог вэ?

Г: Сайхан эмээл хазаартай мориос эхлээд л Монголын соёл харагдана. Сайхан Монгол дээл гутал. Цагаан дээл гэж байдаг, та нар мэдэхгүй байх. Дээр үед тиймэрхүү дээл хувцас өмсөж байсан. Дэвэл гэж ярьдаг. Сайхан эмээл хазаартай морио унах, малаа унаж эдэлж байвал, хангал догшин морь, тэмээгээ сургаж номхруулж байвал тэр чинь Монголын соёл.

Х: Танай нутагт ер нь тэмээ их хэрэглэдэг байсан уу?

Г: Байсан шүү. Сүүлийн нэг арваад жилд тэмээ хэрэглэхээ больсон. Түүнээс урьд бол байнга тэмээгээр нүүж байсан. Араг гэж юм байлаа, түүнд хүүхдээ хийж аччихаад л тэмээгээр нүүдэг байлаа. Одоо ч бас энэ уул хад ихтэй машин явахгүй газар хэдэн айлууд тэмээгээр нүүнэ л дээ.

Х: Сүүлийн жилүүдэд танай орон нутагт өөрчлөгдөж байгаа зүйл байна уу? (зан заншил, хүмүүсийн сэтгэлгээ г.м)

Г: Тийм юм байгаа. Сүүлийн үеийн залуучууд зан харилцааны хувьд их өөр болсон. Дээр үед айл хоршоо байж байхад “танай мал энд байна”, “тэнд байна” гээд хэлдэг байсан. Одоо иймэрхүү юм ховорхон шүү дээ. Угаасаа монголын өв уламжлал гэж юм алдагдаад байгаа. Сүүлийн үеийн хүүхдүүд тийм юм жаахан хомсхон л болоод байгаа юм л даа. Нэг мал байвал дөхүүлээд өгдөг байсан. Соёлоо дагаад тэгдэг юм уу мэдэхгүй юм. Хүний зан чанар гэдэг юм чинь муудаад байгаа юм л даа. Би өөрөө л болж байвал болж байдаг, бусад нь хамаагүй. Гэхдээ яахав саахалт хоршоо байгаад тусладаг амьтан зөндөө л дөө. Тэгээд бас залуучууд малаас жаахан хөндийрч байна л даа. Мал малладаг хүүхэд ер нь ховор болоод байна шүү. Юмны үнийн өсөлт, бараа таваар дийлдэхгүй болж байна. Бензин шатахууны үнэ гэж юм сүүлийн нэг жил замбараагаа алдлаа.

Х: Таны ер нь амьдралдаа эрхэмлэж явдаг зүйл юу вэ?

Г: Морио унаад, адуу малаа эдлээд, үхэр тугалаа саагаад л, тэмээ малаа эдлээд л тэр бид нарын эрхэмлэж явах өв соёл мөн.

Х: Та Монголынхоо ямар зүйлээр бахархдаг вэ?

Г: Малаар л ер нь омогшиж явдаг даа. Малтай, морьтой адуутай, ер нь таван хошуу малтай байвал монгол хүн чинь болно, нэг их газардаад байхгүй шүү.

Х: Аав ээжээс чинь сургаж захисан зүйл бий юу?

Г: Өө, байна шүү. Хүн шиг л сайхан амьдраад явж бай гэж аав захидаг байсан.

Х: Байгаль цаг уурын өөрчлөлт хэр их байна?

Г: Хавар шуурга их гарч, өвс ногоо ургахаа больж байна. Үе үе тийм гамшгууд байна. салхи шуурга, цас бас хэцүү байна. Энэ хавраас 6 сар хүртэл шуурч байна. Ногоо гэж юм гарахгүй. Голынхоо ногоонд байгаа нь л энэ. Хөдөө ногоо гэх юм байхгүй, энэ ногоороод байгаа чинь голын ногоо. Энэ юунаас болж байхыг ёстой мэдэхгүй. Байгаль дэлхийгээ сайхан хайрлаж цэвэрхэн авч явахгүйгээс л болдог юм болов уу. Тахилгатай уул усаа тахихгүй байна. Манай энэ доор тахилгатай уул байдаг. Засаг захиргаа бас тахиулахгүй байгаа, дарга цэрэг нь удирдахгүй байгаа. Лус савдаг баярлуулахгүй байгаа.

Х: Танд цаашдаа хадгалж үлдэх юм сан гэж боддог зүйл бий юу?

Г: Байлгүй яахав. Энэ онгон байгалиа ариун сайхан чигээр нь үр хүүхдүүддээ үлдээх юмсан гэж боддог. Онгон байгалиар нь байлгахыг хичээж л байна.

Х: Монгол хүнийг, монгол хүн болгож байгаа зүйл юу вэ?

Г: Тэр чинь ердөө л байгаль дэлхий, мал хөрөнгө байна шүү дээ.

Х: Та морь уядаг уу?

Г: Уядаг. Сумын алдарт уяач. Манай худ хөгшин Хэнтийн Галшарт байдаг, би ноднин жил тэндээс азарга авчирч адуундаа тавьсан. Сүүлийн үед цустай адуу л их орж ирээд байна даа. Одоо янз бүрийн эм тариа гээд, өвс ногоогоор уяхаа больж. Монгол адуу гэдэг юм чинь бараг устах тал руугаа орж байна. Би жинхэнэ унаган морио унадаг. Хэнтийгээс харин нэг азарга авч ирсэн, тэр бол монгол азарга л даа. Ах нь дээхэн үеийн уяач л даа.

Х: Өөр тулгамдаж байгаа асуудал байна уу?

Г: Ноолуурын үнэ бага байна. Эрт ч гэсэн, орой ч гэсэн адилхан л байх ёстой. Өвс ногоо сайн үед ноолуур сайн гарна. Муу бол бас муу гарна. Ер нь малчин хүний ганц харьцдаг зүйл бол байгаль шүү дээ. Байгаль дэлхий, өвс ногоо сайн бол тэгээд боллоо. Энүүгээр шарилж, шаваг, ерхөг, борон гэх мэт шимтэй өвс гарна. Борон идвэл хар мах сайн гарна. Ерхөг идвэл тарга сайн авна. Урагшаа шивээ л их гарна.

Х: За, ярилцсанд их баярлалаа.

Г: Баярлалаа.

6. Баян-Өлгий аймаг, 13-р баг Н.Бааст, 86 настай

Х: Сайн байна уу, та надад өөрийгөө танилцуулна уу?

Б: Мэргэн хошууны Зүтгэлт гүний Хар Бүргэд гэдэг овогтой Нямхүүгийн Бааст. Би Урианхай хүн. Би 1936 онд Ховд голын “Улаан-харгана” гэдэг газар төрсөн. Миний аавыг Жамсран гэдэг хүн байсан. Би эхээс хөюулаа байсан. Нэг эгч байсан нь сургуульд явж байгаад 13 настайдаа ослоор өнгөрсөн. Тэгээд би эцгээс гагцаар (ганцаар) үлдсэн. Манайх 200-аад толгой өөртөө тохирсон малтай айл байсан. Шийр мал, адуу, бод мал байсан. Миний ээж намайг 3 настай байхад нас барсан юм гэсэн. Тэгээд аав асраад хүн хийсэн. Манай аав Буянт сумын намын хороон дарга байсан юм. Тэгээд намайг манай хамаатны төрөл ойр хүн нагац эгчээр асруулсан. Тэгээд аавын нэрийг орхиод Нямхүү гэдэг хүнээр би овоглогдсон. 1960 онд манай аав 60 настайдаа тэтгэвэрт гарч 62 настайдаа өөд болсон. Тэгээд манай аавын өв хөрөнгө надад хоцорсон. Би 1961 онд гэрлэсэн. Ерөөсөө гагц л эрэгтэй хүүхэдтэй. Одоо тавин хэдтэй байна. Манай гэр бүлийн хүнийг Хүүхээ гэдэг хүн байсан. Хүү цөөхөн мал дээр ажилладаг.

Х: Та хаагуур малаа маллаж байв, бэлчээр, нутаг ус чинь хаагуур байв?

Б: Би 16 наснаас эхлээд Цагаан-Төнх гэдэг газар сумын төвд ойр байсан. Түүнээс ойр 1957 онд анхны нийгэмчлэл болоход “Шинэ-зам” нэгдлийн мал авч хариулсан. Тэгээд тэр чигтээ мал хариулаад 55 настайд ардчилал гэж юм болоход тэтгэвэрт гараад түүнээс хойр (хойш) 1992 он хүртэл мал малласан. 1992 онд мал тараасан байх. Тэгээд хувьдаа малтай болж түүнээ өсгөсөн.

Х: Хэзээнээс төвд орж ирэв?

Б: Төвд орж ирээд 15 жил болж байна.

Х: Та ямар, ямар мал хариулж байв?

Б: Би хариулаагүй мал байхгүй. 1957 онд эхлээд “Социализм-зам” нэгдлийн хонь, ямаа аваад хариулсан. Түүнээс 1959 он хүртэл хариулаад дахиад мал нийгэмчлэл болсон. Тэгэхэд Монгол үхэр аваад хариулсан. Тэгээд гурван удаа туувраар гадаадад нэвтрүүлсэн. Хоршооны мал гэж туугаад “Хөх-эрэг”-ээр гадаадад нэвтрүүлсэн. Гурван жил хариулаад гурван удаа дандаа эр малыг туусан.

Х: Мал маллахаас өөр та юу хийж байв?

Б: 1964 оноос эхлээд Алтанцөгц сумын артельд ахуй үйлчилгээнд мужаанаар ажилласан. Тэнд ахуй үйлчилгээнд гэрийн бүх мод, бас банз татдаг байлаа. Хамгийн сүүлд 2 жил ахуй үйлчилгээний нярав хийж байсан. Мужаан, нярав нийлээд 11 жил Алтанцөгцөд ажилласан. Артель тарсаны дараа 1972 оноос эхлээд “Социализм-зам” нэгдлийн адуу авсан. 1992 он хүртэл адуу хариулаад 1992 онд бүгдийг тараасан. Хувьчилсаны дараа 13 адуутай, 60 үхэртэй, 200 толгой шийр малтай байсан. 1994 онд манай самган нас барсан. Олон жил адуу малласан. Манай эхнэр гүү саадаг байсан.

Х: Адууны соёл гэж ярьдаг, тэрнийг та юу гэж ойлгодог вэ?

Б: Монгол адууны соёл гэдэг чинь ашиг шимийг нь эдэлдэг, эмнэг хангал морийг сургадаг, адууг жилийн дөрвөн улиралд дөрвөн газар оторлож таргалуулахыг хэлнэ. Адууг хавар, намар, өвөл, зун отроор хариулж гэр орондоо ихээр ойртдоггүй байсан. Хамаа (хаана), өвстэй хамаа бэлчээртэй газар байна, түүгээр явж таргалуулна.

Х: Та хаагуур, хаагуур отроор явдаг байв?

Б: Би намар 10 сараас эхлээд 12 сар хүртэл “Сайхан дэвсэг”, “Нуурт” гэдэг газруудаар, 12-3 сар хүртэл “Сэвс”, “Хүрэмт” гэдэг газар өвөлжөөнд хариулдаг байсан.

Х: Чухам яагаад энэ газруудыг сонгож отроор явдаг байв? Газар нутгийн онцлогоос болов уу?

Б: Онцлог нь байсан. Газар усанд нь амьтан их очдоггүй, тийм газарт аглаг зэлүүд газар намрын улиралд малыг таргалуулж сэргээж байсан. Хаврын улиралд 3-4 сараас эхэлж “Олон нуур” гэдэг газар гүүгээ төлүүлдэг. Нуурт чинь намрын улиралд аваачиж нуурын ус, урсгал ус уулгаж, аглаг зэлүүд газарт аваачиж, сайн өвсөнд гаргаж таргалуулж ашиг шимийг нь үздэг байсан.

Х: Бусад малыг хэрхэн малладаг байв?

Б: Бусад малыг манай гэрийн хүн, хүүхэд хоёр хариулдаг байсан. Хойт “Олон нуур” гэдэг газарт төллүүлж тэвээрүүлдэг байсан.

Х: Та цэрэгт явж байсан уу?

Б: Би цэрэгт ерөөсөө яваагүй.

Х: Та ер нь Монгол нүүдлийн соёл гэдгийг юу гэж ойлгодог вэ?

Б: Монгол нүүдлийн соёл гэдгийг би хариулсан малаа үхүүлэхгүй мэнд, мах бариулж таргалуулж, чанартай сүү ноосыг авч, хангал эмнэгийг сургаж, унаа морио унахыг би соёл гэж боддог. Одоо малыг тэгж отор нүүдлээр явж таргалуулахгүй байна шүү.

Х: Отроор хэр хол явдаг байсан бэ?

Б: Намрын цагт бол бүр доошоо Ховдын гол ороод, 10-12 сар хүртэл Шилд гарна. Ховдын гол Алтанцөгц сумын төвөөс 90 км газар явна. Олон нуур луу 70 км газар “Сайхан дэвсэг” гэдэг газар оторлуулж тарга хүч авхуулдаг. Манай нутаг усны онцлог бол ерөөсөө намрын цагт Ховдын гол сайхан хөдөө хөх өвсөн дээр ордог.

Х: Таны бодлоор мал маллахын хамгийн сайхан зүйл юу вэ?

Б: Малыг маллавал залхуурч, залхаж болохгүй. Өдөр хариулна, шөнөд манана. Чоно нохойноос хамгаална. Тэвээрүүлнэ, тэнхээрүүлнэ, хужир усанд цатгана тэгж л мал маллавал малчин болно. сумын аварга, аймгийн аварга унагачин гэж нэр алдар авч байсан.

Х: Та морь уяж байсан уу?

Б: Морь ихээр уяж байсангүй. Яахав уяж л байсан. Морио уралдаж барьдаг байсан.

Х: Өөр танд монгол хүнийхээ хувьд эрхэмлэж явдаг зүйл бий юу?

Б: Нам засагтаа үнэтэй цэнтэй хөдөлмөр хийж, хөдөлмөрөө үнэлүүлж, аав ээж, ах дүү, багийнхаа ард түмэнд үнэлэгдэж, хариулсан малдаа хариуцлагатай байх нь зөв гэж боддог. Тэр л байх гэж би боддог.

Х: Танд ажиглагдаж байгаа өөрчлөлтүүд байна уу? (байгаль, цаг уур, хүмүүс г.м)

Б: Одоо бол настай хүмүүс алга болсон. Бага үеийн хүмүүс бол хөдөлмөрөөс зугтдаг, малаас зугтдаг, аймгийн төв рүү ордог болоод байна. Дээр үед бол багийн дарга, суман дарга, аймгийн дарга гэдэг хүмүүсийн урдаас үг хэлдэггүй байсан. “Тэг” гэхээр “за”

гэдэг, тийм газар оторло, хариул, тарга хүчтэй болго гэвэл дагадаг байсан. Одоогийн хүмүүс хувийн малтай болоод тэр юм уу. Мал маллаж базааж байгаа юм алга.

Х: Танд хадгалж үлдэхийг хүсдэг зүйл бий юу? (оюун санаа, өв соёлын хувьд)

Б: Би монгол хүнийхээ хувьд мал хөрөнгөө хүүхэддээ хадгалья гэж боддог. Манай бага үеийн хүмүүсийн хувьд соёл муутай, харьцаа муутай байна. Хүмүүжил муу байна. Бид бол эх эцгийнхээ нэр, багийн даргынхаа нэр, сумын даргынхаа нэр, аймгийн даргынхаа нэрийг хэлдэггүй байсан. Аав ээж л гэхээс биш хамаагүй нэрийг нь хэлдэггүй байсан. Дээр үед бол тэгж харьцдаггүй байсан.

Х: Казах хүмүүс дунд амьдрах ямар вэ?

Б: Зүгээр. Бид дасчихсан болоод тэр юм уу. Бидэнд хор хүргэхгүй. Казах хүмүүс бол соёлтой. Энд 80% нь Казах шүү дээ. Бусад 20% нь Дөрвөд, Урианхай, Тува, Халх улсууд байгаа. Гэхдээ манай Баян-Өлгий бол Казах, Монгол адилхан, орвол ороод цай уучихдаг, хоол идчихдэг. Казах хүмүүс надад ч гэсэн өндөр насны тусламж өгдөг. 50-100 жилийн медаль, хөдөлмөрийн хүндэт медаль хүртэл өгсөн байна.

Х: Та Казах хүмүүсийн дунд амьдарч байгаа болохоор сайн мэдэж байгаа байх, Монгол хүмүүс Казах хүмүүсээс юугаараа ялгагддаг вэ? (соёл, сэтгэлгээний онцлогийн хувьд)

Б: Казах хүмүүс бол хөдөлмөрч, хоолыг бол дээд зэрэг иддэг, хувцас бол авч хэлэлцдэггүй. Манай Монгол хүмүүс соёлоор бол баахан дорой. Гэрт нь ороход үүдээ сахиад өгнө, босч чадахгүй бол өргөөд өгнө, юм үзэхгүй байвал энэ айлаас гаргаад тэр айлд оруулаад өгнө. Соёлтой. Манай Монгол хүмүүс бол баахан үндэс ялгаварладаг. Казахууд тэгж байна, ингэж баайна иймэрхүү ухааны юм ярьдаг.

Х: Та өдөр тутамдаа юу хийдэг вэ?

Б: Би өдөр тутамдаа малын сур элдэж жилдээ 2 үхрийн арьсаар чөдөр тушаа, морины олом, жирэм, цулбуур, хазаар хийдэг, түүнээ бас хэд гурван цаасаар өгчихдөг. Нүдний барагцаагаар хийгээд дадчихсан учраас ингээд хийдэг дээ.

Х: За, ярилцсанд их баярлалаа.

Б: Баярлалаа.

7. Увс аймаг Ховд сум Ожилдоо овогтой Мөнхбаяр 44 настай

Х: Таныг хэн гэдэг вэ?

М: Надыг Ожилдоо Мөнхбаяр гэдэг. Увс аймгийн Ховд сумын Халиунбулагт 1978 онд гэртээ төрсөн, ургийн овог Бөөгөд, эхээс 10-уулаа. 5 хүү, 5 охин. Бага насаа аав ээжийн гар дээр л өнгөрүүлж Ховд суманд 8-р анги төгссөн.

Х: Таны ургийн овог ямар учиртай юм бол?

М: Манай аавын талд бөө хүн байсан үүнээс үүссэн гэдэг юм байна лээ.

Х: Таны гэр бүлийн хүнийг хэн гэдэг вэ? Хэдэн онд айл гэр болж хэдэн хүүхэдтэй болсон бэ?

М: Гэр бүлийн хүнийг маань Даапүрэв гэдэг. Бид хоёр 2001 онд айл гэр болж 2 хүүхэдтэй болсон. Манай том охин Анагаахын их сургуульд сувилагч, бага эмчээр сурдаг, хоёрдугаар курс, бага хүү 8-р анги.

Х: Өмнө нь ямар ажил эрхэлж байв, одоо юу хийдэг вэ?

М: Өмнө нь айл өрх болоогүй байхдаа малчин байгаад 2006 оноос хойш төвд орж ирээд хувиараа машин засах, ноолуур зарж, дэлгүүр түц ажиллуулж худалдаа наймааны бизнес эрхэлсэн.

Х: Аав ээж нь ямар хүмүүс байсан бэ?

М: Манай аав ээж хоёулаа малчин гаралтай. Халиунбулаг гэдэг газарт мал малладаг малчин улс байсан. Одоо хоёулаа байхгүй ээж маань 2 жилийн өмнө нас барсан.

Х: Танайх ямар, ямар мал малладаг байсан бэ?

М: Бид нар хонь ямаа л малладаг байсан. Шийр мал, бог мал ч гэж хэлдэг. Одоо манайх төв дээр арваад үхэртэй.

Х: Ховд суманд хүмүүс ер нь бог мал л малладаг байсан гэж ярих юм. Яагаад тэгдэг юм бол?

М: Тийм, Сумын төвд шийр мал маллах гэвэл бэлчээр байхгүй хөдөө бол уул руу гаргана. Суманд үхэр маллахад хүйтэн боллоо гэхэд пин, хашаа, саравчиндаа хашчихна, дээр үед амьдрал хүрэлцээ муу байсан болохоор хөдөө үхэр малладаггүй. Тэгээд л шийр малаа хариулдаг байлаа.

Х: Хэдий хэрээний тоо толгой малтай байсан бэ?

М: Зуугаад шийртэй байсан. Аав ээжээсээ аваад тал хагасыг нь худалдаж авч байлаа. Тэгээд яваандаа үхэртэй болсон.

Х: Эхээс арвуулаа гэсэн. Таны ах эгч ямар хүмүүс байдаг вэ?

М: Ах эгч дандаа малчин улсууд байгаа, нэг ах маань харин Гоожуурын хүрхрээнд жуулчны баазтай бусад нь бол бүгд энэ нутагтаа малчин.

Х: Танай орон нутгийн хүмүүсийн сэтгэлгээний онцлог ч гэдэг юм уу тиймэрхүү зүйл таньд ажиглагддаг уу?

М: Анх дээр үеэсээ сэтгэл нь маш сайхан байсан. Одоо харьцаа, айл хоршоо байхад хоол цай авч ирээд өгөх, нэгэндээ туслах жишээтэй. Хүний чанар гэдэг зүйл маш өндөр байсан. Харин сүүлийн жилүүдээс хүн чанар гэдэг зүйл нь нийгмээ дагаад ч юм уу муудаад хүн хүндээ итгэх итгэл алга болсон. Жишээ нь одоо нэг ажил хийхээр болвол хуурмаг юм хийх ч юм уу мөнгөний төлөө, яг сэтгэлээрээ хүнд тусалъя гэсэн сэтгэл алга болчихсон. Нэг ёсондоо зах зээлд шилчихсэн. Би бол гэр бариад өгөөч гэвэл мөнгө нэхэхгүйгээр шууд очиж тусална.

Х: Таны амьдралдаа баримталдаг зарчим юу вэ?

М: Зарчим бол ерөөсөө л хүнд тусламтгай. Жишээ нь би байнгын тээвэрт явдаг. Тэгээд хүмүүс юм аваад ир гэвэл авчраад өгдөг. Тэглээ гээд таван цаас нэхдэггүй. Тэр хүнд тус болж л байгаа бол болоо. Ганц баримталдаг зарчим. Түүнийг хүмүүс их ярина. Мөнхбаяр ганц мянган цаас нэхэхгүй итгэлтэй, найдвартай. Би архи дарс тамхи хэрэглэдэггүй учраас илүү итгэл даадаг юм болов уу гэж боддог.

Х: Монгол хүнийг монгол хүн болгодог зүйл нь юу гэж боддог вэ?

М: Монгол хүн ерөөсөө л хүн чанартай, харьцаа харилцаа сайтай байх ёстой гэж би боддог.

Х: Одоо ингээд харж байхад энийгээ л аваад хадгалаад үлдчих юм сан гэж боддог үнэ цэнтэй зүйл байдаг уу?

М: Ганцхан манай ард түмэн дээр үеийнх шигээ хүн чанар сайтай, харьцаа сайтай л байвал их сайн байна. Дээр үед хар буруу санаа байдаггүй байлаа. Одоо бол мөнгө л олж байвал юу ч хамаа байхгүй мэт болчихсон. Бас байгаль орчноо яг байгаагаар нь авч үлдээсэй тэгвэл ан амьтанд ч ээлтэй, үр хүүхдэд ч үнэт зүйл нь болох юм аа.

Х: Өв уламжлал гэж юуг хэлэх вэ?

М: Миний бодож байгаагаар аав ээжээс өвлөгдөн үлдсэн зүйл жишээ нь гэр, зарим хүн “Энэ манай ааваас үлдсэн юм байгаа юм, Энэ манай аавын удмын мал байгаа юм” гэдэг ч юм уу нандигнадаг, хадгалдаг үнэт эдлэл гэх мэт. Надад бол ааваас минь үлдсэн мөнгөн оосортой гаанс бий.

Х: Эд материаллаг өв уламжлалаас гадна, оюун санааны ямар өв уламжлал аав ээжээсээ авч үлдсэн бэ?

М: Хамгийн гол нь аав ээжээсээ хадгалж авсан оюун санааны өв бол архи дарс уухгүй, тусч, сэтгэл санаа сайхантай, хүн чанартай байх юм уу. Үр хүүхдээ ч мөн ингэж өсгөж үлгэр дуурайлал болж өвлүүлэхийг хичээдэг.

Х: Та хүүхдүүдээ хэрхэн хүмүүжүүлж байна? Таны аав ээж мөн таныг хэрхэн хүмүүжүүлдэг байсан бэ? Ялгаатай байна уу?

М: Бидний үеэс одоо бол өмсөж зүүх, идэх уухаас эхлээд шал өөр. Бидний үед гурил мах л байхад болдог байлаа өглөө эрт босгоно, малд байнгийн явуулж ажил хөдөлмөрт эртнээс сургадаг байлаа. Одоо хүүхдүүдээ ингэж л ажил хөдөлмөрт сургах хэрэгтэй, гэр барьдаг хүүхэд байхгүй болж байна. Гэр бариад сурахад амьдралд нь хэрэгтэй. Тийм болохоор өөрсдөө үлгэрлэж сургах хэрэгтэй.

Х: Танайх зуны гэрээ барьж байгаа юм байна, хажуу гэр нь мөн танай гэр үү?

М: Тийм, банаг гэр гэдэг учраас өвөлдөө барьдаг. Манай аав ээжээс уламжлан үлдсэн бидний аав ээжтэйгээ өссөн гэр. Үүнийгээ өвлийн цагт бариад, өөрийнхөө гэрийг зундаа барьдаг. Би адгийн (хүүхдүүдээсээ хамгийн бага нь) хүү учраас надад өвлөгдсөн юм.

Х: Сум орон нутаг, байгаль, цаг уур, хүмүүсийн сэтгэлгээ зэрэг дээр өөрчлөгдөж байгаа, тулгамдаж байгаа асуудал байна уу?

М: Сум орон нутагт маань байгалийн хуурайшилт маш их явагдаж байна. Бороо орохгүй. Миний бодлоор байгалийн ус нь татраад багасаад байх шиг санагдаад байгаа юм. Гол нарийсаад, булаг шанд ширгээд, хүнийг зовоож байгаа юм тэр байна. Бид нар чинь одоо зуслан гарна. Энэ гэр байшингаа цоожлоод орхидог, энд байх боломж байдаггүй. Ялаа шумуул гарна. Энэ сумын бүх айл хамгийн наад тал нь тавиас дээшээ зусландаа зусна, зөвхөн албан хаагч энд үлдэнэ. Намар найман сарын хорин гэж орж ирж энд буудаг. Дээр

үед ганцхан эсвэл хоёр трактораар нүүдэг, заримдаа бүх малчид тэмээ унаагаар ачиж нүүдэг байсан. Одоо сүүлийн үед машин тэрэг нь ихдээд портероор нүүдэг болчихсон.

Х: Танай энд ямар, ямар гол байдаг вэ?

М: Ховд гол гээд том гол урсаж байна, Шивэрийн гол тэгээд “Олон нуур” гээд 108 нууртай газар байгаа. “Шаазгай нуур” хойд талдаа “Ачит нуур”-тай манай энэ хавь хамгийн их гол устай газар л даа.

Х: Ширгэсэн гол бий юу?

М: Ширгэсэн гол нь нуурын булгаас нуурлуу эх авч урсдаг булаг тасраад эхэндээ нэг жаахан болчихсон, дээр нь олон нуур чиглэлд хоёр гурван газар ус гардаг байж байгаад ийм юм боллоо булаг шанд байсан тэгээд ширгээд алга болсон хув хуурай. Тэгээд одоо нуур нь дотогшоо бага, бага жижигхэн болчихсон ч байна үүнийг одоо хуурайшилттай холбоотой юм болов уу гэж боддог.

Х: Зундаа хөдөө гарчихаар худалдаа наймаа, тээврээ хийх үү?

М: Хийнэ, тэндээсээ ирж очоод л явна. Хөдөө нь очоод бөөн айлууд буусан газар дэлгүүр хоршоо барьчихна. Одоо корона гээд ойрын 3 жил явж чадаагүй. Тэрнээс урдаар ах нь зунжин 6 сарын 1 нээс яваад 8 сард орж ирдэг байлаа. Машинаар жуулчинд Алтай таван богд, Цамбагарав, Олон нуур, Хяргас нуур, Хөвсгөл гээд зунжин явж ирдэг байсан. Энэ зун харин хоёр, гурван компанитай гэрээ хийсэн. Нилээн газар хэссэн мөн Хэнтийн Дадал суманд хоёр хоноод ирсэн. Баруун таван аймгийн бүх сумдаар явсан.

Х: Та хэдэн жил мал малласан бэ?

М: Би арваад жил малласан. Аав ээжийнхээ гар дээр тэгээд өөрөө айл өрх болоод арваад жил маллаад төв газар орж ирсэн.

Х: Танайх ямар баг гэж явдаг вэ?

М: Манай сум 4 багтай. Манайх Шивэр баг гэж явдаг, 2-р баг гэдэг.

Х: Энэ олон газар үзэж байхад юу бодогдож байв? Танай сум энэ олон газраас юугаараа ялгарч байна?

М: Манай сум ганцхан энэ үзэсгэлэнт байгалиараа ялгарна. Ийшээ явахаар Олон нуур, рашаан, вансэмбэрүү үзнэ, тийшээ явахаар хүрхрээ үзэх жишээтэй. Манай сум өндөр өндөр уултай, өргөн голтой, ан амьтад нь тусгай хамгаалттай газар байдаг. Түүнээс биш

сумын хөгжлөөрөө ялгарахгүй. Манай сумаас илүү хөгжилтэй тасархай тасархай, жишиг сум зөндөө байна.

Х: Тусгай хамгаалалттай газар нь ямар ямар ан амьтад байдаг вэ?

М: Өмнө-Отор гээд эндээс 60 километрийн зайд зуслангийн газар хамгаалалтын нөхөрлөл гэж байгуулаад хориод айл байдаг. Би үүний ерөнхий менежер гэдэг юм уу бичиг хэргийг хөтөлдөг юм. Тэнд одоо аргаль, янгир, ирвэс бүх л амьтан бий, дандаа дархан цаазанд орсон амьтад. Тэндээ жуулчид хүлээн авна, гадаадын жуулчин орж ирж тахь, аргаль агнана. Морь, янгир унуулна, санхүүжилт нь орон нутагт мөн нөхөрлөлийн найзуудад ч орно. Тэндээс бид нар морь унааг нь, жуулчид ирж байрлах гэрийг нь бэлдэнэ. Тэгээд гэр бариад гэртээ хоносон хөлсөө авна. Нөхөрлөл байгуулахдаа нэг айлаас зуун мянгыг өгөөд дундын сан бүрдүүлчихсэн тэндээсээ юмаа гаргаад анчдад зориулсан хоёр гурван гэр бэлддэг.

Х: Тэндээс ямар, ямар амьтан агнаж болох вэ?

М: Аргаль, тахь хоёр л агнана. Бусад жижиг шонхор шувуу, хойлог агнахгүй. Ноднин гэхэд л таван тахь агнасан нь сум орон нутагт гучаад сая төгрөгний орлого орсон.

Х: Сум орон нутаг нь тэр орлогоороо юу хийж байна вэ?

М: Сумын байгаль хамгаалах чиглэлд нь буцааж тал хувийг нь ашигладаг. Тэр нөхөрлөлийн хэмжээнд булаг шанд хаших ч юм уу, байгалийн тусгай хамгаалалттай газарт хаалт хийх, ан амьтанд хужир, давс тавьдаг.

Х: Ан амьтад нь тэр ууландаа л өөр тийшээ явалгүй байдаг юм уу?

М: Цаашаа Олон нуур, Хороо гэдэг газар руу зундаа гарчихаад байгалийн амьтан чинь угаасаа тэр өвстэй сайхан өндөр ууландаа ирчихдэг.

Х: Үнэхээр сонирхолтой зүйл ярилаа. Танайх тээвэрт явдаг гэсэн шүү дээ. Бараанд явна гэсэн үг үү? Хаанаас бараагаа татдаг вэ?

М: Бараагаа Баян-Өлгийгөөс татна бас хотоос татна. Хотоос бол том ачааны машинаар, эндээс бол яахав жижиг машинаар татдаг. Баян-Өлгий эндээс 112 километр, шороон замтай. Хот бол эндээс 1500 километр газар, дээр нь ачааны зардал гарна. Тийм болохоор ихэнхдээ л Баян-Өлгийгөөс хүнсний зүйл, барилгын материал зэргийг татдаг.

Х: За, ярилцсанд их баярлалаа.

М: Баярлалаа.

8. Алх овогтой Гүрмийн Нансалмаа, 67 настай

Х: Сайн байна уу? Та залуудаа юу хийж байсан бэ?

Н: Бигэр сумын “Эрх чөлөө” нэгдлийн гишүүн. 1972 онд 7-р ангиа төгсөөд илгээлт аваад малчин болсон. Тэр үед 300 төгрөгөөр илгээлт өгдөг байсан. 1988 онд “Тэргүүний саальчин болсон. Тэгээд би засгийн газрын “Хүндэт жуух” бичиг авч байсан. 220 ямаанаас 240 ишиг бойжуулж байлаа. Пүрэвдорж гэж сумын нэгдлийн дарга байсан, Зундуй гэж хүн жуух бичгийг маань гардуулж өгсөн юм. Тэр үед их гоё байлаа. Одоо манайх 3-р баг гэж явдаг. Одоо ч гэсэн тэтгэвэртээ гараад малаа маллаад л амьдарч байна.

Х: Хаана малаа маллаж байсан бэ?

Н: Бурхан буудай, Баян-Сайр, энэ ууландаа, баруун талдаа Шар хадны булагт малаа маллаж байлаа.

Х: Таны гэр бүлийн хүн ямар хүн байдаг вэ?

Н: Балдан гэж хүн байж байгаад бурхан болчихсон юм. Тэр хөгшин 1970 онд цэрэгт яваад, бид хоёр 1973 онд айл орон болж байлаа. Тэгээд хамт мал маллаж амьдарсан. Бурхан буудайд нутаглаж байгаад одоо манай гэр орон бол Баян Сайрт байна. Их сайхан ажилтай хүн байсан. 65 хүрээд л уушгиар явсан даа. Одоо миний үеийнхэн дуусаж дээ. Үетийн аманд ганцаараа үлдлээ.

Х: Та хэдэн хүүхэдтэй вэ?

Н: Найман хүүхэдтэй, том хүү маань хотод Тахилтад хувийн бизнес хийгээд, дэлгүүр ажиллуулж байгаа. Дараагийн охин Алтантуяа “Алтан буудай” төвд ажилладаг. Худалдааны тэргүүнээр шагнуулсан, хамгийн бага малчин хүү маань “Аймгийн аварга малчин”, манай Баянхүйд байна. Дараагийнх нь энэ жил “Сумын аварга малчин” болсон Батбаатар гэж байна. Отгон хүү Батбаатартайгаа бас отгон охин Аззаяа, Хатанбаатар, Насжавтай айл буучихсан. Гайгүй явж байна, хэдэн хүүхэд минь. Надад одоо гачигдсан дутагдсан юм алга. Би хотод өвөлжөөд, зундаа нутагтаа ирдэг.

Х: Та өдөр тутамдаа юу хийж байна?

Н: Би бол сааль сүүгээ сайхан хийдэг юм. Өглөөдөө 200-аад ямаа саагаад 6 хувин 80 литр сүү авдаг. Охин маань төрчихсөн, аравхан хонож байгаа, нялх биетэй болохоор тэрнийгээ ганцаараа борлуулж байна.

Х: Танайх ямар, ямар малтай вэ?

Н: Тэмээнээс бусад нь бий. Хонь ямаа, адуу, сарлагтай. 15 гүү унагласан, 17 үхэр тугалсан. Эмээ нь өөр дээрээ 120 бог малтай. Хүү л хариулж өгдөг юм. Надад хөдөлмөрийн чадвар байх биш. Би бол сааль сүүнийхээ ажлыг хийгээд л янзын их зуншаад хэдэн хүүхэддээ хуваагаад л өгчихдөг. Хотод хоёр хүү, хоёр охин байна.

Х: Өдөр тутамдаа та сааль сүүний ажил гэж юу, юу хийж байна?

Н: Сүүгээ хөөрүүлээд, таргаа бүрнэ, ааруулаа хийнэ, бяслагаа шахаад, айргаа исгэнэ. Тогоо нэрнэ. Эмээ нь сүүгээр эдүүлээд л ааруулаа их гоё хийдэг шүү дээ. Манай аарууланд хүн нугасгүй. Мөн бор тос хийнэ. Бор тосоо гартаа бөөгнүүлээд үрлэн чихэр шиг хийчихнэ. Тэгээд таваг дүүргэсэн чинь их гоё харагддаг юм байна. Ааруулаа болохоор зүсээд жижигхэн жижигхэн саран ааруул хийдэг. Саран ааруулыг хэвэнд хэвлээд хийдэг.

Х: Бор тос гэдэг нь юу билээ?

Н: Бор тос гэдэг нь зөөхийгөө хайлаад гурил, сахар хийгээд хольдог. Тэгээд тэр бүтээгдэхүүнээ үрлэн хэлбэртэй болгоод идээ тавьсан байна.

Х: Юуны сүүгээр цагаан идээгээ боловсруулж байна. Сарлагаа саадаг уу?

Н: Ямааны сүүгээр энэ бүгдийг хийж байна. Одоо зусландаа гараагүй хаваржаандаа байна. Тэгээд сарлаг чинь тугал нь дийлдэхгүй, хүүхэдтэй л саах байх, би чинь хөл муутай болохоор чирэгдэнэ. Би бол дан ямаагаараа зуншина. Долоон сар хүргээд ямааны сүү багасна, өтгөрнө. 200-аад ямаа бий. 8 сарын хорьд хүртэл саана. Хөгшин бид хоёр 4 нялх хүүхэдтэй байхдаа 510-аад адуу маллаж байсан, тэр үед манайх тэмээгээр нүүдэг байлаа. Ундны усаа үүрдэг байлаа. Одоогийн хүүхнүүд мотоциклоор ус авчихна, жаргалтай юм.

Х: Хэр олон тэмээтэй байсан бэ?

Н: Манайх 20 гаруй тэмээтэй байсан. Жилбүү гэж аттай, Гамбир гэж цагаан ингэ байсан. Бамбарууш гэж хөөрхөн ирээд саалгачихаад явчихдаг сайхан амьтан байдаг байсан. Манайх чинь таван хошуу малтай байлаа.

Х: Хэзээнээс тэмээ маллахаа больсон бэ?

Н: 1990 оноос хойш маллахаа больсон, яагаад гэхээр нутаг таарахгүй. Энэ ууланд бут байхгүй болохоор тэмээ тогтдоггүй юм байна лээ. Манайх урьд нь голд нутагладаг байж байгаад, нутгаа солиод ууланд гарсан юм. Тэгээд л хэдэн тэмээгээ зарахыг нь зарсан даа. Үетэд өвөлждөг одоо Алтайнсайрд, Баянсайрд зусдаг юм. Тал руугаа намаржчихдаг. Ингээд л сайхан нүүгээд нутагладаг. Миний нутаг, гоё нутаг шүү. Бурхан буудайнхаа энгэрт.

Х: Та нутаг орныхоо онцлогийг яриач?

Н: Үетийн амнаас гурван гол урсдаг. Тэгээд усаар бол тасардаггүй тийм сайхан байгальтай. Энэ Бигэр нуур байж байх жишээтэй. Айлууд төмс, байцайнаас эхлээд тариа ногоо тарьдаг.

Х: Сүүлийн үед өөрчлөгдөж байгаа зүйл юу байна?

Н: Ган гачиг болж байна хөөрхий. Энүүгээр 11 айл байсан нүүгээд л залуучууд болчихсон. Тэгээд сайн байна уу? гэж мэндэлдэг хүүхэд алга байна. Юу байна? гэж асуух юм. Сааль хийх хүүхэд алга. Юмаа мэдэхгүй.

Х: Танай сум орон нутгийн хүмүүс ихэвчлэн ямар ажил хийж байна. Малчид хэр их байна?

Н: Манай нутаг их баян юм байна. Бүгд хашаандаа ногоо, гоё жимс тарьж байна. Манай сумын 100 жилийн ой 2024 онд болно. Тэгээд айл бүхэнд гурван мод өгсөн байна. Би баярлаж байгаа юм. Малчид их байна. Хонио хайчилна, ажил ихтэй шүү дээ. Өвс тариад хураагаад зарна. Тэгээд нэг машин өвсийг нь мануус 150 мянгаар худалдаж авна. Ер нь малын тэжээлээ авахад хотоос авчирсан бол хоёр нугалж зардаг. Эндээ тарьсан бол үнэ нь арай хямд байдаг. Түүхий эд нь үнэгүй байна. Одоо манайх сая бүх ямаагаа самнаад өгөхөд л 90 мянгатай байна шүү дээ. Цагаан ноолуур нь 110 мянга байсан юм. Тэгээд 120 айлын орон сууц барьж байна, манайхан чинь ажилтай.

Х: Яагаад танайх ийм орой ямаагаа самнаж байна?

Н: Хөөрөхгүй байна. Цас их орсноос болоод ямаагаа үрэгдчихнэ гээд орой самнадаг байхгүй юу. Өндөр газар чинь чийг ихтэй, идэш муутай. Агь, шовог иднэ тэгээд цагаан өвс иднэ. Сая манай хүүхэд 650 ямаа самнасан. Бүгдийг нь 80 мянган төгрөгөөр өгсөн. Харин цагаан ноолуураа 95 мянгаар өгсөн.

Х: Та хэзээ, ямар үед хамгийн их баярлаж байсан бэ?

Н: Эмээ нь нэг л удаа баярлаж үзсэн. Засгийн газар хүндэт “жуух бичиг”, 30 төгрөгний цаг тэгээд нэг баярын бичиг өгсөн.

Х: Танай энд дарсны нээлт болж байгаа юм байна. Ямар жимсээр хийж байна?

Н: Энэ манай нутгийн ганц брэнд шүү дээ. Та хэд ийм гоё нээлт дээр ирсэн байна. Чацаргана дарслаад хийж байна. Бас манай энд ургадаг шөвгөр улаан гээд алим байдаг юм. Түүнийг эсгээд сахар хийгээд бэлэн болохоор нь сувилалд бид нарт бас өгдөг. Байгуулагдаад 50 жил болоод өнөөдөр өрөгтгөлөө хийж байна. Чацаргана, алим хоёроо тариад хичнээн тонноор нь авч ирээд дарсаа хийдэг.

Х: Өөр ямар жимс, ногоо ургадаг вэ?

Н: Манай хөдөө зэрлэг сонгино их ургаж байна.

Х: Танай сум, орон нутгийн хүмүүсийн сэтгэлгээний онцлог ч гэдэг юм уу, ер нь танай сумын хүмүүс ямар хүмүүс байна вэ?

Н: Манайхан ер нь мундаг шүү дээ. Нийтгэч, одоо ингээд худаг гаргасан ч гэсэн хамжаад худагтай болчихно. Морьтой Жамбал гээд хөгшин бор голд тариа тарьдаг хүн байгаа. Одоо үед бүх хүн машин мотоцикл унаж байхад тэр хүн дал хүрч байгаа хэр нь морио унаад, дурангаа үүрээд л явдаг.

Х: Энэ “Шимт дээж” гэдэг дарсны үйлдвэрт хичнээн хүн ажилладаг вэ?

Н: Даргыг нь Энхтүвшин гэдэг. 20, 30 хүн байна.

Х: Байгаль цаг уур, бэлчээр ус нь ямархуу вэ?

Н: Бэлчээр жаахан хомсдуу л байна даа. Одоо ингээд гоё ногоорчихоод шуураад байх юм. Долоон сард гардаг Рашаантын рашаан өчигдөр гарчихсан байх юм.

Х: Таныхаар монгол хүний эрхэмлэх ёстой үнэ цэнтэй зүйлийг юу гэж боддог вэ?

Н: Одоо хүний амьдрал бэлэнчлээд сурчихсан байна. Дээр үед тэмээгээ хөтлөөд нүүдэг, морио унадаг, алхдаг байсан. Би гэхэд өрхөө өөрөө оёчихдог байлаа. Одооны охид, хүүхнүүд өрхөө өнгөлөхгүй байна. Утсаар тоглоод л, машин унаад л, телевизор үзээд л сууж байна. Би бол монгол хүний эрхэмлэх ёстой зүйлийг таван хошуу малаа л гэж боддог.

Х: Одоо үеийн хүүхдийн хүмүүжил хэр байна, хүмүүсийн харилцаа хандлага нь дээр үеийнхээс яаж өөрчлөгдсөн байна вэ?

Н: Хөгшчүүл нь харилцаа сайтай байна. Одооны хүүхэд бол “бууралдаа юм аваад ир” гэхээр “завгүй” гэж хэлээд утас оролдоод сууж байна. Ер нь хүмүүжил алга. Хүнийг хүндлэхгүй байна. Уул нь таваг дүүрэн идээ тавиад, аяга дүүрэн цай аягалаад өгөхөд буян тогтдог гэдэг. Тэгэхэд ус буцалгаж өгчихөөд хэдэн чихэр тавьчихаад л байдаг. Гэхдээ хүүхдийн хүмүүжил хөдөө талдаа арай дээр, хотод бол хүмүүжилтэй хүүхэд байхгүй байна шүү дээ. Тэгээд хүмүүжил гэдэг бол ээж аавтай л холбоотой байдаг байх.

Х: Та найман хүүхдээ хэрхэн хүмүүжүүлж өсгөсөн бэ?

Н: Би найман хүүхдээ ваннд хийчихээд, арганд суулгаж байгаад хүн болгосон. Миний хүүхдүүд шороо самарч, сүүл хөхөж хүн болсон. Дагуулж явдаггүй байлаа, одооны энэ ээж аав дагуулаад л явах юм. Одоо нулимсгүй уйлахад л “ээж хүүхэд ав” гээд байх юм. Ямар учиртай байдаг юм. Хөдөө өсөж байгаа ач нар бол аягатай хоолоо бариад идчихэж байна. Хотын хүүхэд бол хоол идэж чаддаггүй асгаж цутгаад л. Тэгээд ээж нь махыг нь түүгээд халбагадаж өгдөг. Хөдөө хотын ялгаа тийм л байна. Би чинь арван долоохон насандаа хоёр хүүхдээ асарч байсан их юм мэднэ. Хөдөөний хүүхэд хамаагүй зөөлөн чихтэй байдаг. Хотын хүүхэд ороо хураахгүй яваад өгнө. Хөдөөний хүүхэд нүүрээ угаагаад ороо хураагаад малдаа гардаг тийм гоё.

Х: Та залуудаа юу хийдэг байв?

Н: Ингэ саагаад л, хармаг мориор түүгээд л. Өнөөдөр ярьж л байлаа. Нансалмаа буурцгийн аварга болж байсан гээд. Арвын бетон ганзгалаад л давхиад ирдэг байлаа.

Х: Хармаг гэдэг нь юу юм бол?

Н: Хармаг гэдэг нь архи нэрдэг ургамал байхгүй юу. Хүрэнгээд л. Одоо ч ургадаг. Тэр үед төгрөг тавин мөнгө байсан. Тэгээд тэр хармагны буурцагаар хийсэн архи нь дөчин найман төгрөг байсан.

Х: Таньд монголчуудын өв соёлоос үүнийг л хадгалж үлдээсэй гэж бодсон зүйл байдаг уу?

Н: Хүн хүнээ хүндлэх. Бусадтай сайхан харьцаж, хоол унд сайтай, сайхан угтаж байгаасай гэж боддог. Хүнд идээ тавьсан байсан ч ууттай нь тавих юм бол хүн хүрэхгүй. Сайхан задгай, дүүрэн байх юм бол буян нь хураагдаад л байдаг гэж байгаа юм. Тийм

учраас хүнд аяга дүүрэн цай, таваг дүүрэн идээ тавьж байгаасай гэж хүсдэг. Хүмүүс үнэндээ залхуу байна. Ажилтай хүн сайхан амьдарч, ажил муутай залхуу хүн тааруухан л амьдарч байна. Ямаагаа саахгүй одоо тэгээд ишигээ яаж баринаа гээд л санаагаар унаад. /инээв/

Х: Ишгийг яаж барих уу?

Оройдоо ишгийг ялгачихдаг юм. Хашаанд хийгээд, өглөө ямаагаа саагаад хоньтойгоо явуулаад орой таван цагт ишгээ ялгаад л өглөө саана. Хөдөөний амьдрал сайхан байна даа.

Х: Сайхан яриа өгсөнд баярлалаа.

Н: Баярлалаа миний хүү.

9. Увс аймгийн Ховд сум, Цэрэнчимэд

Х: Таны ургийн овог юу вэ?

Ц: Миний ургийн овог Сэтэрхий зүүтрэг.

Х: Энэ ямар утгатай овог вэ?

За энэ одоо манай Дөрвөдүүд дунд л ийм уг байдаг юм л даа. Дөрвөдийн дээд үеийн Далай хааны нэг ийм овог байдаг юм. Бөхмөрөн, Түргэн тал руугаа ихэвчлэн их байгаа.

Х: Та хаана төрсөн бэ? Аль багт?

Н: Одоо энэ Ачит нуур байгаа манай сум Бөхмөрөн сум Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сум дамнасан цэнгэг устай сайхан нуур байдаг. Тэр нуурын баруун цэгээн гэдэгт төрсөн. Тэр баруун цэгээн одоо Ногоон нуур сумын харьяа болоод явчихлаа. 1955 онд би хонин жилд төрсөн юм. Тэгэхэд тэр үед бол нүүдэлчин ард түмэн учраас манай аав ээж баруун тийшээ отроор нүүж байсан. Тэгээд нүүдэлд явах замд тэр нуурын баруун цэгээнд төрсөн юм аа. Ачит нуурын баруун хөвөөнд төрсөн.

Х: Та хоёр хэдийд гэр бүл болов? Хэдэн хүүхэдтэй вэ?

Ц: За, бид хоёр чинь 1980 онд гэр бүл болсон. Одоо 40 хэдэн жил болж байх шиг байна. Гурван хүүхэдтэй. Манайх таван хүүхэд төрүүлсэн тэгээд хоёр хүүхэд нь багадаа эндсэн. Тэгээд одоо гурван хүүхэдтэй. Одоо өрх тусгаарлаад тусдаа гарсан.

Х: Сумандаа байна уу? Мал маллаж байгаа хүүхэд байна уу?

Н: Манай том хүү Улаанбаатар хотод байна. Компьютер технологийн мэргэжилтэй. Дараагийн хүү энд сумын төвд байна аа. Сумын төвд Засаг Даргын Тамгын Газрын хөдөлмөр халамжийн байцаагч. Нийгмийн ажилтан мэргэжилтэй л дээ.

Х: Охин нь энэ хэдийн ээж үү?

Энэ хэд хүүгийн хүүхдүүд. Түүрүүнд энд хэвтээд байсан хүүхэд тэр манай охиных, тэднийх хоёр хүүхэдтэй. Охин тогооч мэргэжилтэй, хувиараа гуанз ажиллуулж байгаа. Охин Гантуяа тэгээд хэдүүлээ байж байдаг юм.

Х: Та ер нь залуудаа ямар ажил төрөл эрхэлдэг байв?

Ц: Өө, би ч залуудаа нөгөө нэгдэл нийгмийн үед нэгдэл гээд ХАА-н нэгдэл байх үед механик олон жил хийсэн. Механикч гэдэг чинь нэг техник хариуцсан хүн шүү дээ. Тэгээд тэрний өмнө тракторын жолооч байсан. За тэгээд нэгдэл хувьчлагдаад нэгдлийн ажил дууссан. Дараагаар нь хувиараа машин тэрэг бариад л жолооч, малчин л хийлээ. Багийн иргэдийн нийтийн хурлын дарга, багийн дарга хийгээд л, баг маг эргэсэн нэг тийм жижиг сажиг сонгуульт ажлуудыг олон жил хийсэн. Одоо тэтгэвэрт гараад сумын ахмадын хорооны дарга гэсэн нэг сонгуульт ажилтай л байж байна шүү дээ.

Х: Ер нь л дарга хийж байсан юм уу даа?

Ц: Тийм. Тэгээд жижиг сажиг ажил хийгээд төрсөн нутагтаа ерөнхийдөө ингээд л байж байна. Одоо нас 67 хүрч явна. Одоо хаа холдох вэ дээ, эндээ л байхаас өөр арга алга.

Х: Танайх ямар мал малладаг вэ? Хэр удаан мал маллав?

Ц: Өө, тэр хувьчлалын дараагаар зүгээр өөрсдийнхөө хувьчлалаар авсан хэдэн малаа 3 жил орчим малаа малласан.

Х: Яг хөдөө байсан уу? Одоо төв дээр үхэртэй юм байна шүү дээ.

Ц: Тийм одоо төв дээр, тэр бол ийшээ зайдуухан хөдөө холгүйхэн л байдаг байлаа. Сумын төвөөсөө зайдуухан хонь ямаа л маллаж байсан.

Х: Шийр мал гэж ярьдаг юм байна лээ шүү дээ, тийм ээ?

Ц: Тийм ээ тийм, бог мал л даа. Хэд гурван богоо бас хоёр гурван жил хариулсан. Тэгээд хүүхдүүд хичээл сургуульд яваад л тэгээд бас мал хараа энд тэнд хүн амьтан дээр тавиад машин техниктэй болоод бас машинаар ойр зуур ажил, тээвэр хийхээр явж байсан.

тэтгэвэрт гартлаа машин техникээр тиймэрхүү юм хийгээд л байсан. Багийн хурлын дарга тэгээд сонгуульт ажлуудыг ерөнхийдөө гүйцэтгээд л байсан.

Х: Та ер нь нилээн нийгмийн идэвхтэй хүн үү?

Ц: Үгүй ээ, одоо тэгээд байгаа боломжоороо л нийгмийн юманд оролцоно оо оролцоно. Бас тийм байхгүй бол болохгүй байна л даа. Ер нь одоо социализмын үеийн хүмүүс бас тийм ёс суртахуунтай сурч ирсэн юм л даа. Тэгээд одоо тэр утгаараа одоогийн хүмүүсийн янз бүрийн нийгмийн идэвх сулраад байна л даа. Нийгмийн оролцоо их муу болчихоод их төвөгтэй байгааг бас би шүүмжилдэг юм л даа. Тэгээд ер нь л муу байна. Түүн дээр явал зохилтой юм бэ гэж бодож явдаг.

Х: Та нүүдэлчин хүмүүсийн оюун санааны үнэт зүйлийг юу гэж ойлгодог вэ? Одоо энэ маань л юм даа гэж ойлгож явдаг зүйл байна уу?

Ц: За, ер нь Монгол улс, монголын ард түмэн гэдэг бол бас их онцлог. Бусад төвлөрсөн сууриншилд ажиллаж амьдардаг улс орнуудын хажууд бол Монголд ажиллаж амьдарч байгаа хүмүүс бол онцлогтой. Монголын энэ цэнхэр доор төрсөн хувьтай хүмүүс учраас онцлогтой. Өөр өөрсдийн арга ухаанаар амьдардаг. Олон зуун жил амьдарч ирсэн түүхтэй бас их сайхан хүмүүс л дээ. Тэр утгаараа өөр өөрсдийгөө ерөөсөө яаж ийгээд л бүгдийг болгодог. Монгол хүний ёс заншил гэдэг бол тэр нь их онцлог. Хувцсаа хийгээд өмсчихдөг, хоолоо хийгээд идчихдэг. Ерөөсөө л бүхий л амьжиргааны төрөл бүрийн хэрэглэгдэхүүнээ ашиглаж өөрийн нөөц боломжоороо тэр битгий хэл дархан мужаан хүн багажаа өөрөө хийчихдэг. Өөрийн хийсэн багажаараа мужаан, дархан хийдэг тийм л байсан онцлогтой. Одоо бол юм хөгжөөд тэгж өөрөө багаж хийдэг хүн гэж байхгүй. Бэлэн зэлэн сайхан л болоод байна. Ер нь онцлог, онцлог талууд монгол хүнд олон байна. Ер нь одоо ажиллаж амьдрахдаа монгол хүн чинь ямар билээ. Нүүдэлчин монгол гэдэг чинь бүх юмаа өөрөө л хийдэг. Өөрийн арга ухаанаар хийдэг ёс заншил байсан. Ёс заншил гэдэг юм их сайхан байсан байгаа юм л даа. Бичигдээгүй хууль байхгүй юу даа. Тэр бол нэгэнт монгол хүн болж төрснийхөө хувь заяанд итгэж төрийнхөө сүлдэнд залбираад сайхан амьдардаг. Тэндээ ажиллах л ёстой, амьдрах л ёстой гэсэн бараг иргэний үүргээ нэг талдаа бичигдээгүй хуулиар л зохицуулж байсан. Ийм л сайхан ёс заншил. Байгаль орчинтойгоо харьцсан зөв л харьцаж бид амьдрах ёстой. Байгаль дэлхий байж хүн байж байна гэдгийг ойлгож чаддаг тийм их ёс суртахуунтай ёс зүйтэй нэг ёсны тэр зан заншлаараа, аав ээжийн захиасаар ирсэн уламжлалт ёс заншлыг сайхан зөв хадгалж ирсэн түүхээр л монгол хүний гол бахархал болов уу гэж би боддог. Жишээ

нь байгальтайгаа зөв харьцаад энэ байгаль чинь л байгаль байж хүн байдаг учраас энэ модыг энэ уул усыг өөрийн юм шиг хамгаалж устгачихгүй хайрлаж ирсэн ийм л их сайхан уламжлалт арга л даа. Уламжлалт арга ухаанаараа л байгалиа, бүх юмаа хамгаалж ирлээ. Уламжлалт аргаар ерөөсөө амьдарч ирсэн ийм их сайхан уламжлалын арга ухаанаар л монгол хүн их бахархмаар юм байгаа юм л даа.

Х: Таны аав ээж ямаршуухан хүмүүс байв? Таныг яаж хүмүүжүүлж байв?

Ц: Аав ээж сайхан байлгүй яах вэ дээ. Би айлын бага нь л даа. Манай аав ээж бас л гурван хүүхэд өсгөсөн юм аа. Сайхан л хүмүүс байсан. Би айлын хамгийн бага нь болохоор аав маань намайг 8 нас хүрч байх үед өнгөрсөн. Ээж маань түүнээс хойш 8, 9 жил болоод өнгөрсөн. Би хагас өнчин өссөн хүн л дээ. Аав маань нилээн багад өнгөрсөн болохоор ээжийнхээ хажууд л байж байсан. Хамгийн бага хүүхэд юм болохоор эрх хүүхэд байсан. Сургуульд байхдаа бол онц сурдаг хүүхэд байлаа.

Х: Аав ээжээсээ хойш хэний гар дээр өсөв?

Ц: Ээж маань 17 настайд л өнгөрсөн л дөө. Тэр үед сургуульд 8-р анги төгсөөд бидний үед коллежид явдаг байсан юм. Техник мэргэжлийн сургуульд би хувиарлагдсан юм. Одоогийн коллеж л доо. ЗХУ-ын ХАА-н техник мэргэжлийн сургуульд механикжуулагч мэргэжил эзэмшсэн. Механик ч гэдэг чинь ерөөсөө энэ газар тариалангийн трактор комбайн, ХАА-н машин тэр бүгдийг ЗХУ-д цогцоор нь сургадаг байлаа шүү дээ. Тэр үед чинь хэд хэдэн зуугаар нь хүүхдүүдийг аваачиж сургадаг. Тэгээд тэр хувиарыг аваад одоогийн ОХУ-ын Омск мужид 2 жил суралцсан. Тэр хооронд л ээж маань өнгөрөөд тэгээд зундаа ирдэг л байсан л даа. Тэгээд 2 жил болоод сургуулиа төгсөөд Баруун турууны сангийн аж ахуйд ХАА-н яамны томилолтоор анх ирсэн.

Х: Тэр нь хаана байдаг газар вэ?

Ц: Манай аймагт ганцхан Баруун турууны сангийн аж ахуй байсан. Тэнд томилолтоор ирж анх ажлынхаа гарааг эхэлж байлаа. Тэгээд тэндээ хоёр жил ажиллаад буцаад цэргийн албанд явсан.

Х: Цэргийн алба хаана хаасан бэ?

Ц: Улаанбаатар хотод гурван жил цэргийн алба хаасан. Одоогийн тэр Орбит станцын хажууд радио тагнуулын анги гэж байсан юм. Одоо больсон байна лээ. Тэр ангид 3 жил цэргийн алба хаагаад эргээд сумандаа ирсэн. Өөрийнхөө суманд ирээд төрсөн ах дээрээ

ирсэн. Төрсөн нутгаасаа хүн холдож чаддаггүй юм байна лээ. Эргээд Баруун турууны сангийн аж ахуйд очвол очих л байсан. Сумандаа ирээд сангийн аж ахуй руу яваагүй. Сумандаа мэргэжлээрээ трактор барьж байгаад, “би ер нь жаахан боловсролоо ахиуль” гэж бодоод Улаанбаатар хотод дахиж авто тээврийн сургуульд явсан. Ажилчдын элсэлт гээд тэр үед чинь бас чанга байлаа. Аймаг орж ажилчдын элсэлтийн конкурс өгөөд тэнд 3 жил суралцсан. Гурван жил суралцаад механик болсон. Механик инженер болж байгаа юм л даа. Эргээд нутагтаа ирээд 10-аад жил ажиллаад, нэгдэл хувьчлагдаад бүх юм хувьд гараад тэгээд мэргэжлийнхээ ажлыг хийгээгүй орхисон. Тэгээд машин барих, мал маллах, багийн хурлын дарга энэ тэр гээд л явж байсан.

Х: Яагаад мал маллах болов?

Ц: Тэр үед суманд байсан хүмүүст хэд хэдэн мал хуваагаад өгсөн юм. Тэрийгээ бас юм болгож арчилж тордох шаардлагатай. Өөр яах ч боломж байхгүй, хийж байсан ажил байхгүй, хувьчлагдаад тараад явахаар чинь одоо яах вэ дээ.

Х: Танайх хэдэн мал авч өсгөсөн бэ?

Ц: Өө, ерөнхийдөө бид бараг 200 дөхүү малтай байсан байх өө. 150, 160-аас 200-д хүрээд л нэг тиймэрхүү л байсан даа. 5, 6 ам бүлийн хувь гээд авсан байхгүй юу. Тэгээд тэр нэгдэл гэж байх үед манай сумын хөгжил нэгдэл гэж байсан. Хөгжил нэгдэл механик, ерөнхий механикч тэгээд нэгдлийн зөвлөлийн гишүүн. Зөвлөлийн тэргүүлэгч гишүүн гээд бас сонгуульт ажлуудтай бас тэгээд гайгүй залуухан ч байсан. Тухайн үедээ албанд залгаад л явж байсан юм. Одоо бодоход би ч бас гайгүй юм хийж байсан байна шүү. Тэр чинь бас багагүй машин техник хөдөлгөх бүрэлдэхүүнтэй. Ерөнхийдөө 20, 30-аад юм хөдөлгөнө. Тэгээд элдэв шалдав янз бүрийн эвдрэл саатал ч гарна. Тэрийг хөдөлгөнө, энэ нэгдлийн өвс хадланг бэлтгэнэ. Нөгөө механикжсан трактроор тэр үедээ ажил ч тасрахгүй. Унаа машин бүгдийг нь л механик ч бэлэн байдалд байлгах ёстой юм. Засвар үйлчилгээ хийж, жолооч нараа ажилд хувиарлаж хариуцдаг байсан. Ийм нийгэмд нийгмийн ажил төрлийг болгоод зохицуулаад нэг ёсны хоёр нийгэмд л амьдарч явна даа. Одоо тэгээд яах вэ энэ зах зээлийн чөлөөт нийгэмд ажиллаж хөдөлмөрлөж чадсан нь сайхан амьдарч байна, болж байна. Төр засгаас гавьяаны тэтгэвэрээ авч байна, болж байна.

Х: Таныг жаахан байхаас ч гэдэг юм уу социализмын үед эсвэл одоо зах зээлийн үед хүмүүсийн хандлага, сэтгэлгээ ахуй амьдрал ер нь яаж өөрчлөгдөж байна? Ажиглаад байхад хүмүүс одоо ийм л болоод байна даа гэдэг ч юм уу?

Ц: Яах вэ, одоо социалист нийгмийн үед бид нар ерөөсөө л хийж бүтээх, нийгмийн өндөр сахилга журмыг баримталж цаг нарыг ашиглаж сурсан, бас их сайхан хамтын хөдөлмөрийг хөгжүүлж байсан ийм л хүмүүс л дээ. Жишээ нь малчин хүн гэхэд малаа өсгөхийн төлөө, амжилтанд хүрэхийн төлөө, барилгачин хүн гэхэд барилгаа барихын төлөө явдаг байлаа. Хөдөө аж ахуйн нэгдэлд ажиллаж байсан болохоор хадланч хүн гэхэд л малын өвс тэжээлийг бэлтгэж тэрийгээ л нэр төртэй биелүүлж, нормт ажилтай учраас төлөвлөгөөгөө биелүүлэхийн төлөө л явж байсан байхгүй юу. Хамтын хөдөлмөр гэдэг чинь их үр дүнтэй сайхан байсан. Тэр бол яах аргагүй л хамтын хөдөлмөрийн хүчээр бий болсон. Сум орондоо тэрийг хийж байсан гэхэд үнэхээрийн бахархалтай. Одоо эргээд харахад заримыг нь нураагаад авч байсан ч “үгүй ээ энэ одоо нээрээ сайхан юм хийсэн байна шүү” гэж харахаар. Одоо бол яах вэ хүмүүс хувиараа хөдөлмөр эрхэлж өөрсдийгөө болгож л байна. Тэртээ тэргүй хувийнх юм болохоор хувийнхаа эрх ашгийг бодсон юм хийнэ. Нэг талдаа тэр социалист нийгмийн үед хамтын хүч хөдөлмөрийн дунд ажиллаж амьдарч байсан хүний хувьд бол зарим юм нь бас арай ч нэг баймааргүй байх байсан болов уу гэсэн бодогдох үе байна. Гэхдээ одоо яах вэ, нийгмийн зохицлоор энэ нийгэм бас сайхан хөгжиж байна. Одоо бүх талын худалдаа харилцаа, бүх юм сайхан болсон. Монгол улс хөгжиж байна, буруу гэх юм байхгүй. Зах зээлийн нийгэмдээ зөв л зохицож ажиллаж амьдарч чавдал болж байна. Одоо хүмүүс хувь хүний ёс суртахуун, ёс зүйн хувьд жаахан чанараа алдагдаж байгаа явдлууд байна, одоо нуух юу байх вэ. Би ахмадууддаа ч хэлдэг.

Х: Яаж алдагдаж байна?

Ц: Ер нь хамтын хүч хөдөлмөр, бусдад үлгэрлэж манлайлахыг манай ахмадууд хийх ёстой юм шүү. Залуу үеийнхэнд манлайлж явах шаардлагатай юм шиг байгаа юм. Юу чаддаг вэ түүгээрээ л. Мөнгө шаардахгүй зүгээр нэг эмнэлгээр орохдоо гутлаа нэг сайхан цохиод орчих хэрэгтэй. Одоо хүмүүс гутлаа ерөөсөө цохихгүй шууд чигээрээ гүйгээд л орж байна шүү дээ. Тэрэнд бол мөнгө шаардлагагүй шүү дээ. Хоёрт бол цаг ашиглахгүй байна. 2 цагт гэж зарласан бол сүүлийн үед бүр байхгүй болчихлоо. Энэ корона энэ тэр гээд өвчин дэглэмтэй учир цугларч болохгүй болсон. Тэрний нэг хоёр жилээс урд нь бас тэгдэг байсан. Одоо бүр цугларч цаг ашиглана гэж ерөөсөө байхгүй. Ерөөсөө нийгмийн идэвх байхгүй болсон. 2 цагт гэсэн бол 3 цагт нэг хүн ирвэл ирнэ, ирэхгүй бол ирэхгүй ер тэгээд хагас хугас нь ирнэ дээ. Ахмадууд тэрийг үлгэрлэж хиймээр байна. Жишээ нь сардаа нэг дуулах ахмадын дуун цэнгүүнээ ерөөсөө л цагтаа хийж байя. 8 цаг гэж тэр

цэнгүүнээ эхэлсэн бол 10-т таръя гэхээр хүмүүс чинь аягүй бол 10 гэхэд урдаас ирж явдаг юм. Тэгэхээр ийм байдлаар залхаахаар бодох хэрэгтэй гэж би хэлдэг юм л даа.

Х: Хүлээгээд л суудаг уу?

Ц: Хүлээгээд сууна шүү дээ. Тэгээд түрүүчийн ирсэн хүмүүс залхаалтанд орж байгаа юм чинь. Нэг ёсны түрүүлж ирсэн нь залхаж бүр хохирно. Ерөөсөө бүр юм эхлэхгүй болохоор чинь эвшээгээд сууж байхаас өөр арга байхгүй. Тийм асуудлууд байдаг шүү, Ер нь хаа сайгүй бараг ийм болчихсон шиг байна лээ. Хүмүүсийн оюун ухаан юу ч гэмээр, ямаар юм бэ дээ.

Х: Танай ахмадын хороо ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?

Ц: Ер нь төрийн бус байгууллага. Гишүүнчлэлгүй төрийн бус байгууллага байхгүй юу. Хэн ямар үзэл бодолтой, ямар нам, хаанахых гэдэг нь хамаа байхгүй ерөөсөө энэ орон нутагт байгаа тэтгэвэрийн насны хүмүүс л хамрагдаж байгаа шүү дээ. Тэгээд хүмүүсийн нийгмийн идэвхийг дээшлүүлэх, оролцоог нэмэгдүүлэх цаашлаад ахмадуудын дунд хэд хэдэн чухал асуудлууд байдаг юм л даа. Ганцаардлыг бууруулах, гансралыг тайлах гэх мэт. Ахмадуудын хагас хувь нь л одоо ганцаараа голдуу амьдардаг. Тэгээд тэр хүмүүсийн ганцаардлыг арилгахад бс чиглэнэ. Зарим нь гансраад ч сууж байдаг хүмүүс байна. Стресс тайлах, хөдөлгөөнтэй байлгах талаас нь анхаарна. Хөдөлж байна гээд тэд нар чинь хөдөлгөөн бүхнийг хийж чадахгүй, хүн бүхэн хийх хөдөлгөөнтэй тэмцээн уралдаануудыг зохион байгуулна. Тийм юмнуудыг л хийдэг дээ.

Х: Ер нь хэр их хүмүүс ирж байна танай хороонд?

Ц: Манай хороо чинь бүртгэлтэй, тэтгэвэрт гарсан 270 хүн байдаг л даа. Тэгээд яах вэ хэвтрийн ч хүн байна. Жил бүхэн ахмадын хорооноос эргэж тойрно. Биеийн байдлыг нь асууна. Боломж гарвал ганц хайрцаг сахар ч болов хийгээд “бие хаа тань гайгүй юу, таныг эргээд ирлээ” гээд өгөх жишээний юм болдог.

Х: Байнгын тогтмол ирж байдаг хичнээн хүмүүс байгаа вэ?

Ц: Байнгын дөч, тавиас шальдаггүй юм. 50-аас доошоо л ирдэг. Нэг талдаа бас оролцоо муу.

Х: Танай энэ сум орон нутгийн хүмүүсийн сэтгэлгээний гэвэл та юуг хэлэх вэ?

Ц: Өө, манай сумын хүмүүс бол гайгүй сайн ажилсаг хүмүүс шүү дээ. Ерөөсөө хаа ч байсан ажиллаж, амьдарч чаддаг тийм хүмүүс л дээ. Тэгээд ч манай сум чинь Монгол

Улсын Тэргүүний Сумаар 2014 онд шалгарч байсан. Би тэр үед төвийн багт багийн хурлын дарга байлаа. Хоёр ч удаа шалгуулсан л даа. Тэрний өмнө жил нь бас шалгуулаад арай чадаагүй. Ховд аймгийн нэг сум орсон байсан тэгээд дараа жил нь манай сум шалгарч байсан .

Х: Ямар шалгуураар шалгарах вэ?

Ц: Тэр чинь бас олон шалгууртай. Ерөөсөө сумын хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулсан ажил. Мэдээж тэр бүгд л өссөн байх ёстой. Малын өсөлт, хүн амын өсөлт тэгээд улсын тэргүүний сумын болзол тусгай л даа. Тэгээд ядахнаа зүгээр ахуйн юм гэвэл хог новшоо цэвэрлэхээс эхэлнэ. Сумын төвийн эргэн тойрны хогны асуудал ярвигтай байдаг юм л даа. Мөн тэр баг суманд ажиллаж байгаа хүмүүсийн хашаа хороо, орчин цэвэрхэн байх ёстой гээд шаардлага өндөр шүү дээ. Төвөөс ирж шалгадаг байсан байхгүй юу. Тэгээд тэргүүний сумаар шалгарч байсан. Манайх аргагүй сайн болоод шалгарч байсан байхгүй юу, тэрнээс муухан байсан бол улсын хэмжээнд яаж шалгарч чадах вэ дээ. Тийм учраас манай сумын ард түмэн бол бүтээлч, ажилч хөдөлмөрч ард түмэн, юуг ч хаана ч явсан хийж чадна. Тэгээд ч энд тэнд төв суурин газар ажиллаж амьдарч байгаа манай сумын хүмүүс сайн явдаг.

Х: Танайх сумын төв дээр үхэртэй юм байна тийм ээ?

Ц: Аа тийм, амины хэдэн цөөхөн үхэртэй.

Х: Хэдэн үхэртэй вэ?

Ц: За нэг 20 гаран юм байна аа. Эргүүлж тойруулаад л байж байна даа.

Х: Гол нь сүү саалийг нь хэрэглэх үү?

Ц: Мал байхад юм юм л хэрэгтэй шүү дээ. Сүү саалийг нь авч ашиглаж сүүтэй цай ууна, энэ хүүхдүүд авч ууна. Жил бүр махыг нь иднэ, хотод байгаа хүмүүстээ идэш хүргэнэ. Энэ хүүхдүүд бүгд гэртээ нэг, нэг үхэр алж авна. Жишээ нь тэгээд л байлгаж байна, байлгахүй бол болохгүй.

Х: Өөр сумын төв дээр малтай айлууд хэр байдаг вэ?

Ц: Хэд хэдэн малтай айлууд байна шүү. Манайх шиг яг ийм айлууд байна.

Х: Энэ жил ер нь малын тарга тэвээрэг хэр байна?

Ц: За энэ өвөл бас өнтэй сайн гарсан, сайн өвөлжсөн. Энэ Урианхай тийшээ цагаан сараас хойш жаахан зүтгүү болчихлоо. Одоо өвс ногоо бас оройтож гарч байна. Зуншлага их л оройхон эхэлж байна даа. Хур бороо орвол гайгүй болчих байлгүй дээ.

Х: Ер нь энэ хавиар бэлчээр, өвс ногоо гайгүй юу?

Ц: Бэлчээрийн хувьд бол яах вэ одоо бид байгалийн эрхшээлд л, ер нь монгол хүн, малчин хүн гэдэг бол байгалийн эрхшээлд л байдаг болохоор нэг талдаа төвөгтэй л дөө. Байгаль цаг уур хатуурхаад тэр жилийн ургамлын гарц, өвсний гарц муу байх юм бол мал хунар зутарна. Өвс тэжээлээ бэлдэж чадахгүйд хүрнэ, бас хэцүү. Ер нь олон ч байсан цөөхөн ч байсан мал маллаж байгаа хүмүүст байгаль цаг уур ихээхэн нөлөөлнө шүү дээ. Тэгээд яах вэ дээ, төв суурин газрууд учраас тааруухан. Нэмэгдэл тэжээл ашиглаад болгоод л байж байна.

Х: Нэмэгдэл ямар тэжээл ашигладаг вэ?

Ц: Одоо бид чинь дандаа л өвсөө урд голын хөндийгөөс бэлтгэж авдаг.

Х: Хадлангаа өөрсдөө бэлтгэх үү?

Ц: Өөрсдөө энэ хэдэн хүүхдүүдээ дайчлаад л. Намар хадлан болохоор “хадлангаа л авмаар байна” гээд шаардаад л, хүүхдүүдээрээ хийлгэж авна л даа. Хорголжин, багсармал тэжээлийг бол Баян-Өлгий, Улаангом энэ тэрээс л авдаг. Тэгээд одоо Орос дайнтай болчихлоо Баян-Өлгийгөөр хорголжин тэжээл ирэх юм уу, үгүй юу мэдэхгүй. Ер нь хорголжин тэжээл ховордож магадгүй шүү.

Х: Бэлчээр ер нь хэзээнээс ийм болов, урьд нь гайгүй байсан уу?

Ц: Бэлчээр сүүлийн үед малын өсөлтөөс шалтгаалж байна нэгт, хоёрдугаарт бэлчээрийн хувиарлилтаа ашиглаж чадахгүй, малын тоо толгой нэмэгдээд талхлалт нилээн болчихлоо. Байгаль цаг уур бас гарцаагүй нөлөөлнө. Бороо ороод хур тунадас, чийг өгөхгүй байвал ингээд л шороон шуурга тавиад байх чинь болохгүй л асуудал байгаа юм л даа. Байгалийнхаа эрхшээлд ингээд байж байдаг ард түмэн шүү дээ малчин хүн. Байгальдаа залбираад л, байгаль орчноо хамгаалаад л амьдрах л учир холбогдолтой байгаа юм л даа. Хүн бүр тэрийг бас ойлгохгүй л байна.

Х: Та Монгол нүүдэлчдийг бусад нүүдэлчдээс юугаараа ялгаатай гэж боддог вэ?

Ц: Ер нь монгол нүүдэлчин хүмүүс хатуужил тэвчээр сайтай шүү. Хаана ч тэр чанараараа бас арга ухаан байн. Одоо бас нэлээн сайн хөгжсөн байх гэж би боддог шүү. Ямар ч

юмыг хийчих сэтгэлийн тэнхээтэй, монгол хүний бахархмаар юм тэр л дээ Нүүдэлчин ард түмнээс заяасан, хүмүүжсэн бас өөрт нь зохилдсон тийм чанар л даа. Тэсвэр хатуужил сайтай ер нь.

Х: Яагаад тэсвэр хатуужил сайтай болж байна гэж та боддог вэ?

Ц: Монгол хүний амьдарч байгаа орчин, нэн ялангуяа энэ хөдөөгийн орчин, хөдөө ажиллаж амьдарч байгаа, нүүж сууж байгаа, морио унаад явж байгаа юм. Жишээ нь монгол уламжлал гэдэг чинь морио унад явах, тэмээгээ ачаад явахыг л хэлж байгаа шүү дээ. Нэг ёсны малаа хариулаад явж байгаа энэ бүхэнд манай цаг уурын онцлог ч байна. Халуунд нь халж, хүйтэнд нь хөрж явдаг энэ бүхэн бол хүмүүсийн тэсвэр хатуужилд нөлөөлж байгаа нь дамжиггүй. Тэрэнтэй уялдаад тэр хүний хийж бүтээх юм нь өөрийн сэтгэлгээгээр хийдэг, оюун ухаан нь тэр хэмжээгээр хөгжсөн ийм л онцгой чанартай хүмүүс л дээ. Амьдралаа авч явах боломжтой.

Х: Өөр танд хэлж ярих орхигдсон зүйл байна уу? Тулгамдаж байгаа асуудал байна уу?

Ц: Хүн бүр монгол арга ухаанаа зөв эзэмшээд, өв уламжлалаа бүгдээрээ хадгалаад явж чадвал монгол улсад хэрэгтэй л байгаа юм. Үүнийг залуу хүмүүс ойлгоод өв уламжлалаа мартаггүй, соёл өв уламжлалаа хадгалж л явмаар байна л даа.

Х: Энэ өв соёл гээд ярьж байна шүү дээ. Үүнээс энийгээ л хадгалаад үлдчих юм сан гэж бодож явдаг зүйл байгаа юу?

Ц: Ерөөсөө л энэ өв соёлоороо байгалиа хамгаалж чаддаг монголд уламжлагдаж ирсэн арга. Энийг алдмааргүй байна. Энийгээ бүгдээрээ хадгалмаар байдаг. Яваандаа арилж мэднэ л дээ. Дэлхий нийтээрээ даяаршиж байгаа нөхцөлд тэгээд монгол хүний энэ сайхан зан харилцаа байна аав ээж, ахмал хүнээ хүндэлдэг. Яваа яваандаа энэ даяаршилд яах ч юм бүү мэд шүү дээ.

Х: Сайхан яриа өгсөнд баярлалаа.

Ц: Чамд бас баярлалаа.

10. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум, М.Лхагвасүрэн, 57 настай

Х: Сайн байна уу? Таныг хэн гэдэг вэ?

Л: Намайг Монхорын Лхагвасүрэн гэдэг. 1965 онд төрсөн. Говь-Алтай аймгийнхаа төв дээр төрсөн. Ургийн овог Бэрсүүд. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Шанданцайр гэх нутагт нутаглаж Рашаант багт харьяалагдаж амьдарч байна.

Х: Танай гэр бүлийн хүнийг хэн гэдэг вэ?

Л: Туул

Х: Танайх хэдэн хүүхэдтэй вэ?

Л: Хоёр хүүхэдтэй

Х: Хүүхдүүд нь юу хийдэг вэ?

Л: Том эмэгтэй нь одоогоор ажил хийдэггүй, бага эрэгтэй нь тусдаа гарсан. Дотоодын цэргийн хэлтэст ажилладаг.

Х: Та хоёр хэдэн онд гэрлэсэн бэ?

Л: 1991 онд гэрлэсэн.

Х: Ямар сургууль төгссөн бэ? Цэргийн алба хааж байв уу? Залуудаа ямар ажил эрхэлж байсан бэ? Тэр тухайгаа хуваалцаач?

Л: 8-р анги төгсөөд, цэрэгт гурван жил алба хаагаад, тэгээд ирснээсээ хойш л мал маллаж байна даа.

Х: Танайх хаагуур, хаагуур нутагладаг байв?

Л: Өө, энэ хавиараа өвлийн цагт малаа маллаж байгаад, зуд зурхан болвол оторт Алтай сум явдаг байлаа. Өмнө нь Адуун чулуугаар их нутагладаг байж байгаад нодлин л наашаа орж ирээд байгаа юм.

Х: Адуун чулууны гол нь эндээс зайтай юу? Хаана байдаг вэ?

Л: Энэ урагшаа нэг даваад л байдаг. Байгаль нь сайхан л даа. Ноднин үер их буугаад, доороосоо машин тэрэг явахаа байгаад тэгээд энд зусаад байгаа юм.

Х: Та нутаг усныхаа онцлогийг яриач? Жишээ нь Адуун чулууны гол гэх газар ямар онцлогтой вэ?

Л: Адуунчулууны гол бол устай, модтой бол модтой үнэхээрийн сайхан байгальтай хангай газар байгаа юм. Манай нутаг маш гоё л доо. Гэхдээ даанч ирвэс ихтэй. Малаа

өгөөд байх хэцүү. Тэглээ гээд алж болохгүй. Бараг нь дайжаад наашаа гараад ирсэн. Ганц нэг айл байх нь байдаг.

Х: Та ямар, ямар мал маллаж байв? Одоо ямар, ямар мал малладаг вэ?

Л: Ах нь дээр үед таван хошуу мал маллаж байлаа. Одоо бол үхэр, хонь, ямаа л маллаж байна.

Х: Яагаад үхэр, хонь, ямаа маллаж байна, адуу яагаад маллахгүй байгаа вэ?

Л: Адуу ерөөсөө тэгээд зуд болохоор алдахыг нь алдаад зуданд дуусгасан. Тэмээ ч гэсэн залуу байхад эргүүлээд л байдаг байсан. Энэ говь руу орж ирээд алдахыг нь алдаад хариулж чадахаа байгаад алга хийчихсэн. Тэгээд адуу тэмээ хоёр маллахаа байсан. Үхэр, бог мал л маллаж байна, гарын дор байхгүй юу.

Х: Танай нутгийн цаг уурын байдал ямар вэ?

Л: Ойрын хоёр, гурван жил их хүнд байсан. Ноднингоос хойш сайжирсан. Тэрнээс өвс ногоо гандуу тэгээд л оторт явдаг байлаа.

Х: Оторт хаашаа явдаг вэ?

Л: Манай аймгийн Алтай сум, Завхан сум гэж бий. Бараг хилийн зааг дээр байдаг тийшээ явна.

Х: Эндээс хичнээн километрийн зайд байдаг вэ?

Л: Бараг 400 гаран километр, гурван говь гаталж байгаа юм чинь. Хол л доо.

Х: Яагаад тийм хол оторлодог юм бол?

Л: Яахав, өвс хөөгөөд л. Манай нэг хамаатны хүн байдаг юм. Тэгээд “ийшээ хүрээд ир, өвс ногоо сайхан байна” гэхээр нь зэрэг явдаг. Нутаг нь сайхан юм билээ, даанч хол болохоор ирж очих нь их хэцүү. Манайх чинь малаар л амьдарч байгаа юм чинь өвсөө бараадаад л байж байна даа.

Х: Малаа ер нь хэрхэн маллаж байна? Мал маллах арга ухаанаасаа хуваалцаач?

Л: Мал ерөөсөө ногоо сайтай жил бол гайгүй, газар ногоо гарахаа байгаад ирэхээр зэрэг мал маллана гэдэг хэцүү болж ирнэ. Одоо тэгээд алт ухаад байхаар, газар дэлхий хүртэл гарахаа байж байх шиг байна.

Х: Энэ хавиар уул уурхай их байдаг уу?

Л: Уул уурхай гайгүй, бичил нинжа алт ухдаг. Одоо хүмүүс хувиараа маш их алт ухдаг. Энэ буруу л юм байгаа юм. Дандаа энэ уулын судгуудыг нь дагуулаад юу ч үгүй болтол ухчихдаг.

Х: Танай суманд тулгамдаж байгаа өөр асуудал байна уу?

Л: Өөр ч байхгүй дээ.

Х: Та ер нь нүүдэлчин хүний үнэ цэнтэй, эрхэмлэж явдаг зүйл нь юу гэж боддог вэ?

Л: Хамгийн сайхан амьтан тэмээ байсан юм. Тэмээтэй байхад сайхан байсан, дуртай газраараа явна, тэмээгээрээ хөтлөж нүүнэ, бензин тос гээд байхгүй. Одоо бол айл бүр л машин унадаг болж.

Х: Таныг бага байхад тэмээгээр нүүдэг айл их байсан уу?

Л: Өө, олон байсан. Намайг бага байхад ямар сайхан байсан гэнэ. Одоогийнхтой яаж харьцуулхав. Одоогийн хүүхдүүд маш залуу болчихсон, маниусын үед өглөө 6-д босоод л, саалиа аваад, малаа дагаж хариулаад л янзын сайхан байсан. Тэгэхэд одооны хүүхдүүд сааль сүүгээ авахгүй нь элбэг. Бас дээр нь хөдөө хүүхэдгүй болсон юм л даа, бидний үед хүүхэд ихтэй байсан. Энэ хавиар залуу малчид нэг үеэ бодвол их болсон, гэхдээ хүүхдүүд нь жаахан. Яахав залуу малчин гээд байгаа нь 30 гарсан, 40 гарсан хүмүүс байгаа.

Х: Та монгол нүүдлийн соёлыг юу гэж ойлгодог вэ?

Ц: Давтагдашгүй агуу зүйл байсан юм.

Х: Танай нутаг усны онцлог юу вэ?

Ц: Манай нутаг усны онцлог бол төвдөө ойрхон, байгалийн цогцолбор сайхан. Говьтой, хангай хосолсон сайхан газар. Одоо жишээ нь модтой, устай, хадтай нутаг даа.

Х: Малаа хаанаас усладаг вэ?

Ц: Булаг шанд ихтэй түүнээсээ усална.

Х: Таны аав, ээж ямар хүмүүс байсан бэ?

Ц: Манай ээж малчин хүмүүс байдаг. Аав маань 82 настай. Насаараа мал малласан. Залуудаа “Түмэн” баригад гэж байхад мужан хийж байсан. Ээж маань 78 настай. Адуун чулууныхаа гол дээр ээж, аав хоёр маань хэдэн үхрээ хараад л нутаглаж байна.

Х: Таныг аав, ээж чинь яаж хүмүүжүүлж байсан бэ? Та хүүхдүүдээ хэрхэн хүмүүжүүлдэг вэ? Тэр үеийнхээс яаж өөрчлөгдсөн гэж боддог вэ?

Х: Одоо үед бол маш өөр болсон. Дээр үед аав, ээжийнхээ харцнаас нь айдаг байсан. Би бол хоёр хүүхэддээ хангинана уу л гэхээс гар хүрч үзээгүй юм. Харин хүүхдийн хүүхдүүд үгэнд орохгүй шал өөр болчихсон.

Х: Одоо энэ монгол нүүдлийн соёл, бусад ард түмний соёлоос юугаараа ялгарна гэж та боддог вэ?

Л: Бусад орны амьтны махнаас, монгол малын мах, сүү сүүн бүтээгдэхүүн нь амт чанараараа илүү. Гол нь малын идэж байгаа ургамалдаа байгаа юм. Манай монголын мал дандаа янз, янзын эмийн ургамал идэж байгаа.

Х: Энүүгээр байгаа айлууд голдуу ямар мал өсгөж байна?

Л: Хонь, ямаа, адуу, тэгээд цөөхөн үхэр өсгөж байна.

Х: Яагаад тэгж байгаа юм бол?

Л: Тэмээ бол ийм хангай газар тогтдоггүй, говь руугаа л гүйнэ.

Х: Үхэр яагаад бага өсгөж байна?

Л: Сурсан газар өөдөө явчих гээд одоо Адуун чулуу руугаа, тэндээ нутагладаг байсан юм болохоор гүйчихдэг. Одоо манайх монгол үхэртэй ийш нь аваад ирэхээр тугалаа хаяад л тогтохгүй Адуунчулуу руу яваад өгнө. Манайх шиг отроор явдаг айл бол тэнд очоод тугалаар нь аргамжвал аргамжаад тэгээл тогтохгүй идээшиж сурсан нутаг руугаа гүйчихдэг.

Х: Та Монгол хүнийхээ хувьд юугаар нь бахархаж явдаг вэ?

Л: Монгол орныхоо газар нутгаар нь л бахархаж явдаг даа.

Х: Таны аав ээжээс сургамжилдаг, захидаг зүйл байдаг уу?

Л: Хүнд битгий муу санаж яв, бие биедээ тус болж яв л гэдэг хүмүүс байдаг.

Х: Сум орон нутгийн хүмүүсийн тань, сэтгэлгээний онцлог юу вэ?

Л: Манай энэ хавийн хүмүүс их тусархуу улс байдаг. Цагаахан, танай манай гэх юм байхгүй. Гэр буулгаж байвал ирээд буулгаад, ачилцаад өгдөг тийм нэг сайхан зан чанартай хүмүүс бий.

Х: Хүмүүс ер нь сүүлийн үед өөрчлөгдөж байна уу? Хүний чанар хэр байна?

Л: Ойр хавийн хүмүүс бол гайгүй.

Х: Ийш тийшээ отор хийж явахад ямар, ямар асуудал тулгарах уу?

Х: Ногоотой газар хайгаад явна, тэгээд хүний нутагт хөөгдөнө. Хамгийн гол нь бэлчээрийн асуудал байдаг. Очиход манай өвөлжөө, хаваржааны газар гээд хөөгддөг. Ялангуяа зуны цагт оторт явахаар ийм зүйл маш их болно. Мэдэхгүй газар их хэцүү л дээ.

Х: Танай ийшээ бас хүмүүс ирдэг үү?

Л: Ирдэг. Гэхдээ өвөлжөөгүй, зуслан газар болохоор харьцангуй гайгүй. Энэ зуслан газар учраас манай эндэхийнх хөөж барьдаггүй. Доошоо энэ хаваржаа, өвөлжөө рүү буучихвал хөөнө л дөө.

Х: Таны бодлоор мал маллахын хамгийн сайхан зүйл нь юу вэ?

Х: Хамгийн сайхан зүйл нь өөрийн дураараа хариулж болно. Тэдэн цагт бэлчээхийг хүснэ, тэр цагтаа л бэлчээж болно. Хүний эрхэнд биш, өөрийнхөө эрх чөлөөнд байдаг. Нэг хэцүү юм нь өвөл зунгүй л дагах юм даа. Хоолоо гаргаад идчихнэ, түлээ түлшээ аргал хорголоо түүгээд түлчихнэ сайхан шүү дээ.

Х: Танай нутагт ардын хар, бор аргаар дом засал хийдэг үү?

Л: Хүүхэд айсан үед ширэглээд, хар халзан туулай хийнэ. Ханиалгаад байна гэвэл манай нуруунд ургадаг навч байдаг түүнийг түүгээд буцалгаад л уулгана. Гэдэс өвдөж байна гэвэл “таван салаа” чанаад өгчихдөг. Манай эндэх эмийн ургамал л их хэрэглэнэ. Манай хөгшчүүл ходоод өвдөж байна гэвэл “хундан цагаан” цэцэг түүгээд уулгадаг байсан.

Х: Танай энэ хавийн байгалийн онгон дагшин байдал хэр алдагдаж байна?

Л: Бидэн шиг малчин хүнд гол хэрэгтэй зүйл болох газар усаа л жоохон хамгаалмаар байна. Жишээ нь одоо “Өлийн гол” гэж байсан ширгэлээ л дээ. “Шаврын гол” гэж нэг гол байсан нинжа нар ухаад хаячихсан, одоо бас ширгэх байх.

Х: Гол нь “нинжа” нараас л асуудал үүсээд байна уу?

Л: Тийм, гол нь газар усаа маш их ухаж байна. Гол байлаа гэхэд урсгал дагуулж, эхийг нь ухаад баллаад хаячихаж байгаа юм. Булаг шанд маш их ширгээд байна даа.

Х: Социализмын үе болон ардчилал гарснаас хойш хүмүүсийн сэтгэлгээ хэрхэн өөрчлөгдөж байна?

Л: Хүмүүс удирдлагагүй, өөр өөрсдийнхөө дураараа амьдарч эхэлсэн.

Х: Ирвэс байдаг гэж байсан, өөр ямар ан амьтан байдаг вэ?

Л: За өөр янгир, буга байгаа. Буга их элбэг.

Х: Та мал маллахаас гадна өдөр тутамдаа юу хийж байна?

Л: Манайх цагаан идээ боловсруулж зардаг. Дээхэн үед хониныхоо ноосоор эсгий хийдэг байсан, одоо бол тушаачихдаг болсон. Үхрийн арьсаа элдэж сур хийж, тэмээнийхээ ноолуураар тохом хийдэг байлаа. Энэ хавийн адуутай айл хазаар, ногтоо хийнэ тэрнээс бусдаар өөр зүйл хийхгүй болсон.

Х: Эсгийг яаж хийдэг байсан юм бол?

Л: Хонины ноосоо савж бутлаад, сайхан хэмжээг нь авсан дэвсгэр дээр зулж байгаад, ус цацаж норгоод, ахиад дээр нь зулаад ус цацаад, хуйлчихдаг байсан. Дараа нь задлаад давхарлана. Тэгээд л эсгий. Ялангуяа хурганы ноос бол янзын сайхан нягт, хавтгай эсгий болдог.

Х: За ярилцсанд их баярлалаа.

Л: Баярлалаа.

11. Баян-Өлгий аймаг, Хайдавын Өлзийсайхан

Х: Сайн байна уу, та надад өөрийгөө танилцуулна уу?

Ө: Намайг Хайдавын Өлзийсайхан гэдэг. Ургийн овог Өөлдийн Ноён Цорс. 1969 онд Ховд аймгийн Жаргалант суманд төрсөн. Манай эхнэр бас Ховд аймгийн Жаргалант суманд төрсөн. Манайх 3 хүүхэдтэй. Нэг бэр, 2 ачтай.

Х: Та одоо ямар ажил эрхэлдэг вэ, залуудаа юу хийдэг байсан бэ?

Ө: Би ерөөсөө Ховд аймагт төрж өсөөд л 1987 онд 10 жил төгсөөд конкурс өгөөд Москва хотод Хилийн цэргийн дээд сургуульд хуваарь авсан. Тэгээд 1987 оноос 1 жил цэргийн бэлтгэлээ Дорнод аймгийн Эрэнцавд хийсэн. Нэг жил цэргийн бэлтгэлдээ явчихаад Москва руу явсан. 1992 онд Москва хотын Хилийн цэргийн командын дээд сургуулийг төгсөөд Баян-өлгий аймагт дэслэгч цолтой заставын орлогчоор томилогдож ирсэн. Тэгээд эндээ заставын орлогч, заставын дарга, заставын офицер, заставын ахлах офицер

хийж байгаад Ховд аймаг руу шилжээд Ховд аймгийн Үент суманд даргын орлогч, хилийн тануулын тасгийн дарга, даргын орлогч, хийж байсан. Тэгээд сүүлд эндээ буцаж ирээд хилийн боомтуудаар ахлах ажилтан хийж байгаад тэтгэвэрт гарсан. Насаараа л хилийн боомт, хил дээр л явлаа. 2014 онд тэтгэвэрт гарсан.

Х: Тэтгэвэрт гараад та ямар жил хөдөлмөр хийж байна?

Ө: Манай хилийн цэрэг Ахмадын холбоо гэж том холбоотой. Анги болгоны хилийн цэрэгт ахмадын хороотой. Энд ирээд тэтгэвэрт гарчихаад байж байхдаа ахмадын хороонд тэргүүлэгч хийгээд, одоо ахмадын хорооны дарга хийдэг. Улаанбаатар хотод бас яг энэ ангиас ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан 214 хүн байна.

Х: Та цэргийн ангийн ямар, ямар үйл ажиллагаан дээр байнга очих уу?

Ө: Тэтгэвэрт гарсан ахмадууд, хилийн цэргийн үйл ажиллагаа хоёрыг хооронд нь холбоно. Сургууль төгсөөд л нөхрөө дагаад явсан зөндөө олон хүүхнүүд, охидууд байгаа. Эмч, инженер байна. Тэгээд л заставд нөхрөө дагаад л угаагч, тогооч хийсээр байгаад л нөхөр нь тэтгэвэрт гарч байгаа олон хүмүүс байна. Ахмадуудын асуудал их хэцүү. Өвчин зовлон, үхэл хагацал, тэтгэвэр бага, амьдралд хүрэхгүй, энэ хэдийг харин хилийн цэргээс сайн харж үзнэ. Судалгаатай, тиймэрхүү л хүмүүсийг бид нар эргэж тойрч явж байгаа. Цэргийн анги дээр шинэ цэргийн сургалтын төв байна. Тэнд очоод яриа хийнэ. Бид нарыг төгсөж байхад улс төрийн анги гэж тусдаа төгсдөг байлаа. Улс төрийн анги нь команд болон суртал ухуулгын чиглэлээр төгсдөг байсан. Хилийн цэргийн амьдрал маш хатуужилтай. Ялангуяа манай хилийн цэргийн анги бол 24 цагийн 8 цагт нь үүрэг гүйцэтгэнэ, 8 цагт нь унтана, 8 цагт нь сурч боловсорно. Явган, морьтой, цасан шуурга, борооноор бүгд л явна. Тийм үеэр л янз бүрийн хүн явна, энийг л өрсөж амьдарна. Хатуужил манай хилийн цэрэгт байх ёстой, энэ чиглэлээр бид нар хүүхдүүдэд яриа хийдэг юм.

П: Та хэдэн жил цэргийн алба хаасан бэ?

Ө: Би чинь цэргийн сургууль төгссөн юм чинь цэргээсээ авхуулаад тэтгэвэр хүртэлээ цэргийн хүн гэсэн үг.

П: 1 жилийн хугацаанд цэргийн албыг хаагаад хатуужил суугаад гарч чадах хугацаа юу?

Ө: Цэрэг чинь мэргэжлийн боловсрол талдаа орж байна, гэрээт цэргүүд байна, хугацаат албаны ахлагч нар байна, мэргэжлийн офицерууд байна. Эх орноо батлан хамгаалах гэж байгаа юм чинь мэдээж хүн болгоны үүрэг шүү дээ. Ядаж цэргийн анхан шатны бэлтгэлийг мэдсэн байх хэрэгтэй. 1 жилийн алба нэлээн хэцүү л болоод байна. Хуучин 3 жилийн алба хаагаад хатуу хөтүү бүх юмыг үздэг байсан. Одоо бол тийм биш болсон. Одоо нийгэм нь бас нөлөөлөөд байна шүү. Юм болохоор хүний эрх яриад байдаг. Тэгээд цэргүүд 1 жил болоход л цэргийг дарамталж байна гээд л аав ээж нь яриад байгаа. Цэргийн хүн гэдэг чинь бүх юмыг даван туулсан хатуужил сурах ёстой. Хүйтэнд хөрж, халуунд нь халж, мөлхвөл мөлхөж, өлсвөл өлссөн ч өлсөөгүй юм шиг үүргээ гүйцэтгэж, тангарагдаа үнэнч байхын төлөө л явах ёстой. Дарга цэрэг нь жаахан хатуу шаардлага тавихаар “энэ намайг загнаж байна, дарамталж байна” гээд л ар гэр лүүгээ ярина. тэгээд тэрийг нь хүмүүс өлгөж аваад л арми дэглэж байна гэдэг. Тайван цагт хөлс их урсгавал, дайны цагт цус бага урсгана гэж Жанжины хэлсэн үг үнэн үг байхгүй юу. Энэ бол зөвхөн цэрэгт ирж байгаа хүүхдүүдээ биш байгаа юм. Одооны залуучуудын хамгийн гол юм нь цэцэрлэгийн наснаас нь авхуулад маш буруу хүмүүжсэн. Бид нар дээр үед “таван салаа боов” гээд авдаг л байлаа. Бид нарт муудсан юм байхгүй. Сургуульд явахад бас эцэг эх нь хүүхдэд юм хэлэхгүй. Ийм маягаар хүүхдийг бөмбийлж явсаар байгаад сайн сурсан ч юм биш. Цэрэгт сайн боловсролтой, мөнгөтэй хүний хүүхэд ирэхээ больчихсон. Тэгээд ядарсан хүмүүсийн, борчуулын хүүхдүүд ирдэг болчихсон. Тэгээд багаасаа тийм суурьтай хүүхэд цэрэгт ирэхээр үг даахаа байсан. Энд ирэхээр армийн амьдрал өөр, тэр зангаараа байх гээд байдаг. Сүүлийн үед “1 жилийн цэрэг, цэцэрлэгийн хүүхэд адилхан боллоо” гэж онигоо яваад байгаа. Ийм маягаас болоод залуучуудын чанар муудаж байна. Утас, компьютер тоглоно, идэж ууж байгаа юм нь бэлэн юм, хийжүүлсэн ундаа. Энэ бол нэлээн нөлөөтэй. Жил ирэх тусам намхан цэргүүд, ачаалал дааж чадахгүй, ядардаг, няцдаг болоод баайна. Яахав тэрэн дотор сайхан залуучууд ирнэ. Бүгд тийм биш. Тэрэнд аав ээжийн л хүмүүжил байна. Тэгээд бас дээд сургууль төгссөн хүмүүс, офицерууд ирж л байна. Зарим нь энгийн сургуулиас амьдралын шаардлагаар офицер болгосон хүмүүс байна. Сүүлийн үед бас нам дагаж их гүйх юм. Хүний толгой хүрэхгүй юм байна шүү дээ. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийнэ гэдэг маягаар явах хэрэгтэй байна л даа. Шударга сайхан ажиллаад явдаг, өөрийнхөө толгойгоор дээшээ явчихмаар байдаг. Гэтэл нам дагаад л даргын цүнх бариад явсан залуу дээр нь гарчихаад л нөгөө залуустаа тааз болж байгаа юм. Залуу хүндээ зайгаа тавиад өгөх хэрэгтэй. Ийм ийм зүйлээс болоод цэрэгт ирж байгаа залуус нялцгардуу, хэт хүний эрх ярьдаг болчихсон байна.

Х: Таны аав ээж таныг хэрхэн хүмүүжүүлж байв, та хүүхдүүдээ хэрхэн хүмүүжүүлэв?

Ө: Бид нар социализмын үед 1977-1987 онд хүмүүжсэн. Бид нар чинь баатарчууд, пионер, эвлэлээр нь дамжсан хүмүүс. Бид нарт тэгэх ёстой, ингэх ёстой л гэсэн ганцхан зарчим байлаа. Багшийн өмнөөс хамаагүй үг хэлж болохгүй. Юу ч байсан багш нарын зөв. Захиргаадалтын ч үе байсан. Чи ингэж сураад ингээд явах ёстой л гэсэн нэг л шугамаар байлаа. Тэр ангийн багш нар, эвлэлийн хороон дарга нар хүний төлөө маш сайн явдаг байсан. Зарим нэг багш нарт алгадуулах, зодуулах үе гарч л байлаа. Цэргийн ангийн хүүхдүүдийн тал байдаг. Газар газрын хүүхдүүд ирдэг. Аав ээжийгээ дагаад хилийн засталаар явсан хүүхдүүд цаанаа нэг анги байдаг хоорондоо нийлээд сахилгагүй нь дэндчих гээд байдаг. Очсон газрынхаа сургуульд спорт урлагаар манлайлчих гээд байдаг. Яагаад гэхээр цэрэг хараад л тэгдэг юм уу. Хамгийн гол нь сайн л хэлж ярьж байхгүй бол болохгүй. Хүүхдийн өөрсдийн л ухамсраас болж байна л даа. Аав ээжийн үгийг сайн биелүүлээд явчихдаг байвал болж байна. Би бол тулаад харьцаж байгаа багш нар нь загнахад дургүйцэхгүй. Зүгээр байсан хүүхдийг ирээд чичээд байдаг багш байхгүй шүү дээ. Тийм болохоор энэ дээр наанатай цаанатай хандах хэрэгтэй. Би одоо хүүхдүүдийн багш нартай холбоотой. Гол нь багш нартай нь л сайн холбоотой байж хүүхдийг хүмүүжүүлнэ. Одоо яг хүүхдийнхээ төлөө явдаг багш ер нь байхгүй.

З: Цэргүүд хэрхэн өөрлөгдөж байна вэ?

Ө: 1992-1997 онд хөдөөний бадриун, үг даадаг, хүдэр чийрэг, юм хэлдэггүй, тиймэрхүү нөхдүүд байлаа. Тухайн үедээ хамтраад л юмаа хийгээд л сүүлдээ гүйцэгдэхгүй болно. Тэгж өөрийгөө дайчилдаг, цасанд явган үүрэг гүйцэтгэнэ, морь малтайгаа харьцаад биеэ даагаад явчихдаг цэргүүд байсан. Одоо шаардлага сулраад хүний эрх гээд хийлгэх юм нь багасаад улам суларсаар байна. Дарга нар нь ч цэргээс айгаад шаардлага тавихаа больчихож. Би бол ясны цэрэг учраас эх орондоо нэгэнт тангараг өргөж байгаа бол энэ армид тушаал биелүүлэхийн тулд хатуу юм бас байх ёстой. Ямар нэгэн үүрэг гарахад бэлэн л байх ёстой. Даргын үг бол эх орны тушаал. Одооны ямар ч хүн мөнгө өгчихвөл яаж ч магадгүй болчихоод байна. Дээгүүрээ ч гэсэн тийм л болоод байна. Хөөрхий хилчид өдөр шөнөгүй явган хилээ манаад л гэтэл бид юу манаад байгаа юм. Бид нар цасан шуурганд уулын мухарт үзээд л байхад манай баялгууд гараад л явчихсан байгаа биз дээ. Одоо тэр баахан динозврын яс, тэр чинь төмөр замаараа л томчуудын оролцоотой гараад явж байна. Энэ л харамсалтай байгаа байхгүй юу.

Х: Та хаана, хаана томилогдож ажиллаж байсан билээ?

Ө: Цэргийн албыг бол Дорнодод хаасан. Баян-өлгийн баруун хилээр л ажиллсан.

П: Баруун хилийн гол онцлог юу вэ?

Ө: Уулын бүс, ой тайгын бүс, говь тайгын бүс, тал хээрийн бүс, төвийн бүс гэж таван бүсэд хуваачихсан. Манай энэ уулын бүс ачаалал өндөртэй. Харагдах орчин багатай, өвлийн цагт цас их орно, зарим хэсэгт байгалиараа хилээ хамгаалчихдаг. Бараг юу ч явж чадахааргүй 2 метр цас орно. Зарим үед явахгүй гээд яахав. Уулынхаа амаар цасанд мөр гаргаж үзнэ. Уулын бүс зуны цагт л 4 улирал үзүүлчихнэ. Их хурдан шуурна, уул өөд өгсөх тусмаа шуургатай. Тэнд ажиллаж байгаа албан хаагчид ачаалал өндөртэй. Өндөр өвсөнд ууланд явна, тал хээрийхэн бас халуунд явна. Өндөр ууланд зарим нэг хүний даралт ихсэх зэрэг асуудал гарна. Энэ Баян-өлгий аймаг чинь бараг цэвдэг голдуу. Бөөр нурууны асуудал их гарна. Цастай, хүйтэн, чийгтэй.

Х: Та Баян-өлгийд хэдэн жил амьдарч байгаа вэ?

Ө: Бараг 20 жил болж байна.

З: Казах хүмүүсийн сэтгэлгээний онцлог, хамгийн түрүүнд анзаарагддаг, давуу болон сул тал юу вэ?

Ө: Хувь хүний ухамсартай л холбоотой байна. Казахуудыг үндэсний үзэлтэй гэж ярих нь зарим талаараа хэтрүүлж байна. Нээх надад тийм зүйл мэдэгдэхгүй байна. Зарим нь “эд нар болохгүй байна” гэж ярьдаг. Хүний харьцаанаас л болдог гэж бодож байна. Үндэсний үзэл ярьвал Казахын талын хувьсгалчид хэдэн нөхдүүд л байдаг. Бүх юмыг л даврааж, дэврээж байдаг. Хасагууд, Дөрвөдүүд, Урианхай гэсэн иймэрхүү л яриа явна. Хөдөө явахад сайхан Казах хүмүүс байна. Зарим нөхдүүд очихоор хэлээ гаргахгүй хүмүүс байна. Хувь хүний ухамсраас шалтгаалж байна. Одоо сүүлийн үед гайгүй болж байна. Манай энэ Урианхай, Тува, Дөрвөд гэсэн хүмүүс ер нь хүүхдийнхээ боловсролд их анхаардаг улсууд байсан. Хөдөө, аймгийн төвд бол цус ойртолт болж байна. Одоо сүүлийн үед хүүхдүүдээ дээд сургуульд явуулж байна л даа. Энд одоо өрсөлдөх чадвартай хүүхдүүд алга. Казахууд чинь хөрөнгө мөнгө ихтэй, багаар ажиллахдаа сайн, манайхан тархай, бутархай. Яг ажилд авъя гэхэд манайхан шаардлага хангах муу.

Х: Монгол хүний үнэт зүйл гэвэл та юу хэлэх вэ? Цэрэг хүний үнэт зүйл юу вэ?

Ө: Монгол хүн түүх ихтэй. Монгол хүнд, цэрэг хүнд ч гэсэн эх орон л хэрэгтэй. Эх орноо хайрлах, эх оронч сэтгэлгээ гэдэг хүн болгонд байж л энэ улс орон цаашаа явна. Наад захын жишээ нь л хүн уусан ундаа архины шилээ аваад хогийн саванд хийх байна. Эх орон, түүхээ сайн мэддэг, та хэд бас юм үлдээхийн төлөө л явж байна шүү дээ. Эх орондоо л хайртай байх хэрэгтэй. Хилчин бид нар хилийн дээс алхаад өөр газар очиход нэг л өөр байдаг шүү дээ. Зуны өглөө хилийн баганан дээр очиход багананы цаана Хятадын нутаг нэг л саарал, хүний нутаг харагддаг. Тэгж байгаад өөрийнхөө нутаг руу харахад өнгө зурагтай харагддаг. Энэ дээр л эх орон харагдаж байгаа юм.

Х: За, ярилцсанд их баярлалаа.

Ө: Баярлалаа.